

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ



ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ АСУУДАЛ

ОНОЛ, АРГА ЗҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

2023 №01 (84)
21 дэх жилдээ

СЭТГҮҮЛИЙН БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Дорждамба ЗҮМБЭРЭЛЛХАМ

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ
ПРОФЕССОР

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Пүрэвдорж БАТБААТАР

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Бөхчулуун БАТ-ЭРДЭНЭ

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Бадам БАТЗОРИГ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Жигжидсүрэн БОЛДБААТАР

ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ
ПРОФЕССОР

Баатар БОЛДБААТАР

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Галбат ГАНТӨМӨР

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Жамсран ДОЛГОРСҮРЭН

ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ
ПРОФЕССОР

Думбурай МЯГМАРЦЭРЭН

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Наваанпэрэнлэй ЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Очирхуяг ЗОРИГТ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Авирмэд ЛХАГВА

МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН
ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

Чойжил НЯМСҮРЭН

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Тамжид ОЮУНЧИМЭГ

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Заяатхүү ТӨРМАНДАХ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

ХВАН И ГАБ

ДОКТОР, ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

ДУГААРЫГ ЭРХЛЭН ГАРГАСАН

Лувсан Бат-Очир

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Улсын бүртгэлийн дугаар 237

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Дорждамба ЗҮМБЭРЭЛЛХАМ

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ
ПРОФЕССОР

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Вандан-Иш АМАРСАНАА

ДОКТОР (Ph.D)

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Батсүх АЛТАНСҮХ

ДОКТОР (Ph.D)

Шаравдорж АРИУНБИЛЭГ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Лувсан БАТ-ОЧИР

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Рагчаасүрэн БАЯРМАГНАЙ

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Сэнгээ ГАНТУЛГА

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Амарсайхан МАНЛАЙ

ДОКТОР (Ph.D)

Жаргалсайхан МӨНХБОЛД

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Намжилдорж МӨНХЗУЛ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Бат-Ерөөл МӨНХДОРЖ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Бадарч НАРМАНДАХ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Жутьяа НЯМДУЛАМ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Батхишиг ЛХАГВАСҮРЭН

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Буриад ЛХАГВАРАГЧАА

ДОКТОР (Ph.D)

Шархүү ЧУЛУУНБАТ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Батзэвэг ЭНХБОЛД

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Магмадорж ЭРДЭНЭБАЯР

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Дорж ЭНХТӨР

ДОКТОР (Ph.D)

ГАРЧИГ

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ		
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил ба шинжлэх ухаан	<i>Б.Хулан Д.Булган</i>	5
Бослого, үймээний нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ	<i>В.Амарсанаа</i>	13
Хүүхэд өртсөн зам тээврийн ослын шалтгаан, нөхцөл	<i>О.Болорцэцэг</i>	23
Гэр бүлийн зөрчил, маргаан үүсэх шалтгаан, бууруулах арга зам	<i>Н.Өнөржаргал</i>	31
Гээгдэл эд хөрөнгө завших гэмт хэргийн эрүүгийн нөхцөл байдал, чиг хандлага	<i>Г.Чингис</i>	36
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийн өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ	<i>М.Мөнхбаатар</i>	42
ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ		
Бүх насаар хорих ялын олон улсын эрх зүйн зохицуулалт	<i>Г.Гантөмөр</i>	49
Мал хулгайлах гэмт хэрэгт ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолд хийсэн дүн шинжилгээ	<i>Л.Бат-Очир</i>	56
The Problem of Retroactivity In Amending Statutes of Limitation - A German Perspective	<i>Peter Kasiske</i>	63
ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ		
Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэргийг Сэлэнгэ аймагт шүүхийн өмнөх шатанд шалгаж шийдвэрлэсэн байдалд хийсэн дүн шинжилгээ	<i>Г.Болор-Эрдэнэ</i>	68
ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ		
Цагдаагийн байгууллагаас явуулах зарим объектын судалгаа, боловсруулалтыг сайжруулах арга зам	<i>Г.Бямбадорж</i>	74
Дотоодын цэргийн байгууллагын түүхэнд гүйцэтгэсэн үүрэг, түүний онцлог	<i>Т.Хүрэлбаатар Б.Ариунтөгс</i>	82
ЭРДЭМТЭН, СУДЛААЧДЫН ҮЗЭЛ БОДОЛ		
Framework of The European Data Protection Law	<i>Namsrai Battulga</i>	91
Таны судалгааны арга зүйн мэдлэгт: Судалгааны тайлан бичихэд анхаарах зарим асуудал	<i>Д.Батцэцэг</i>	95
Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь прокурорын оролцоо, тулгамдсан асуудал	<i>М.Отгонжаргал Н.Мөнхзул</i>	100
Шингэрүүлсэн хийн түлшнээс үүдэлтэй гамшгийн эрсдэл, өнөөгийн байдал	<i>О.Ганхуяг</i>	111
Уул уурхайн салбарт ажиллагсдын хүүхдүүдийн нийгмийн зарим асуудал /Өмнөговь аймгийн Ханбогд сумын жишээн дээр/	<i>Э.Золбоо</i>	120
“Гэмт явдалтай тэмцэх асуудал” онол, арга зүйн сэтгүүл-20 жил	<i>Б.Мөнхзул</i>	131
Өмгөөлөгч нийтийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор шүүхэд нэхэмжлэл гаргах асуудал	<i>Д.Энх-Амар Г.Мөнхцэцэг</i>	134

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛ БА ШИНЖЛЭХ УХААН

CRIME PREVENTION AND SCIENCE

Б.Хулан

*ДХИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн
Хувийн эрх зүйн тэнхимийн багш, ахлах дэслэгч*

Д.Булган

*ДХИС-ийн Удирдлагын академийн дэд профессор,
доктор (Ph.D), дэд профессор, цагдаагийн дэд хурандаа*

Товч агуулга: Эрдэм шинжилгээний өгүүллийн хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь ямар шинжлэх ухааны судлах зүйл болох талаар хэлэлцүүлэг өрнүүлнэ. Тухайлбал, цагдаа судлал ба цагдаагийн шинжлэх ухааны судлах зүйл, криминологийн шинжлэх ухааны бүрэлдэхүүн хэсэг үү, гэмт хэргийн шинжлэх ухаан нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг судалдаг, хууль зүйн шинжлэх ухааны буюу цагдаагийн эрх зүй эсхүл гэмт хэргээс урьдчилан сэргийлэх эрх зүй байх эсэх талаар судаллаа.

Abstract: In this academic article, we will discuss the scientific study of crime prevention. For example, whether police studies and police science are part of criminology, whether criminology studies crime prevention, legal science or police law, or crime prevention law. studied.

Түлхүүр үг: гэмт хэрэг, урьдчилан сэргийлэх ажил, гэмт хэргийн шинжлэх ухаан, криминологийн шинжлэх ухаан, онол, төрөл, ангилал.

Key words: crime, preventive work, crime science, criminology science, theory, type, classification.

Удиртгал

“Гэмт хэрэгтэй тэмцэх”, “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, “гэмт явдлаас урьдчилан сэргийлэх”, “таслан зогсоох”, “урьдчилан сэргийлэх” гэсэн хоорондоо ойролцоо мэт олон нэр томьёо гэмт хэргийн болон криминологи, хууль зүйн шинжлэх ухаанд хэрэглэгдэж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг гэмт хэргийн шинжлэх ухаан, криминологийн шинжлэх ухаан, цагдаагийн шинжлэх ухаан, цагдаагийн эрх зүйн талаас нь судалж, тайлбарлах нь маргаантай хэдий ч олон ургалч үзэл, орчин үеийн чиг хандлагад тулгуулан авч үзэх нь зүйтэй юм. Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй хөгжүүлснээр гэмт хэргийн гаралтыг бууруулах, саармагжуулах боломж бүрдэнэ.

Энэхүү өгүүллэгийн зорилго нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг судалдаг шинжлэх ухааны үндэслэлийг тодорхойлох, судлаачдын үзэл баримтлалыг харьцуулан судалж, өөрсдийн байр суурийг илэрхийлж, судалгааны эргэлтэд оруулахыг зорилгоо.

Энэхүү зорилгын хүрээнд дараахь зорилтыг дэвшүүллээ. Үүнд: нэг-т; цагдаа судлал ба цагдаагийн шинжлэх ухааны судлах зүйл эсэх, хоёр-т; гэмт хэргийн шинжлэх ухааны судлах зүйл эсэх, гурав-т; криминологийн шинжлэх ухааны судлах зүйл болох нь дөрөв-т; эрх зүй судлал буюу хууль зүйн шинжлэх ухааны судлах зүйл болох талаар судлаачдын үзэл баримтлалыг харьцуулан судалж, өөрсдийн байр суурь, үзэл бодлыг энэхүү өгүүллээр илэрхийлэв.

“Гэмт хэрэгтэй тэмцэх”, “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, “гэмт явдлаас урьдчилан сэргийлэх”, “таслан зогсоох”, “урьдчилан сэргийлэх” гэсэн хоорондоо ойролцоо мэт олон нэр томьёо криминологи, цагдаа судлал, гэмт хэргийн болон хууль зүйн шинжлэх ухаанд хэрэглэгдэж байна. Өөрөөр хэлбэл, “урьдчилан сэргийлэх” гэсэн ойлголт нь зөвхөн криминологи төдийгүй эрх зүйн ойлголт, нийгэм судлал, хүн ам зүйн хүрээний өргөн агуулга илэрхийлсэн, шууд болон шууд бусаар шинжлэх ухааны бусад олон салбартай холбогддог бөгөөд эдгээр нэр томьёо нь хоорондоо харилцан уялдаа холбоотой ойлголтууд юм.

Нэг.Цагдаагийн шинжлэх ухаан ба гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил. “Монгол Улс дахь Цагдаа судлалын төлөв байдал” сэдэвт судалгааны ажилд “Цагдаа судлал гэдэг нь цагдаагийн байгууллагаас гүйцэтгэдэг үйл ажиллагаа, түүнд хамаарах бүх төрлийн судалгааны ажлыг ойлгоно”¹. Гэмт хэрэг, түүний шалтгаан нөхцөлийг судлах, гэмт хэрэг мөрдөх, нотлох баримт цуглуулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагуудын тогтолцоонд цагдаагийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, хамтын ажиллагаа, шүүхийн шинжилгээ зэрэг судлагдахууны онол, практикийн асуудал ерөнхийдөө цагдаа судлал гэсэн ойлголтод хамаарна гэж тайлбарласан.

“Цагдаа судлал”, “цагдаагийн эрх зүй”-н нэр томьёоны зарим асуудал”² сэдэвт өгүүлэлд “цагдаа судлал” гэсэн нэр томьёо нь “цагдаагийн байгууллагаас хийгдэж байгаа бүхий л үйл ажиллагааг судалдаг судалгаа, сургалт, шинжилгээний тогтолцоо юм” гэж тодорхойлжээ. Харин “цагдаагийн шинжлэх ухаан” гэсэн нэр томьёо Монгол Улсад төдийлөн судалгааны эргэлтэд ороогүй бөгөөд англи хэлнээ “police science”³ (орос хэлэнд хэрэглэгдэж буй нэр томьёог өмнө дурдсан учраас энэ хэсэгт давхцуулсангүй) гэж орчуулж байна. Цагдаагийн шинжлэх ухаан гэсэн нэр томьёоны хүрээнд криминологи, шинжлэн магадлахуй, цагдаагийн сэтгэл судлал, сэтгэц эмгэг судлал, эрх зүй судлал, олон нийтийн цагдаа, гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоо, ял судлал зэрэг нийгмийн шинжлэх ухаанууд хоорондоо харилцан хамааралтай гэж тайлбарласан талаар судалжээ.

С.В.Юрьевич “Германы цагдаагийн шинжлэх ухаан” /Полицейская наука в Германии/ гэсэн өгүүлэлд⁴ цагдаагийн шинжлэх ухаан дараахь хэсгүүдийг өөртөө агуулна гэжээ. Үүнд: цагдаагийн ажил, цагдаагийн стратеги, зорилго, тэдгээрийн хөгжил, цагдаагийн сургалт, цагдаа, гэмт хэрэг, түүнээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн хяналт, цагдаа-олон нийтийн ажиллагаа, цагдаагийн харьцуулсан судалгаа зэрэг асуудлыг хамруулжээ. Мөн цагдаагийн шинжлэх ухаан гэдэг нь салбар хоорондын, олон улсын, эмпирик, норматив шинжлэх ухаан юм гэж тайлбарлажээ.

“Европ дахь цагдаагийн шинжлэх ухааны үзэл баримтлал” (Perspectives of police science in Europe)⁵ гэсэн судалгааны ажилд цагдаагийн шинжлэх ухаан уу? эсхүл цагдаа судлал уу? гэсэн хэлэлцүүлэг өрнүүлж, “Цагдаагийн Шинжлэх Ухаан” гэсэн нэр томьёо дээр тогтож, үүнийг ирээдүйд үргэлжлүүлэн хэлэлцэх шаардлагатай гэж үзсэн байна. Мөн энэ шинжлэх ухааны судлах зүйлд нь цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж буй бүхий үйл ажиллагааг судалдаг бөгөөд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, түүнд үнэлгээ хийх асуудлыг тухайлан авч үзсэн байна.

Цагдаагийн шинжлэх ухаан нь цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд олон төрлийн үүргийг (урьдчилан сэргийлэх, мөрдөн байцаах чиглэлээр) хамааруулан судалдаг байна. Цагдаагийн байгууллага нь үйл ажиллагааныхаа чиглэлээр олон янзын арга, хэрэгсэл, стратегитай байдаг.

¹ Монгол Улс дахь цагдаа судлалын төлөв байдал. -УБ., 2017

² Долгорсүрэн, Ж. Булган, Д. Цагдаа судлал, цагдаагийн эрх зүйн нэр томьёоны зарим асуудал //Хууль сахиулахуй:онол, арга зүйн сэтгүүл. 2020. №02(24). 149 дахь тал

³ https://en.wikipedia.org/wiki/Police_science

⁴ Юрьевич,С.В. Полицейская наука в Германии. <https://cyberleninka.ru/article/v/politseyskaya-nauka-v-germanii>

⁵ Perspectives of police science in Europe. (CEPOL) <https://www.cepol.europa.eu. 2023.02.24>

Жишээлбэл, эргүүл нь ... унадаг дугуйн төрөлтэй, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод хөдөлгөөнт дохиолол өгөх, хяналтын камер эсхүл далд микрофон ашиглах, сэжигтэй алан хядагчид, гэмт хэргийн бүлэглэлүүдийг ажиглах техник хэрэгсэл, үймээн самуунтай тэмцэхэд усан буу, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөхцөл байдлын, олон нийтэд түшиглэсэн, асуудалд чиглэсэн цагдаагийн стратеги зэрэг тактикийн болон стратегийн түвшинд байдаг бөгөөд үүнийг мэдээж цагдаагийн өдөр тутмын ажилд ашигладаг. Ийнхүү дээрх чиг үүргүүдийн хүрээнд тухайлбал, урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг үнэлэх нь цагдаагийн судлаачдын нийтлэг ажил бөгөөд цагдаагийн байгууллага үүргээ биелүүлэхийн тулд юу нь үр дүнтэй, юу нь үр нөлөөтэй болохыг шинжлэх ухааны үндэслэлтэй үнэлэхийг эрмэлздэг талаар судалгаанд дурджээ.

Цагдаагийн шинжлэх ухааны гол зорилго нь цагдаагийн үйл ажиллагааны талаарх үйл баримтыг тайлбарлах, түүнтэй холбоотой ерөнхий болон боломжтой хувилбарыг тодорхойлж, бодит мэдлэгийг бүтээхэд чиглэдэг. Энэхүү зорилгодоо хүрэхийн тулд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны туршлага, мэдлэг бусад чиглэлийн шинжлэх ухааны мэдлэгийг бүтээхэд нийтлэгээр хэрэглэгддэг аргуудыг ашиглана гэжээ⁶. Мөн судалгааны ажилд криминологи, цагдаагийн шинжлэх ухаан нь хоёр өөр шинжлэх ухаан мэт боловч түүхэн талаас нь авч үзвэл криминологи нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгоход шууд бусаар маш их хувь нэмэр оруулсан бөгөөд эцэстээ Цагдаагийн шинжлэх ухаанд ч бас хувь нэмэр оруулсан гэжээ.

Хоёр. Гэмт хэргийн шинжлэх ухаан ба гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг “гэмт хэргийн шинжлэх ухаан”-ы талаас сүүлийн жилүүдэд судалж, тодорхойлох, тайлбарлах хандлага байна. Энэ талаар эрдэмтэн судлаачид өөрсдийн ном бүтээл, судалгааны ажилдаа үндэслэлтэй тайлбарласан нь бий.

“Гэмт хэргийн шинжлэх ухаан: гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, шинэ хандлага”⁷ бүтээлд “гэмт хэргийн шинжлэх ухаан” (crime science) гэсэн нэр томъёог хэрэглэсэн бөгөөд энэ нь гэмт хэргээс хэрхэн урьдчилан сэргийлэх, илрүүлэх талаар судалдаг шинжлэх ухаан бөгөөд криминологи, эдийн засаг, сэтгэл судлал, математик, газар зүй, архитектур болон бусад салбаруудад тулгуурлан гэмт хэргийн хэв шинжийг судалж, асуудлыг шийдвэрлэх арга замыг боловсруулахад чиглэсэн олон талт арга барил гэж тодорхойлсон.

Судлаачид гэмт хэргийн шинжлэх ухааны талаар дараахь дөрвөн бүлэгт хуваан (хэсэг) судалжээ. Үүнд:

1. Гэмт хэргийн шинжлэх ухаан нь шинжлэх ухаан болон үүссэн хөгжил, төлөвшилийг тодорхойлон авч үзсэн.
2. Гэмт хэргийн шинжлэх ухаанд хэрэглэгддэг онол, арга зүйн асуудлыг судлан авч үзсэн.
3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг практик жишээнүүдэд тулгуурлан судалсан бөгөөд гэмт хэргийн шинжлэх ухаан олон талт, өргөн хүрээтэй нөлөө үзүүлж болохыг тодорхойлон судалсан.
4. Гэмт хэргийн илрүүлэлттэй холбоотой жишээнүүдийг судалж, хэлэлцүүлсэн байдаг.

Энэхүү бүтээлд гэмт хэрэгт хариу арга хэмжээ авах шинэ арга замыг эрэлхийлэх боломжуудыг тусгасан бөгөөд “гэмт хэргийн шинжлэх ухаан нь гэмт хэргийн илрүүлэлтийг сайжруулж, гэмт хэргийн нийгэмд үзүүлэх нөлөөллийг

⁶ Энэхүү судалгааны ажлыг Европын цагдаагийн холбооны гишүүн орнуудын судлаачид буюу Ханс-Герд Жаске (Герман), Торе Бьорго (Норвеги), Франциско дель Баррио Ромеро (Испани), Сис Квантен (Нидерланд), Робин Мавби (Их Британи), Милан Пагон (Словени) зэрэг улс орнуудын эрдэмтэн судлаачид 2006 онд хийсэн байна.

⁷ Melissa J. Smith, Nick Tilley (2005) Crime Science: New Approaches to Preventing and Detecting Crime.

бууруулж, “гэмт хэрэг бага гаргах эцсийн үр дүн”-г тодорхойлсон нэгдсэн арга барилын нийлбэр юм” гэж тодорхойлсон.

Гэмт хэргийн шинжлэх ухаан, криминологийг хооронд нь харьцуулан авч үзэхэд гэмт хэргийн шинжлэх ухаан нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга замыг эрэлхийлдэг бол⁸, криминологи нь гэмт хэрэгтнүүдэд илүү анхаарал хандуулж, гэмт хэрэгтний зан төлөв, түүнийг тайлбарласан байдаг. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн шинжлэх ухаан нь “гэмт хэрэг”-т илүү анхаарал хандуулж, түүнийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байдаг.

“Криминологийн онол”⁹ гарын авлагын арван дөрөвдүгээр бүлэгт “гэмт хэргийн шинжлэх ухаан”-ы талаар судалсан байна. Энэхүү бүлэгт криминологийн үгийн санд “гэмт хэргийн шинжлэх ухаан” гэсэн нэр томъёо сүүлийн жилүүдэд орж ирсэн талаар дурдаад энэ нь зөвхөн гэмт хэргийн тухай ойлголтыг тайлбарлахад бус, гэмт хэргийг бууруулахад чиглэсэн тул криминологи биш бөгөөд гэмт хэргийн шинжлэх ухаан гэсэн өөр нэр томъёог хэрэглэсэн нь зөв гэж тайлбарласан.

Мөн гэмт хэргийн шинжлэх ухаан нь криминологийн өөр нэг хувилбар мөн үү, эсхүл энэ нэр томъёонд хамаарах онол урьдчилан сэргийлэх ажилд илүү сайн дүгнэлт өгч чадах уу гэсэн хэлэлцүүлэг өрнөсөн. Эдгээр хувилбаруудыг дэмжиж, гэмт хэргийн шинжлэх ухаан нь гэмт хэргийг судлах, хянах парадигмыг санал болгодог бөгөөд энэ нь криминологиос өөр юм гэж тайлбарласан. Тиймээс гэмт хэргийн шинжлэх ухааныг гэмт хэрэгтэй тэмцэх боловсрол, бодлогын чухал хэрэгцээнд нийцсэн бие даасан салбар гэж үзэх нь зүйтэй гэж дүгнэжээ.

Гэмт хэргийн шинжлэх ухааны талаар сүүлийн жилүүдэд нэлээд газар авч, хөгжиж байгаа хэдий ч маргаантай асуудлууд хэвээр байсаар байна. Тухайлбал,

- Шинэ Зеландын Вайкатогийн их сургууль¹⁰, АНУ-ын Цинциннати их сургууль¹¹ болон бусад газарт гэмт хэргийн шинжлэх ухааны тэнхимийг анх байгуулсан.
- Гэмт хэргийн шинжлэх ухааны сургалтын хөтөлбөр бий болсон. Их Британийн Нортумбрия их сургууль (Northumbria University), Нидерландын Твенте их сургууль (University of Twente), Темпл их сургууль (Temple University), АНУ-ын Филадельфи зэрэг хэд хэдэн сургуулиудад гэмт хэргийн шинжлэх ухааны чиглэлээр төгсөлтийн дараах ангиуд бий болсон.
- Их Британийн Аюулгүй байдлыг (батлан) хамгаалах яамны судалгааны хэлтэс болох DSTL (The Defence Science and Technology Laboratory) гэмт хэргийн шинжлэх ухааны албыг байгуулсан.
- Гэмт хэргийн шинжлэх ухаан гэсэн нэр томъёог АНУ, Австралийн криминологичид улам бүр хэрэглэх болсон.
- Лондонд жил бүр зохион байгуулдаг гэмт хэргийн шинжлэх ухааны сүлжээний цугларалтад дэлхийн өнцөг булан бүрээс цагдаагийн болон бусад эрдэмтэн судлаачид ирдэг байна.
- Гэмт хэргийн шинжлэх ухаанд зориулсан “Springer Open Access” салбар хоорондын “Гэмт хэргийн шинжлэх ухаан” гэсэн сэтгүүл¹² гарч байна.
- Гэмт хэргийн шинжлэх ухааныг криминологийн сурах бичиг, илтгэл, өгүүлэлд иш татсаар байна. Өөрөөр хэлбэл, урьдчилан сэргийлэх ажил нь гэмт хэргийн

⁸ Willison, Robert; Siponen, Mikko (1 September 2009). “Overcoming the insider: reducing employee computer crime through Situational Crime Prevention”. *Communications of the ACM*. 52 (9): 133–137. doi:10.1145/1562164.1562198. ISSN 0001-0782. S2CID 2987733

⁹ Clarke, R. SAGE Handbook of Criminological Theory (2010). ISBN 978-1-4129-2038-4. Printed by MPG Books Group, Bodmin, Cornwall. p.14.

¹⁰ Вайкатогийн их сургууль нь Шинэ Зеландын Хамилтон хотод 1964 онд байгуулагдсан олон нийтийн судалгааны их сургууль юм.

¹¹ Цинциннатигийн их сургууль нь Охайо мужийн Цинциннати хотод байрладаг олон нийтийн судалгааны их сургууль юм. 1819 онд Цинциннати коллеж нэртэйгээр байгуулагдсан, Цинциннатигийн хамгийн эртний дээд боловсролын байгууллага бөгөөд жил бүр 44,000 гаруй оюутан элсүүлдэг бөгөөд Охайо мужийн хоёр дахь том их сургууль юм.

¹² “Crime Science” (electronic - open access). *Crime Science*. Springer Nature. ISSN 2193-7680. Retrieved 21 January 2021.

шинжлэх ухаан уу? криминологийн шинжлэх ухаанд хамаарах уу гэдэг нь маргаантай хэвээр байсаар байна. Тухайлбал, зарим судлаачид криминологийн шинэ салбар гэж үздэг бол зарим нь бүр эсрэг байр сууриар тайлбарласан нь ч бий.

Гурав. Криминологийн шинжлэх ухаан ба гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил. Монголын судлаачид криминологийн зарим бүтээлүүдэд тухайлбал, Д.Зүмбэрэллхам “Криминологийн онол” бүтээлдээ криминологийн шинжлэх ухааны судлах зүйлд гэмт хэрэг, гэмт хэрэгтэн, гэмт хэргийн хохирогч, нийгмийн орчин, гэмт явдалд нөлөөлөх хүчин зүйлүүд бүхлээрээ хамаарахаас гадна гэмт хэрэгтнийг шийтгэлээр засан хүмүүжүүлэх арга хэмжээ, зан үйл, төлөв байдлын урьдчилан таамаглал, гэмт явдлыг хянах арга ба хэлбэр хамаарна¹³ гэжээ.

Мөн Л.Батжав бүтээлдээ¹⁴ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг криминологийн шинжлэх ухааны судлах зүйлийн нэг бүрэлдэхүүн хэсэг болох талаар дурдсан. Энэхүү бүрэлдэхүүн хэсэгт дараахь 4 агуулгыг судалсан байна.

- Гэмт явдал түүний үндсэн шинж;
- Гэмт явдлын шалтгаан, нөхцөл;
- Гэмт хэрэгтэн бие хүн;
- Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ зэрэг болно.

Мөн Н.Жанцан бүтээлдээ¹⁵ криминологи нь гэмт явдлын шалтгаан, нөхцөл, гэмт хэрэгтэн бие хүний онцлогийг судалж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ боловсруулах шинжлэх ухаан гэж үзээд криминологийн шинжлэх ухааны судлах зүйлийг 5 бүрэлдэхүүн хэсэгт хуваан судалжээ. Дээрх 4 бүрэлдэхүүн дээр “гэмт хэргээс учирсан хохирол”-ын талаар судалжээ.

Дотоодын эрдэмтэн, судлаачдын бүтээлүүдээс үзэхэд урьдчилан сэргийлэх ажил нь криминологийн шинжлэх ухааны бүрэлдэхүүн хэсэг гэж тайлбарласан бөгөөд сүүлийн жилүүдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг криминологийн энэхүү уламжлалт ойлголтод тулгуурлан авч үзэж, тайлбарласан байна. Гэмт хэргийн шинжлэх ухааны ойлголтод тулгуурлан авч үзвэл криминологийн шинжлэх ухаанаас салган авч үзэх хэрэгцээ шаардлага гарна. Учир нь орчин үеийн гэмт хэргийн шинжлэх ухаанд гэмт хэрэгтэн, бие хүн, тэдгээрийн зан төлөвийг судалдаггүй бөгөөд зөвхөн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, түүнтэй холбоотой онол, арга зүйн асуудлыг судалдаг байна.

Криминологийн шинжлэх ухаан, гэмт хэргийн шинжлэх ухааныг зааглан авч үзвэл:

1. Дээр дурдсанчлан гэмт хэргийн шинжлэх ухаан ба криминологи хоёрын гол ялгаа нь гэмт хэргийн шинжлэх ухаан нь үйл явдал, нөхцөл байдалд анхаарлаа төвлөрүүлдэг бол криминологи нь гэмт хэрэгтэн, түүний зан үйл, төлөвт анхаарлаа төвлөрүүлдэг.
2. Гэмт хэргийн шинжлэх ухаан нь богинохон түүхтэй хэдий ч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр судалгаа, шинжилгээг түлхүү хийдэг бөгөөд өөр өөр онол, хэрэглээг хамарсан онолын таамаглалуудын уялдаа холбоог авч үздэг. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийг судлах, хянах, урьдчилан сэргийлэх өөр парадигмыг илэрхийлдэг.
3. Тэдний өөр өөр парадигмуудтай нийцүүлэн, гэмт хэргийн шинжлэх ухаан ба криминологи хоёрын хооронд судалгааны арга барил, эрхэм зорилго болон бусад олон ялгаа байдаг. Тухайлбал, криминологи нь судалгааны хувьд гэмт хэрэг үйлдэгч, зан чанарт анхаарлаа хандуулдаг бөгөөд сүүлийн хэдэн арван жилд онолыг турших болон гэмт хэрэгтэнд илүү чиглэсэн судалгаа хийхэд ихээхэн анхаардаг. Энэхүү судалгаанд сэтгэл зүй-логикийн үнэлгээ,

¹³ Зүмбэрэллхам, Д. Криминологийн онол. -Уб., 2022. 21 дэх тал

¹⁴ Батжав, Л. Гэмт явдал, түүний шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх асуудал. -Уб., 2002. 8 дахь тал.

¹⁵ Жанцан, Н. Криминологи. -Уб., 2000. 3 дахь тал

боловсролын түвшний хэмжүүр, олон талт статистик шинжилгээ г.м. Харин гэмт хэргийн шинжлэх ухаанд гэмт хэргийн тодорхой асуудлыг шийдвэрлэхэд туслах судалгааны загварыг илүү их ашигладаг бөгөөд үүнд асуудалд дүн шинжилгээ хийж, таамаглал дэвшүүлж, боломжит шийдлүүдийг тодорхойлдог. Ашигласан аргууд нь хохирогчийн судалгаа, эрсдэлийн үнэлгээ, гэмт хэргийн аудит, үнэлгээ, халуун цэг, давтан хохирогчийн шинжилгээ зэрэг аргуудыг ашигладаг.

Дээрх бүтээлүүдийг харьцуулан үзэхэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг “криминологи”, “цагдаа судлал буюу цагдаагийн шинжлэх ухаан”, “цагдаагийн эрх зүйн”-н аль аль талаас нь судалж, тодорхойлон авч үзсэн байна. Тиймээс судлаачийн хувьд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь бие даасан шинжлэх ухаан (гэмт хэргийн шинжлэх ухаан), криминологийн судлагдахууны бүрэлдэхүүн нэг хэсэг, эсхүл цагдаагийн эрх зүйн тусгай ангид хамаарч бие даасан салбар эрх зүй болон хөгжих боломжтой эсэх талаар эргэцүүлэн судалж үзлээ. Эндээс эрх зүй судлал талаас тодорхойлон авч үзвэл “гэмт хэргээс (зөрчил) урьдчилан сэргийлэх эрх зүй” гэсэн бие даасан салбар эрх зүйн болон хөгжих боломжтой байна. Харин барууны орнуудын чиг хандлагыг судалж үзвэл түүнтэй уялдуулан “гэмт хэргийн шинжлэх ухаан” болон хөгжих боломжтой байна. Үүнийг нэгтгэн дүгнэвэл гэмт хэргийн шинжлэх ухааны хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх эрх зүйг судлан авч үзэх боломжтой юм.

Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг судалсан ном бүтээл ховор бөгөөд энэ талаар хэлэлцүүлэг, эрдэм шинжилгээний хурал, ном бүтээл, илтгэл, өгүүллэгүүдийг туурвиж, судалгааны ажлыг хөгжүүлэх, судалгааны эргэлтэд оруулах хэрэгцээ шаардлагатай байсаар байна. Өөрөөр хэлбэл, “гэмт хэргийн шинжлэх ухаан”, “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх эрх зүй”-н гэсэн судлаач бидний дүгнэлт нь нэлээн маргаан дагуулна. Учир нь энэ чиглэлийн судалгааны ажил ховор байгааг илтгэж байгаа юм. Тиймээс цаашид судалгааны ажлыг хөгжүүлэх, энэ чиглэлийн эрдэмтэн, судлаачдыг бэлтгэх, бий болгох нь зүйтэй юм.

4. Энэ сэдвийн хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг судалдаг шинжлэх ухааны талаар авч үзсэний учир нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын ойлголт, төрөл, эрх зүйн зохицуулалт, урьдчилан сэргийлэх стратеги, төлөвлөгөө, түүний хэрэгжилт, үр нөлөө, үр дүнг тодорхойлох асуудлыг цогцоор нь судалж, практикт сайн туршлагыг бий болгох хэрэгцээ шаардлагыг тодорхойлж байна.

Дөрөв. Эрх зүй судлал ба гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил.

Монгол Улсад эрх зүйг судалдаг шинжлэх ухааныг хууль зүйн шинжлэх ухаан, эрх зүй судлал гэж нэрлэж, хэрэглэдэг. Тухайлбал, “Хууль зүйн шинжлэх ухаан бол эрх зүйн мэдлэг гэдэг өвөрмөц бүтээгдэхүүн гаргадаг оюуны үйлдвэрлэлийн лаборатори¹⁶, “Хууль зүйн шинжлэх ухаан нь эрх зүйн үзэгдлийн мөн чанар, зүй тогтол, хэтийн төлөв, чиг хандлагыг судалдаг нийгмийн шинжлэх ухааны нэг салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм¹⁷ гэж тодорхойлсон нь бий. Харин Н.Лүндэндорж “Jurisprudence-Эрх зүйн судлал: философи, онол” бүтээлд судлаачдын олон янзын байр суурийг харахад ерөнхий эрх зүй судлал нь хууль зүйн практик, үзэгдэл, харилцаа, үзэл санааг эрх зүйн тодорхой онол, философийн үзэл баримтлалын үүднээс задлан шинжлэх, хийсвэрлэн тайлбарлах, бясалгах замаар бүтээсэн, эрх зүйн дотоод, гадаад асуудлыг хамарсан онол, сэтгэлгээний байгууламж юм¹⁸ гэж эрх зүй судлал талаар тодорхойлон авч үзсэн.

¹⁶ Сэнгэдорж, Т. Хууль зүйн шинжлэх ухааны ойлголт, зарчим, арга зүй. -УБ., 2000. //Эрх зүй сэтгүүл №4. 88 дахь тал

¹⁷ Баярсайхан, Д. Эрх зүйн онол. -УБ., 2010. 128 дахь тал

¹⁸ Лүндэндорж, Н. Jurisprudence-Эрх зүйн судлал: философи, онол. -УБ., 2011. 14 дэх тал

Мөн зарим ном бүтээлүүдэд эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаан¹⁹, иргэний эрх зүй нь хууль зүйн шинжлэх ухааны салбар шинжлэх ухаан болох нь²⁰, цагдаагийн эрх зүйн шинжлэх ухаан²¹ гэсэн нэр томъёоны талаар хууль зүйн ном бүтээлүүдэд судалж, тодорхойлон авч үзсэн нь бий.

Академич С.Нарангэрэл: “Эрх зүй судлал нь хууль зүйн шинжлэх ухаан, хууль зүй судлал, сургалтын байгууллагад хууль зүйн мэргэжлийн нэр”, “эрх зүйн шинжлэх ухаан нь эрх зүй, түүний бүхий л үзэгдлийг шинжлэн судалдаг шинжлэх ухааны салбар”, “цагдаагийн эрх зүй нь захиргааны эрх зүйн дэд институт, судлагдахуун”, “цагдаагийн эрх зүйн судлах зүйл нь цагдаагийн дотоод удирдлага²²” хэмээн тайлбарлажээ.

Г.Банзрагч “Эдийн засгийн захиргааны эрх зүй” бүтээлдээ захиргааны эрх зүйн тусгай ангийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлон авч үзэхдээ захиргаа-улс төрийн салбарын удирдлагаас “цагдаагийн эрх зүй”, “нийтийн хэв журмын эрх зүй”, “аюулгүй байдлын эрх зүй”, “байгаль орчны эрх зүй” ... зэрэг төрөлжсөн захиргааны эрх зүй хөгжих боломжтой гэжээ. Түүний сацуу одоо нэгэнт тогтсон татварын эрх зүй, санхүүгийн эрх зүйг, төрийн албаны эрх зүй, нутгийн удирдлагын эрх зүй, экологийн эрх зүй зэрэг нь цаашид захиргааны эрх зүйн тусгай ангийг бүрдүүлэгч төрөлжсөн эрх зүйн хувиар хөгжих нь гарцаагүй юм²³.

“Монгол Улсын цагдаагийн эрх зүйн курс” бүтээлд цагдаагийн байгууллагын захиргааны үйл ажиллагааг гадаад болон дотоод үйл ажиллагаа гэж ангилан авч үзсэн. Гадаад үйл ажиллагааг өргөн утгаар нь а) нийтийн хэв журам хамгаалах, б) олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа, в) эрх зүйн зөрчилтэй тэмцэх гэж ангилжээ.

Эрх зүйн зөрчилтэй тэмцэх салбарт цагдаагийн эрх бүхий алба хаагч нь “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүний шалтгаан нөхцөлийг тогтоож арилгах, гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа болон үйлдэж байгаа тухай мэдээлэл авмагц таслан зогсоох, учирч болох хор аюулыг зайлуулах шуурхай арга хэмжээ авах, танхайрах, согтуурах, нийтийн эзэмшлийн эд хөрөнгө эвдэх, гэмтээх, хүйтэн зэвсэг хууль бусаар авч явах гэх мэт зарим зөрчилтэй тэмцэл хийх, хууль тогтоомж зөрчигчдөд албадлага хэрэглэх, шийтгэл хүлээлгэх зэрэг өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулна²⁴.

Цагдаагийн эрх зүйн бүтээлүүдэд цагдаагийн байгууллагын захиргааны үйл ажиллагаанд гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхэлдээ хамаарахгүй бөгөөд мөрдөн шалгах, мөрдөн шалгах нууц ажиллагаа нь бусад салбар эрх зүй тухайлбал, “эргүүгийн процессын эрх зүй”, “гүйцэтгэх ажил” зэрэг бусад салбар эрх зүйн зохицуулах зүйл гэжээ. Өөрөөр хэлбэл, эрх зүйн зөрчилтэй тэмцэх ажлын хүрээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг цагдаагийн байгууллагын захиргааны үйл ажиллагаанд хамааруулан үзжээ.

Дээрх судлаачдын бүтээлүүдийг харьцуулан үзээд бид “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх эрх зүй” гэсэн төрөлжсөн салбар эрх зүй болон хөгжих боломжтой эсэх, хэрэв боломжтой бол захиргааны эрх зүйн тусгай ангид хамаарах уу гэсэн асуултууд гарч байна.

Захиргааны эрх зүй гэдэг нь захиргааны хувьд тусгайлан зориулагдсан, өөрөөр хэлбэл, захиргааны шийдвэр гаргах ажиллагаа болон бусад үйл ажиллагаа,

¹⁹ Гантөмөр, Г. Гантулга, С. нар. Эрүүгийн эрх зүйн ерөнхий анги. -УБ., 2020. 21 дэх тал.

²⁰ Мөнхжаргал, Т. Монгол Улсын иргэний эрх зүй ерөнхий анги.-УБ., 2000. 11 дэх тал.

²¹ Долгорсүрэн, Ж. Булган, Д. Монгол Улсын цагдаагийн эрх зүйн курс. -УБ., 2014. 20 дахь тал.

²² Нарангэрэл, С. Эрх зүйн толь бичиг. Нэмэн засварласан хоёр дахь хэвлэл. -УБ., 2008. 632, 551, 609, 619 дэх тал.

²³ Банзрагч, Г. Эдийн засгийн захиргааны эрх зүй. -УБ., 2013. 10 дахь тал.

²⁴ Долгорсүрэн, Ж. Булган, Д. Монгол Улсын цагдаагийн эрх зүйн курс. -УБ., 2014. 66 дахь тал.

захиргааны байгууллагатай²⁵ харилцааг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээнүүдийн нийлбэр цогц юм²⁶.

Монгол Улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 7-д Засгийн газрын бүрэн эрхийн хүрээнд “хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журам бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээг авч, хэрэгжүүлнэ”²⁷ гэж заасан. Энэ нь нийтийн захиргааны байгууллагын гүйцэтгэх үүргийг хэрэгжүүлэх суурь зохицуулалт юм.

Мөн “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-д гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн төрийн байгууллагуудын зохион байгуулалтын бүтэц, тогтолцоо, чиг үүрэг, эрх хэмжээг тодорхойлж, эрх, үүргийг нь зааж өгсөн нь захиргааны эрх зүйн хэмжээ гэж үзэх үндэслэлтэй юм.

Дүгнэлт

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг олон талаас нь өөр өөр шинжлэх ухаан судалдаг болох нь судалгааны явцад ажиглагдлаа. Манай улсын хувьд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь криминологийн шинжлэх ухааны нэг бүрэлдэхүүн хэсэг гэсэн тогтсон ойлголт байдаг хэдий ч баруун европын улс орнуудад гэмт хэргийн шинжлэх ухаан (crime science) гэсэн бие даасан шинжлэх ухаан болон хөгжиж байна. Энэ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, буруулахтай холбоотой харилцааг судалж, хөгжүүлэхэд чиглэсэн байна. Мөн “цагдаа судлал буюу цагдаагийн шинжлэх ухаан”-д криминологийн шинжлэх ухаан, эрх зүй судлал буюу хууль зүйн шинжлэх ухаантай харилцан хамааралтайгаар тодорхойлогддог байна (судалгааны ажилтай төдийлөн хамааралтай бус тул гүнзгийрүүлэн судлаагүй болно).

Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын талаарх судалгаа, шинжилгээний ажлыг эрчимжүүлэх, хөгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна. Гэхдээ гэмт хэргийн шинжлэх ухаан уу? Цагдаа судлал уу? Криминологи уу? Эсхүл эрх зүй судлал, түүний дотор цагдаагийн эрх зүйд хамааралтай эсэх нь өнөөдрийг хүртэл тодорхойгүй байсаар байна. Гэсэн хэдий ч олон ургалч үзэл, орчин үеийн чиг хандлагад тулгуулан авч үзэж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй хөгжүүлснээр гэмт хэргийн гаралтыг бууруулах боломж бүрдэнэ. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн шинжлэх ухаан нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх олон талт, нарийвчилсан ажлуудыг судалж, хөгжүүлэх, үр нөлөөг нь шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлох, дүн шинжилгээ хийхтэй холбоотой судалгааг хөгжүүлэх гол үндэс бүрдэх юм. Мөн эрх зүйн шинжлэх ухааны талаас нь авч үзвэл “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх эрх зүй” гэж хөгжүүлэх, судлах боломжтой бөгөөд захиргааны эрх зүйн тусгай ангийн төрөлжсөн эрх зүйн болон хөгжих юм.

²⁵ Захиргааны ерөнхий хууль 5 дугаар зүйлд захиргааны байгууллагын талаар заасан. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүрэг хэрэгжүүлэх Засгийн газрын байгууллагууд нь захиргааны байгууллага болно.

²⁶ Одгэрэл, П. Захиргааны эрх зүйн ерөнхий анги. -Уб., 2016. 21 дахь тал.

²⁷ Монгол Улсын Үндсэн хууль 1992 он, ТМ №01.

БОСЛОГО, ҮЙМЭЭНИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

ANALYSIS OF RIOT SITUATIONS

В.Амарсанаа

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн багш, доктор (Ph.D), цагдаагийн хошууч

Товч агуулга: Өнгөт хувьсгал нь улс орны удирдлагыг огцруулах, улс төрийн нам, төрийн бус байгууллага, сөрөг хүчнийг ашиглан сонгуулийн үр дүнг өөрчлөх, иргэдийн сэтгэл зүйг аливаа хэлбэрийн тэмцэлд бэлтгэх, төв талбай, олон нийтийн газруудад нийтийг хамарсан цуглааныг зохион байгуулах зэрэг урьдчилсан төлөвлөсөн, шат дараалсан үйл ажиллагааг өөртөө багтаадаг. Жишээ нь: улс төрийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог иргэд, нийгмийн бүлэг, олон нийтийн байгууллагын гишүүд хоорондоо нэгдэх, төрийн эрх баригчдыг солих, эсхүл сонгуульд нэр дэвшигчийн ажиллагааг хааж боогдуулах уриалга гаргах, сонгуулийн үр дүнг урьдчилж эс зөвшөөрөх, рейтинг тогтоох урьдчилсан судалгаа хийж сурталчлах, сонгуулийг хойшлуулах, зохион байгуулахгүй байх шаардлага тавих зэрэг үйлдлээр илэрдэг. Энэхүү өгүүлэлд Монгол Улсад уг үйл явдлын урьдчилсан нөхцөл бүрдсэн эсэх, урьд өмнө өрнөж байсан бослого, үймээн нь өнгөт хувьсгалын шинжийг агуулж байсан эсэхийг тодруулахыг зорилгоо.

Abstract: The Color Revolution includes pre-planned and staged activities such as the removal of the country's leadership, the use of political parties, non-governmental organizations, and the opposition to change the results of elections, prepare the psyche of Citizens for any form of struggle, organize mass gatherings in central squares and public places. For example, citizens, social groups, and members of public organizations actively involved in political activities may join together, call for the replacement of state authorities, block election candidates, pre-empt election results, conduct preliminary rating research, promote, and demand that elections be postponed or not held. The article seeks to clarify whether there were preconditions for the event in Mongolia and whether the riots and riots that took place in the past had the character of a color revolution.

Түлхүүр үгс: Авлига, бослого, нам, улс төр, үймээн, хувьсгал, эдийн засаг.

Keywords: Corruption, rebellion, party, politics, panic, revolution, economy.

Дэлхийн улс орнуудад нийгмийн харилцааг өөрчлөхөд чиглэсэн хувьсгал олон гарч байсан бөгөөд, өөр өөрийн зорилго, чиглэлээрээ хоорондоо ихээхэн ялгагддаг юм. Эдгээрээс Франц, Америк, Оросын хувьсгалыг онцолж болно. ХҮIII зууны сүүл үеийн Франц, ХХ зууны эхэн үеийн Орос оронд гарсан хувьсгал нь тухайн үедээ ноёрхож байсан хуучин харилцааг халах ангийн тэмцлийн үр дагавар болж, хаант засаглалыг өөрийн орондоо эцэс болгосон юм. Эдгээр хувьсгалыг радикал хүч толгойлсон бөгөөд, гол хэрэгсэл нь хүчирхийлэл байжээ. Өөрөөр хэлбэл, эдгээр орны улс төрийн дэглэмийг өөрчлөхдөө хүч, зэвсэг хэрэглэсэн нь гол онцлог юм. ХҮIII зууны Америкийн Нэгдсэн Улсыг байгуулахын төлөө тэмцэл мөн хүчирхийллийн шинжтэй хувьсгалд тооцогддог. Гагцхүү, Франц, Оросын хувьсгал нь үндэстний хүрээнд гарч байсан анги хоорондын тэмцэл байсан бол Америкийн хувьсгал Их Британийн хаант засаглалын хараат байдлаас ангижирч, тусгаар улс байгуулах зорилготой байжээ. Эндээс үзэхэд, нийгмийн улс төрийн дэглэм, засаглалын харилцааг үндсээр нь халж солиход хувьсгалт шинжтэй өөрчлөлтүүд зайлшгүй шаардагддаг байна.

1990 оны үеэс монголын нийгэмд гарч эхэлсэн гүн гүнзгий өөрчлөлтийг ардчилсан хувьсгал хэмээн үздэг. Нийгмийн улс төр, эдийн засаг зэрэг бүхий л харилцааг эрс өөрчлөх болсон нь уг өөрчлөлтийн хувьсгалт шинжийг илэрхийлдэг байна. Түүхийн энэ он жилүүдэд ард иргэд ардчилсан нийгмийн суурь болсон үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх, хуран цуглах, мэдэгдэл

гаргах, эвлэлдэн нэгдэх, сөрөг нам байгуулах болон бусад тэгш эрх эдлэх болсон. Үүний үр дүнд монгол улсад олон тооны нам, эвсэл, холбоо үүсэн байгуулагдаж, үйл ажиллагаа явуулах болсон бөгөөд, тэдгээрийн тоо улам өсөх хандлагатай байна. Монгол Улсын Дээд шүүхэд бүртгэлтэй 36 нам, улсын бүртгэлд бүртгэгдсэн 20583 төрийн бус байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас нийгэмд үйлчилдэг 16755, гишүүддээ үйлчилдэг 2260, сан 1568 байна. Хэдийгээр ардчилсан тогтолцоотой улс болохын хувьд бусдын эвлэлдэн нэгдэх эрхийг төрөөс хязгаарлах боломжгүй боловч, дөнгөж гурван сая гаруй хүн амтай манай улсад хэтэрхий олон төрлийн нам, эвсэл, холбоо бүрэлдэн тогтсон нь улс орны эв нэгдэлд сөргөөр нөлөөлөх хортой юм.

“Улс төрийн намын тухай” хуулийн 1 дүгээр зүйлд: “Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийг хангах зорилгоор улс төрийн нам байгуулах, үйл ажиллагааг нь зогсоох, тараах, улсын бүртгэлд бүртгэх, намын зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, үүнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино” гэж заасан. Энэ хуулийн 5 дугаар зүйлийн (намын үйл ажиллагааны зарчим) 5.1.1-д “ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдэл, тусгаар тогтнолыг хангах, нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлэх”²⁸ гэж тодорхой заасан байдаг. Гэтэл Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй намууд дундаас бусдыгаа бодвол харьцангуй олон тооны гишүүдтэй, төрийн эрхийг ээлжлэн барих болсон Монгол ардын нам болон Ардчилсан нам хоёрын хоорондын зөрчил жил ирэх тусам хурцдах хандлага ажиглагдаж байгаа явдал нь үндэсний эв нэгдэл, тусгаар тогтнолыг хангах зарчимд нийцэхгүй юм.

Нам хоорондын үл ойлголцлын талаар Б.Батбаяр (Баабар) “2004 оны сонгуулиар Ардчилсан намаас “Алтан гадас”-ынхан голдуу тойроггүй хоцорч, их эвсэлд нэгдсэн “Эрэл” хамаг аятай тойргуудад тухалчихсан гээд бас л хэл ам болж байв. Тэр үед их эвслийг байгуулахаар Б.Эрдэнэбат, С.Оюун нартай Ардчилсан намын дарга М.Энхсайхан үзэглэж байж билээ. Сонгуулийн дараа хамтарсан Засгийн газар байгуулахыг нэг хэсэг нь дэмжиж, нөгөө хэсэг нь эсэргүүцэж баахан хагарсан. Монгол ардын хувьсгалт намын хэсэг хамтарсан дүр үзүүлж байгаад Хамтарсан Засгийн газраа Үндэсний эв нэгдлийн Засгийн газар гээчээр сольсон бөгөөд энэ үед хамтрахыг эхнээсээ эсэргүүцэж байсан М.Энхсайхан тэргүүтэй шинэ тутам байгуулагдсан Үндэсний шинэ нам, Ард түмний нам, Бүгд найрамдах нам, Иргэний зориг ногоон нам гээд жижигчүүд нэгдэж байлаа. 2008 оны сонгуулийн дараа Монгол ардын хувьсгалт намын дарга С.Баяр хамтрахыг урьсан нь Ардчилсан намыг дахиад л хуваачихсан юм. Албан тушаалын сургаар намынхаа даргын эсрэг нүүр улаймаар сүлбэлдэж байгааг харсан хүмүүс “Улс төр гээч нь ийм аюултай байдаг юм байх даа” гэж гайхширч байсан билээ”²⁹ гэж нэгэн нийтлэлдээ өгүүлжээ.

Сүүлийн жилүүдэд нам хоорондын ашиг сонирхлын зөрчил, тэмцлээс шалтгаалж, тодруулбал, олонхын суудал авсан эрх баригч намын үйл ажиллагааг бусад намын зүгээс ямар нэгэн үндэслэлгүйгээр харлуулах, үйл ажиллагаанд нь элдэв байдлаар саад хийх явдал газар авсан. Хэдийгээр энэ үзэгдэл хэдэн намын хоорондын үл ойлголцол мэт харагдах боловч, Монголын улс төрийн бодлого, цаашлаад улсын эрх ашиг, нийгэм, эдийн засгийн тогтвортой байдалд хор хөнөөл учруулах аюултай юм.

Нам хоорондын үл ойлголцол, тэмцэл, сонгуулийн дүнг хүлээн зөвшөөрөхгүй байдлаас үүссэн маргаан зэрэг нь Монгол Улсад 2000 оноос хойшх хугацаанд багагүй хэмжээний жагсаал, цуглаан гарах урьдчилсан нөхцөл болсон. Үүний нэг том жишээ нь 2008 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн эмх замбраагүй байдал юм.

2008 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн 13:00 цагийн үед сонгуулийн дүнг эсэргүүцсэн иргэдийн жагсаал эхэлж, Сүхбаатарын талбайд 200-300 орчим хүн цугласан бөгөөд, 14 цагийн үед Монгол ардын хувьсгалт намын байрны гадаа хүмүүс

²⁸ Улс төрийн намын тухай хууль. <https://legalinfo.mn/mn/detail/508>.

²⁹ Батбаяр Б. Манай намуудын хагарал. Нийтлэл. Интернет холбоос: <http://www.baabar.mn/article/2442>.

жагсаж эхэлсэн байна. Өдрийн сонины 2008 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн нийтлэлд “14:00 цагт эхэлсэн эсэргүүцлийн жагсаал хэдхэн минутын дараа учир утгагүй үймээн болж хувирав”³⁰ гэж мэдээлжээ. 15 цагийн үед нөхцөл байдал бүр хүндэрч, цагдаагийн ажилтнууд руу босогчид чулуу нүүлгэж, Монгол ардын хувьсгалт намын байрны цонхнуудыг чулуугаар цохин хагалж эхэлсэн байна. Улмаар 17 цагийн үед Монгол ардын хувьсгалт намын байрны нэг давхарын өрөөнүүдэд ээлжлэн түймэр тавьж, эд хогшлыг эвдэн сүйтгэж, цагдаа нарын зүг дайрсан байна. Гадаа талбайд машин шатаж, намын байрны зарим хэсэг шатаж байснаас гадна “Гэмтэл согог сэргээн засах клиник”-т энд тэндгүй ёолсон, толгойгоо боосон, гар хөлөө зүсүүлсэн, хугалсан хүмүүсээр дүүрсэн байна. 19 цагийн үед намын байран дотор байсан хүмүүс угаартаж, нөхцөл байдал хяналтаас гарсан байна³¹. Эмх замбраагүй байдлын уршгаар түүхийн үнэт сан хөмрөг устаж, олон тооны хүн гэмтэж бэртэн, барилга байгууламж, автомашин, эд зүйлс сүйтгэгдэж, галдан шатаагдсанаас гадна таван хүний амь нас хохирсон байна.

Энэхүү бослого, үймээний шалтгаан нь сонгуулийн дүнтэй холбоотой ажээ. 2008 оны 6 дугаар сарын 30-ны өдөр сонгуулийн эцсийн дүн гарсан бөгөөд, Монгол ардын хувьсгалт нам сонгуульд ялалт байгуулсан байна. Гэтэл уг сонгуулийн дүнг эсэргүүцсэн хэдэн мянган жагсагчид 7 дугаар сарын 01-ний өдөр Монгол ардын хувьсгалт намын байрны өмнө эсэргүүцлийн хөдөлгөөн өрнүүлсэн бөгөөд, улмаар бослого, үймээн, зэвсэгт мөргөлдөөн болж хувирсан байна. Энэхүү хувьсгалын үед болсон явдал дундаас сонирхолд татахуйц нэг зүйл нь гэвэл тухайн эмх замбраагүй байдал болж байсан газарт гэнэт бульдозер гарч ирсэн бөгөөд, уг бульдозерыг зогсоох оролдлого хийх үед дотор нь байсан хүмүүс резинэн сумтай буугаар буудсан байна. Уг үйлдэл нь 2000 онд Сербид өрнөсөн бульдозерын хувьсгалын үеэр болж өнгөрсөн нөхцөл байдалтай тун төстэй байдлаар явагдсан болохыг онцлох хэрэгтэй юм.

Уг бослого, үймээнээс өмнө онцолбол зохих хэд хэдэн жагсаал, цуглаан болж, багагүй хүн амыг хамарсан байна. Эдгээр цуглаан нь 2008 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн бослого, үймээн болоход ямар нэгэн байдлаар нөлөөлсөн, утвар нөхцөл болсон байж болзошгүй юм. Тодруулбал, 2006 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр Батзандан, Баасан, Магнай нараар удирдуулсан 1500-4000 орчим хүнийг хамарсан “Автобусны үнийг бууруулах” тухай шаардлагыг улсын их хурлын нэр бүхий гишүүдэд тавьж, Төрийн ордны хойд талын төв хаалганд цуглан “МАХН-ын саалийн үнээ Энхболд, Бадамжунай, Пүрэвдорж” гэсэн бичигтэй чихмэл шатааж, Төрийн ордны хамгаалалтын ажилтнуудын хувцасыг урж, танхайрсан үйлдэл гаргасан байна. Мөн оны 4 дүгээр сарын 05-ны өдөр САПУ-ын хохирогчдын зүгээс жагсаал хийж, Төрийн ордон руу орохоор дайрсан бөгөөд, бослогод нийт 800 орчим хүн оролцсон байна. 2007 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр хаягдал түүхий эдийн бизнес эрхлэгчдийн зүгээс “хаягдал хайлш, төмрийг хилээр гаргах тухай хуулийн заалтыг эргэн харах тухай” Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга нарт шаардах бичиг гардуулж өгөх хүсэлт тавин, Төрийн ордны хаалга руу дайрч, Сүхбаатарын талбай дээр суулт хийсэн байна.

2008 оны 7 дугаар сарын 01-ний өдөр Улаанбаатар хотод болж өнгөрсөн үймээн самуунаас хойш дахин ийм олныг хамарсан, галт зэвсэг, техник ашигласан, том хэмжээний бослого, хөдөлгөөн хараахан өрнөөгүй боловч жижиг хэмжээний жагсаал, цуглаан (өлсгөлөн зарлах, суулт хийх гэх мэт) багагүй өрнөсөн юм. Тэдгээрээс 2020, 2021 онд болж өнгөрсөн зарим нэгийг онцолбол:

- Коронавирусийн халдвар авсан эх, нярайг нимгэн хувцастай тээвэрлэсэн асуудлаас үүдэн УОК, НОК, ЭМЯ-ны хайхрамжгүй, буруутай үйлдэлд хариуцлага тооцуулах;

³⁰ Өдрийн сонин. 2008 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн дугаар.

³¹ Ганболд Ш., Очгэрэл Ц. 2008.07.01. Өчигдөр, Өнөөдөр, Маргааш. УБ. 2010. 19-47 дахь тал.

- Сошиал орчинд видео бичлэг нь цацагдсан нэр бүхий шүүгч нарт хариуцлага тооцуулах;

- “Оюу толгой”-н гэрээтэй холбоотойгоор асуудлаар УИХ-ын нэр бүхий гишүүн өлсгөлөн зарласан;

- Ял шийтгэгдсэн хүүхдүүдийнхээ давж заалдах шатны шүүх хурал ойртсонтой холбогдуулан хөл нүцгэн жагссан;

- Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилт, банк, банк бусын зээлийн хүүг бууруулах;

- БНХАУ-д үйлдвэрлэсэн вакциныг дархжуулалтад ашиглахыг эсэргүүцэх;

- Ерөнхийлөгчийн сонгууль, намын дотоод асуудалтай холбоотойгоор нэр бүхий УИХ-ын гишүүд Сүхбаатарын талбайд өлсгөлөн зарласан гэх мэт бөгөөд, зохион байгуулагдсан эсэргүүцлийн жагсаал, цуглаанууд нь нийтийг хамарсан эмх замбраагүй байдалд хүрэхээргүй буюу тайван байдлаар өрнөж дууссан байна.

Төв, орон нутгийн хэмжээнд 2021 оны 1 дүгээр улиралд улс төрийн нам, иргэний хөдөлгөөн, холбоо, төрийн бус байгууллага, иргэд, олон нийтийн зүгээс давтагдсан тоогоор 53 удаагийн буюу 387 цаг үргэлжилсэн жагсаал, цуглаан, 4 удаагийн 261 цаг үргэлжилсэн өлсгөлөн, суулт зохион байгуулагдаж, давхардсан тоогоор 4080 орчим иргэн оролцсон байна. Улаанбаатар хотод 53, хөдөө орон нутагт 4 удаа зохион байгуулагдсанаас “Жагсаал, цуглаан хийх журмын тухай” хуулийн дагуу харьяа нутаг дэвсгэрийн Засаг даргын тамгын газарт бүртгүүлээгүй байна. Энэ онд зохион байгуулагдсан жагсаал, цуглааныг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13.7 хувиар өссөн, 3 дугаар сард зохион байгуулагдсан жагсаал, цуглаан нь өмнөх сараас 87.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Мөн сүүлийн үед зохион байгуулагдаж буй жагсаал, цуглаанд залуучууд өргөнөөр хамрагдах, ижил төрлийн уриа лоозон барих (цаасан хайрцаг дээр гараар бичсэн), цахим сүлжээгээр нэгдэн нийлэх шинж тэмдэг ажиглагдах болсон байна³².

Төв, орон нутгийн хэмжээнд 2021 оны 5 дугаар сарын байдлаар улс төрийн нам, иргэний хөдөлгөөн, холбоо, төрийн бус байгууллага, иргэд, олон нийтийн зүгээс давтагдсан тоогоор 80 удаагийн буюу 458 цаг үргэлжилсэн жагсаал, цуглаан, эсэргүүцлийн арга хэмжээ зохион байгуулагдаж, 5 удаагийн 401 цаг үргэлжилсэн өлсгөлөн суулт зохион байгуулагдаж, давхардсан тоогоор 5100 орчим иргэн оролцсон байна. Үүнээс Улаанбаатар хотод 75, хөдөө орон нутагт 5 удаа зохион байгуулагдсанаас “Жагсаал, цуглаан хийх журмын тухай” хуулийн дагуу харьяа нутаг дэвсгэрийн Засаг даргын тамгын газарт бүртгэлтэй 0, бүртгэлгүй 80 байна. 2021 оны 9 дүгээр сарын байдлаар Монгол улсын хэмжээнд том жижиг нийлсэн 188 жагсаал, цуглаан болж, олон нийтийг хамарсан боловч, цааш хурцдалгүйгээр намжсан байна.

Жагсаал, цуглаан, өлсгөлөн суулт, төрийн бодлого, шийдвэрийг эсэргүүцэхтэй холбоотой үүссэн нөхцөл байдлын талаарх цагдаагийн байгууллагын судалгаа, тайлан, танилцуулгаас үзэхэд, Монгол Улсын хэмжээнд жагсаал цуглаан өрнөх явдал харьцангуй ихэссэн гэж дүгнэхээр байна. Эдгээр жагсаал цуглаан, жижиг хэлбэрийн өлсгөлөн суулт нь цааш даамжирсан тохиолдолд, олон нийтийг хамарсан бослого, үймээн болох эрсдэлтэй учир нөхцөл байдлыг байнга хянаж байх нь зүйтэй юм. Монголын ардчилсан холбооны удирдах зөвлөл болон “Ард түмний хурал” зохион байгуулах ерөнхий зөвлөл зэрэг хөдөлгөөний гишүүдийн зүгээс Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийг хойшлуулах гол үндсэн зорилго бүхий эсэргүүцлийн жагсаал, цуглаан зохион байгуулж, оролцогчдын массаас хамаарч нийтийг хамарсан эмх замбраагүй байдал руу шилжүүлэх, Төрийн ордон руу хууль бусаар нэвтэрч үймээн үүсгэхийг зорьж байгаа тухай мэдээлэл хүртэл авагдсан байна.

Ард иргэдийн зүгээс төрийн үйл ажиллагаанд итгэх итгэл алдагдаж, эсэргүүцлийн хөдөлгөөн өрнүүлэх үндсэн шалтгаануудын нэг нь улс төрийн


³² Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны танилцуулга. (2021.04.29)

намуудын хоорондын талцал, нэг нэгнийхээ үйл ажиллагааг харлуулах, төрийн бодлогыг хэрэгжүүлэхийн эсрэг зохион байгуулалттай явуулга зэргээс гадна авилгын асуудал юм.

Энэ талаар Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ: “Би Ерөнхий сайдаар томилогдоод дөрвөн зорилт дэвшүүлсний нэг нь авлигатай тэмцэх. Монгол Улс авлигын индексээр 111-т жагсаж байна. Энэ маш муу үзүүлэлт. Авлигыг бууруулахын тулд хатуу арга хэмжээ авч хэрэгжүүлэхээс өөр аргагүй. Учир нь, өнгөрсөн 30 жилийн хугацаанд бүрэлдэж бий болсон манай нийгмийн соёл, хөрсөөр төрийн үйлчилгээний хүнд суртлын асуудалтай бид нүүр тулж байна. Хэн нэгэн таньдаг хүнээ өмгөөлөх үйлдэл Ерөнхий сайдаас гарахгүй. Өнгөрсөн хэдэн сарын хугацаанд авлига, албан тушаалтай холбоотой 1196 гомдол, мэдээлэл ирснээс 741 нь шалгагдаж, 142 холбогдогчтой 85 хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байна. Үндэсний хороо байгуулагдсанаас хойш ийм олон хэрэг гарсан нь харамсалтай” гэж авилга, ашиг сонирхлын хэрэг хурцадмал байдалд хүрснийг тэмдэглэсэн байна. Үнэхээр Монгол улс авилгын индексээр 111-т жагсаж байгаа явдал нь цаашид шийдвэрлэх асуудлуудын тэргүүн эгнээнд тавигдах хэмжээний зүйл мөн юм. Авилгын асуудал нь аливаа бослого, үймээн, тэр ч байтугай өнгөт хувьсгал өрнөхөд ямар хэмжээний нөлөө үзүүлдэг талаар Сербид өрнөсөн бульдозерын хувьсгалаас харж болох юм. 2000 оны үед Сербид авилгын дүнгээр дэлхийд 124 дүгээр байранд бичигдэж байсан бөгөөд, уг шалтгаанаас болж улс орны хөгжил тэр чигтээ зогсож, ард иргэд нь ядууралд нилдээ автсан явдал нь засгийн эрх баригчдыг өөрчлөх суурь шалтгаан болжээ.

Монгол Улсын хувьд авч үзвэл, Авилгатай тэмцэх газраас 2007 онд нийт 85, 2008 – 193, 2009 – 180, 2010 – 132, 2011 – 142, 2012 – 164, 2013 – 187, 2014 – 239, 2015 – 238, 2016 – 235, 2017 – 427, 2018 – 1138, 2019 – 1300, 2020 – 1331 авилгын хэргийг шалгаснаас, 2007 онд 16 хэргийг, 2008 онд 60, 2009 онд 51, 2010 онд 41, 2011 онд 43, 2012 онд 33, 2013 онд 43, 2014 онд 69, 2015 онд 55, 2016 онд 67, 2017 онд 106, 2018 онд 224, 2019 онд 156, 2020 онд 236 хэргийг тус тус яллах дүгнэлт үйлдүүлэх буюу шүүхэд шилжүүлэх саналтайгаар шийдвэрлэсэн байна.

График №1. Авлигатай тэмцэх газраас 2007-2020 онд шалгасан эрүүгийн хэргийн тоон мэдээ:



2007 оноос хойш 2020 оны хугацаанд АТГ-аас шалгасан эрүүгийн хэргийн тоо жил бүр өссөн үзүүлэлттэй байна. Шалгасан эрүүгийн хэргийн өсөлтөөс шалтгаалан, яллах дүгнэлт үйлдүүлэхээр шүүхэд шилжүүлсэн хэргийн тоо шууд хамааралтайгаар өссөн байна. 2018 оноос эхлээд АТГ-аас шалгасан эрүүгийн хэргийн тоо огцом өссөн бөгөөд, цаашид ч нэмэгдэх хандлагатай байна.

Авилга, ашиг сонирхлын гэмт хэргийн нийгэмд үзүүлэх хор уршгаас урган гарсан ард иргэдийн төрийн бодлогод дургүйцэх явдал, түүнийг дэврээхэд чиглэсэн үзэл суртлын шинжтэй турхиралт, нийгмийн тогтвортой байдлыг алдагдуулах замаар төрийн засаглалыг өөрчлөх гэсэн санаархал зэргийг хэрэгжүүлдэг гол хүчтэй хэлбэр нь интернет, цахим мэдээллийн хэрэгсэл болохыг өмнө дурдсан билээ. Өнгөт хувьсгалыг амжилттай явуулахын тулд хэдэн жилийн өмнөөс нийгмийн ухамсарт шингээдэг байна. Ингэхийн тулд олон нийтийн холбоо, мэдээллийн хэрэгслийг өргөн ашиглах нь хамгийн үр дүнтэй арга юм. техник, технологи өндөр хөгжсөн өнөө үед интернет, цахим сүлжээ, залуучуудын идэвхтэй ашигладаг “Facebook”, “Twitter”, “Instagram”, “ВКонтакте” болон бусад харилцаа холбооны хэрэгслийг түлхүү ашиглаж, нийтэд “хувьсгал өрнүүлэх нь зөв зүйл” гэж бодол, ухамсарт суулгах ажил нь маш үр дүнтэй хэрэгждэг. Харилцаа холбооны зохицуулах хорооны мэдээллээр Монгол Улсад интернет хэрэглэгчдийн тоо 2012 онд 570 мянга байсан бол уг тоо 2017 онд 2.1 сая, 2018 онд 2.8 саяд, 2019 онд 3.1 саяд, 2020 онд 3.8 саяд хүрч хүрч 6.6 дахин нэмэгдэж, фэйсбүүк хэрэглэгчдийн тоогоор Ази тивд нэгдүгээрт, дэлхийд аравдугаарт жагсах болсон нь цахим хэрэглээний хамрах хүрээ, хэрэглээ хурдацтай өсөж байгааг харуулж байна³³.

Цахим хэрэглээг даган бусдын нэр төр, алдар хүндэд халдах, гутаан доромжлох, иргэдийг залилан мэхлэх, төөрөгдүүлэх, үзэл бодлоор нь талцуулах, хүчирхийлэлд уриалах, мансуурал, садар самуун явдлыг сурталчлах, мөрийтэй тоглоом тоглуулах зэрэг гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй хууль бус үйлдлүүд эрс ихсэх хандлагатай болж, эдгээр нь богино хугацаанд олон хүнд хүрдэг сөрөг байдлыг үүсгээд байна.

Иргэд фэйсбүүк, твиттер зэрэг гадаад улсад сервертэй шууд зохицуулалт хийх боломжгүй системүүдийг идэвхтэй ашиглаж байгаа нь гэмт хэрэгт өртөж хохирох нөхцөл боломжийг бүрдүүлж байгаа бөгөөд нөгөө талаас энэхүү хяналтгүй системүүд гэмт этгээдүүдэд хууль бус үйл ажиллагаагаа халхавчлах, ул мөрөө баллах, дүр төрхөө өөрчлөх боломжийг бий болгож байгаа нь гэмт хэрэг өсөн нэмэгдэх нэгэн шалтгаан болж байгаагаас гадна, үүнийг дагаад цахим орчинд нийтийн эмх замбараагүй байдал үүсгэх, хууль бус жагсаал цуглаан зохион байгуулахыг уриалсан, олон нийтийг өдөөн хатгасан үйлдэл ихсэх хандлагатай байна. Дээрх тоон үзүүлэлтээс Олон Улсад төдийгүй Монгол Улсад олон нийтийн сүлжээ нь гэмт хэрэг үйлдэгдэх хамгийн том талбар болж, хар тамхи, хүн худалдаалах, галт зэвсгийн хууль бус худалдаа, садар самууныг сурталчлах зэрэг уламжлалт гэмт хэргүүд цахим орчныг ашиглан үйлдэгдэж, кибер гэмт хэргийн шинжийг давхар агуулах болсон. Тэгвэл Олон улсын судалгааны байгууллагаас “кибер гэмт хэргийн цар хүрээ, учруулж болох хор хөнөөл нь терроризмын аюул заналаас илүү гарсан” гэсэн дүгнэлт хийсэн байна. Цаашид нийгмийн бүхий л харилцаа цахимжих нь тодорхой болсон өнөө үед Монгол Улсад олон нийтийн сүлжээнд давхардсан тоогоор 2.200.000 гаруй иргэдээс бүрдэх цахим орчин бий болсон явдал нь өнгөт хувьсгал өрнүүлэх үйл ажиллагаанд цахим орчны нөлөө маш өндөр болох эрсдэл нуугдаж байгаа болохыг харуулж байна.

Иймд 2.200.000 гаруй цахим иргэдийн аюулгүй орчинг бий болгох зорилгоор эх сурвалж нь тодорхойгүй мэдээ, мэдээллийг олон нийтэд түгээж буй мэдээллийн хэрэгслүүдэд мониторинг, судалгаа, шинжилгээ хийж ажиллах нь технологийн хувьсгал, дижитал шилжилтийн энэ үед цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийн тэргүүн эгнээнд хамаарах асуудал болжээ.

Монгол Улсад өнгөт хувьсгалын технологи хэрэгжиж болзошгүй дараах эрсдэлт хүчин зүйлс байна. Үүнд:

Иргэдийн бухимдал гүнзгийрч байна. Эдийн засгийн нөхцөл байдал хүндэрч, ажилгүйдэл нэмэгдэн төр, засгийн амлалт биелэхийг ард иргэдийн зүгээс хүлээх

³³ Харилцаа, холбооны зохицуулах хороо. <https://crc.gov.mn/>.

хүлээлт, ядуурал, ажилгүйдэл, авилга, шударга бус байдал зэрэг нийгмийн асуудал шийдэгдэхгүй байгаа нь иргэдийн итгэл алдарч, бухимдахад хүргэж байна. Иргэдийн бухимдал гүнзгийрч, олон нийтийн төрд итгэх итгэл ихээхэн алдарч, нийгмийн салбаруудад эрх ашгаа хамгаалуулсан хөдөлгөөн, төрийн бус байгууллагууд үүсэн бий болж, төрийн бодлого шийдвэрийг эсэргүүцэх, шүүмжлэх, газар нутгаа болон тодорхой бүлэг хүмүүсийн эрх ашгийг хамгаалах зэргээр улс төрийн зорилготой үйл ажиллагаа идэвхжих болсон.

Гадаадын иргэн, харьяатын газрын бүртгэлийн санд нийт 85 олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллага, салбар төлөөлөгчийн газар бүртгэлтэй байдаг. Эдгээр байгууллагуудын дунд Серби улсад өрнөсөн өнгөт хувьсгалд санхүүгийн болон бусад дэмжлэгийг үзүүлсэн АНУ-д төвтэй “Бүгд найрамдахчуудын хүрээлэн”³⁴ Монгол Улсад идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа нь анхаарал татаж байна.

Эсэргүүцлийн жагсаал, цуглаан идэвхжиж байна. Улс төрийн үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар нөлөөлөх зорилгоор иргэний нийгмийн байгууллага, хөдөлгөөн зэргээр нам, эвсэл, төрийн бус байгууллагын дэмжлэг бүхий эвсэл, холбоо жил ирэх тутам нэмэгдэж, тэдгээрээс зохион байгуулах жагсаал, цуглаан, улс төрийн үйл ажиллагаа идэвхжих хандлагатай байна.

Гадаад улсад өрнөсөн өнгөт хувьсгалын бэлгэ тэмдгийг ашиглаж байна. Сүүлийн жилүүдэд зохион байгуулагдаж буй жагсаал, цуглаанд ашиглагдаж буй уриа, лоозонд гадаад улсад өрнөсөн өнгөт хувьсгалын бэлгэ тэмдэг болох “зангидсан гар”-ыг хэрэглэж байна. Түүнчлэн, зарим нэвтрүүлэг, жагсаал цуглаан, төрийн бус байгууллагын туг, арга хэмжээний бэлгэ тэмдгээр зангидсан гарыг сонгон хэрэглэх явдал элбэг болсон.

Зураг №1. Эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбооноос 2017 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулсан жагсаал, цуглаанд хэрэглэсэн бэлгэ тэмдэг “Чагнуур атгасан гар”



Зураг №2. “Дэлхийн монгол ногоон нэгдэл” төрийн бус байгууллагын туг



³⁴ АНУ-д төвтэй Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн (IRI) нь “ардчиллын байгууллагын үүсэл хөгжилтөд туслах, Монгол Улсын төрийн намуудад техникийн туслалцаа үзүүлэх” үндсэн чиглэлтэйгээр 1997 оны 06 дугаар сарын 13-ны өдөр бүртгэгдсэн байна.

Гадаадын иргэдийн үйл ажиллагаа идэвхжиж байна. Монгол Улс дахь “ЛГБТ” төрийн бус байгууллагын удирдах зөвлөлийн гишүүнээр 2016-2017 он хүртэлх хугацаанд ажиллаж байсан А.Менард нь тус байгууллагын санхүүжилтийг босгох “fundraising” үйл ажиллагааг голчлон эрхэлдэг байсан. Оксфордын их сургуульд магистрийн зэргийг улс төр судлалаар төгсөж, улс төр, уул уурхай, газрын баялгийн чиглэлээр мэргэшсэн тэрээр АНУ-ын Төрийн департментийн томилолтоор Үндэсний аюулгүй байдлын чиглэлийн залуу мэргэжилтнүүдийн хамтаар гадаад оронд ажиллаж байжээ. Мөн тэрээр Трумэний нэрэмжит Үндэсний аюулгүй байдлын хөтөлбөрт нэгжийн дэд захирлаар ажиллаж байсан байна³⁵. Тэрээр олон улс дахь Сонгуулийн үйл ажиллагаанд идэвхтэй ажиглагчаар оролцдог бөгөөд Украин, Беларусь, Кыргызстан, Гүрж, Македон, АНУ зэрэг улсуудад ажиглагчийн үүрэг гүйцэтгэсэн байна³⁶.

А.Менард нь Монгол Улсад оршин сууж байхдаа Монгол Улсын нийгэм, эдийн засаг, уул уурхай, ардчилал, хүний эрхийн асуудлаар мэдээлэл цуглуулж, “Young Mongols” номыг бичсэн бөгөөд, уг номны оршлын үг хэсэгт Хонгконгийн ардчиллын төлөө тэмцэгч, Демосист намын ерөнхий нарийн бичгийн дарга Ж.Вонг Монгол Улсын ерөнхий сайд асан Р.Амаржаргал, Улсын Их Хурлын гишүүн асан Ц.Оюунгэрэл нараар номын талаарх сэтгэгдэл хүртэл бичүүлж байжээ³⁷.

Тэрээр “Washington post” өдөр тутмын сонины 2019 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн дугаарт “Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн хуулийн төсөл нь Монгол Улс дахь иргэний нийгэмд аюул учруулж байна” гэсэн нийтлэлийг хэвлүүлсэн байна. Тус нийтлэлд үндэсний эв нэгдэлд хэтэрхий анхаарлаа хандуулах нь иргэний нийгэмд заналхийлж байгаа талаар дурджээ.

Цахим орчинд гарч буй зарим мэдээллийн талаар: Өнгөт хувьсгалын нэг шинж тэмдэг нь аливаа улсын төр засгийг удирдах хэрэгт болон сонгуулийн үйл ажиллагаанд гадны байгууллага дэмжлэг үзүүлж оролцох юм. Энэ талаас нь авч үзвэл, энэ удаагийн Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн өмнө нам улс төрийн хүчнээс гадны байгууллагын дэмжлэг авч байна гэсэн албан ёсны мэдэгдлүүд хийж байна. Тухайлбал, УИХ-ын чуулганы 2021 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдааны үеэр гишүүн Ц.Мөнх-Оргил “Сонгууль будилуулах ажлыг Ардчилсан нам хийж эхэллээ. Ц.Туваанаас тодруулга авмаар байна. АНУ-ын “DCI” гэдэг нөлөөллийн үйл ажиллагаа явуулдаг лобби компанитай АН-ын дарга гэх Ц.Тувааны гарын үсэгтэй 50 мянган америк долларын гэрээ байгуулсан байна. Гэрээг дөрөвдүгээр сарын 12-ноос зургаадугаар сарын 12-ны өдөр хүртэлх хугацаатай байгуулсан нь илт хууль зөрчсөн үйлдэл” гэж хэлсэн нь анхаарал татаж байна. Уг мэдэгдэлд дурдагдсан АНУ-ын “DCI” компанийн талаар ил эх сурвалжийн мэдээллээс судалж үзэхэд, энэхүү компани нь тус улсын Вашингтон хотод төвтэй хэвлэл мэдээлэл, ухуулга сурталчилгааны үйл ажиллалааг явуулдаг байна. Бүрэлдэхүүнд нь нийгмийн судлаачид, хуульчид, хэвлэл мэдээллийн байгууллага, сошиалд нөлөө бүхий хүмүүс ажилладаг гэсэн мэдээлэл тавигджээ. DCI групп нь 1996 оноос хойш олон нийттэй харилцах чиглэлээр олон төрлийн үйл ажиллагаагаа явуулж, АНУ-ын томоохон корпорацууд, худалдааны холбоод, ашгийн бус байгууллага, боловсролын байгууллага, Засгийн газрын агентлаг зэрэгт нөлөөллийн үйлчилгээ үзүүлдэг байна. DCI-ийг 2000 оны АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд Ж.Бушийг ялалт байгуулахад ихээхэн нөлөө үзүүлсэн. Түүнчлэн 2002 онд Мьянмарт Ан Сан Су Чи тэргүүтэй улс төрийн хоригдлууд суллагдсаны дараа DCI тус улсын цэргийн хүчинтэй хамтран ажиллаж, цэрэг армийнхан Ан Сан Су Читэй хэрхэн хамтарч буй талаар эерэг хандлагыг олон нийтэд түгээхэд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн гэж бичжээ. Мьянмарын Засгийн газрыг төлөөлж цэргийнхэн тус компанид 348 мянган америк доллар төлсөн байна. Тус компани Нигер, Пуэрто-Рико, Мьянмарын Засгийн газар болон өндөр албан тушаалтнуудтай

³⁵ Wikipedia the free encyclopedia. (2021.01.10). https://en.wikipedia.org/wiki/Aubrey_Menard.

³⁶ <https://aubreymenard.com/-/1about>. (2021.01.12).

³⁷ <https://www.youngmongols.com/endorsements>. (2021.01.12).

хэд хэдэн удаа хамтарснаас гадна дэлхийд тэргүүлэх томоохон компани, группүүдтэй тогтмол хамтарч ажилладаг байна³⁸. Шар хэвлэлд уг компанийг “Монголын нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдралын талаар үнэлэлт, дүгнэлт бүхий мэдээлэл бичиж, мэдээллээ АНУ-ын Хууль зүйн яам руу илгээдэг. Энэ (DCI) групп нь Ардчилсан намтай хамтарч ажиллаж байж болзошгүй байна. Ингэхдээ Х.Баттулгыг Ардчилсан намаас Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвших боломжгүй болж буй халуун цэг дээр анхаарч ажиллаж буй нь ойлгогдож байна” гэж хэвлэлийн зарим эх сурвалжид таамаглал төдий байдлаар бичжээ³⁹.

Гадны оролцоотой бичигдсэн хуулийн төслийн талаар: Өөрийн орны онцлог, уламжлал, зан заншилд сууриллаагүй, нутагшуулах боломжгүй эрх зүйн зохицуулалтыг өөр бүлээс зээлдсэн, хөрсөн дээр бууж, амьдралд хэрэгжих боломжгүй, хүчээр тулгасан зохицуулалт бүхий хуулийн төслийг батлуулахаар эрмэлзэж байгаа нь гаднын оролцоог нэмэгдүүлж байна. Тухайлбал: “Бэлчээр хамгаалах тухай хуулийн төсөл” 2019 он, “Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хуулийн төсөл” 2018 он⁴⁰ зэрэг болно.

Цахим мэдээллийн орчинд хяналтгүй мэдээлэл тараах: Дэлхийн улс орны фейсбүүкийн платформ судалгаанд улс төрийн зорилгоор хуурамч хаягаар хяналтгүй мэдээ, мэдээлэл дамжуулдаг орны судалгааг гаргаж, энэхүү асуудлыг анхааралдаа авч ажиллахгүй байгаа улс орны дунд Монгол Улсыг хамааруулсан байна⁴¹.

Дүгнэлт

Улсын Их Хуралд олонхийн суудалтай нам болон түүний сөрөг хүчнүүдийн дунд өрнөх эрх мэдлийн төлөө тэмцлийн үр дүнд төрийн механизмын тогтвортой үйл ажиллагаа алдагдаж, ард иргэд нам, эвсэл, холбоогоор талцан хуваагдаж, эх орны хөгжил, дэвшил, эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагаанд саад учирч, иргэдийн амьжиргааны түвшин доройтсоноор нийгэмд бухимдал, стресс үүсэх, улмаар төрийн үйл ажиллагаанд сэтгэл дундуур байгаа ард иргэд элдэв төрлийн бослого, үймээн дэгдээхэд хүргэдэг байна. Улсын дотоодын үл ойлголцол, үймээн самууныг гадаадын улс орнууд овжин ашиглаж, өөрсдийн нөлөөг тогтоож, эд баялгийг авах далд санаатайгаар өнгөт хувьсгал өрнөхөд дэмжлэг үзүүлэх, шууд болон шууд бус байдлаар оролцох явдал цөөнгүй гарсан болохыг дэлхийн түүхээс харж болох юм.

Монгол Улсын хувьд авилгын гэмт хэрэгтэй тасралтгүй тэмцэж, энэхүү нийгмийн үзэгдлийг мэдэгдэхүйц хэмжээнд багасгаж, улсын төсвийн хөрөнгийг шударгаар, ард олны төлөө зарцуулах, эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх чиглэлийн арга хэмжээ авахгүй бол нийгэмд баян-хоосны ялгаа хүчтэй илрэн гарах аюултайгаас гадна, ард иргэдийн амьдралын түвшин огцом буурах нь гарцаагүй юм. Үүний үр дүнд нийгэмд олон төрлийн жагсаал цуглаан, өлсгөлөн суулт, бослого үймээн гарах нь зөвхөн цаг хугацааны асуудал болж хувирах юм. Магадгүй гадны хөгжилтэй улсуудын зүгээс энэхүү үйл явдлыг далимдуулан өөрсдийн нөлөө, ноёрхлыг тогтоох оролдлого явагдахыг ч үгүйсгэхгүй юм.

Монгол Улсад өрнөж буй жагсаал, цуглаанууд нэгдсэн нэг зорилгогүй, нийгэмд үүссэн тулгамдсан асуудалд чиглэгдсэн, иргэний хөдөлгөөн, төрийн бус байгууллагуудаас тус тусдаа жагсаж, цуглах байдлаар өөр өөр цаг хугацаа, газар орон /байршил/-д зохион байгуулагдаж байгаа нь манай улсад “Өнгөт хувьсгал” үүсэх нөхцөл байдал хараахан бүрдээгүй гэж дүгнэж болохоор байна. Хэдийгээр өнгөт хувьсгал нь сонгодог хэлбэрээр хараахан өрнөөгүй боловч, хувьсгал өрнөхөд

³⁸ Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны танилцуулга. (2021.04.29).

³⁹ <https://equur.mn/200853/>. (2021.01.12).

⁴⁰ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн албан ёсны сайт. (2021.01.13). <https://nsc.gov.mn/mn/c/9/list>.

⁴¹ <https://www.theguardian.com/technology/2021/apr/12/facebook-fake-engagement-whistleblower-sophie-zhang>. (2021.01.15).

нөлөөлөх шалтгаан, хувьсгалыг зохион байгуулж, үр дүнтэй үргэлжлүүлэхэд чухал үүрэгтэй цахим орчны идэвхжилт, гадаад улсын зүгээс чиглэсэн төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа, ард иргэдийн амьжиргааны түвшний доройтол гэх мэт урьдчилсан тохироо бүрэлдэх хангалттай нөхцөлтэй байна.

Санал

1. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс чиг үүргийн байгууллагуудаар жил бүр бослого, үймээний нөхцөл байдалд дүн шинжилгээ хийлгэж, эрдэмтэн, судлаачдын дунд хэлэлцүүлэг өрнүүлж байх;

2. Гадаадын төрийн бус байгууллагуудыг бүртгэх, үйл ажиллагаанд нь хөндлөнгөөс хяналт тавих ажлыг сайжруулах;

3. Цахим орчин, олон нийтийн мэдээллийн хэрэгслийг хянах тогтолцоог сайжруулан, бослого, үймээн, өнгөт хувьсгалын нөхцөл байдлыг хянаж, урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн алба, байгууллагын хүрээг өргөтгөж, гадаадаас ирж болзошгүй аюул, заналхийллийг дотоодоос бүрэн хянах боломжтой болгох зэрэг саналтай байна.

Ашигласан материал

- Ганболд Ш., Очгэрэл Ц. 2008.07.01. Өчигдөр, Өнөөдөр, Маргааш. УБ. 2010.
- Өдрийн сонин. 2008 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн дугаар.
- Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны танилцуулга. (2021.04.29)

Цахим эх сурвалж

- <https://aubreymenard.com/-1about>. (2021.01.12).
- <https://equur.mn/200853/>. (2021.01.12).
- <https://www.theguardian.com/technology/2021/apr/12/facebook-fake-engagement-whistleblower-sophie-zhang>. (2021.01.15).
- <https://www.youngmongols.com/endorsements>. (2021.01.12).
- Wikipedia the free encyclopedia. (2021.01.10). https://en.wikipedia.org/wiki/Aubrey_Menard.
- Батбаяр Б. Манай намуудын хагарал. Нийтлэл. Интернет холбоос: <http://www.baabar.mn/article/2442>.
- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн албан ёсны сайт. (2021.01.13). <https://nsc.gov.mn/mn/c/9/list>.
- Улс төрийн намын тухай хууль. <https://legalinfo.mn/mn/detail/508>.

ХҮҮХЭД ӨРТСӨН ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ШАЛТГААН, НӨХЦӨЛ БАЙДАЛ

CAUSES AND CONDITIONS OF TRAFFIC ACCIDENTS INVOLVING CHILDREN

*О.Болорцэцэг
ДХИС-ийн магистрант,
цагдаагийн ахлах дэслэгч*

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд Монгол Улсын хэмжээнд зам тээврийн ослоор хүүхдийн бие, эрүүл мэнд хохирсон хэлбэр, нөлөөлсөн хүчин зүйлийг судалж, дүн шинжилгээ хийн, осол, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, бууруулах арга замын талаар санал-зөвлөмж боловсруулсан.

Abstract: In this report, how the life and health of children were damaged by road traffic accidents throughout Mongolia, and the influencing factors study and analyze and prevent accidents and incidents. some ways to reduce are briefly discussed.

Түлхүүр үгс: Хүүхэд, автомашин, амь нас, байгууламж, бэртэл, гэмтэл, зам, замын хөдөлгөөний аюулгүй байдал, хохирол, хүн, асран хамгаалагч, эрүүл мэнд.

Keywords: Children, Car, Life, facility, injuries, damage, Road, Traffic Safety, damage, person, guardian, health.

Үндсэн хэсэг

Дэлхий дахинд осол гэмтлийн улмаас жил бүр 5.8 сая хүн амь насаа алдаж, 600 гаруй сая хүн бэртэж гэмтэж, хөгжлийн бэрхшээлтэй болж, 700 тэрбум ам.долларын хохирол учирч байгаа бол үүнээс зам тээврийн ослын улмаас 1.25 сая гаруй хүн амь насаа алдаж 50 гаруй сая хүн бэртэж гэмтэж 65 тэрбум ам.долларын хохирол учруулж байгаа нь хүн амын нас баралтын гурав дахь гол шалтгаан болж байгаа тухай дэлхийн Эрүүл мэндийн байгууллагаас онцолжээ.⁴²

"Зам тээврийн ослоор хохирогсдод хүндэтгэл үзүүлэх дэлхий нийтийн өдөр"-ийг жил бүрийн 11 дүгээр сарын 3 дахь 7 хоногт дэлхий нийтээрээ тэмдэглэн өнгөрүүлж хүндэтгэл үзүүлдэг уламжлалтай. Уг өдрийг анх 1993 онд Английн Вант улсад тэмдэглэсэн ба үүнээс хойш улс орнууд уг арга хэмжээг авто ослоор амь үрэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх, сэтгэл санааны болон бусад хохирол амсаж суугаа тэдний ар гэр, ойр дотныхонд гашуудал илэрхийлэх, сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх өдөр болгон тэмдэглэж байхаар Нэгдсэн үндэстний байгууллагын Ерөнхий ассамблейгаас шийдвэрлэсэн байна.⁴³

Сүүлийн 5 жилийн байдлаар улсын хэмжээнд хүүхэд өртсөн зам тээврийн осол 4951 бүртгэгдэн 5152 хүүхэд осолд өртжээ. Зам тээврийн ослын улмаас 196 хүүхэд амь насаа алдаж, 4956 хүүхэд гэмтэл авснаас 347 хүүхэд хүндэвтэр, хүнд гэмтсэн байна.

Зам тээврийн осолд өртсөн хүүхдүүд ихэвчлэн "Гэр-сургууль-цэцэрлэг" гэсэн маршрутаар замын хөдөлгөөнд оролцохдоо зам хөндлөн гарахдаа зорчих хэсгийн гарцтай гарамтай хэсгээр зам хөндлөн гарахгүй байх, асран хамгаалагчгүй хөдөлгөөнд оролцох, ойртон ирж буй тээврийн хэрэгслийн урдуур гүйх зэргээр зам тээврийн осолд ихээхэн өртөж хохирдог. Орон нутгийн замд хүүхдийн хамгаалалтын бүс, хамгаалалтын суудал хэрэглэж хэвшээгүй, хэрэглэхгүй байгаагаас тээврийн хэрэгслээр зорчигч хүүхдүүд амь насаа алдсаар байна.⁴⁴

Манай улсын зам тээврийн дүрэмд зааснаар явган зорчигч зохицуулдаг буюу гэрлэн дохиотой гарц, зохицуулдаггүй буюу цагаан шугаман гарцаар зам хөндлөн гарах зохицуулалттай.

⁴² 1 Зам тээврийн ослын өнөөгийн байдал. УБ. 2018. 9 дэх тал

⁴³ <https://www.trends.mn/n/7382>

⁴⁴ Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл-2022 он

Монгол Улсын замын хөдөлгөөний тухай хуульд зааснаар иргэн, хуулийн этгээд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж чадахааргүй өвчтэй буюу ядарсан үедээ явганаар болон тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцохгүй байх, эцэг эх, асран хамгаалагч, бүх шатны боловсролын байгууллагын холбогдох албан тушаалтан 10 хүртэлх насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх үүрэгтэй юм.

Улсын хэмжээнд 2022 онд хүүхэд өртсөн зам тээврийн осол 463 бүртгэгдсэний 240 буюу 51.8 хувь нь Улаанбаатарт 223 буюу 48.2 хувь нь орон нутагт бүртгэгдсэн байна.



Зам тээврийн осолд өртсөн хүүхдүүд ихэвчлэн гэр, сурууль, цэцэрлэг гэсэн маршрутаар явж байгаад зам тээврийн осолд өртдөг байна. Энэ маршрутаар явахдаа анхаарал болгоомжгүй хөдөлгөөнд оролцох, зам хөндлөн гарахдаа гарц, гарамтай хэсгээр гарахгүй байх, асран хамгаалагчгүй хөдөлгөөнд оролцох, ойртон ирж буй тээврийн хэрэгслийн урдуур гүйх зэргээр өөрсдийн замын хөдөлгөөний мэдлэг дутмагаас осолд өртдөг хэдий ч жолоочийн хариуцлагагүй үйлдэл, замын байгууламжаас хамаарч осолд өртөх тохиолдол гарсаар байна.

Хүүхэд өртсөн байдлыг 2022 оны байдлаар төв, орон нутгаар харьцуулан авч үзэхэд, орон нутагт Баянхонгор, Төв, Дархан-Уул аймгууд давамгайлж байна.⁴⁵

Хүүхэд өртсөн зам тээврийн осол, нас барсан, гэмтсэн хүүхдийн мэдээ-2022 он

д/д	Төв, орон нутаг	Зам тээврийн осол			Нас барсан хүүхэд			Гэмтсэн хүүхэд		
		2021 он	2022 он	Харьцуулалт т	2021 он	2022 он	Харьцуулалт т	2021 он	2022 он	Харьцуулалт т
1	Архангай	8	9	12.5	6	4	-33.3	3	5	66.7
2	Баян-Өлгий	12	15	25.0	3			9	15	66.7
3	Баянхонгор	7	22	3.1᠔	1	5	5᠔	7	24	3.4᠔
4	Булган	10	11	10.0	2	6	3᠔	8	10	25.0
5	Говь-Алтай	7	6	-14.3	2	2	0.0	5	6	20.0
6	Говьсүмбэр	3	3	0.0				3	5	66.7
7	Дархан-Уул	15	31	2.1᠔	2	4	2᠔	18	28	55.6
8	Дорноговь	11	13	18.2	4	2	-50.0	7	13	85.7
9	Дорнод	16	16	0.0		1		18	19	5.6
10	Дундговь	5	10	2᠔	1	2	2᠔	7	10	42.9
11	Завхан	8	12	50.0	1	3	3᠔	8	9	12.5
12	Орхон	11	20	81.8		1		11	23	2.1᠔

⁴⁵ Монгол Улс дахь зам, тээврийн осол зөрчлийн статистик үзүүлэлт 2022 он

13	Өвөрхангай	6	16	2.7᠔		6		8	12	50.0
14	Өмнөговь	7	10	42.9	2	2	0.0	6	9	50.0
15	Сүхбаатар	4	10	2.5᠔		1		7	11	57.1
16	Сэлэнгэ	18	20	11.1	2	2	0.0	21	19	-9.5
17	Төв	38	40	5.3	6	8	33.3	43	51	18.6
18	Увс	6	14	2.3᠔	1	3	3᠔	5	14	2.8᠔
19	Ховд	12	22	83.3	2	7	3.5᠔	11	19	72.7
20	Хөвсгөл	8	15	87.5	3	4	33.3	5	12	2.4᠔
21	Хэнтий	11	21	90.9	2	6	3᠔	10	23	2.3᠔
Орон нутаг		223	336	50.7	40	69	72.5	220	337	53.2
22	Баянгол	25	60	2.4᠔	2			26	64	2.5᠔
23	Баянзүрх	57	94	64.9	1	2	2᠔	69	101	46.4
24	Сүхбаатар	24	67	2.8᠔				27	67	2.5᠔
25	Сонгинохайрхан	55	93	69.1	2	5	2.5᠔	60	104	73.3
26	Хан-Уул	41	76	85.4	4			39	83	2.1᠔
27	Чингэлтэй	28	39	39.3	1			31	40	29.0
28	Багануур	4	8	2᠔	1			4	8	2᠔
29	Багахангай	1	1					1	1	0.0
30	Налайх	5	5					8	5	-37.5
31	бусад									
Улаанбаатар		240	443	84.6	11	7	-36.4	265	473	78.5
Улс		463	779	68.3	51	76	49.0	485	810	67.0

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас улс орнуудын замын хөдөлгөөний аюулгүй байдлын түвшинг тогтооход харгалзах гол үзүүлэлт нь 100,000 хүн амд ногдох нас баралтын түвшин байдаг. Монгол Улсын хувьд энэ үзүүлэлт нь 2022 оны байдлаар 5 байгаа нь өмнөх оны үеэс буурсан байна.

ДЭМБ-аас гаргасан “Дэлхийн замын хөдөлгөөний аюулгүй байдлын тайлан 2018”⁴⁶ дурдсанаар дэлхийн дундаж 18,2, манай улс бүсчлэлд нь хамаарч байгаа ази-номхон далайн бүсийн дундаж 16,9 байна.

Дэлхийн улс орнууд зам тээврийн ослын шалтгаан нөхцлийг тогтооход системийн шинжилгээний аргуудыг өргөнөөр ашиглах болсон бөгөөд “Хүн-Зам /орчин/-Тээврийн хэрэгсэл” гэсэн гурван хүчин зүйлсийн нөлөөллийг харгалзахыг зөвлөж байна. Германы эрдэмтдийн судалж тогтоосноор зам тээврийн ослын нэг сөрөг хүчин зүйл болоод байгаа замын нөлөөлөл 31 хувь буюу түүнээс дээш, Оросын эрдэмтэн А.П.Матросов⁴⁷ зам тээврийн ослын шалтгаан нөхцлийг нарийвчлан тогтоох зорилгоор 1971 онд хийсэн судалгаагаар замын нөхцөл нь гарсан ослын 70 хувьд нь ямар нэг байдлаар сөрөг нөлөө үзүүлсэн гэж үзсэн бол Шведийн судлаач Хелена Стигсон нар⁴⁸ энэ нөлөөллийг ойролцоогоор 63 хувь гэж дүгнэжээ. Тэд үзэхдээ зам тээврийн осол нь 100 хувь хүний хүчин зүйлээс хамаарахгүй бусад нөлөө бүхий хүчин зүйлүүд багтаж байна гэж үзсэн байна.

Манай улсад 2022 оны байдлаар зам тээврийн 779 осол бүртгэгдсэнээс хүүхэд нас барсан 76, зам тээврийн ослоор гэмтсэн 810 хүүхэд бүртгэгдсэн байна.

Улаанбаатар хотод хүүхдүүд замын хөдөлгөөнд явганаар оролцож байхдаа амь нас, эрүүл мэндээрээ хохирсон бол орон нутагт тээврийн хэрэгслээр зорчигч нилээдгүй хувийг эзэлж байна. Замын хөдөлгөөнд оролцож явахдаа зам тээврийн осолд 7-14 насны, эрэгтэй хүүхдүүд их өртжээ. Хүүхэд өртсөн зам тээврийн осол гарсан цаг, хугацаа, гариг, сар, улирал нь хүүхдийн сургууль хичээлийн цаг хугацаатай давхцаж байгаа ба хүүхдүүд гэр-сургууль-гэр маршрутаар явахдаа өртөх тохиолдол их байна.


⁴⁶ <https://www.who.int/publications-detail/global-status-report-on-road-safety-2018>

⁴⁷ Замын хөдөлгөөний аюулгүй байдлын цагаан ном 2018. Зам тээвэр, хөгжлийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Эрүүл мэндийн яам. УБ., 2019. 66-67 дахь тал.

⁴⁸ Helena Stigson, Maria Krafft & Claes Tingvall. Use of Fatal Real-Life Crashes to Analyze a Safe Road Transport System Model, Including the Road User, the Vehicle, and the Road. Traffic Injury Prevention, 9:5, 2008. page 463- 471, DOI: 10.1080/


Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 13.2.7-т “Эцэг эх, асран хамгаалагч, бүх шатны боловсролын байгууллагын холбогдох албан тушаалтан 10 хүртэлх насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх” гэж зааж өгсөн.


Зам тээврийн осолд өртсөн нийт 536 хүүхдийн 272 буюу 50.7 хувь нь явганаар, 203 буюу 37.9 хувь нь тээврийн хэрэгслээр зорчигч, 41 буюу 7.6 хувь нь унадаг дугуйгаар, 20 буюу 3.7 хувь нь бусад /тээврийн хэрэгсэл жолоодсон, гэртээ байсан, хашаандаа, машины ард г.м/ замын хөдөлгөөнд оролцож байхдаа амь нас, эрүүл мэндээрээ хохирч, гэмтэл бэртэл авчээ.



Зам тээврийн осолд өртсөн нийт 536 хүүхдийн хүйсийн хүүхдийн хүйсийн байдлаас үзэхэд 387 буюу 61.9 хувь нь эрэгтэй, 238 буюу 38.1 хувь нь эмэгтэй хүүхдүүд байна.

Зам тээврийн осолд өртсөн хүүхдийн хүйс /улс, улаанбаатар, орон нутаг/






Хүүхэд өртсөн зам тээврийн ослын 179 буюу 38.7 хувь нь зуны улиралд, 130 буюу 28.1 нь намар, 18.1 хувь нь өвөл, 15.1 хувь нь хаврын улиралд бүртгэгдсэн байна.


Орон нутгийн замд гарсан осол нь нэг цэгт давхцахгүй, суурийн газар буюу суурингийн гаднах замд дийлэнх осол бүртгэгдсэн. Улаанбаатар хотод хүүхэд өртсөн осол нь явган зорчигч хэлбэрээр осолд өртсөн тохиолдол нь хотын зах, гэрэлтүүлэг хангалтгүй газар осол, гэмтэл илүү бүртгэгдсэн байна.

Хавар, зуны улиралд цаг агаар дулаарч байгаатай холбоотой гадуур сэлгүүцэх, унадаг дугуй, дугуйт тэшүүр зэргээр зам орчны ойролцоо тоглож байгаад гэмтэж бэртэх явдал тохиолддог.



Хүүхэд зам тээврийн осолд өртөж буй тохиолдол нь эцэг, эх, багш сурган хүмүүжүүлэгчид, жолооч нар хамгийн их буруутай гэж үзэж байна. Мэдээллийн технологи, мэдээлэл зүй, цахим ертөнц эрчимтэй хөгжиж буй энэ нийгэмд эцэг, эх, багш, томчууд бид тэдний мэдээллийн технологи, интернетийн орчинд ажиллах эсвэл хэлний мэдлэг гэх мэтчилэн бусад мэдлэг боловсролд анхаарал хэт хандуулаад Замын хөдөлгөөнд зөв оролцох, замын хөдөлгөөний мэдлэг боловсролд анхаарал хандуулахгүй орхигдуулж байна. Хүн бүр замын хөдөлгөөнд оролцогч байдаг тэр дундаа явганаар замын хөдөлгөөнд оролцдоггүй нэг ч хүн байхгүй гэж хэлж болно. Иймд явган зорчигч хүүхдүүдэд замын хөдөлгөөний мэдлэг олгож,

тэднийг замын хөдөлгөөнд зөв боловсон оролцох дадлыг нь эзэмшүүлж чадаагүйтэй холбоотой юм.⁴⁹



Хүүхэд өртсөн зам тээврийн осол Даваа гаригт 13.6 хувь нь, Мягмар гаригт 12.3 хувь нь, Лхагва гаригт 15.8 хувь нь Пүрэв гаригт 15.1 хувь нь, Баасан гаригт 16.8 хувь нь Бямба гаригт 14.0 хувь нь, Ням гаригт 12.3 хувь нь бүртгэгдсэн байна.

Сургуулийн өмнөх насны хүүхдийн сурган хүмүүжүүлэгч нь эцэг, эхчүүдээс дутахгүй үүрэг хүлээдэг бөгөөд багшийн хэлснийг хүүхэд гэртээ харин давтаж өөрийнхөө ой ухаанд бүрэн суулгадаг онцлогтой. Энэ тал дээр багшийн нэр хүнд эцэг эхийнхээс илүү гэж хэлэхэд нэг их алдас болохгүй. Ингэхээр сурган хүмүүжүүлэгч хүүхдэд аюулгүй байдлыг хангах дадал олгох явцдаа энэ давуу байдлаа ашиглах нь чухал юм.

Сургуулийн өмнөх насанд суусан дадал, зуршил хоёр нь хожим мэдлэгийг олж авахад ихээхэн хэрэгтэй байдаг.

Замын хөдөлгөөний дүрмийн анхан шатны мэдлэгийг хүүхдэд олгох, замын хөдөлгөөнд соёл, дуг журамтай оролцуулах дадлага эзэмшүүлэх, осол хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх асуудал төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, насанд хүрсэн иргэн бүрийн эрхэм үүрэг юм. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын ирээдүй нь одоогийн хүүхэд багачуудтай салшгүй холбоотой учир тэдний аюулгүй орчныг бүрдүүлэх асуудлыг олон хүчин зүйлээс хамааруулан, цогц байдлаар авч үзэх ёстой. Хүүхдийн хүмүүжил, боловсролтой, эрүүл энх сурч амьдрах орчныг бүрдүүлэхэд эцэг, эх багш сурган хүмүүжүүлэгчийн үүрэг нэн чухал юм.

Дүгнэлт

Олон улсын судалгааны байгууллагуудаас зам тээврийн ослын улмаас хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хувь хүний эд хөрөнгө хохирч, эрсдэлд орж байгаа гол шалтгааны нэг нь “тээврийн хэрэгслийн хурд” хэтрүүлэлтээс болж байна гэж тогтоосон. Амьдралын өртөг өндөртэй орнуудад зам тээврийн ослоос шалтгаалсан үхэл 30 орчим хувийг эзэлж байхад бага буюу дунд түвшний орнуудад зам тээврийн ослын 50 орчим хувь нь хурд хэтрүүлснээс шалтгаалан үйлдэгдэж байна.⁵⁰ Хурд хэтрүүлэлт бол аминд тулсан ажил гарсан гэж шалтгалах төдий асуудал биш юм. Энэ бол хувь хүн, жолоочийн ухамсар, хариуцлага, хандлагын асуудал юм.

⁴⁹ С.Энхтөр. Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх нь 2012 онд магистрийн дипломын ажил.

⁵⁰ <http://uridchilan-sergiileh.police.gov.mn>

Зам тээврийн осол жил ирэх тусам буурч буй сайн үзүүлэлт гарч байгаа нь жолоочдын хариуцлагатай байдалтай шууд холбоотой юм байна. Тээврийн цагдаагийн албанаас зохион байгуулсан хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх “Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх өдөр”, “Хүүхдэд ээлтэй жолооч”, “Анхаар хүүхэд”, “Хөдлөхөөсөө өмнө шалга”, гэх мэт олон нийтийг уриалсан хөдөлгөөнүүд үр дүнгээ үзүүлсэн нь жолоочийн хариуцлагатай холбон үзэж болохоор байна.

Манай улсад замын эвдрэл гэмтэл, нүх, овоолсон шороо, мөстсөн хэсэг замын бусад хангалтгүй нөхцөлийг тойрч гарах гэсэн жолооч хөдөлгөөний гэнэт өөрчлөх, тойрч гарах эсрэг ургалд орох, зэрэг үйлдлийн бурууг жолооч эсвэл бусад зорчигч нарт хариуцуулж байна. Энэ нь замын нөхцөлөөс болж бий болсон ослын тоог буруу гаргаж өгөх хариуцлагыг буруу хүлээлгэхэд хүргэж байгаа юм. Иймд замын засвар арчлалтыг хариуцсан байгууллага нь үйл ажиллагаагаа сайжруулах ёстой.

Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа жолооны курсууд нь жолооч бэлтгэхдээ зөвхөн “ашиг-олох”-ыг эрмэлзэж, сайн жолоочийг бэлтгэж гаргахаас гадна, шинээр бэлтгэгдэн гарч буй жолоочид замын хөдөлгөөнд соёлтой оролцох, хүлээцтэй хандах, хурд хэтрүүлэх түүний улмаас ямар ноцтой эрсдэл учирч болзошгүй талаар сургалтыг нэмэлтээр оруулдаггүй.

Санал

Судалгааны үр дүнд үндэслэн дараах санал дэвшүүлж байна. Үүнд:

- Автомашины жолооч нарыг жилд 1-ээс доошгүй удаа богино хугацааны давтан сургалтад хамруулж, хурдаа тохируулж явах, хамгаалах бүс хэрэглэх, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, баталгаатай зам гүүрээр зорчих, бага насны хүүхдэд тавих анхаарлаа нэмэгдүүлэх талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх;
- Хөдөө, орон нутгийн замд замын хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслийн хурдны хязгаарт хяналт тавих хяналтын камерыг олноор байршуулах;
- “Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх өдөр”, “Хүүхдэд ээлтэй жолооч”, “Анхаар хүүхэд”, “Хөдлөхөөсөө өмнө шалга” зэрэг нөлөөллийн арга хэмжээг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээгээр дамжуулан идэвхитэй өрнүүлэх, хүн олноор цугласан газар танилцуулгыг нэмэлтээр байршуулах,
- Эцэг, эх асран хамгаалагч болон багш, сурган хүмүүжүүлэгчдийн зүгээс хүүхдэд тавих хяналтыг сайжруулах. Ингэхдээ ерөнхий боловсролын сургуулиас албан ёсоор зохион байгуулж буй эцэг, эхийн хурлаар энэ асуудлыг хэлэлцэн, тогтмол сургалт зохион байгуулах, сургуулийн захиргаанаас уг үйл ажиллагаанд хяналт тавих;
- Тусгай зориулалтын хүүхдийн автобусыг стандартын дагуу тоноглон олноор бэлтгэн хөдөлгөөнд оролцуулах, “Зогс” тэмдгийг автобусны хажууд заавал байршуулах, жолоочид тавих шалгуур үзүүлэлтийг өндөрсгөх, давтан сургалтад хамруулах.

Ашигласан материал

- Зам тээврийн ослын өнөөгийн байдал. УБ. 2018
- Х.Доржпалам. “Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн эрх зүй криминологийн асуудал” докторын зэрэг горилсон бүтээл. МУИС
- Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл. УБ.2022 он
- С.Энхтөр. “Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажил” 2012 он
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын цагаан ном УБ., 2019.

Цахим эх сурвалж:

- <http://uridchilan-sergiileh.police.gov.mn>
- <https://www.trends.mn>
- <https://www.who.int/publications-detail/global-status-report-on-road-safety-2018>

ГЭР БҮЛИЙН ЗӨРЧИЛ, МАРГААН ҮҮСЭХ ШАЛТГААН, БУУРУУЛАХ АРГА ЗАМ

CAUSES OF FAMILY CONFLICTS AND ARGUMENTS, METHODS OF REDUCTION

Н.Өнөржаргал

*ДХИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн
Хувийн эрх зүйн тэнхимийн багш, ахлах дэслэгч*

Товч агуулга: Хүн оршин байгаа цаг хугацаанд аливаа зөрчил, маргаан үүссээр ирсэн. Нийгмийн анхдагч нэгж нь гэр бүл юм. Тэгвэл тухайн нийгмийн эд эсүүд болох хүмүүсийн хүмүүжил, төлөвшил нь гагцхүү гэр бүлээс үүдэлтэй. Иймээс гэр бүлийн орчин дахь зөрчил, маргаан үүсэх суурь шалтгаан болсон гэр бүл төлөвлөлтийн талаар албан ёсны байгууллагуудаас хийсэн судалгаанд тулгуурлан гэр бүлийн зөрчил, маргаанд нөлөөлж буй хүчин зүйлийг илрүүлэн гаргаж, дүн шинжилгээ хийхийг зорилоо.

Abstract: As long as humans have existed, conflicts and disputes have arisen. The primary social unit is the family. The upbringing and development of people, who are the cells of that society, originates only from the family. What are the causes of conflicts and disputes in the family environment, and what factors have been discovered and analyzed based on the research conducted by organizations about family planning, which is the basis for the reduction of crimes and conflicts from disputes and activities. intended to do.

Түлхүүр үг: Гэр бүл, гэрлэлт, гэр бүлийн үнэт зүйл, гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн зөрчил, гэр бүлийн хүчирхийлэл.

Keywords: Family, marriage, family values, family planning, family conflict, family violence.

Удиртгал

Гэр бүлийн гишүүдийн хэн нэг нь нөгөөгөө хүч, эрх мэдлээр давамгайлж, бие махбод, сэтгэл санаа, бэлгийн харилцаа, эдийн засгийн хувьд хохирол учруулж, доромжлон хүч хэрэглэж байдаг. Гэр бүлийн хүчирхийлэл нь нийгэмд бодитойгоор оршин хувь хүн, нийгмийн тодорхой хэсгийн эрх ашгийг зөрчиж байна. Гэр бүл дэх хүчирхийлэл нь хүний хувийн амьдрал, амин хувийн нууцтай салшгүй холбоотой байдаг тул маш эмзэг асуудал юм.

Гэр бүлийн хүчирхийлэл нь байнгын үргэлжилсэн шинжтэй, хүн, өрх гэр, нийгэмд асар их хэмжээний хохирол учруулдаг тул түүнийг орчин үеийн боолчлолын нэг хэлбэр гэж дэлхий нийтэд үздэг болжээ.

Гэр бүл, ахуйн хүрээнд үйлдэгдэж байгаа бие махбодийн хүчирхийллийн улмаас хохирогчид ихэвчлэн хөнгөн гэмтэл эсвэл гэмтэл учраагүй байх нь элбэг. Уг хэрэг нуугдмал хэлбэрээр үйлдэгддэг тул нотолгооны хувьд хангалттай бус, хохирогч мэдүүлгээсээ буцах, худал мэдүүлэг өгөх зэрэг олон шалтгаан нөхцлөөс үүдэн хүчирхийлэгч хариуцлага хүлээхгүй байх тохиолдол их байна. Иймээс тус зөрчил, маргааны шалтгаан, түүнийг бууруулах арга замын талаар судлахыг зорилоо.

Үндсэн хэсэг

“Гэр бүл” гэж гэрлэлтийн үр дүнд буй болсон, эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг,⁵¹ хэлнэ гэж заасан.

Өрх гэр гэсэн ойлголт нь анх Ромын эрх зүйд бий болсон, гэр бүл нь нэгэн өрхийн тэргүүний эрхшээлд буй хүмүүсийн нэгдэл, өрх гэр ба эрэгтэй, эмэгтэй хүний удам нь гэр бүлийн харилцаа юм⁵² гэж үзсэн.

⁵¹ Монгол улсын гэр бүлийн тухай хууль. УБ., 1999

⁵² Одонхүү, Т. Ромын эрх зүй.-УБ., 1999.87 дахь тал.

Гэр бүл нь өрхийн тэргүүний засаглал дор байгаа хувь этгээд, эд хөрөнгийн нэгдэл гэж үзээд

- Агнатууд буюу ясан төрлийн гэр бүл; (эцэг талаасаа нэг гаралтай гишүүд, хүүхэд үрчлэн авснаар бий болдог)
- Когнатууд буюу цусан төрлийн гэр бүл; (өрхийн тэргүүний засаглал байхгүй ч түүнтэй цусан төрлийн холбоотой эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нэгдэл) ангилсан.⁵³

Гэр бүлийн талаар философич, социологичид дараах байдлаар тайлбарлан томъёолжээ. Үүнд:

- И.Кант, Фикте нар нийгмийн хөгжлийн анхдагч бичил орчин бөгөөд хууль ёсоор харилцах хүйсийн харилцаа буюу хууль ёсны гэрээ;
- Г.В.Гегель байгалийн болон ёс суртахууны өмчтэй холбоотой үүсэх холбоооууг санааны шууд субстанцын хувьд өөрийнхөө өөрийгөө мэдэрч буй нэгдэл буюу хайрыг өөрийнхөө тодорхойлж болгодог, тэгэхээр гэр бүлийн доторх уур амьсгал нь энэхүү нэгдэл дэх өөрийнхөө бодгаль чанарыг өөртөө буй болон өөрийнхөө төлөө жинхэнэ чухал чанар гэдгийг ухамсарлах энэхүү нэгдлийн гишүүн;
- К.Маркс, Ф.Энгельс нар эхнэр болон нөхрийн хоорондын хийгээд эцэг, эх, хүүхдийн хоорондын харилцаа юм.⁵⁴

Харин гэр бүл хэмээх ойлголтыг хууль зүйн шинжлэх ухаанд эрдэмтэд дараах байдлаар тайлбарласан байна.

- Т.Мөнхжаргал иргэн хүнд байгаль, нийгмээс заяасан зайлшгүй эдлэх ёстой туйлын эрх, Б.Улаанбаатар гэрлэлтийн үр дүнд бий болсон, эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүд⁵⁵
- С.Нарангэрэл гэрлэлт, төрөл, садан, үрчлэлт буюу хүүхдийг гэр бүлдээ хүмүүжүүлэхээр авсан өөр бусад хэлбэрээс үүдэн эд хөрөнгийн бус амин хувийн ба эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хүмүүсийн хүрээ⁵⁶ гэж тус тус тайлбарлажээ.

Түүхэн үед гэр бүл, өрх гэсэн ухагдахууныг хэрэглэж байсан бөгөөд гэр бүл түүхэн хөгжлийн явцад хөгжин өөрчлөгдөж байдаг эрэгтэй, эмэгтэй (одоо цагт ижил хүйстэн болохыг хүлээн зөвшөөрч байгаа) хүмүүсийн хоорондын харилцааны нийгмийн хэлбэр, өрх гэр бий болох үндсэн нэгж нь гэр бүл юм гэж дүгнэж болно.

Гэр бүл гэдэг нь гэрлэлт, үрчлэлт гэр бүлдээ хүүхэд өсгөн хүмүүжүүлэх харилцааны үр дүнд бий болсон эд хөрөнгийн бус болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий хүмүүсийг хэлнэ.

Гэр бүл болох анхны нөхцөл нь гэрлэлт ба Ромын хуульчдын тодорхойлсноор эрэгтэй, эмэгтэй хүмүүс бүхий амьдралын холбоо, бурхны болон хүний эрхийн нэгдэл, хамтран амьдрах зорилго бүхий эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн холбоо гэж бурхантай холбож хүний жам ёсны эрхийн нэг илрэл, оршин байх үндэс гэж тайлбарлаж байжээ.

Г.В.Ф.Гегель гэрлэлт өөрийнхөө мөн чанараар зан суртахууны харилцаа ба өмчтэй төдийгүй, түүний түгээмэл хийгээд тасралтгүй орших бие хүн, И.Кант зөвхөн хүүхэд төрүүлэх, хүмүүжүүлэх ажлаар хязгаарлагдахгүй, өөр хүйсийн хүмүүс бие, хүйсийн шинжийг агуулсан насан турш эзэмдэхийн тулд нэгдэх явдал гэж зөвхөн хүйсийн харилцаа болон хүүхэд төрүүлэх үйл явц биш гэдгийг онцолжээ.

⁵³ Тунгалаг, Д. Гэр бүлийн ёс суртахуун.- Уб., 2000. 11 дэх тал.

⁵⁴ Бүрэнжаргал, Т. Гэр бүлийн социологи.- Уб., 2008. 46 дахь тал.

⁵⁵ Улаанбаатар, Б. Иргэний эрх зүйн тайлбар толь.- Уб., 2005. 93 дахь тал.

⁵⁶ Нарангэрэл, С. Эрх зүйн эх тайлбар толь.- Уб., 2008. 141 дэх тал.

Хууль зүйн тайлбар толь-д⁵⁷ гэр буй болгох болон гэрлэгчдийн харилцан эрх, үүргийг үүсгэхийн тулд байгуулагдсан эмэгтэй ба эрэгтэй хоёрын сайн дурын, эрх тэгш холбоо эрх зүйн үр дагавар үүсгэхэд чиглэсэн факт гэж томъёолсон байна.

Гэр бүлийн зөрчил маргаан, хүчирхийлэл түүний тухай ойлголт. Гэр бүлийн зөрчил гэдэг нь үзэл бодол сэдэл тэмүүлэл, чиг хандлагын эсрэг байдлын үндсэн дээр гэр бүлийн гишүүдийн хооронд бий болох үл ойлголцлыг хэлнэ.

Сэтгэл зүйч В.А. Сынсено зөрчлийг тайлбарлахдаа хосууд удаан хугацаагаар тусгаар байх нь эцэстээ бие биеэ ойлголцоход магадгүй сөргөөр нөлөөлж болно.

- Харилцан бие биеийнхээ бодол санаа, олон талыг дэмжихгүй, хөндийрөх байдлаас;
- хөдөлмөрийн хуваарьлалт тэнцвэргүйгээс зөрчил үүснэ гэж үзжээ.

Тэрээр гэр бүлийн зөрчлийн шалтгааныг авч үзэхдээ микро болон макро орчны хүчин зүйлүүдийг судлах нь чухал гэжээ.

Микро орчины хүчин зүйлд: - гэр бүлийн материаллаг байдал хангалтгүй үүнд:

- Хүүхдээ цэцэрлэг сургуульд явуулах боломжгүй;
- Удаан хугацаанд өөрийн гэсэн орон гэргүй байх;
- Эхнэр, нөхөр болон бусад гишүүд амьдарлаа хэвийн үргэлжлүүлэх нөхцөлгүй болох гэх мэт хүчин зүйлүүд хамаарагдана.

Макро орчины хүчин зүйлд:

- Гишүүдийн нийгэмд эзлэх байр суурь;
- Хамт олон бүлэгт хамаарагдах байдал;
- Тэдний нийгэмшилд гүйцэтгэх үүргийн тухай асуудал чухал юм.⁵⁸

Гэр бүлийн зөрчил маргааны илрэх хэлбэр нь уурлах, бухимдах бөгөөд энэ байдал сэтгэл түгшсэн үетэй холбоотой үүсдэг. Сэтгэлийн хямрал нь гэр бүлийн зөрчлийн нэг шалтгаан болж олон хэлбэрээр илэрдэг бөгөөд судлаачид дараах байдлаар ангилдаг.

- Хувь хүний зөрчил;
- Гэр бүлийн гишүүдийн хоорондын зөрчил буюу эхнэр-нөхөр, эцэг/эх-хүүхэд, хадмууд хүргэн/бэрүүд гэх мэт;
- Гэр бүлийн хоорондын буюу нэг гэр бүл нөгөө гэр бүлтэй зөрчилдөх;
- Гадаад орчинтой холбоотой (гэр бүлээс гадуурх, гадны нөлөөтэй бий болсон харилцаа) гэж ангилан авч үзсэн.

Гэр бүлийн холбогдолтой маргаан нь гэр бүлийн эрх зүйн шинжлэх ухаанд өргөн агуулгатай ойлголт бөгөөд гэр бүл судлал, хууль зүйн шинжлэх ухааны судлагдахуун билээ.

Гэр бүлд үүссэн зөрчил, маргааны илрэх хүнд хэлбэр нь хүчирхийлэл юм.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн үйлчлэлд хамаарах этгээдүүдийн нэг нь нөгөөдөө сэтгэл санааны дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодид халдсан үйлдэл, эс үйлдэхгүйг гэр бүлийн хүчирхийлэл гэнэ.⁵⁹ Өөрөөр хэлбэл гэр бүлийн хүчирхийлэл гэдэг нь гэрлэсэн, урьд нь гэр бүлийн харилцаатай байсан, эсхүл хэзээ нэгэн цагт хамт амьдарч байсан бусад ойр дотны хүмүүсийн зүгээс, хүч эрх мэдлээр далайлгаж, эрхшээлдээ оруулах зорилгоор бие махбод, сэтгэл санаа, бэлгийн харилцаа, эдийн засгийн хэлбэрээр хяналтаа тогтоож, өөрийн хамааралд оруулж буй тэгш бус харилцаа юм.⁶⁰

Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Цагдаагийн ерөнхий газартай хамтран Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн криминологи судалгаа⁶¹, Цагдаагийн ерөнхий газраас Гэр бүлийн хүчирхийллийн

⁵⁷ Нарангэрэл, С. Монгол Улсын хууль зүйн нэтэрхий толь бичиг.-УБ., 2021. 98 дахь тал.

⁵⁸ <https://pdelgermaa.blogspot.com/>

⁵⁹ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль

⁶⁰ www.familycenter.mn

⁶¹ Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн криминологи судалгааны тайлан (2018-2020).-УБ., 2021.

улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн судалгаа⁶² зэрэг судалгааны тайлангуудад гэр бүлийн зөрчил, маргаан, гэр бүлийн хүчирхийллийн талаар судалсан байна.

Монголын гэр бүлийн харилцааны хэв шинж, өөрчлөлтийн судалгаагаар гэр бүлийн харилцааны өөрчлөлт, өнөөгийн байдал түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлох зорилгоор 10 аймаг, 30 сум, нийслэлийн 9 дүүргийн 2016 өрхийг хамруулан гэр бүлийн суурь судалгаа хийсэн байна.

Судалгаагаар гэр бүлийн зөрчил, маргааны шалтгаанд санхүүгээс үүдэлтэй (41.4%), согтууруулах ундааны хэрэглээнээс (15.7%), хүүхдийн асуудлаар (15.3%), өр зээл (13.9%), үзэл бодлын зөрчлөөс (11%) үүсч байна. Үүсч байгаа зөрчил, маргааныг гэр бүлийн гишүүдээр нь харьцуулахад ихэвчлэн эхнэр-нөхрийн хооронд (79.9%), эцэг, эх болон хүүхдүүд (19.1%), хадам, хүргэн, бэрүүдийн хооронд (7.1%) зонхилж байна.⁶³ Эдгээр шалтгаануудын гол үндэс нь гэрлэлтийн насны залуус гэр бүлээ төлөвлөөгүй гэрлэлтээ батлуулснаас үүсэж байна. Иймд гэрлэлтийг батлахдаа гэрлэхэд харшлах шалтгаанаас гадна гэр бүл төлөвлөсөн эсэхийг шалгах шаардлагатай байна гэж харж байна.

Гэр бүлийн гишүүдийн боловсролын түвшний ялгаа нь зөвхөн цалингийн асуудал төдийгүй амьдралын ухаан, зан суртахууны төлөвшил, ёс суртахууны ялгаа, заагийг бий болгодог бөгөөд үүнээс үүдэлтэй сэтгэл санааны таагүй байдал бий болдог. Энэ нь гэр бүлийн маргааны нэг шалтгаан болж бие биеэ үл хүндэтгэх, эрх мэдэл, байр сууриа булаацалдахад хүргэх хүчин зүйл болж байна.

Гэр бүлийн хүчирхийллээс үүдэлтэй зөрчил, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн субъект нь гэр бүлийн эрх зүйн харилцааны оролцогчдод үндэслэгдсэн өргөн хүрээтэй ойлголт юм.

Цагдаагийн байгууллагад 2021 онд нийт 2,073,412 зөрчил бүртгэгдсэний 9526 буюу 0.6% нь Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлд заасан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих” зөрчил эзэлж байна.⁶⁴

Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгчдийн хувьд бол 2021 оны байдлаар эхнэр 645, нөхөр 102, хамтран амьдрагч 370, дагавар хүүхэд 55, бусад 317 байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс эхнэр 83, нөхөр 55-аар нэмэгджээ.⁶⁵

Мөн 2021-2022 оны гэр бүлийн хэрэг маргаан гэрлэлт цуцлахтай холбоотой шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхэд гэрлэлт цуцлуулж байгаа шалтгаан нь зан байдал тохироогүй, гэр бүлийн хүчирхийлэлд өртөгддөг, гэр бүлээс гадуурх харилцаа зэрэг нь дийлэнх хувийг эзэлж байна. Үүнээс үзэхэд гэр бүл төлөвлөлт хийгээгүй, нэг нэгнийгээ сайн таньж мэдээгүй гэр бүл болсноос үүдэн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэх нөхцөл байдал бий болж байгаа нь харагдаж байна.

Дүгнэлт

Аливаа нийгмийн зохион байгуулалт гэр бүлээр эхэлдэг төдийгүй гэр бүл нь улс бүрэлдэх үндэс болдог. Нийгмийн суурь нэгж болох гэр бүлийн гишүүдийн жам ёсны эрхийг зөрчиж байгаа хамгийн түгээмэл хэлбэр нь хүчирхийлэл түүний дотор ураг төрлийн холбоотой хүмүүсийн хооронд үйлдэгдэх ахуйн шинж чанартай гэр бүлийн хүчирхийлэл байна.

Сүүлийн жилүүдэд нийгэм, эдийн засгийн тогтворгүй байдал болон нийгмийн хөгжлийн бусад хүчин зүйлийн нөлөөллөөр гэрлэгчдийн боловсролын ялгаа, хамтын амьдралын явцад бэрхшээлийг даван туулах сэтгэл зүйн бэлэн байдал, амьдралын баталгаа, гэр бүлээс гадуурх харилцаа, гэр бүлийн хүчирхийлэл архидалт зэргээс шалтгаалан гэрлэлтээ цуцлуулж байна. Үүний нэг томоохон шалтгаан нь гэр бүл төлөвлөлт юм.

⁶² Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн судалгаа.-Уб., 2021

⁶³ Монголын гэр бүлийн харилцааны хэв шинж, өөрчлөлт. Судалгааны тайлан.-Уб., 2020

⁶⁴ Цагдаагийн газраас гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг зөрчлийн судалгаа.-Уб., 2021

⁶⁵ Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн криминологи судалгааны тайлан (2018-2020).-Уб., 2021.

Санал

- Залуу гэр бүлд сэтгэл зүйн үнэгүй зөвлөгөө өгөх төв байгуулах;
- Гэр бүлийн тулгамдсан асуудал, түүнийг даван туулах арга замыг олох зорилготой сургалтыг харьяа нутаг дэвсгэрийн баг, хорооноос зохион байгуулах;
- Гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн үнэт зүйлийн талаар ерөнхий боловсролын сургуулийн ахлах анги болон их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт оруулах;
- Хүчирхийлэл үйлдэгчийг хүний эрхийн асуудлаар боловсрол, мэдлэгээ дээшлүүлэх, зан үйлээ өөрчлөхөд чиглэсэн албадан болон сайн дурын сургалт явуулах нөхцлийг бүрдүүлэх.

Ашигласан материал

Ном, сурах бичиг:

- Одонхүү, Т. Ромын эрх зүй. УБ., 1999.
- Тунгалаг, Д. Гэр бүлийн ёс суртахуун. УБ., 2000
- Мөнхжаргал, Т. Гэр бүлийн эрх зүй. УБ., 2004
- Улаанбаатар, Б. Иргэний эрх зүйн тайлбар толь. УБ., 2005
- Нарангэрэл, С. Эрх зүйн эх тайлбар толь. УБ., 2008
- Нарангэрэл, С. Монгол улсын хууль зүйн нэтэрхий толь бичиг. УБ., 2021
- Тунгалаг, Д. Гэр бүлийн ёс суртахуун. УБ., 2000

Хууль тогтоомж:

- Монгол улсын гэр бүлийн тухай хууль. УБ., 1999
- Монгол улсын гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль. УБ. 2018

Судалгаа, тайлан:

- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн криминологи судалгааны тайлан (2018-2020). УБ., 2021
- Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн судалгаа. УБ., 2021

Цахим эх сурвалж:

- <https://pdelgermaa.blogspot.com/>
- www.familycenter.mn

ГЭЭГДЭЛ ЭД ХӨРӨНГӨ ЗАВШИХ ГЭМТ ХЭРГИЙН ЭРҮҮГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЧИГ ХАНДЛАГА

CRIMINAL CRIMES OF EMPLOYMENT SITUATION AND TRENDS

Г.Чингис.
ДХИС-ийн магистрант,
цагдаагийн ахлах дэслэгч


Товч агуулга: Гээгдэл эд хөрөнгө завших гэмт хэргийн эрүүгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар санал-зөвлөмж боловсруулсан.

Abstract: The criminal situation of embezzlement was analyzed and recommendations were made to prevent this type of crime.

Түлхүүр үг: Эд хөрөнгө, гээгдэл эд хөрөнгө, гэмт хэрэг, гэмт хэргийн хөдөлгөөн, гэмт хэргийн түвшин, халдлагын зүйл.

Key words: Property, tangible property, crime, criminal movement, crime rate, type of attack.

Цагдаагийн байгууллагад сүүлийн 10 жилийн хугацаанд бүртгэгдсэн гээгдэл эд хөрөнгө завших гэмт хэрэг болон өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн бүтцэд энэ төрлийн гэмт хэргийн эзлэх хувийн жинг авч үзвэл:⁶⁶



Эндээс үзэхэд, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн бүтцэд хулгайлах, залилах гэмт хэрэг дийлэнх хувийг эзэлж, дээрэмдэх, хөрөнгө завших, гээгдэл эд хөрөнгө завших гэмт хэрэг харьцангуй бага бүртгэгдсэн байна.

⁶⁶ <http://www.1212.mn/> Үндэсний статистикийн хороо



Гээгдэл эд хөрөнгө завших гэмт хэргийн хөдөлгөөнөөс үзэхэд, тогтмол буураагүй үзүүлэлттэй байна.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргүүд нь аливаа этгээд бусдын эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг үйлдлийн ямар аргаар нь хууль бусаар олж авч байгаагаас хамаарч хүлээлгэх эрүүгийн хариуцлага ялгамжтай байдаг. Харин гээгдэл эд хөрөнгө завших гэмт хэрэг нь тухайн эд хөрөнгийг хууль бусаар олж авахдаа ямар нэгэн идэвхитэй үйлдэл хийгээгүй байдаг. Тохиолдлын шинжтэй нөхцөл байдлын улмаас буюу эзэмшигч өмчлөгчийнх нь болгоомжгүй үйлдлээс шалтгаалан энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгддэг. Тиймээс ч гээгдэл эд хөрөнгө завших гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлага бусад өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгтэй харьцуулахад бага байдаг.

Гээгдэл эд хөрөнгө завших гэмт хэргийн субъект насны хувьд 16-аас дээш настай хэрэг хариуцах эрх зүйн чадвар, чадамжтай этгээд байх бөгөөд субъектэд байх бас нэгэн шинж бол түүний олсон гээгдэл эд хөрөнгө болох алдуул мал, гээгдэл эд хөрөнгө, андуурагдсан илгээмж боломж алдаатай гүйлгээний эзнийг хэн болохыг мэдээгүй байхыг шаардана.⁶⁷

Бусдын аливаа гэсэн, алдсан эд зүйлийг өөрийн өмч болгон завших үйлдэл нь ёс зүйн хэм хэмжээний зөрчил үүсгэж байдаг. Ёс суртахууны хэм хэмжээгээ зөрчин гэмт хэрэг үйлдсэн хүн бүр нь өөрийн гэсэн онцлог шинжтэй, дахин давтагдашгүй бие хүн гэдэг утгаараа өөрийгөө тодорхойлох олон шинж чанартай. Гэмт хэрэгтнийг ангилах гэж тодорхой шалгууруудыг харгалзан зэрэглэлд оруулах, бүлэглэн хуваахыг ойлгоно.⁶⁸

Тиймээс “Гээгдэл эд хөрөнгө завших” гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийн онцлог шинжүүдийг харгалзан бүлэглэн хувааснаар энэхүү гэмт хэрэгтэй тэмцэх арга зам эрчимтэй ахиц дэвшил гарна.

Монгол Улсын шүүхээс таслан шийдвэрлэсэн гээгдэл эд хөрөнгө завших гэмт хэргийг shuukh.mn⁶⁹ цахим хуудаснаас үзэхэд, 2022 оны эхний 8 сарын хугацаанд 156 хэрэг хянан шийдвэрлэжээ.Эдгээр гээгдэл эд хөрөнгө завших гэмт хэргийг үйлдсэн

⁶⁷ С.Жанцан. “Монгол Улсын эрүүгийн эрх зүй /ерөнхий ба тусгай анги/.” УБ., 2011. 381 дэх тал

⁶⁸ Ц.Цэлмэг. “Криминологи”. УБ., 2011. 89 дэх тал

⁶⁹ <https://shuukh.mn>

этгээдүүдийн нийтлэг шинж болон хохирогчдын хохирлын хэмжээ, түүнийг эргэн төлж барагдуулсан эсэх талаар судалгаа хийсэн болно. Судалгааг явуулахдаа дараах хэсэгт ангилж авч үзлээ.

- Хүйсний хувьд /гэмт хэрэг үйлдсэн этгээд/;
- Насны хувьд /гэмт хэрэг үйлдсэн этгээд/;
- Боловсролын байдал /гэмт хэрэг үйлдсэн этгээд/;
- Гэр бүлийн байдал /гэмт хэрэг үйлдсэн этгээд/;
- Эрүүгийн эрх зүйн шинж /гэмт хэрэг үйлдсэн этгээд/;
- Гэмт хэрэг гарж буй нутаг дэвсгэрийн хувьд.
- Гэмт хэрэгт өртөгдөж буй объект
- Хохирогчдод учруулсан хохирлыг нөхөн төлсөн байдал.

1.Хүйсний хувьд:

Улсын хэмжээнд нийт бүртгэгдсэн гээгдэл эд хөрөнгө завших гэмт хэрэгт холбогдсон яллагдагч нарыг хүйсээр авч үзвэл, эмэгтэйчүүд 2017 онд 13.9%, 2018 онд 13.6%, 2019 онд 13.3%, 2020 онд 17.5%, 2021 онд 16.15%-ийг тус тус эзэлж байна.

Статистик үзүүлэлт	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он
Бүгд	18,131	16,389	17,110	16,667	18078
Эмэгтэй	2,532	2,218	2,287	2,907	2,927
18 хүртэлх насны	1,066	956	1,356	990	921

2022 оны эхний 8 сарын байдлаар гээгдэл эд хөрөнгө завших гэмт хэрэгт 85 эрэгтэй, 68 яллагдагчаар татагдсан байна.

2. Насны хувьд.

Энэ төрлийн гэмт хэргийг залуучууд түлхүү гэмт хэрэг үйлддэг нь тэд нийгэмтэй харьцах харьцаа нь төлөвшөөгүй, өөрт нь болон нийгэмд ашигтай холбоо байхгүй буюу тун сул, үзэл бодол нь бүрэн төлөвшөөгүй, амьдралын туршлагагүй, нийгмийн баялгаас хүртэх хувь хэмжээ бага, нийгэмд эзлэх байр суурь бага байдаг зэрэг нөхцөл байдалтай холбоотой.

Нас ахих тусам бие хүний нийгэмтэй харьцах харьцаа сайжирч, үзэл бодол нь төлөвшин гэмт хэрэг үйлдэх идэвхи нь буурдаг тул настай хүмүүс харьцангуй бага гэмт хэрэг үйлддэг.

Дэлхийн хэмжээнд явуулсан судалгаагаар нийт гэмт хэргийн 70 орчим хувийг 35 хүртэлх насны хүмүүс үйлддэг бөгөөд тэд голчлон, хүч хэрэглэсэн гэмт хэрэг, хулгайлах, дээрэмдэх, танхайрах, хүчиндэх зэрэг гэмт хэрэг үйлдэж байхад 40 наснаас дээш ихэвчлэн хээл хахууль авах, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, ашиглан шамшигдуулах хэргийг голчлон үйлддэг байна.⁷⁰


Гээгдэл эд хөрөнгө завших гэмт хэргийг насны ангиллаар залуу нас 16-30 насны, идэр нас 31-40 насны, 41-50 нас буюу ахимаг нас, 51 болон түүнээс дээш буюу ахмад нас гэсэн ангиллаар авч үзэхэд, 48 хувийг залуу нас, 36 хувийг идэр насны залуучууд эзэлж байна. Энэ нь залуучуудын нийгмийн байр суурьтай болоогүй тэдгээрийн бүрэн төлөвшөөгүй, амьдралын туршлагагүй, нийгмийн баялгаас хүртэх хувь хэмжээ бага байдаг зэрэг нөхцөл байдалтай холбоотойгоор энэ гэмт хэрэг үйлдэгдэхэд хүргэсэн гэж авч үзсэн.

3. Боловсролын байдал.

Энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийн боловсролын түвшин харьцангуй өндөр байна.

⁷⁰ Ц.Цэлмэг. “Криминологи”. УБ., 2011. 91 дэх тал

Гээгдэл эд хөрөнгө завших гэмт хэргийг үйлдсэн яллагдагч нарын боловсролын байдал



Энэ төрлийн гэмт хэргийг ихэвчлэн бүрэн дунд, дээд боловсролтой хүн үйлдсэн байна.

4. Гэр бүлийн байдал.

Гээгдэл эд хөрөнгө завших гэмт хэргийг үйлдсэн яллагдагчид:

1.	Ганцаараа амьдардаг	11
2.	Эхнэр/ нөхөртэйгээ хоёулаа	4
3.	Ам бүл 3	23
4.	Ам бүл 4	20
5.	Ам бүл 5 ба түүнээс дээш	42

Энэ төрлийн гэмт хэрэг нь тохиолдлын шинжтэй үйлдэгддэг онцлогтой гэмт хэрэг учраас ганц бие, гэр бүлгүй хүмүүс болон ам бүл олуулаа өнөр өтгөн гэр бүлтэй хүмүүс ч энэ гэмт хэргийг түлхүү үйлдсэн байна.

Гээгдэл эд хөрөнгө завших гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан 113 иргэний дийлэнх олонх нь анх удаагаа гэмт хэрэг үйлдэж байгаа бөгөөд өмнө ямар нэгэн ял, шийтгэл эдэлж байгаагүй байна. Үүнээс энэ төрлийн гэмт хэрэгт холбогдогч гэмт хэрэгтнүүдийн зан төлвийн онцлогийг авч үзвэл, ихэвчлэн хууль, дүрмийг баримталдаг ч боловсролын байдал болон бусад нөхцөл байдлын улмаас хууль, эрх зүйн мэдлэг хангалтгүй, шунахайн сэдэл нь ёс зүйн хэм хэмжээгээсээ давж гарж ирсэн нь харагдана.

5. Гэмт хэрэг үйлдэгдэж буй нутаг дэвсгэр

Гээгдэл эд хөрөнгө завших гэмт хэргийн үйлдэгдсэн нутаг дэвсгэрээр нь ангилан авч үзлээ. Нийт гэмт хэргийн 41% нь хот суурин газар үйлдэгдэж, 59% нь хөдөө орон нутгийн хүрээнд үйлдэгджээ. Эдгээр нь 21 аймагт дүйцүүлэн авч үзэхэд хот суурин газрын үзүүлэлтээс нилээдгүй бага харагдах юм.

Гээгдэл эд хөрөнгө завших гэмт хэрэг хийгээд нийт гэмт хэрэг нь түлхүү хүн ам ихтэй хот, суурин газар ихэвчлэн үйлдэгдэж байх ба иргэдийн тоо харьцангуй сийрэг хөдөө орон нутаг энэ гэмт хэрэг үйлдэгдэх тохиолдол нь хомс байна.

6. Гээгдэл эд хөрөнгө завших гэмт хэрэгт өртөгдөж буй объект

Монгол Улсын Үндсэн хуулийн 2 дугаар зүйлд “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна”, 3 дугаар зүйлд “Өмчлөгчийн эрхийг

гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно” гэж өмчийн харилцааг тунхаглан баталгаажуулах болсон.⁷¹

Тус хуулийн “Хүний эрх, эрх чөлөө” гэсэн хоёрдугаар бүлгийн 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй”⁷² гэж заасан.

Харин хэн нэгний гэсэн эд зүйлийг олж авах нь хууль бус, бусдын өмчид эзэмшил тогтоохыг гээгдэл эд хөрөнгө завших гэмт хэрэг гэж үзэж хууль цааз бичигт өнө эртнээс цээрлэн хариуцлага тооцон ирж байсан түүхтэй.

2015 оны Эрүүгийн хуульд “Төлбөр тооцооны алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, эд хөрөнгө, гээгдэл эд хөрөнгө, алдуул малыг бусдын өмчлөл, эзэмшилд байгааг мэдсээр байж завшсаны улмаас ...” гэж халдлагын зүйлийн хүрээг өргөтгөсөн.

Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гээгдэл эд хөрөнгө завших гэмт хэргээс үзэхэд:

- Гар утас 91%;
- Бэлэн мөнгө 3%,
- Ахуйн хэрэгцээний зүйлс 3%
- Үнэт эдлэл 1%
- Зөөврийн компьютер 1%-ийг тус тус эзэлж байна.

Дээрх үзүүлэлтээс дийлэнх тохиолдолд хүмүүс утсаа таксинд орхих, үйлчилгээний газар орхиж явах, гудамжинд гээх тохиолдол ихэнх хувийг эзэлж байна.

7.Хохирогчдод учруулсан хохирлыг нөхөн төлсөн байдал

Гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг мөрдөн байцаалтын шатанд 100% нөхөн төлүүлсэн байна.

Дүгнэлт

Улсын хэмжээний статистик мэдээллээс үзэхэд, гээгдэл эд хөрөнгө завших гэмт хэрэг тогтвортой буурахгүй байгаагийн зэрэгцээ иргэдийн ухаалаг утасны хэрэглээнээс шалтгаалж, гэмт хэргийн гаралт, хохирлын хэмжээ нэмэгдэх хандлагатай байна.

Иргэд гээгдэл эд хөрөнгийг завших үйлдэл нь гэмт хэрэг, зөрчилд тооцогддог болохыг мэддэггүй учраас гэмт хэрэг, зөрчил үйлдэх, улмаар эрүүгийн хариуцлага, шийтгэл хүлээх явдал цөөнгүй байна. Иргэдийн хууль эрх зүйн мэдлэг, ёс зүйг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх ажил дутмаг болох нь тогтоогдов.

Энэ төрлийн гэмт хэргийг бүрэн дунд, дээд боловсролтой, эрхэлсэн тодорхой ажилтай, залуучууд ихэвчлэн үйлдэж байгаагаас үзэхэд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийг боловсролгүй, эрхэлсэн ажилгүй иргэд ихэвчлэн үйлддэг хэвшсэн ойлголтыг эвдэж байна.

Энэ төрлийн гэмт хэргийн хохирлыг 100 хувь мөрдөн байцаалтын шатанд барагдуулсан байгаа нь онцлогтой байна.

Гээгдэл эд хөрөнгө завших гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хангалтгүй байна.

Санал

- Гээгдэл эд хөрөнгө завших гэмт хэргийн шалтгаан, нөхцлийн талаар криминологийн судалгаа хийж, судалгааны үр дүнд үндэслэн урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээ зохион байгуулах
- Иргэдийн эрх зүйн мэдлэг, ухамсарыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулах
- Гээгдэл эд зүйл хүлээн авах, хадгалах төвийг нээн ажиллуулах

⁷¹ Монгол Улсын Үндсэн хууль УБ. 1992 он

⁷² Мөн тэнд

- Гээгдэл эд хөрөнгө завших гэмт хэрэгт хохирохоос сэргийлэх санамжийг олон нийтийн газар байршуулах, мэдээлэл хүргэх

Ашигласан материал

Монгол Улсын хууль тогтоомж

- Монгол Улсын Үндсэн хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 1992. №1
- Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга) //Төрийн мэдээлэл. УБ., 2016. №7
- Зөрчлийн тухай хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 2017. №24

Сурах бичиг, гарын авлага, нэг сэдэвт бүтээл

- Жанцан С. Монгол Улсын эрүүгийн эрх зүй /схемчилсэн тайлбар, зүйлчлэлийн асуудал/. УБ., 2011
- Н.Жанцан. Криминологи. УБ., 2012
- Д.Зүмбэрэллхам. Криминологийн онолууд. УБ., 2022
- Гантулга С, Энхболд Б. Эрүүгийн эрх зүй: тусгай анги. УБ., 2018
- Ц.Цэлмэг. Криминологи. УБ., 2011

Цахим эх сурвалж

- [http:// www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)
- [http:// www.shuukh.mn](http://www.shuukh.mn)
- [http:// www.1212.mn](http://www.1212.mn)

МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫГ ХУУЛЬ БУСААР АШИГЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

RESULTS AND ANALYSIS OF THE CURRENT SITUATION OF CRIME OF ILLEGAL USE OF DRUGS AND PSYCHIATRIC SUBSTANCES

М.Мөнхбаатар.

ДХИС-ийн магистрант, цагдаагийн ахлагч

Товч агуулга: Монгол Улсад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ нэмэгдсэний улмаас энэ төрлийн гэмт хэрэгт холбогдогчдын тоо жилээс жилд өсөж байна. Энэ төрлийн гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замын санал-зөвлөмж боловсруулсан.

Abstract: Due to the increase in drug use in Mongolia, the number of people involved in this type of crime is increasing year by year. Analyzing the statistics of this type of crime, we aim to find solutions to some of the problems.

Түлхүүр үг: Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, гэмт хэрэг, сэжигтэн.

Keywords: Narcotic Drugs, Psychotropic Substances, Crimes, Suspects.

Монгол Улсад сүүлийн жилүүдэд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр нэвтрүүлэх гэмт хэргийн арга, хэлбэр улам нарийсч, энэ төрлийн гэмт хэргийг олон улсын илгээмж, шуудан, хүнсний болон бараа бүтээгдэхүүн дотор нууж, бусдад ачаа тээшээр дамжуулан дайх хэлбэрээр хууль бусаар хил нэвтрүүлэх, борлуулахдаа товлосон газарт нууж үлдээх, цахим сүлжээ ашиглан байршил зааж өгөх, бусдын данс ашиглан мөнгө авах, шилжүүлэх зэргээр зохион байгуулалттай үйлдэгдэж байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг нь үндэстэн дамнасан гэмт хэргийн төрөлд хамаарахын хувьд нийгмийн хор аюул ихтэй, хүний эрүүл мэндэд учруулах хор нөлөө өндөртэйгөөс гадна зохион байгуулалттай гэмт бүлгээр үйлдэгддэг манай улсад үйлдэгддэг бусад төрлийн гэмт хэрэгтэй харьцуулахад үйлдлийн арга болон нийгмийн хор уршиг, үр дагавраараа нэлээд ялгаатай.

Энэ төрлийн гэмт хэргийн гаралт жилээс жилд нэмэгдэж, нарийн зохион байгуулалтад шилжиж байгаа бөгөөд нийгмийн хөгжлийг дагаад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэгч, зарж борлуулагч этгээд хууль бус үйлдэлдээ цахим сүлжээг ашиглаж цар хүрээгээ далд хэлбэрээр улам тэлсээр байна.

Үндсэн хэсэг

Гэмт хэргийн гаралт ихсэх тусам мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэгч этгээдийн тоо нэмэгдсээр байна⁷³. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис нь төв мэдрэлийн системийн үйл ажиллагааг цочроож сэтгэлийн хөөрөл, сэтгэлийн баясал, хий үзэгдэл буюу солио үүсгэх, эсвэл төв мэдрэлийн системийн үйл ажиллагааг саатуулж булчин сулруулах, нойр хүргэх, тайвшруулах зэрэг үйлчлэлийг үзүүлэх чадвартай, эмнэлгийн бус зориулалтаар тогтмол хэрэглэвэл эмгэг хэрэгцээг бий болгох чадавхтай эм бодисуудыг сэтгэц идэвхт бодис гэж нэрлэдэг⁷⁴.

⁷³ Эдийн засгийн хувьд бүх орлого, эд хөрөнгөө хар тамхи авахад зарцуулж, эцэст нь ядууралд өртөх, ажилгүй болох, гэр оронгүй болох, өрөнд орох аюултайгаас гадна улс орны эдийн засагт ч асар их гарз хохирлыг учруулдаг.

⁷⁴ С.Бямбасүрэн. Сэтгэцийн эмгэг судлал, УБ.,2013. 469 дахь тал.

Мансууруулах бодис мөн эсэхийг эмнэлгийн, нийгмийн, хуулийн хэмжүүрээр тогтоодог⁷⁵.

Мансууруулах, сэтгэц идэвхт эм бодисуудыг



гэж гурван бүлэгт ангилан үздэг⁷⁶.

Эрүүл мэндийн талаас тухайн эм, бодисыг нэг удаа хэрэглэснээр төв мэдрэлийн системд нөлөөлж, сэтгэцийн болон бие махбодын хамааралд орж, хар тамхинд донтох өвчтэй болсноор хувийн хүсэл эрмэлзэл, хэрэгцээ нь зөвхөн мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис руу тэмүүлэх хүслээр солигдож, оюун ухаан доройтож, бүх эрхтэн системийг өвчлүүлж, тухайн эрхтэнд хавдар үүсэхээс гадна В, С гепатит, бэлгийн замын халдварууд, ХДХВ/ДОХ гэсэн өвчинд өртөх эрсдэлийг нэмэгдүүлж, тун хэтрүүлсэн тохиолдолд шууд үхэлд хүргэх аюултай.

Зүүн Өмнөд Ази, Төв Азийн орнууд төдийгүй хоёр хөршид ч оршин байгаа гэмт бүлэглэлүүд манай улсыг сонирхож Монгол иргэдийг гэмт хэрэгт татан оролцуулах нь нэмэгдэж эдгээр улсуудаас гаралтай химийн нийлэгжсэн аргаар гаргаж авсан сэтгэцэд нөлөөлөх бодисыг улсын хилээр нэвтрүүлсэн, нэвтрүүлэхийг завдсан, зарж борлуулсан, хэрэглэсэн хэрэг зөрчлийн тоо ихсэж байгааг статистикийн НҮБ-аас жил бүр гаргадаг дэлхийн хар тамхитай тэмцэх 2010 оны илтгэлд манай улсыг дамжин өнгөрүүлэгч орон гэж тэмдэглэж байсан бол 2016 оноос хэрэглэгч улс болж дурдагдсан нь энэ хор аюул сэтгэл түгшээх хэмжээнд хүрээд байгааг харуулна.⁷⁷

НҮБ-ын Гэмт хэрэг хар тамхитай тэмцэх алба, хар тамхи, мансууруулах бодисын эргэлтийн талаарх 2019 оны тайлангаа 2020 оны 06 дугаар сард гаргасан. Энэхүү тайланд “Дэлхийн дахинд 35 сая хүн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээнээс үүдсэн өвчлөлөөр өвчилж, яаралтай тусламж шаардлагатайгаас 53 сая хүн өвчин намдаагч “одиод”, 11 сая хүн тарилгаар хэрэглэдэг хар тамхи, мансууруулах бодисын тогтмол хэрэглэгч бөгөөд үүнээс 1.4 сая хүн нь ДОХ, 5,6 сая хүн нь гепатит С-тэй гэх тоон баримтыг илтгэлдээ онцолжээ”. Дэлхийд 15-64 насны 275 сая хэрэглэгч бүртгэгдсэн байна⁷⁸.

Манай хөрш орнуудын хувьд дээрх төрлийн гэмт хэрэг, холбогдогчийн тоо, эд мөрийн баримтаар хураагдаж буй бодисын хэмжээ жил ирэх тусам нэмэгдэж, синтетик төрлийн мансууруулах бодис хууль бус зах зээлд өргөн нэвтэрч байгаа нь Монгол улсын үндэсний аюулгүй байдал, хүн амын эрүүл мэнд, удмын санд сөргөөр нөлөөлж болзошгүй байдал үүссэн. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис дараах урсгалаар манай улсад нийлүүлэгдэж байна.Үүнд:

- БНХАУ буюу азийн орнууд
- ОХУ
- Европын улсууд

⁷⁵ ЭМЯ, НЭМХ, СЭМҮТ, ДЭМБ. Мансууруулах эм бодис ба нийгмийн эрүүл мэнд, УБ., 2016. 11 дэх тал

⁷⁶ С.Бямбасүрэн. Мансуурал судлал. УБ., 1999. 4-5 дахь тал

⁷⁷ <https://gia.gov.mn/>

⁷⁸ <http://wdr.unodc.org/wdr2019/>


- БНХАУ-н ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн Эрээн хот, Монгол улсын Дорноговь аймгийн Замын-Үүд дэх хилийн шалган нэвтрүүлэх боомт гэх мэт ачаалал ихтэй хилийн боомтуудад 2 талдаа зорчигч ачаа, тээшинд хийх хяналт, шалгалт сул, рентген аппарат хангалтгүй байгаагаас болж боомтоор хар тамхи, мансууруулах бодис хууль бусаар хил нэвтрүүлэх боломжийг бүрдүүлсээр байна гэж үзэх боломжтой.

Цар тахлын үед буюу 2021 онд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэрэг 187 бүртгэгдсэнийг 2020 онтой харьцуулахад найман хувиар, холбогдон шалгагдсан сэжигтэн 22.8 хувиар буурсан эерэг үзүүлэлт гарсан. Гэвч эд мөрийн баримтаар хурааж авсан бодисын хэмжээ 26.8 хувиар өссөн байна. Тодруулбал, 2021 онд илрүүлж хураан авсан бодисын хэмжээ 10 мянга орчим хүн тун хэмжээгээр өссөн. Шалтгаан нь олон улсын шуудан илгээмж ашиглан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэг өссөнтэй холбоотой.

Сүүлийн 5 жилийн хугацаанд Монгол Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн гэмт хэргийн 40 орчим хувийг газрын боомтоор нэвтрүүлсэн хэрэг, дөрвөн хувийг агаарын боомтоор, 56 хувийг шуудан илгээмжийн үйлчилгээ ашиглан улсын хилээр нэвтрүүлсэн хэрэг эзэлж байна. Олон улсын шуудан илгээмжийн үйлчилгээ ашиглан нэвтрүүлсэн хэрэг 2020, 2021 онд өсөж, газрын боомт, агаарын боомтоор нэвтрүүлсэн хэрэг буурсан.

Сүүлийн үед метамфетамин дэлхийн хар зах зээлд ихээр нийлүүлэгдэж, энэ төрлийн бодисыг их хэмжээгээр тээвэрлэх, нийлүүлэх гэмт хэрэг огцом өссөн. Шинэ төрлийн мансууруулах бодисын зах зээл өргөжин тэлж байгаа улс орнуудын тоонд ОХУ, БНХАУ багтаж, тухайн улсуудад энэ төрлийн гэмт хэргийн гаралт жил ирэх тутам өссөөр байна. Үүнийг дагаад хөрш улсуудаас гадна Турк улсаас мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис манай улсад нэвтрүүлэх гэмт хэргийн гаралт нэмэгдэж болзошгүй байна⁷⁹.


График №1.



2012 оноос 2021-оныг хүртэл хугацаанд буюу нийт 10 жилийн хугацаанд энэ төрлийн гэмт хэргийн гаралт 3 дахин нэмэгдсэн байна. Бүртгэгдэж байгаа гэмт хэрэг өсөж байгаа үзүүлэлт нь олон улсаас мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус нийлүүлт их байгаа харуулж нөгөө талдаа худалдан авах сонирхол бүхий этгээдүүдийн бүлэг бөөгнөрөл их байгаа харуулж байна.

⁷⁹ Б.Тэмүүлэн. Мансууруулах эм, сэтгэцэ нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хорих ял эдлүүлэх ажиллагааны онцлог. Магистрын ажил. УБ., 2021. 4 дэх тал

График №2.⁸⁰



Статистик тоо баримтуудаас хархад Амжиргааны түвшин өндөр дүүргүүдэд энэ төрлийн гэмт хэрэг их бүртгэгдэж байсан бол одоо бүх дүүргүүдэд бүртгэгдсэн байгаа нь цаашид бүх аймагт энэ төрлийн гэмт хэрэг бүртгэгдэх өндөр эрсдэл байгааг харуулж байна.

График №3.⁸¹





График №4.




⁸⁰ Улаанбаатар хотод бүртгэгдсэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг өмнөх оноос 33 (18.5%)-аар буурахад Хан-Уул дүүрэгт 20 (54.1%)-оор буурсан нь голлон нөлөөлжээ

⁸¹ <https://police.gov.mn/>

Улсын хэмжээнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийг 2021 оны 9 дүгээр сарын байдлаар 2022 оны мөн үетэй харьцуулав. Үндэсний статистикийн хорооны тоо мэдээ болон Цагдаагийн ерөнхий газрын тоог мэдээ 2 хоорондоо зөрүүтэй байгаа дээрх графикаас харж болно. Энэ мэдээллийн нэгдсэн систем алдаа дутагдалтай байгаа тод харуулж байна. Мөн мэдээллүүд зөрүүтэй байгаа нь тоо мэдээнд дүн шинжилгээ хийж судалгааны үр дүнг бодитой гаргахад сөргөөр нөлөөлж байна.

График №5



Дээрх графикаас хархад Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүдэд 2021 оноос өссөн үзүүлэлттэй байгаа нь тухай 2023 онд энэ төрлийн гэмт хэрэг 2 дахин нэмэгдэж болзошгүй харуулж байна.

График №6.



Монгол Улсын хэмжээнд сүүлийн 5 жилийн хугацаанд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой 939 гэмт хэрэгт 1173 сэжигтэн бүртгэгдсэнээс 91 хувь нь эрэгтэй, 8.9 хувь нь эмэгтэй хүн холбогдон шалгагдсан байна. Нийт холбогдогчдын 92.2 хувийг 35 хүртэлх насны хүүхэд, залуучууд эзэлж байна. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэгч, донтогч нарын насны байдал залуужиж, 13-25 насны хүүхэд залуучууд ихээр гэмт хэрэгт холбогдох хандлагатай байна. Хамгийн бага нь 13 настай эмэгтэй хүүхэд гэмт хэрэгт холбогдон шалгагдсан. Хүүхдийн 13-14 нас нь шилжилтийн үе буюу хүүхдээс том хүн болдог, зан төлөв нь

төлөвшдөг, донтолтод өртөх магадлал хамгийн өндөр үе юм. Энэ үед хүүхдэд эцэг эхийн анхаарал, зөвлөгөө чухал.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн 10 хүүхэд тутмын долоо нь сониуч зангаасаа болж, 10 хүүхэд тутмын дөрөв нь найзуудаа даган дуурайж, чөлөөлөх цаг, зав ихтэйгээс болж 23.6 хувь нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэдэг байдаг. Хүүхэд, залуучуудыг хар тамхи, мансууралд оруулж байгаа гол зүйлийн нэг бол хар тамхины талаар тодорхой мэдлэггүй байх, цахим орчноос болон гадаадад амьдарч байсан хэн нэгнээс худал мэдээлэл авах явдал юм. Үүнээс болж хар тамхи, мансууруулах бодисыг хүний биед хоргүй, дасал болдоггүй, донтохгүй, хүссэн үедээ хэрэглэхээ больж болдог, бусад улс оронд хэрэглэхийг зөвшөөрсөн гэсэн ташаа ойлголт, буруу мэдээлэлтэй болсон байдаг.

Дүгнэлт

Дээрх судалгаанаас үзэхэд, 2019 онд хамгийн өндөр буюу 257 бүртгэгдэж байсан бол 2021 онд 187 бүртгэгдсэн байсан. Үүнээс үзэхэд гэмт хэргийн тоон үзүүлэлт 2012-2019 он хүртэл өссөн. 2019-2022 он хүртэл буурсан үзүүлэлттэй байгаа хэдий ч сүүлийн 3 жилд бүртгэгдсэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хууль бусаар ашигласан гэмт хэргийн гаралт их байгаа нь анхаарал татаж байна. 2021 онд илрүүлж хураан авсан бодисын хэмжээ 10 мянга орчим хүн тун хэмжээгээр өссөн. Шалтгаан нь олон улсын шуудан илгээмж ашиглан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэг өссөнтэй холбоотой юм. Цар тахлын үед буюу 2021 онд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэрэг 187 бүртгэгдсэнийг 2020 онтой харьцуулахад найман хувиар, холбогдон шалгагдсан сэжигтэн 22.8 хувиар буурсан эерэг үзүүлэлт гарсан. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах /ЭХТА 20.7/ гэмт хэрэг 2021 оны 09 дүгээр сард улсын хэмжээнд 127 бүртгэгдэж байсан бол 2022 оны 09 дүгээр сарын байдлаар 147 гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Гэвч эд мөрийн баримтаар хурааж авсан бодисын хэмжээ 26.8 хувиар өссөн байгаа нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлт их байгааг харуулж байна.

Гэмт хэргийн тоо үзүүлэлт нэмэгдэж байгаа шалтгаан нь Монгол улс аль хэдийн хэрэглэгч орон болсон гэдгийг дахин батлан харуулж байна. Статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд эрхэлсэн ажил төрөлгүй, орлогын эх үүсвэргүй, бусдад өр зээлтэй, урьд өмнө ял шийтгэгдэж байсан, цагдаагийн байгууллагад шалгагдаж байгаа, бага насны хүүхэдтэй өрх толгойлсон, ганц бие амьдралтай эмэгтэйчүүд гэх мэт этгээдүүд ашиг олох шунахайн сэдлээр энэ төрлийн гэмт хэргийг үйлдэж, хүрээгээ тэлсээр БНХАУ-д амьдардаг биеэ үнэлэгчид, халаасны хулгайч нарын дунд мансууруулах бодисын хэрэглээ ихээхэн газар авсан ба эдгээр этгээдүүдээр зуучлуулах, дамжуулах замаар монгол иргэд БНХАУ-д мансууруулах бодисыг худалдан авдаг нь хэд хэдэн эрүүгийн хэргийг шалгах явцад тогтоогдоод байгаа. Үүнээс гадна эдгээр этгээдүүд бусдыг мансууруулах бодисын хууль бус наймаа, тээвэрлэлтэд элсүүлэх, шинээр хэрэглэгч бий болгох, гадаадын гэмт бүлэглэлийг манай улсад зохион байгуулах эрсдэлийг бий болгож байна. Энэ төрлийн гэмт хэрэг цаашид өсөх дотоодод мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис боловсруулах, маш том эрсдэл байна гэж дүгнэхээр байна.

Санал

- Ази, Европын зарим улс, орнуудад амжилттай хэрэгжсэн гэр бүл болон сургуульд суурилсан мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ, донтолтоос урьдчилан сэргийлэх олон улсын туршлага, хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдээс өөрийн орны хөрсөнд тохирох хөтөлбөр, ажил, арга хэмжээг нарийн үе шаттайгаар хэрэгжүүлэх.
- Төрийн болон төрийн бус байгууллагад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ, донтолтоос урьдчилан сэргийлэх чиглэлээр мэргэшсэн сэтгэл зүйч бэлдэж тандалт, судалгаа, сургалтыг тогтмол явуулах.

- Үндэсний статистикийн хорооны тоо мэдээ, Цагдаагийн ерөнхий газрын тоо мэдээ 2 зөрүүтэй байгаа нь төвлөрсөн тоо бүртгэлийн систем хэрэгтэй байгааг харуулж байна.

Ашигласан материал

- Гэмт явдалтай тэмцэх асуудал, онол арга зүйн сэтгүүл. УБ.,2011 он дугаар 02 (36)
- С.Бямбасүрэн. Сэтгэцийн эмгэг судлал, УБ.,2013
- ЭМЯ, НЭМХ, СЭМҮТ, ДЭМБ. Мансууруулах эм бодис ба нийгмийн эрүүл мэнд, УБ., 2016
- С.Бямбасүрэн. Мансуурал судлал. УБ.,1999
- Тагнуулын Ерөнхий газрын Аюулгүй байдал судлалын хүрээлэнгээс бэлтгэсэн мэдээлэл. УБ.,2022
- Б.Тэмүүлэн “Мансууруулах эм, сэтгэцэ нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хорих ял эдлүүлэх ажиллагааны онцлог” магистрын ажил. УБ., 2021
- <https://police.gov.mn>
- <https://gia.gov.mn/47/item/763>
- <http://wdr.unodc.org>
- <http://www.nso.mn>
- <http://www.1212.mn>

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

БҮХ НАСААР ХОРИХ ЯЛЫН ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

INTERNATIONAL LEGAL REGULATION OF LIFE IMPRISONMENT

*Г.Гантөмөр.
ОТИС-ийн Хууль зүйн сургуулийн багш,
доктор (Ph.D), профессор*

Товч агуулга: Эрдэм шинжилгээний өгүүлэлд бүх насаар хорих ялын олон улсын эрх зүйн зохицуулалт, тухайлбал, уг ялыг хэрэглэх, хуульчлах хэрэгцээ, хэмжээ хязгаар, оногдуулах, эдлүүлэх ажиллагааны зарчим, журамд тавигдах шаардлагын талаар дэлхий нийтийн болон бүс нутгийн хэмжээний хүний эрхийн талаарх болон бусад олон улсын эрх зүйн бичиг баримтанд хэрхэн тодорхойлсон байдалд дүн шинжилгээ хийсэн болно.

Abstract: This scientific article analyzes the international legal regulation of punishment in the form of life imprisonment, in particular the need for the application and legalization of punishment, the limits, principles and procedures for its appointment and execution, international and regional human rights treaties and other international legal documents that make up the international legal framework of this punishment.

Түлхүүр үгс: хүний эрх, олон улсын хэм хэмжээ, бүх насаар хорих ял, бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдол, оногдуулах, бүх насаар хорих ял эдлүүлэх журам, нөхцөл.

Key words: human rights, international legal norms, life imprisonment, prisoners sentenced to life imprisonment, procedure and conditions for the appointment and serving of life imprisonment.

Удиртгал

Дэлхийн ихэнх улсуудын Эрүүгийн хуульд бүх насаар хорих ялыг хуульчилсан ба цээрлэлээрээ цаазаар авах ялын дараа ордог, цаазаар авах ялыг халсан орнуудын хувьд хамгийн хүнд, бас онцлог ялын төрөл юм.

НҮБ-ын “Хүний иргэний болон улс төрийн эрхийн факт”-ын нэмэлт II протокол буюу “Цаазаар авах ялыг халах” тухай конвенц-ийг баталсанаас хойших 20-иод жилийн хугацаанд олон улсын хэмжээнд цаазаар авах ялыг халах, татгалзах үйл явц хүчтэй өрнөж байна.

НҮБ-ын “Хүний иргэний болон улс төрийн эрхийн факт”-ын нэмэлт II протокол буюу “Цаазаар авах ялыг халах” тухай конвенцийг НҮБ-ын Ерөнхий ассамблей 1989 оны 12-р сарын 05-ны өдөр баталж, 1991 оны 07-р сарын 11-ний өдөр хүчин төгөлдөр болсон бөгөөд 2021 оны 4-р сарын байдлаар уг конвенцид 89 улс нэгдэн ороод байна.

Мөн бүс нутгуудын хэмжээний хүний эрхийн бичиг баримтанд зарим өөрчлөлтүүдийг оруулжээ. Тухайлбал: Европын Зөвлөлийн “Хүний эрх ба үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай конвенц”-ийн нэмэлт VI протокол буюу “Цаазаар авах ялыг халах тухай” протокол нь 1983 оны 4-р сарын 18-ний өдөр Страсбург хотод батлагджээ.

Европын Зөвлөлд 46 улс, Европын Холбоонд 27 улс багтах ба 1997 оноос хойш Европ тивд цаазаар авах ялыг гүйцэтгээгүй, 2013 оноос Европ нь цаазаар авах ялгүй бүс нутаг болоод байгаа юм. Европын зөвлөлийн гишүүн орнуудаас гагцхүү Беларусь улс уг конвенцид нэгдэн ороогүй байна⁸².

⁸² Ежегодная уголовная статистика Совета Европы (SPACE) 2004.8 и 2014.7.

Мөн Америкийн улсуудын байгууллагын Ерөнхий ансамблейгаас 1978 онд баталсан “Хүний эрхийн тухай” конвенцийн 1990 оны нэмэлт протоколд “...*гишүүн орнууд цаазаар авах ял хэрэглэхгүй байх, хэрэв хэрэглэх бол онцгой нөхцөлд буюу дайны цагт цэргийн гэмт хэрэг үйлдсэнээс бусад тохиолдолд цаазаар авах ялыг хэрэглэхгүй байх*...”-ыг үүрэг болгосон байдаг⁸³.

2022 оны байдлаар 108 улс цаазаар авах ялыг бүрмөсөн халсан, 6 орон цаазаар авах ялыг ердийн эрүүгийн хэрэгт хэрэглэхгүй, зөвхөн дайны цагт эсвэл дайн бүхий байдлын үед онц хүнд гэмт хэрэг үйлдсэн онцгой тохиолдолд хэрэглэхээр байгаа бол 60 гаруй оронд цаазаар авах ялыг Эрүүгийн хуульд ялын төрөл болгон хуульчилсан хэвээр байна⁸⁴.

Түүнчлэн 2018 онд дэлхийн 193 улсаас 169 улсад цаазаар авах ялыг хэрэглээгүй /оногдуулаагүй, гүйцэтгээгүй/ болохыг олон улсын “Amnesty International” байгууллагын мэдээнд дурьджээ⁸⁵.

Монгол улс ч уг үйл явцаас ангид байсангүй, ийм сонголтыг 2012 онд хийж, Улсын Их Хурал “Цаазаар авах ялыг халах тухай” конвенцийг соёрхон баталж, 2015 онд Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулахдаа цаазаар авах ялыг ялын төрлөөс хасч, хугацаагүй хорих ялыг хорих ялын төрөл болгон хуульчилсан билээ.

Сүүлийн жилүүдэд цаазаар авах ялыг халах, татгалзах үйл явцыг дагалдан дэлхийн улсууд бүх насаар хорих ялыг хуульчлах болсоноор уг ялаар шийтгүүлэгсдийн тоо өсөх хандлага ажиглагдаж байна. Олон улсын Ялын шинэчлэл /Penal reform international/ байгууллага болон Английн Ноттенгэймийн их сургуулийн эрдэмтдийн 2017 онд хийсэн хамтарсан судалгаагаар 2000 онд дэлхийн хэмжээнд 261.000 ялтан уг ялаар шийтгүүлж, ялаа эдэлж байсан бол энэ тоо, 2014 онд 305.323, 2017 онд 479.002 болж өссөн нь үүнийг батална⁸⁶.

Бүх насаар хорих ялын тухай асуудал нь хүний эрх, сэтгэл зүй, эрх зүйн философи, эрх зүйн социологи, эрх зүйн харьцуулсан судлал, ЭЭЗүй, Олон улсын ЭЭЗүй, ШШГЭЗүй зэрэг олон шинжлэх ухаан, эрх зүйн салбарын судлагдхууны өнцгөөс тодорхойлон тайлбарлаж болох өргөн хүрээтэй асуудал болно.

Иймээс бүх насаар хорих ялыг хэрэглэх, хуульчлах хэрэгцээ, хэмжээ хязгаар, оногдуулах, эдлүүлэх ажиллагааны зарчим, тавигдах шаардлага, бүх насаар хорих шийтгүүлсэн хоригдлын эрхийг хангах талаар дэлхий нийтийн болон бүс нутгийн хэмжээний хүний эрхийн болон бусад олон улсын бичиг баримтанд хэрхэн тусгагдсаныг авч үзье.

Үндсэн хэсэг

Бүх насаар хорих ялын талаарх олон улсын зохицуулалтыг судлан үзэхэд уг асуудал нь

1-рт: Хүний эрхийн талаарх олон улсын үндсэн бичиг баримт, нийтлэг хэм хэмжээ,

2-рт: хорих ял эдлүүлэх болон хоригдлын эрхийг хангахтай холбоотой тусгай хэм хэмжээ,

3-рт: бүх насаар хорих ялыг эдлүүлэхтэй болон бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлын эрхийг хангахтай холбоотой дэлхийн хэмжээний болон бүс нутгийн хэмжээний олон улсын хэм хэмжээ, бичиг баримтуудад тодорхойлогджээ.

1.Дэлхийн хэмжээний буюу НҮБ-аас баталсан хүний эрхийн, тухайлбал хорих ял шийтгүүлсэн этгээдийн /хоригдлын/ эрхийг хангахтай холбоотой олон улсын нийтлэг хэм хэмжээ, олон улсын бичиг баримтад “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”, “Хүний иргэний болон улс төрийн эрхийн факт” хамаарна. Учир нь

⁸³ <http://www.oas.org/juridico/english/Sigs/a-52.html>

⁸⁴ https://ru.wikipedia.org/wiki/смертные_казни

⁸⁵ Хуторская Н.Б. Пожизненное лишение свободы в мире // ж. Уголовно-исполнительное право. 2018. № 13. С. 67

⁸⁶ <https://cdn.penalreform.org/wpcontent/uploads/2018/04pdf>

“Хүний эрхийн түгээмэл тунхаглал”, “Хүний иргэний болон улс төрийн эрхийн факт” нь бүх насаар хорих ял эдэлж буй хоригдлын эрх зүйн байдалд шууд ба шууд бусаар хамаарах ба бүх насаар хорих ял шийтгүүлсэн этгээд хүний эрхийн талаарх олон улсын үндсэн бичиг баримтанд заасан хүний эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ.

Хорих ял шийтгүүлсэн этгээдийн /хоригдлын/ эрхийг хангахтай холбоотой олон улсын хэм хэмжээнд гэмт явдлаас урьдчилан сэргийлэх, эрх зүйн зөрчил үйлдэгсдэд хандах асуудлаар 1955 онд хуралдсан НҮБ-ын Анхдугаар хурлаас баталсан *“Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд”*⁸⁷, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1990 оны 12 дугаар сарны 14-ны өдрийн 45/111 дугаар тогтоолоор баталсан *“Хоригдлуудтай харьцах үндсэн зарчмууд”*⁸⁸, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1988 оны 12 дугаар сарны 09-ны өдрийн 43/173 дугаар тогтоолоор баталсан *“Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц”*⁸⁹ зэрэг багтана.

Дээр дурьдсан олон улсын бичиг баримтуудад бүх насаар хорих ял эдлүүлэх талаар болон бүх насаар хорих эдэлж буй хоригдлын эрх, үүргийг тусгайлсан заасан зохицуулалт байхгүй, хоригдлын эрх, үүрэг, хоригдлуудын эрхийг хамгаалах, хорих анги, тэдгээрийн албан хаагчдад тавигдах нөхцөл, шаардлага, хоригдолтой харьцах зарчмыг тодорхойлсон нийтлэг зохицуулалттай олон улсын хэмжээнүүд байна. Үүний учир шалтгаан нь эдгээр хорих ял эдлүүлэхтэй холбоотой олон улсын бичиг баримтууд батлагдах үед буюу өнгөрсөн зууны 1950-1980 онуудад бүх насаар хорих ялыг харьцангуй цөөн орнууд хэрэглэдэг, бүх насаар хорих эдэлж буй ялтны эрх зүйн байдалд анхаарал бага хандуулдаг, цаазар авах ялаас татгалзах үйл явц дэлхий дахинд өрнөөгүй, уг асуудал одоогийнх шиг чухлаар тавигдаж байгаагүйтэй холбоотой.

Иймээс дээрх эрх зүйн бичиг баримтанд тодорхойлсон *“хоригдол”* гэдэг ойлголтод бүх насаар хорих ял шийтгүүлсэн этгээд ч хамаарах тул бүх насаар хорих ял эдэлж буй хоригдол нь хоригдлуудын үндсэн эрх, үүргийг эдэлж, эрхээ хамгаалуулах эрхтэй юм.

Бидний судалж буй бүх насаар хорих ялыг эдлүүлэхтэй болон бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлын эрхийг хангахтай холбоотой, тэдгээрийг шууд тодорхойлсон дэлхийн хэмжээний болон бүс нутгийн хэмжээний олон улсын хэм хэмжээ, бичиг баримтууд цөөнгүй байна.

2.Бүх насаар хорих ялыг эдлүүлэхтэй болон бүх насаар хорих шийтгүүлсэн хоригдлын эрхийг хангахтай холбоотой дэлхий хэмжээний олон улсын хэм хэмжээнд юуны өмнө *“Хүүхдийн эрхийн тухай” конвенц*, *“Олон улсын Эрүүгийн шүүхийн дүрэм”*, 1994 оны НҮБ-ын *“Бүх насаар хорих ялын талаарх зөвлөмж”* зэрэг хамаардаг.

1989 оны *“Хүүхдийн эрхийн тухай”* конвенцийн 37-р зүйлд *“...гишүүн орнууд аль болохоор цаазаар авах ял, хугацаанаас өмнө суллах нөхцөлгүйгээр бүх насаар хорих ялыг гэмт хэрэг үйлдэхийн өмнө 18 насанд хүрээгүй хүнд хэрэглэхгүй байхыг эрмэлзэх ёстой”*. гэж заасан байдаг⁹⁰.

“Олон улсын Эрүүгийн шүүхийн Ромын дүрэм”-ийн 7-р хэсэгт Олон улсын шүүхийн дүрмийн 5-р зүйлд заасан тус шүүхэд харьяалагдах төрлөөр устгах гэмт хэрэг, хүмүүнлэгийн эсрэг гэмт хэрэг, түрэмгийллийн гэмт хэрэг, цэргийн гэмт хэргүүдийг үйлдсэн, гэм буруутай этгээдэд оногдуулах ялын талаар тусгасан ба тус хэсгийн 77-р зүйлд гэмт этгээдийн үйлдсэн хэргийн шинж, хор уршиг, гэмт хэрэгтний зан байдал, хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан:

а/. 30 жил хүртэл хугацаатай хорих ял,

б/. бүх насаар хорих гэсэн 2 төрлийн ялыг оногдуулахаар заасан байдаг⁹¹.

⁸⁷ Хүний эрх. Шүүх эрх мэдлийн салбар дахь хүний эрх. НҮБ. УБ.1996 он. 1-24 дэх тал

⁸⁸ Мөн тэнд. 25-26 дахь тал

⁸⁹ Мөн тэнд. 26-38 дахь тал

⁹⁰ Олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхэтгэл. Эрүүгийн эрх зүй, Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. /эмхэтгэсэн Д.Баярсайхан, Т.Золбоо/. УБ. 2012. 55 дахь тал

⁹¹ Олон улсын Эрүүгийн шүүхийн Ромын дүрэм. ХЗҮК. УБ. 2002. 93 дахь тал

Мөн дүрмийн “Таслан шийдвэрлэх тогтоолд заасан ялын хугацааг багасгах тухай асуудлыг шүүхээс хэлэлцэх” гэсэн 110 дугаар зүйлийн 3 заалтад “...Хугацаатай хорих ялаар шийтгүүлсэн хоригдол оногдуулсан ялын гуравны хоёрыг эдэлсэн, эсвэл бүх насаар хорих ялаар шийтгүүлсэн этгээд 25 жилийн ялаа эдэлсэний дараа ялын хугацааг багасгах эсэх асуудлыг шүүх хянан хэлэлцэж болно. Ийнхүү хянан хэлэлцэх ажиллагаа нь дээр дурьдсан хугацаанаас өмнө явагдахгүй.”⁹² заасан нь бидний судалж буй асуудалд шууд холбогдоно.

Бүх насаар хорих ялын талаарх гол бодлогын бичиг баримт болох 1994 оны НҮБ-ын “Бүх насаар хорих ялын талаарх зөвлөмж” (UN Recommendations on Life Imprisonment, 1994) онцгой үүрэгтэй. Уг зөвлөмжид “...Гишүүн орнууд бүх насаар хорих ялыг гагцхүү нийгмийг хамгаалах, хамгийн хүнд гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, шүүн таслах ажиллагаа явуулах зайлшгүй хэрэгцээ, шаардлага, эрүүгийн ялын бодлогын үүднээс хуульчилах ёстой.”, “...Бүх насаар хорих ялыг хуульчилсан гишүүн орнууд хоригдлуудыг хоорондоо харьцах, хүн хоорондын болон нийгэмтэй харьцах боломжийг алдагдуулахгүй байх, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, ажил хөдөлмөр эрхлүүлэх, хийсэн ажлын үр дүн, сурч боловсрох, өөрийгаа хөгжүүлэх, засарч хүмүүжих чиглэлээр гаргасан ахиц дэвшлийг урамшуулах, шашин, соёл, спортын болон бусад чөлөөт цагаа өнгөрүүлэх нөхцөл бололцоогоор хангах үүрэг хүлээнэ.”, “...Гишүүн орнууд улс төрийн ба нийгмийн нөхцөл байдалд бус, хувь хоригдлын нийгэмд аюултай зан байдал, засрал хүмүүжилд өгсөн үнэлгээнд тулгуурлан хорих газраас тэнсэн суллах боломжийг олгох үүрэгтэй.”, “...Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдол ялаа хөнгөрүүлэх, ялаас чөлөөлөх хүсэлт гаргах, уучлал хүсэх эрхтэй.”⁹³ гэж заасан нь бүх насаар хоригдож буй хоригдлын эрхийг хамгаалсан чухал зохицуулалт болсон юм.

Бүх насаар хорих ялын хэрэгжилтэнд анхаарах, хүний эрхийн зөрчил гэж тооцогддог, шүүмжлэл дагуулдаг асуудал нь уг ялыг хэрэглэдэг улс орнууд бүх насаар хорих ял эдэлж буй этгээдийг ганцаарчлан удаан хугацаагаар хорьдог явдал бөгөөд энэ байдлыг засах, талаар НҮБ ба хүний эрхийн байгууллагууд удаа дараа зөвлөмж, мэдэгдэл гаргаж байсны нэг нь Стамбулийн зөвлөмж билээ.

2007 оны 12 дугаар сарын 9-ны өдөр Туркийн Стамбул хотод болсон олон улсын симпозиумаар уг асуудлыг хэлэлцэн, “Ганцаарчилсан камерт хорих нөхцөл, түүний сэтгэл зүйн үр дагаварын тухай” гэсэн зөвлөмжийг гаргасан ба уг зөвлөмжид хорих камерт /тасалгаанд/

а/. цаазаар авах ялаар шийтгүүлэн, түүний биелэлтийг хүлээж байгаа хүн,

б/. хэргийн онцгой нөхцөл байдал, хувийн онц аюултай байдлаас шалтгаалан ганцаарчлан хорих талаар эрх бүхий этгээдийн гаргасан шийдвэрээс бусад тохиолдолд бүх насаар хорих шийтгүүлсэн хоригдол,

в/. хэрэг хариуцах чадварыг үгүйсгэхгүй сэтгэцийн эмгэгтэй хоригдол,

г/. 18 наснаас доош насны хоригдлыг ганцаарчлан хорихыг хатуу хориглож, энэ үйдлийг 1987 оны НҮБ-ын “Эрүүдэн шүүх, бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бус хандах, нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц”-ыг ноцтой зөрчсөнд тооцох талаар дурьдсан байдаг⁹⁴.

Дэлхийн ихэнх орнуудад бүх насаар хорих ялыг эмэгтэйчүүдэд оногдуулдаг. Үүнтэй холбогдуулан бүх насаар хорих ял шийтгүүлсэн эмэгтэй хоригдлын аюулгүй байдлыг хангах, тэднийг бие махбодийн болон бэлгийн хүчирхийлэлд өртөгдүүлэхгүй байлгах, урьдчилсан сэргийлэх чухлаар тавигдаж байгаа бөгөөд асуудлыг тодорхойлсон 2010 оны 12 дугаар 21-ны өдөр НҮБ-ын Ерөнхий ансамблейн 65/229 тоот тогтоолоор баталсан “Хорих ял шийтгүүлсэн болон хорихоос өөр төрлийн арга хэмжээ авагдсан эмэгтэй эрх зүйн зөрчигчидтэй

⁹² Мөн тэнд. 128 дахь тал

⁹³ <https://cdn.penalreform.org/wp-content/uploads/2013/06/UNODC-1994-Lifers.pdf>

⁹⁴ <https://www.refworld.org/cgi-bin/texis/vtx/rwmain/opendocpdf.pdf?refdoc=y&docid=48db9a112>

харьцах дүрэм”⁹⁵ буюу “Бангкокийн дүрэм” нь бүх насаар хорих ялын олон улс зохицуулалтын нэг салшгүй хэсэг мөн.

Уг дүрэм нь 1955 оны “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд”-ийн 8-р зүйлийн “а” заалтад заасан “...*гишүүн орнууд эрэгтэй эмэгтэй хүмүүсийг боломжийн хирээр тусдаа хорих газруудад байлгана. Хэрэв эрэгтэй, эмэгтэй хүмүүс нэг хорих газарт байгаа бол эмэгтэйчүүдийг тусдаа өрөө, тасалгаанд байрлуулбал зохино.*”⁹⁶ гэсэн ерөнхий заалтыг бататгахын зэрэгцээ тэдний аюулгүй байдлыг хангах, хорих газрын эрэгтэй албан хаагчдын болон эрэгтэй хоригдлуудын зүгээс харгис хэрцгий хандах, бие махбодийн ба бэлгийн хүчирхийлэл үйлдэх эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тусгай хэм хэмжээг тодорхойлсон нь онцлог юм. Тухайлбал: уг дүрмийн 53-р зүйлд “...*бүх насаар хоригдож байгаа эмэгтэй хоригдлын аюулгүй байдлыг хангах, тэдэнтэй харьцах, өрөө тасалгаанд хяналт, харуул хамгаалалтыг зөвхөн эмэгтэй албан хаагч хэрэгжүүлнэ.*” гэж заажээ.

3. Бүх насаар хорих ялыг эдлүүлэхтэй болон бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлын эрхийг хангахтай холбоотой, тэдгээрийг шууд тодорхойлсон бүс нутгийн бичиг баримтуудад Европын Зөвлөл, Европын холбооны хэм хэмжээ багтана.

Европ тив нь эдийн засгийн хувьд харьцангуй өндөр хөгжилтэй, ардчилал илүү хөгжсөн, хүний эрхийг дээдлэх, хангах бодитой үйлчилдэг механизмыг бий болгосон, энэ талаар бусад тивүүдийг манлайлдаг, үлгэр жишээ болж байдаг утгаараа бүх насаар хорих ял эдэлж байгаа ялтны эрхийг хангахад ихээхэн анхаардаг, энэ чиглэлээр хэд хэдэн олон улсын эрх зүйн баримт бичгийг баталж мөрдүүлж байна. Эдгээрээс заримыг дурьдвал: 1976 оны Европын Зөвлөлийн Сайд нарын Хорооны зөвлөмж № R (1976) 2. “*Урт хугацаагаар хоригдож ялтнуудтай харьцах тухай*”⁹⁷, 2003 оны Европын Зөвлөлийн Сайд нарын Хорооны зөвлөмж № Rec (2003) 22. “*Хорих газраас хугацааны өмнө тэнсэн суллах журмын тухай*”⁹⁸, 2003 оны Европын Зөвлөлийн Сайд нарын Хорооны зөвлөмж № Rec (2003) 23. “*Бүх насаар болон урт хугацаагаар хоригдож байгаа ялтны талаар хорих байгууллагын захиргааны авах арга хэмжээний тухай*”⁹⁹ зэрэг болно.

2003 оны “Хорих газраас хугацааны өмнө тэнсэн суллах журмын тухай” Европын Зөвлөлийн Сайд нарын Хорооны зөвлөмж /№ Rec (2003) 22/-ийн 4 дүгээр зүйлийн а-д “...*гишүүн орнууд бүх ялтнуудад, түүний дотор бүх насаар хорих ял эдэлж буй ялтнуудад хорих газраас хугацааны өмнө тэнсэн суллагдах нөхцөл бололцоог олгох ёстой.*” гэж заасан бол 2003 оны “Бүх насаар болон урт хугацаагаар хоригдож байгаа ялтны талаар хорих байгууллагын захиргааны авах арга хэмжээний тухай” Европын Зөвлөлийн Сайд нарын Хорооны зөвлөмж /№ Rec (2003) 23/-д бүх насаар хорих ял эдэлж хоригдлыг аль болох нийгмээс тусгаарлахгүй, эс нийгэмшүүлэхгүй байх, бусад хоригдол, гадаад орчин, гэр бүлтэйгээ харьцаа холбоотой байх, хоригдлыг ганцаарчлан хорихгүй байх, хоригдлуудыг үйлдсэн хэрэг, нийгэмд аюултай байдлын түвшин, зан чанар, /темперамент/, хувийн болон сэтгэл зүйн байдал, нас, сонирхол, хоорондын нийцэмжтэй байдлаар нь ангилж ял эдлүүлэх, гэм буруугаа ухамсарлах, хөгжих, сурч боловсрох, ажил хөдөлмөр эрхлэх боломжоор хангах, соёл, спортын ба бусад чөлөөт цагийн арга хэмжээнд хамруулах, эмнэлгийн үйлчилгээг сайжируулах зэрэг хоригдлын эрхийг хангах, ял эдлүүлэхтэй холбоотой асуудлаас гадна хорих эдлүүлэх газрын албан хаагч, удирдлагын эрх, үүрэг, бүх насаар хорих эдлүүлэх байгууллагын үйл ажиллагааны зарчим, тавигдах шаардлагыг тодорхойлсон байдаг.

⁹⁵ https://www.un.org/ru/documents/decl_conv/conventions/bangkok_rules.shtml

⁹⁶ Хүний эрх. Шүүх эрх мэдлийн салбар дахь хүний эрх. НҮБ. УБ.1996. 1-24 дэх тал

⁹⁷ А.Диденко, В.Човган. Пожизненное заключение. Европейские стандарты и Украинская практика. Харьков. 2014. с 63-65

⁹⁸ Мөн тэнд. с 68-78

⁹⁹ Мөн тэнд. с 79- 91

Европын Зөвлөлийн Сайд нарын Хорооны зөвлөмж /№ Rec (2003) 23/-д бүх насаар нь хорих эдлүүлэх байгууллагын үндсэн зорилго, бүх насаар хорих ял эдлүүлэхэд тавигдах нөхцөл, зарчмыг дараахь байдлаар заажээ. Үүнд:

а/.Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдол бүрт түүний үйлдсэн хэргийн төрөл, хэргийн нөхцөл байдал, хувийн зан байдал, сэтгэл зүйн байдалд үндэслэн аюултай байдлын эрсдлийн үнэлгээ хийж, хүсэл сонирхол, хандлагад нийцүүлэн ял эдлүүлэх ганцаарчилсан төлөвлөгөөг гаргаж, түүнд тулгуурлан ялыг эдлүүлэх,

б/.Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдолд түүнийг засан хүмүүжүүлэх, зан байдалд нь нөлөөлөх, ял эдлүүлэх аюулгүй байдлыг хангахад зөвхөн чиглэсэн хязгаарлалтуудыг Эрүүгийн хууль болон хорих ял эдлүүлэхтэй холбоотой процессын хуульд хуульчлах, шүүхийн шийтгэх тогтоолд заасан болон хорих ял эдлүүлэх тухай хуульд зааснаас бусад хязгаарлалт, хориглолтуудыг хэрэглэхгүй байх,

в/.Бүх насаар хорих ял эдэлж буй ялтанд өөрийгөө хүмүүжүүлэх үүргийг хүлээлгэх, түүнийг хариуцлагажуулах, хорих ангийн захиргааны өмнө ял эдлүүлэх ганцаарчилсан төлөвлөгөөгөөр хүлээсэн үүргээ ухамсарлах, үүргээ биелүүлэх боломж, бололцоог олгох,

г/.Бүх насаар хорих байгууллагын харуул хамгаалалтыг зохион байгуулах албан хаагчдын болон хоригдлын аюулгүй байдалд гадаад орчноос ирэх аюул, эрсдэлээс хамгаалах, дотоод орчинд хоригдлуудын хооронд болон хоригдлууд ба хорих ангийн захиргааны албан хаагчдын хоорондын албаны болон хувийн харьцаанаас үүсэх аюултай байдлаас урьдчилан сэргийлэх,

д/.Бүх насаар хорих ял эдэлж байгаа ялтнуудыг аль болох ганцаарчлан хорихгүй байх, бусад хоригдлуудтай харьцах, аюултай байдлын эрсдэл, хоорондын нийлэмжтэй байдлыг нь харгалзан бусад хоригдолтой хамт хоригдох бололцоог олгох,

е/.Бүх насаар хорих ял эдэлж байгаа ялтнуудыг тэдгээрийн засрал хүмүүжүүлд гарсан ахиц өөрчлөлт, хөдөлмөр, спорт, урлагын бусад сайн дурын арга хэмжээнд үзүүлсэн амжилтыг шат дараатайгаар урамшуулж, урам зориг өгч, итгэл үнэмшил төрүүлж замаар зан байдал, хандлагад сайнаар нөлөөлөх¹⁰⁰ зэрэг болно.

Дүгнэлт

1.Сүүлийн жилүүдэд цаазаар авах ялаас татгалзах, уг ялыг халах үйл явц сүүлийн жилүүдэд хүчтэй өрнөж, дэлхийн улсууд бүх насаар хорих ялыг хэрэглэх болсонтой холбоотойгоор уг ялыг оногдуулах, эдлүүлэхтэй холбоотой асуудлыг үндэсний хууль тогтоомжийн хүрээнд олон улсын жишиг, стандартад нийцүүлэн хуульчлах, уг ялаар шийтгүүлсэн хоригдлын эрхийг хангах асуудал чухлаар тавигдаж байна.

2.Энэ асуудалд НҮБ, түүний салбар байгууллагууд анхаарал хандуулан бүх насаар хорих ялыг хэрэглэх, оногдуулах, эдлүүлэхтэй асуудлыг хүний эрхийн олон улсын үндсэн баримт бичгүүд болон шүүх эрх мэдлийн салбарт хүний эрхийг хангахтай холбоотой жишиг дүрэм, журмуудад тодорхойлсон нь бүх насаар хорих ялын олон улсын эрх зүйн зохицуулалтын үндэс болжээ.

3.Европ тивийн улсууд /Беларусь улсаас бусад/ цаазаар авах ялаас татгалзаж бүх насаар хорих ялыг хэрэглэдэг, иймээс уг ялыг хэрэглэх, оногдуулах үндэслэл, хэмжээ хязгаар, бүх насаар хорих ялыг эдлүүлэх зарчим, тавигдах нөхцөл шаардлага, бүх насаар хорих ял эдэлж байгаа ялтантай харьцах, эрхийг хангах, тэдэнд үзүүлэх сэтгэл зүйн болон бусад туслалцаа, үйлчилгээ зэрэг асуудлын нарийвчлан тусгасан бүс нутгийн хэмжээний механизм, эрх зүйн зохицуулалтыг бий болгосон туйлын ач холбогдолтой, бусад тив, улсуудад үлгэр жишээ болж байгааг зориуд тэмдэглэх нь зүйтэй.

¹⁰⁰ А.Диденко, В.Човган. Пожизненное заключение. Европейские стандарты и Украинская практика. Харьков. 2014. с

4.Энэ чиглэлээр сүүлийн жилүүдэд Хүний эрхийн болон бүс нутгийн олон улсын байгууллагууд, их дээд сургуулиуд холбогдох судалгааг явуулж, түүнд үндэслэн бүх насаар хорих ялыг эдлүүлэхэд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор холбогдох зөвлөмжүүдийг гарган гишүүн орнууд хэрэгжүүлж байгаа сайшаалтай юм.

5.Иймээс манай улс бүх насаар хорих ялтай холбоотой дэлхийн болон бүс нутгийн олон улсын эрх зүйн баримт бичгүүд, зөвлөмжүүдийг сайтар судлан, хэрэгжүүлэх, тухайлбал: Эрүүгийн хуульд бүх насаар нь хорих ялыг ялын тогтолцоонд бие даасан ялын төрөл болгон хуульчлах, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд уг ялыг эдлүүлэх асуудлыг тусгайлан бүлэг болон хуульчилах, бүх насаар хорих ял эдлүүлэх тусгай салбарын /байрны/ нөхцөл журам, уг ялыг эдэлж буй хоригдлын эрхийг хангах, тэдэнд үзүүлэх сэтгэл зүйн болон бусад үйлчилгээ, дэмжлэг зэргийг олон улсын жишиг, стандартад ойртуулах, олон улсын байгууллагын зөвлөмж, гадаадын орнуудын сайн туршлагыг тусган хэрэгжүүлэх шаардлага чухлаар тавигдаж байна.

Ашигласан материал

- Хүний эрх. Шүүх эрх мэдлийн салбар дахь хүний эрх. НҮБ. УБ.1996 он.
- Олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхэтгэл. Эрүүгийн эрх зүй, Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. /эмхэтгэсэн Д.Баярсайхан, Т.Золбоо/. УБ. 2012.
- Олон улсын Эрүүгийн шүүхийн Ромын дүрэм. ХЭҮК. УБ.2002 он.
- Сборник стандартов и норм ООН в области предупреждения преступности и уголовного правосудия /на русском языке/. ООН.Нью-Йорк. 2016 год
- А.Диденко, В.Човган. Пожизненное заключение. Европейские стандарты и Украин-ская практика. Харьков. 2014.
- Хуторская Н.Б. Пожизненное лишение свободы в мире //ж.Уголовно-исполнительное право. 2018. № 13. с 67-69

МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГТ ЯЛ ОНОГДУУЛСАН ШҮҮХИЙН ШИЙТГЭХ ТОГТООЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

SENTENCED FOR CATTLE THEFT DONE IN THE COURT'S SENTENCE ORDER ANALYSIS

Л.Бат-Очир.

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй,
криминологийн тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D),
дэд профессор, цагдаагийн дэд хурандаа.*

Товч агуулга: Мал хулгайлах гэмт хэрэгт оногдуулсан ялын төрөл, хэмжээ, түүний үр нөлөө, хэрэгжилт, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар судалсан.

Abstract: Types of punishments imposed for animal theft, its effects, implementation, current situation, factors influencing it, issues to be considered

Түлхүүр үг: Мал хулгайлах, ял, үр нөлөө, хэрэгжилт, шалтгаан нөхцөл, соён гэгээрүүлэх ажил.

Keywords: Livestock theft, punishment, effect, implementation, causes and conditions, enlightenment.

Монгол Улсын Үндсэн хуульд¹⁰¹ "Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна" гэж заасан нь бидний хөгжил, дэвшлийн түүхэнд чухал үүрэг гүйцэтгэсэн мал, түүнтэй харьцах үндэсний бахархал, хүн ам, газар нутгийн онцлог, уламжлалт нүүдлийн соёл, иргэншил, зан заншлийн нийтлэг харилцааг хамгаалсан өвөрмөц зохицуулалт юм. Энэ нь онцлог ашиг шим бүхий малын удмын санг хамгаалах, малчдад төрөөс үзүүлэх нийгэм, эдийн засаг, эрх зүйн тусламж, дэмжлэг, хамгаалал үзүүлэх үүргийг төр хүлээсний илэрхийлэл. Түүхэн эх сурвалжаас үзэхэд, малын удмын сан, түүнийг гэмт халдлагаас хамгаалах явдал бидний үнэт зүйлийн нэг байжээ. Мал хулгайлах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга замын талаар цөөнгүй судалгааны ажил хийгдэж байсан боловч төдийлөн тогтвортой үр дүн гарахгүй байна.

2015 оны Эрүүгийн хуулийн үзэл баримтлал нь Үндсэн хуулиар баталгаажуулсан үнэт зүйлсийг хамгаалахад чиглэсэн бөгөөд Эрүүгийн хуулийн тусгай ангид¹⁰² "Мал хулгайлах" гэмт хэргийг бие даасан гэмт хэрэг болгож хуульчилсан.

Сүүлийн жилүүдэд малын ашиг, шим, түүхий эд, хүнсний хомсдол, хүн амын нягтаршил, бусад нөхцлөөс үүдэн мал хулгайлах үйлдэл буурахгүй байна. Тийм учраас шинэ Эрүүгийн хуулийн хэрэгжилт, ялын бодлого, шүүхийн практикийг судлах зорилгоор шүүхийн шийтгэх тогтоолд дүн шинжилгээ хийсэн. Хэсэгчилсэн судалгааны үр дүнгээр мал хулгайлах гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдлыг бүхэлд нь дүгнэх боломжгүй бөгөөд дараагийн судалгааны ажилд ашиглах боломтой.

Судалгааны ажлын хүрээнд Монгол Улсад эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс мал хулгайлах гэмт хэрэгт оногдуулж буй ялын төрөл, хэмжээ, ял оногдуулхад харгалзаж буй нөхцөл байдал, нутаг дэвсгэрийн онцлог, гэмт хэрэг үйлдсэн хүний нас, хүйс, нийгмийн байдал, гэмт хэрэг үйлдэгдсэн улирал, мал хулгайлах үйлдлийг хэрхэн зүйлчилсэн зэргийг судлан, харьцуулах үүднээс дүгнэлт хийв.

Шүүхийн шийтгэх тогтоолыг¹⁰³ 21 аймгийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оноос өмнөх шийтгэх тогтоолоос түүвэрлэн, нийт 26 асуулт бүхий судалгааны асуулга боловсруулж нэгтгэн.

¹⁰¹ Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992. 5 дугаар зүйлийн 5 дахь хэсэг.

¹⁰² Эрүүгийн хууль. УБ., 2015. 17.12 дугаар зүйл.

¹⁰³ www.shuuh.mn

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс мал хулгайлах гэмт хэргийг зүйлчилсэн байдлаас үзэхэд ихэвчлэн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.12 дугаар зүйлийн 1 дэх хэсгээр зүйлчилж байна. Уг зүйлийн 2, 3 дахь хэсгээр зүйлчилсэн тохиолдол харьцангуй бага байгаа нь Эрүүгийн хуулийн хүндрүүлэх шинж, шүүхээс оногдуулах ялын төрөл, хэмжээг урьдчилан тооцоолдог, зарим тохиолдолд Эрүүгийн хуулийг буруу хэрэглэх, хүндрүүлэх шинжтэй үйлдлүүд далд байх магадлалтай. Энэ талаар ЦЕГ-аас хэрэгжүүлсэн судалгааны тайланд "Мал хулгайлах гэмт хэргийн гаралт нуугдмал байдалд шилжсэн, иргэд мал алдсан талаар бүртгүүлдэггүй"¹⁰⁴ гэж дурдсан.

Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг	Шийтгэх тогтоолын тоо	Хувь
17.12.1	107	99,1
17.12.2	1	0,9
17.12.3	0	0

Баримт 1

А гэгч зэргэлдээ сумаас 10 тооны адуу хулгайлан 40 км газраас туужээ. Адууг туух явцадаа эцэж ядарсан малыг замдаа хаясаар 2 тарган адууг махалж заржээ. Шүүхээс түүний үйлдлийн бодит хохиролд 2 адууг тооцож Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.12.1 дэх хэсгээр зүйлчилж нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулсан.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.12 дугаар зүйлд заасан мал хулгайлах гэмт хэрэг нь бусдын малыг хууль бусаар, нууцаар авснаар төгсөнө. Замд туух явцад эцэж үлдсэн мал нь А-аас үл шалтгаалах нөхцөл байдлын улмаас хууль бус эзэмшлээс гарсан, 10 адууг хулгайлж авах санаа, зорилготой байсан, үйлдлээ хэрэгжүүлсэн үйлдэл байна.

Түүвэрлэсэн шийтгэх тогтоолын хүрээнд хамгийн их үйлдэгдсэн аймаг нь Архангай, Булган, Сүхбаатар, Өвөрхангай аймагт ихээр үйлдэгдсэн байна. Энэ нь Баруун аймгаас ирэх махны нийлүүлэлт, зам дагуу хямд мах худалдан авах, махны чанартай холбоотой.

Аймаг	Шийтгэх тогтоолын тоо	Хувь
Архангай	10	9
Булган	12	11
Сүхбаатар	11	1
Дорнод	3	2
Дорноговь	2	1,8
Хөвсгөл	8	7
Увс	2	1,8
Ховд	4	3,5
Баянхонгор	5	4,6
Өвөрхангай	9	8,3
Төв	6	5,5
Хэнтий	5	4,6
Өмнөговь	1	0,9
Дундговь	1	0,9
Баян-Өлгий	6	5,5
Завхан	1	0,9
Говь-Алтай	1	0,9

¹⁰⁴ Гэмт явдалтай тэмцэх асуудал.сэтгүүл.УБ.,2011. №2. (36)

Сэлэнгэ	1	0,9
Говьсүмбэр	0	
Орхон	0	


Шүүхээс оногдуулсан нийт ялын 30%-д хорих ял, 40%-д нь нийтэд тустай ажил хийлгэх ял, 26%-д хорих ялыг тэнссэн, 4%-ыг торгох ял оногдуулжээ.

Мал хулгайлах гэмт хэргийг 57 малчин үйлдсэнээс¹⁰⁵ үзэхэд орон нутагт үйлдэгдсэн гэмт хэрэгт, нийтэд тустай ажил хийлгэх ял ихэвчлэн оногдуулсан нь энэ гэмт хэрэгтэй тэмцэх ялын ялын үр нөлөө, хэрэгжилт үр дүнгүй, ялын бодлого учир дутагдалтай байсныг 2020 оны 1 сарын 26-ны өдрийн Эрүүгийн хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр тусгай ангийн 17.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл” гэснийг хассан. Энэ талаар ЦЕГ-ын Мэдээлэл судалгааны төвийн (тухайн үеийн нэрээр) тайланд¹⁰⁶ “ял шийтгэлийг оновчтой оногдуулдаггүй” гэжээ. Мөн 26%-д хорих ялыг тэнссэн нь энэ Эрүүгийн хуульд заасан хөнгөрүүлэх нөхцөл байдал, тэнсэх үндэслэл журам байгаа хэдий ч энэ гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогод нийцүүлдэггүй, Эрүүгийн хуулийн үзэл баримтлал, урьдчилан сэргийлэх зорилгыг харгалздаггүй байдал байгааг үгүйсгэхгүй.

Бага тооны хулгайлан хохиролоо барагдуулсан, гэм буруугаа ухамсарласан байдал нь тэнсэх үндэслэл болжээ. Мал, малын түүхий эдийн төвлөрсөн захын үйл ажиллагаа, махны хомсдол, малын гаралттай өвчин, үнийн өсөлт энэ төрлийн гэмт хэргийг үйлдэх болсон.

Хорих ял оногдуулсан					тэнссэн	торгосон	Нийтэд тустай ажил хийлгэх
6 сар	6 сараас 1 жил хүртэлх	1 жилээс 2 жил хүртэлх	2 жилээс 3 жил хүртэл	3 жилээс дээш			
3	10	7	9	1	26	2	40
2 хувь	9 хувь	6 хувь	8,3 хувь	0,9 хувь	26 хувь	4 хувь	40 хувь
30 хувь							



Эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн байдал



¹⁰⁵ <https://police.gov.mn/>


¹⁰⁶ ЦЕГ.Мал хулгайлах гэмт хэргийн шалтгаан нөхцөл, анхаарах зарим асуудал. Судалгааны ажлын тайлан. УБ.,2011.

Оногдуулсан хорих ялын хугацаа




Мал хулгайлах гэмт хэрэг үйлдсэн хүний дийлэнх буюу 52% нь малчид байгаа нь энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг нийгмийн тодорхой бүлэгт чиглүүлэх, төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэх ажил, оногдуулах ялын төрөл хэмжээг хуульд заасан үндэслэл журмыг үндэслэн, ялын бодлого, эрүүгийн хуулийн үзэл баримтлал, зорилгод нийцүүлэн оногдуулах шаардлагатай байгааг судалгааны дүн илтгэнэ.

Ажил мэргэжлийн хувьд




Нийт үйлдэгдсэн гэмт хэргийн 56% нь өвлийн улиралд үйлдэгдсэн нь идэшний цагийн онцлог, хүйтэн үед малд тавих хараа хяналт, гэмт хэргийн ул мөрөө баллах, хадгалалт хамгаалалттай холбоотой. Мөн хүн амын төвлөрөл, хөдөлгөөн, нягтралаас хамаарч хүнсний хомсдол, хэрэгцээ, шаардлага эрс нэмэгдсэн.

Гэмт хэрэг үйлдсэн улирал



16-26 нас	27-36 нас	37-46 нас	46-аас дээш нас
32	31	15	5
38 хувь	37 хувь	18 хувь	6 хувь


Гэмт хэрэг үйлдсэн хүний насны байдлаас үзэхэд ихэвчлэн 16-36 насны залуучууд¹⁰⁷ үйлдэж байна. Тэдэнд чиглэсэн тусгай, нэгбүрчилсэн, соён гэгээрүүлэх урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх, эрчимжүүлэх, энэ гэмт хэрэгтэй тэмцэх шинжлэх ухааны үндэстэй төлөвлөх шаардлагатай.



Мал хулгайлах гэмт хэргийн тал хувь нь бүлэглэж үйлдэж байгаа нь судалгаанаас харж болно. Хамтран оролцсон тохиолдлын 14-т хорих ялыг тэнссэн, 28-д т нийтэд тустай ажил хийлгэх ял, 16-д хорих ял оногдуулжээ. Ингэхдээ ихэвчлэн / 24 тохиолдолд / Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.5 дугаар зүйлд заасан хөнгөрүүлэх нөхцөл байдлыг хэрэглэсэн.

¹⁰⁷ www.shuuh.mn

Хамтран оролцох хэлбэр



Дүгнэлт

Мал хулгайлах гэмт хэргийн гаралт тодорхой нөхцөл байдлын улмаас буурч байгаа ч нийт гэмт хэргийн бүтцэд эзлэх хувь буурахгүй байгаа нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх бодлого бодитой хэрэгжихгүй байгаатай холбоотой. Шүүхийн практикаас үзэхэд (түүвэр судалгаанаас) ихэвчлэн нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулжээ. Хөдөө орон нутагт энэ төрлийн ял оногдуулах нь бодитой бус, ялын зорилго биелэгдэхгүй, үр нөлөөгүй болоход хүрнэ.

УИХ-аас 2020 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулахаар болсон. Шүүхээс энэ төрлийн ялыг оногдуулахдаа эрүүгийн хариуцлагын зорилгод нийцүүлэхгүй оногдуулж байна. Тухайлбал, мал хулгайлах гэмт хэрэг үйлдсэн шүүгдэгч Б.С-д шүүхээс зорчих эрхийг хязгаарлах ялыг оногдуулахдаа¹⁰⁸ ялтны чөлөөтэй зорчих хүрээ хязгаарыг хэт өргөн буюу Булган аймгийн нутаг дэвсгэрээр тогтоожээ.

Уг ял нь гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрх бүхий байгууллагын хяналтад өөрийн оршин суух газраас явахыг хориглох, тодорхой газар очихыг хориглох, шүүхээс тогтоосон чиглэлээр зорчих үүргийг хүлээлгэж, нийгмээс тусгаарлахгүйгээр зсарч хүмүүжих боломжийг олгох зорилготой бөгөөд үйлдсэн гэмт хэргийнх нь шинж чанар, хувийн байдлыг нь харгалзан чөлөөтэй зорчих хүрээ хязгаарыг нь хумьж, чиглэлийг тогтоох зэргээр чөлөөтэй зорчих эрхэд нь тодорхой хугацаанд хязгаарлалт тогтоож буй ял шийтгэлийн төрөл юм.

Монгол Улсын Засаг захиргааны нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаар амйгийн нутаг дэвсгэр нь сум, багт хуваагдах бөгөөд иргэний оршин суух газар нь багийн нутаг дэвсгэрт харьяалагдана. Иймд шүүгдэгч С.Б-ийн гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, гэм буруугийн хэр хэмжээ, нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг, хувийн байдлыг харгалзан, түүний зорчих эрхийг Булган аймгийн нутаг дэвсгэрээр бус байнга оршин суудаг сумын нутаг дэвсгэрээр тогтоох нь зүйтэй байсан.

Санал

- Мал хулгайлах гэмт хэрэг үйлдсэн хүнд “зорчих эрхийг хязгаарлах ял” оногдуулах нь оновчтой эсэх, цахим хяналтын хэрэгслийн үр нөлөө, хэрэгжилт өнөөгийн байдал, ялтны сэтгэл зүй, хяналтын тогтолцоо, нутаг дэвсгэрийн онцлогыг тусгайлан судалж, урьдчилан сэргийлэх арга замыг бодитой төлөвлөж хэрэгжүүлэх.
- Малчдын нөхөрлөл, бүлэг, хэсгийн үйл ажиллагааг дэмжих, урамшуулах, сурталчлах, хамтын ажиллагаа, уялдааг шинэ шатанд гаргах, махны эрэлт нийлүүлэлтэд тавих хяналтыг боловсронгуй болгох, техник, технологийн

¹⁰⁸ Улсын Дээд Үүүхийн 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 18 дугаар тогтоол.

дэвшлийг нэвтрүүлэх, цахим хяналтын тогтолцоог нэвтрүүлэх, төсөл хэрэгжүүлэх.

- Шүүхээс ял оногдуулахдаа гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, гэмт хэргийн хүнд, хөнгөн, түүний нийгмийн аюулын шинж чанар, хохирол, хор уршгийн хэмжээ, зэргийн харгалзан, нутаг дэвсгэрийн онцлог, тухайн орон нутагт үйлдэгдсэн мал хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр ялгамжтай оногдуулах үндэслэл журмыг баримтлан ялын зорилго, үр нөлөө биелэхүйц, төрөл хэмжээг сонгон оногдуулах.

Ашигласан материал

- Монгол Улсын Үндсэн хууль. УБ.,1992.
- Эрүүгийн хууль. УБ.,2015.
- Гэмт явдалтай тэмцэх асуудал.сэтгүүл.УБ.,2011. №2. (36)
- ЦЕГ.Мал хулгайлах гэмт хэргийн шалтгаан нөхцөл, анхаарах зарим асуудал. Судалгааны ажлын тайлан. УБ.,2011.
- www.shuuh.mn
- Улсын Дээд Шүүхийн 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 18 дугаар тогтоол.
- <https://police.gov.mn/>

THE PROBLEM OF RETROACTIVITY IN AMENDING STATUTES OF LIMITATION - A GERMAN PERSPECTIVE

*Prof. Dr. Peter Kasiske
Augsburg University, Germany.*

When the legislature amends the rules governing the statute of limitations for criminal offenses, the question inevitably arises as to which offenses are affected by these amendments. Undoubtedly, the new statutes of limitation apply to those acts that are committed after the amendments have come into force. But what about acts committed before that time? Should the new statutes of limitations also apply retroactively to these acts?

1. The principle of legality and the prohibition of retroactive criminal law

The legislature could clarify these questions by enacting transitional provisions to make clear whether the new statutes of limitations should also apply to earlier acts. Such transitional provisions are only permissible, however, if the new rules shorten the previous statutes of limitations. For then a retroactive application of the new rules would have a favorable effect for the offender. If, on the other hand, the legislature has adopted longer periods of limitation, this will have a detrimental effect on the offender. In this case, retroactivity could be unconstitutional. This is because the principle of legality guaranteed by the constitution ("nullum crimen sine lege") also includes the prohibition of any retroactive effect of criminal laws.

In Germany, the Federal Constitutional Court had to deal with this issue after the German legislature extended the statute of limitations for murder in 1965. This was done because the intention was to prevent a statute of limitations from occurring for murders from the National Socialist era that had not yet been prosecuted. So in this case the retroactive effect of the law had been intended by the legislature. The Federal Constitutional Court ruled that the extension was compatible with the prohibition of retroactivity under Article 103 of the Basic Law (Decisions of the Federal Constitutional Court Volume 25, p. 269 - 2 BvL 15, 23/68 from February, 2nd, 1969). This is because the prohibition of retroactivity only applies to provisions of substantive law that relate to criminal liability, i.e. the preconditions as to whether a criminal offense has been committed at all. These are, in particular, those norms that regulate the conditions under which a certain conduct is punishable. These include the criminal offenses listed in the special section of the Criminal Code, but also provisions of the general section, for example, on punishable attempt or complicity. In the view of the Constitutional Court, however, the statute of limitations does not concern the question of whether a criminal offense has been committed at all, but only regulates the preconditions for a criminal offense to be prosecuted by the criminal prosecution authorities by means of criminal proceedings. The occurrence of the statute of limitations does not mean that a crime no longer exists. Even a murder that is time-barred is still a murder. And the statute of limitations does not change the wrongfulness of the act or the guilt of the perpetrator. The statute of limitations merely means that criminal proceedings may no longer be brought against the perpetrator. Therefore, although the statutes of limitation are regulated in the Criminal Code and not in the Code of Criminal Procedure, they are not norms of substantive criminal law, but regulations of criminal procedural law. The strict prohibition of retroactivity under Article 103 of the Basic Law therefore does not apply to statutes of limitation.

2. The principle of legitimate expectations and the different kinds of retroactivity

However, a retroactive extension of statutes of limitations may also violate the Constitution for another reason. Article 20 of the Basic Law contains the principle of the rule of law. From this principle derives the principle of legitimate expectations. This involves the idea of legal certainty. A citizen must be able to foresee on the basis of the law what legal consequences await him. As far as circumstances are concerned that have already occurred, he must be able to trust that the legal situation will not be subsequently

changed to his disadvantage. For this reason, retroactive amendment of laws is fundamentally problematic with regard to the principle of legitimate expectations. This principle applies to all laws, regardless of whether they concern substantive law or procedural law. In fact, the prohibition of retroactive criminal laws of Article 103 Basic Law is only a particularly strict manifestation of the principle of the protection of legitimate expectations. However, legitimate expectations do not prohibit every form of retroactivity.

However, one must distinguish between two kinds of retroactivity: On the one hand, there is retroactivity if a new law is also applied to such matters as have already begun at the time of its entry into force but have not yet been fully completed. The Federal Constitutional Court refers to this as "apparent retroactivity". On the other hand, retroactivity is conceivable in the form that a new law is also applied to such matters that have already been fully completed when the law enters into force. In these cases, there is a "genuine retroactivity." This distinction between apparent and genuine retroactivity is particularly important in the case of changes to statutes of limitations. I would like to illustrate this with an example:

Let's imagine that on Jan. 1, 2023, the legislature enacts a law that extends the period of limitation for theft from five to eight years. Let us further imagine two perpetrators, A and B. A committed a theft on 1/1/2021. The limitation period for this offence would originally have been expired at the end of 12/31/2025. If the new law is applied retroactively, the limitation period will now not expire until 12/31/2028. This is then a case of apparent retroactivity, because the limitation period for the offence had not yet expired when the law was amended.

Let's assume that B committed a theft on 1.1.2017. Therefore, the limitation period expired at the end of 31.12.2021. If the new law were also applied to B's offence, the statute of limitations that has already occurred would be lifted. Instead, the statute of limitations would not occur until 12/31/2024. This would be a case of genuine retroactivity. This is because the statute of limitations in this case had already been fully concluded when the law was amended.

The strict prohibition of retroactivity under Article 103 of the Basic Law prohibits both apparent and genuine retroactivity. In contrast, the principle of the protection of legitimate expectations under Article 20 of the Basic Law only prohibits genuine retroactivity, according to the Federal Constitutional Court. If a statute of limitations has already occurred, the offender must be able to trust that he can no longer be punished for this act.

An apparent retroactive effect, on the other hand, is permissible as long as it does not violate the principle of proportionality. The Federal Constitutional Court considered the extension of the statute of limitations for murder to be proportionate. This was because it was a matter of punishment for very serious crimes. The common interest in prosecuting these crimes was particularly high and therefore to be weighted higher than the offender's interest in protection of legitimate expectations.

Summary:

In Germany, the Constitution permits retroactive amendment of statutes of limitations for criminal offenses. This also applies if there is an extension of time limits that is disadvantageous to offenders. However, in this case, the retroactive effect may only extend to those criminal acts for which the limitation period had not yet expired before the amendment came into force. If the statute of limitations for a crime has already expired, this effect cannot be retroactively eliminated by a law.

**ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛСЫН
ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦААНД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ**

Петер Казиске

*ХБНГУ-ын Аугсбургийн их сургуулийн Эрүү, эрүүгийн процесс,
эдийн засгийн эрүүгийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч,
доктор (Sc.D), профессор.*

Хууль тогтоогчийн зүгээс эрүүгийн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг зохицуулах журамд өөрчлөлт оруулахын тулд чухам ямар гэмт хэргүүдийг хамааруулах тухай асуудал зайлшгүй тулгарна. Нэмэлт, өөрчлөлт орсоноос хойшх хугацаанд үйлдэгдсэн гэмт хэргүүдэд шинэ хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэх ёстой. Тэгвэл хөөн хэлэлцэх хугацаанд нэмэлт, өөрчлөлт оруулахаас өмнө үйлдэгдсэн хэргүүдэд уг шинэ хөөн хэлэлцэх хугацаа хамаарах уу? гэх асуулт урган гарч байна.

Хууль ёсны зарчимд “Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхийг хориглоно” гэж заасан. Хууль тогтоох байгууллага нь шилжилт хоорондын заалтуудыг баталж, шинэ хөөн хэлэлцэх хугацаанд өмнөх актууд хамаарах эсэх, хууль батлагдах хүртэлх хугацаанд үйлдэгдсэн гэмт хэргүүдийн хөөн хэлэлцэх хугацаанд өөр зохицуулалт оруулах эсэх асуудлыг тодорхой болгох ёстой. Ийм шилжилтийн заагт шинэчилсэн дүрмээр хөөн хэлэлцэх хугацааг богиносгосон тохиолдолд л хэрэглэгдэх боломжтой боловч шинэ дүрэм дэх хуучин заалтын хэсэг нь гэмт хэрэгтэнд ашигтай байх магадлалтай. Нөгөөтэйгүүр, хууль тогтоогч хөөн хэлэлцэх хугацааг уртасгаснаар гэмт хэрэг үйлдсэн этгээдэд сөрөг нөлөө үзүүлнэ. Энэ тохиолдолд өмнөх заалтыг хүчинтэй байлгаж, хэрэглэх нь хууль зөрчсөн байж болзошгүй. Учир нь Үндсэн хуулиар баталгаажсан хуулийн зарчимд “Nullum crimen sine lege” “Өмнөх Эрүүгийн хуулийг хэрэглэх нь хориотой” гэж тусгасан байдаг. Өөрөөр хэлбэл, өмнөх Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэж, ямар ч хэргийг шийдвэрлэж болохгүй юм.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын хууль тогтоогчид 1965 онд хүн амины хэргийн хөөн хэлэлцэх хугацааг сунгасны дараа Холбооны Үндсэн хуулийн шүүхээс энэ асуудлыг шийдвэрлэх шаардлагатай болсон. Энэ нь тухайн (социализмын) үед үйлдэгдсэн хүн амины хэргүүдэд мөрдөн байцаалт явуулаагүй байхад хөөн хэлэлцэх хугацаа тооцогдож дуусахаас урьдчилан сэргийлэх алхам болсон.

Холбооны Үндсэн хуулийн шүүхээс “гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг сунгасан нь Үндсэн хуулийн 103 дугаар зүйлд заасан буцаан хэрэглэхийг хориглох заалттай нийцэж байна гэж үзсэн¹⁰⁹. Учир нь Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхийг хориглох нь зөвхөн эрүүгийн хариуцлага хүлээлгэхтэй холбоотой материаллаг хуулийн заалтууд буюу гэмт хэрэг үйлдсэн эсэх асуудалтай холбоотой. Эдгээр нь ялангуяа тодорхой үйлдлийг шийтгэх нөхцөлийг зохицуулдаг хэм хэмжээ юм. Үүнд: Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан эрүүгийн гэмт хэрэг болон ерөнхий ангийн заалтууд, тодруулбал, ял шийтгэл оногдуулах оролдлого, хамтран үйлдэгчдийн тухай заалтууд хамаарна.

Үндсэн хуулийн цэцийн үзэж байгаагаар, хөөн хэлэлцэх хугацаа нь эрүүгийн гэмт хэрэг үйлдэгдсэн эсэх асуудалд хамаарахгүй бөгөөд, зөвхөн эрүүгийн хэрэг үүсгэн, байцаан шийтгэх ажиллагаа явуулах урьдчилсан нөхцөлийг зохицуулдаг байна. Хөөн хэлэлцэх хугацаа дууссан нь гэмт хэрэг үгүй болсон гэсэн үг биш юм. Хөөн хэлэлцэх хугацаа хэтэрсэн хүн амины хэрэг ч аллага хэвээр байна. Өөрөөр хэлбэл, хөөн хэлэлцэх хугацаа нь гэмт этгээдэд эрүүгийн хэрэг үүсгэхгүй байхыг хэлэхээс бус, тухайн гэм буруутай этгээдийн гэм бурууг өөрчлөхгүй. Иймд хөөн хэлэлцэх хугацааг Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар бус, Эрүүгийн хуулиар

¹⁰⁹ Холбооны Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр. 1969 оны 2 дугаар сарын 2-ны өдөр. 25 дугаар боть. 269 дэх тал.

зохицуулсан боловч, материаллаг эрх зүйн хэм хэмжээ гэхээсээ илүүтэйгээр, процессын эрх зүйн зохицуулалтын хүрээнд хамаарах ойлголт юм. Тэгэхээр Үндсэн хуулийн 103 дугаар зүйлд заасан “буцаан хэрэглэх”-ийг хатуу хориглосон нь хөөн хэлэлцэх хугацаатай хамаагүй.

Хөөн хэлэлцэх хугацааг сунгах нь Үндсэн хууль зөрчих шалтгаан болж болзошгүй. Үндсэн хуулийн 20 дугаар зүйлд “хууль дээдлэх зарчим” гэж бий. Уг зарчмаас хууль ёсны хүлээлтийн зарчим үүсдэг. Иргэн өөрийг нь хууль, эрх зүйн ямар үр дагавар хүлээж байгааг харж чаддаг байх ёстой. Харин аль хэдийнээ үүссэн нөхцөл байдлын хувьд, тэрээр өөрийн хувийн байдлыг дордуулахгүй байх ёстой гэдэгт итгэлтэй байх хэрэгтэй. Иймээс хуульд буцаан өөрчлөлт оруулах нь хууль ёсны хүлээлтийн зарчмын хувьд үндсээрээ асуудалтай байна. Энэ зарчим нь материаллаг эрх зүй, процессын эрх зүйд хамаарах эсэхээс үл шалтгаалан, бүх хуульд хамаатай. Үнэн хэрэгтээ Үндсэн хуулийн 103 дугаар зүйлд заасан Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхийг хориглох нь хууль ёсны хүлээлтийн зарчмыг хамгаалж байгаагийн хатуу илрэл юм. Гэхдээ хууль ёсны хүлээлт нь буцаан хэрэглэх бүх хэлбэрийг хориглодоггүй боловч, хоёр төрлийн хүчинтэй нөхцөлийг ялгах хэрэгтэй. Нэг талаас шинэ хууль хүчин төгөлдөр болох үед аль нэг хэргийн хөөн хэлэлцэх хугацаа эхэлсэн боловч бүрэн гүйцэт дуусаагүй байгаа тохиолдолд хуулийг буцаан хэрэглэж болно. Холбооны Үндсэн хуулийн шүүхээс үүнийг “Илэрхий буцаан хэрэглэлт” гэж нэрлэдэг. Нөгөө талаас, хууль хүчин төгөлдөр болмогц бүрэн үйлдэгдэж дууссан асуудалд ч шинэ хууль үйлчлэхийг хууль буцаан хэрэглэх хэлбэр гэж үзэж болно. Илэрхий ба жинхэнэ буцаан хэрэглэх тохиолдлуудын хоорондох ялгаа нь хөөн хэлэлцэх хугацаа өөрчлөгдсөн тохиолдолд маш чухал. Үүнийг жишээгээр тайлбарлая.

Хууль тогтоогч 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хулгайлах гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг таваас найман жил болгон сунгасан хууль гаргасан гэж бодъё. 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр А, Б нар хулгайлах гэмт хэрэг үйлдсэн гэж төсөөлбөл, энэ гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болох байсан. Хэрэв шинэ хуулийг буцаан хэрэглэсэн тохиолдолд, хөөн хэлэлцэх хугацаа нь 2028 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл дуусахгүй. Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үед гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа хараахан дуусаагүй байсан тул энэ хэрэгт хууль буцаан хэрэглэж болно. Иргэн Б нь 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хулгай хийсэн гэж бодвол, хөөн хэлэлцэх хугацаа 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болсон. Хэрэв шинэ хуулийг Б-н үйлдсэн гэмт хэрэгт хэрэглэсэн бол нэгэнт үүссэн хөөн хэлэлцэх хугацаа цуцлагдах байсан. Үүний оронд хөөн хэлэлцэх хугацаа 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл үүсэхгүй. Энэ нь жинхэнэ буцаан хэрэглэх тохиолдол юм. Учир нь хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад, уг хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нэгэнт бүрэн тооцогдож, дууссан байсан.

Үндсэн хуулийн 103 дугаар зүйлийн буцаан хэрэглэх заалтад эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхийг хориглосон заалт байдаг. Үүний эсрэгээр, Үндсэн хуулийн 20 дугаар зүйлд заасан хууль ёсны хүлээлтийг хамгаалах зарчим нь зөвхөн жинхэнэ буцаан хэрэглэх журам хүчинтэй байхыг хориглодог гэж Холбооны Үндсэн хуулийн цэц мэдэгдэв. Хэрэв хөөн хэлэлцэх хугацаа аль хэдийн дууссан бол гэмт хэрэгтэн тухайн үйлдлийнхээ төлөө цаашид хариуцлага хүлээхгүй гэдэгт итгэх чадвартай байх ёстой.

Холбооны Үндсэн хуулийн шүүхээс “хүн амины хэргийн хөөн хэлэлцэх хугацааг сунгах нь пропорциональ” гэж үзсэн. Учир нь онц хүнд гэмт хэрэгт оногдуулах шийтгэлийн асуудал байсан. Энэ гэмт хэрэгт ял оногдуулах нийтлэг ашиг сонирхол онцгой их байсан тул гэмт этгээдийн хууль ёсны хүлээлтийг хамгаалах ашиг сонирхлоос илүү гэмтэй байх ёстой.

Дүгнэлт

Германы Үндсэн хуулиар эрүүгийн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг буцаан өөрчлөхийг зөвшөөрдөг. Гэмт хэрэгтнүүдийн үйлдсэн гэмт хэргийн хөөн

хэлэлцэх хугацааны хязгаарлалтыг сунгах нь хэрэгтэнд ашиггүй тохиолдолд хэрэглэгдэнэ. Гэсэн хэдий ч, энэ тохиолдолд буцаан хэрэглэх хэрэгжилт нь хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болохоос өмнө хөөн хэлэлцэх хугацаа дуусаагүй байгаа эрүүгийн хэрэгт хамаарна. Хэрэв эрүүгийн гэмт хэргийн хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа аль хэдийн дууссан бол хэрэгжилтийн эцэст гарсан үр дүнг хуулиар буцаан арилгах боломжгүй.

Ашигласан материал

- Холбооны Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр. 1969 оны 2 дугаар сарын 2-ны өдөр. 25 дугаар боть.

Орчуулсан: Б.Уянга

ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ХУУЛЬ БУСААР АШИГТ МАЛТМАЛ ХАЙХ, АШИГЛАХ, ОЛБОРЛОХ ГЭМТ ХЭРГИЙГ СЭЛЭНГЭ АЙМАГТ ШҮҮХИЙН ӨМНӨХ ШАТАНД ШАЛГАЖ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

ANALYSIS OF THE RESULTS OF THE CRIMES OF ILLEGAL EXPLORATION,
USE AND EXTRACTION OF MINERALS IN THE PRELIMINARY STAGE OF COURT IN
SELENGE PROVINCE

Г.Болор-Эрдэнэ

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн
тэнхимийн багш, доктор (Ph.D), цагдаагийн хошууч.

Товч агуулга: Энэхүү өгүүллээр хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэргийг шүүхийн өмнөх шатанд шалгаж шийдвэрлэхэд учирч байгаа хүндрэл, энэ төрлийн гэмт хэргийг шалган шийдвэрлэх эрх бүхий төрийн байгууллагын хамтын ажиллагаа, түүний уялдаа холбоог сайжруулах талаар санал-зөвлөмж боловсруулсан.

Abstract: In this article, the difficulties encountered in investigating and solving the crime of illegal mineral exploration, use, and extraction at the level of the police and prosecutor's organizations, as well as the cooperation between the government organizations authorized to investigate and solve this type of crime, were evaluated and the reasons were explained.

Түлхүүр үгс: Хууль бус уул уурхай, гомдол мэдээлэл гаргагч, гэмт хэрэг, авлига, байршил

Key words. Illegal mining, whistleblowers, crime, corruption, location

Удиртгал

Хууль бусаар ашигт малтмал хайх, олборлох, ашиглах гэмт хэргийн хөдөлгөөнийг сүүлийн 5 жилийн байдлаар авч үзэхэд, тогтмол өссөн үзүүлэлттэй байна.


Энэ төрлийн гэмт хэрэг хамгийн их бүртгэгдсэн Сэлэнгэ аймагт энэ төрлийн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг шалгаж хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, яллагдагчаар татсан прокурорын тогтоолд тус тус дүн шинжилгээ хийж, гомдол мэдээлэл, хэрэг хянана шийдвэрлэхэд учирч байгаа хүндрэлийг тодорхойлохыг зорьсон.

Үндсэн хэсэг

1. Хэрэг бүртгэлтийн хаасан хэрэгт гомдол мэдээлэл гаргагч




Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2018-2022 онд хууль бусаар ашигт малтмал хайх, олборлох, ашиглах хэрэг бүртгэлтийн хаасан хэргийн тогтоолд дүн шинжилгээ хийж, гэмт хэргийн талаарх гомдол мэдээллийг гаргасан субъектүүдээр нь харьцуулж, дундаж үзүүлэлтийг гаргахад: **61%-ийг** цагдаагийн алба хаагчаас; **32%-ийг** орон нутгийн иргэдээс; **7%-ийг** энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх үүрэг хүлээсэн төрийн болон олон нийтийн байгууллагаас цагдаагийн байгууллагад шалгуулахаар ирүүлсэн байна.



Сэлэнгэ аймагт **58%-д** сумын “Засаг дарга”, **34%-д** “Байгаль орчны байцаагч”-ийг хохирогчоор тогтоон оролцуулсан байна.

Нийт хэрэг бүртгэлтийн хэргийн **58** дээш хувьд нь сумын Засаг дарга нар өөрийн шууд удирдлага дор ажилладаг байгаль орчны байцаагч нарыг хохирогчоор томилж байгаа ажиллуулж байна.




Сэлэнгэ аймгийн хэмжээнд хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох нийт хаасан хэрэг бүртгэлийн хэргийн 70 хувь нь тусгай зөвшөөрөлгүй, 30 хувь нь тусгай зөвшөөрөлтэйгөөр ашигт малтмал хайх, ашиглах, олборлох үйл ажиллагаа явуулсан байна.

“Тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмалын эрэл хайгуул, олборлолт, боловсруулалт, ашиглалт явуулсан, үйлдлийг гэмт хэрэгт тооцно” гэж Эрүүгийн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2.1-д тодорхой зааж өгсөн байхад нийт хаасан хэрэг бүртгэлтийн хэргийн 70 хувь нь тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулсан үйлдэл байгаа нь анхаарал татахаар байна.

2. Хэрэг бүртгэлтийн хаасан, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан гомдол мэдээлэлд

Гэмт хэрэгт хамтран оролцогсдын хувьд 3 аймгийг харьцуулан дундаж үзүүлэлтийг гаргаж Анх мэдүүлэхдээ ганцаараа үйлдсэн нь 46%, 2-3 хамтран оролцсон гэж 44% мэдүүлсэн байна.



3. Гэмт хэрэгт хамтран оролцогч нараас яллагдагчаар татагдсан хүний тоо харьцуулалт



Эндээс үзэхэд, эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татахаас өмнө гэмт хэрэгт хамтран оролцогчдын 46 хувь нь ганцаараа гэмт хэрэг үйлдсэн гэж мэдүүлсэн, 44 хувь нь 2-3 хүн гэмт хэрэгт хамтран оролцсон, 7 хувь нь 4-6 хүн хамтран оролцсон, 3 хувь 7 дээш хүн гэмт хэрэг үйлдэхэд хамтран оролцсон гэж мэдүүлсэн байна.

Эдгээр гэмт хэрэгт хамтран оролцогч нараас прокурор эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татагдсан тоон үзүүлэлтийг авч үзвэл, 73 хувь нь ганцаараа гэмт хэрэг үйлдсэн, 14 хувь нь 2 хүн хамтран гэмт хэрэг үйлдсэн, 6 хувь нь 3 хүн хамтарч гэмт хэрэг үйлдсэн, 7 хувь нь 4 хүн хамтран гэмт хэрэг үйлдсэн гэж үзэн хэрэгт яллагдагчаар татсан байна.


Дээрх байдлыг тоон мэдээллийг харьцуулан үзэхэд, ганцаараа гэмт хэрэг үйлдсэн гэж яллагдагчаар татагдсан хүний тоо 27 хувиар өссөн, 2-3 хүн гэмт хэрэгт хамтран оролцсон гэж яллагдагчаар татагдсан хүний тоо 30 хувиар буурсан байна. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд гэмт хэрэгт хамтран оролцогчдыг тогтоох, үйлдэл холбогдлыг нотлох ажиллагаа хангалтгүй, мөрдөгч, прокурор нь гадны ямар нэгэн нөлөөлөлд автаж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хууль ёсны байх”, “Хэргийн бодит байдлыг тогтоох” зарчим, Эрүүгийн хуулийн “шудрага ёсны зарчим” зөрчигдөж гэмт хэрэгт хамтран оролцогч нарыг хариуцлагаас чөлөөлөх асуудал байна гэж үзэж болохоор байгаа боловч гэмт хэрэгт хамтран оролцогч нарын үйлдэл холбогдлыг нэг бүрчлэн тогтооход гэмт хэрэг зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий мөрдөгч, улсын байцаагч нарын ур чадвар дутмаг байдаг талаар прокурортой хийсэн ярилцлагын үр дүнгээс харагдаж байгаа бол мөрдөгчтэй хийсэн ярилцлагаас энэ төрлийн гэмт хэрэг зөрчилд хамтран оролцогч нарын үйлдэл холбогдлыг нэг бүрчлэн тогтоох, нотлоход шаардлагатай нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх, тоног төхөөрөмж дутмаг байдал

нь энэ төрлийн гэмт хэрэг зөрчлийг шийдвэрлэхэд сөргөөр нөлөөлж байна гэж дүгнэж байна.

Прокурортой хийсэн ярилцлагын хэсгээс: Мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй мөрдөгч болон зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан хаагчдаас анхны хэргийн газрын үзлэгийг маш дутуу хийдэг, хөндөгдсөн газрын хэмжээг зөрүүтэй, буруу хэмжиж тэмдэглэлд тусгадаг, мэргэжлийн байгууллагыг оролцуулдаггүй, хэргийн газар байсан техник хэрэгсэл, эд зүйлд үзлэг хийдэггүй, хэрэгт ач холбогдолтой эд зүйлийг хураан авдаггүй.

Мөрдөгчтэй хийсэн ярилцлагын хэсгээс: Нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх тоног төхөөрөмж техник хэрэгсэл дутмаг байдаг.

4.Хэрэг бүртгэлтийн хаасан хэрэг




Сэлэнгэ аймгийн хувьд нийт хэрэг бүртгэлийн хэрэг нээж шалгасан хэргийн 79 хувийг мөрдөгч гэмт хэрэг үйлдэгдээгүй гэх үндэслэлээр, 11 хувийг зөрчлийн шинжтэй, 9 хувийг эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах саналтай прокурорт хүргүүлсэн бол тухайн хэрэг бүртгэлийн хэргийг хүлээж авсан прокурор 93 хувийг нь хааж, 7 хувийг эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татаж шийдвэрлэсэн, нийт хэрэг бүртгэлийн хэрэг нээж шалгасан хэргийн 79 хувийг гэмт хэрэг үйлдэгдээгүй гэж шийдвэрлэсэн байна.

Эндээс үзэхэд, практикт хууль хэрэглээний хувьд цагдаа, прокурор, шүүхийн байгууллага нь нэгдсэн нэг ойлголтод хүрээгүй анх гомдол, мэдээлэл хүлээж авахдаа гэмт хэрэг үйлдэгдсэн гэж хэрэг бүртгэлийн хэрэг нээж мөрдөн шалгах ажиллагаа явуулж дуусмагц анх гаргасан шийдвэрээ үгүйсгэж гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр хааж байгаа нь энэ төрлийн хэрэгт холбогдогч нарыг чирэгдүүлж, эрхийн зөрчсөн эсвэл гадны нөлөөлөлд автах, үйлдэл холбогдлыг нь нотлох ур чадвар дутмаг байгаа учир хэрэг бүртгэлийн хэргийг хааж шийдвэрлэж байна.

Ганцаарчилсан ярилцлагын явцад прокуророос тодруулахад албан тушаалтан оролцсон хэргийг шүүхээр шийдвэрлэж нотлоход маш хүндрэлтэй нөхцөл байдал үүсдэг мөн шүүхээс хэрэг буцах нь прокурорын ажлын үзүүлэлтийн нэг сөрөг үзүүлэлт гэж ажлыг нь үнэлдэг тул нотлогдох боломжтой байдлаар нь хэргийг шүүхэд шилжүүлэх хандлага байгаа гэж ярьж байгаа байдлаас дүгнэхэд авлига, албан тушаалын байдлаар урвуулан ашигласан үйлдлийг шалгах, нотлох, шүүн таслахад одоо практикт тогтсон мөрдөн шалгах ажиллагааны хүрээнд бүрэн нотлох боломжгүй энэ төрлийн хэргийг хэрхэн мөрдөж нотлох талаар мөрдөгч, шүүгч, прокуроруудын чадвар сул байгаа мөн ажлын үзүүлэлтийг хэт явцуу байдлаар дүгнэж байгаа байдал нь сөргөөр нөлөөлж байна гэж дүгнэж байна.

Гэмт хэрэг үйлдсэн байршил



Гэмт хэрэг бүртгэгдсэн байршилаар нь авч үзэхэд Сэлэнгэ аймагт гэмт хэргийн 39,5 хувь буюу 32 хэрэг Ерөө суманд, 22 хувь буюу 18 хэрэг Мандал сумын нутагт, 18,5 хувь буюу 15 хэрэг Орхонтуул сумын нутагт, 12,4 хувь буюу 10 хэрэг Баянгол сумын нутагт, 5 хувь буюу 4 хэрэг Хүдэр сумын нутагт, 2,6 хувь буюу 2 хэрэг Бугант тосгонд, тус тус бүртгэгдсэн байна.



Сэлэнгэ аймагт гэмт хэрэг үйлдэхдээ ашиглаж байгаа багаж хэрэгслээр нь авч үзэхэд эксковатор, скруббер, том оврын ачааны машин ашиглан үйлдэж байна.

Дүгнэлт

1.Сэлэнгэ аймагт энэ төрлийн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үүрэг хүлээсэн төрийн байгууллага гомдол, мэдээлэл гаргаж байгаа орон нутгийн иргэдээс 10 хувь, цагдаагийн алба хаагчдаас 51 хувиар бага гомдол, мэдээлэл гаргасан байна.

Мөрдөгч, прокурор нартай хийсэн ярилцлагаас үзэхэд, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх үүрэг хүлээсэн төрийн болон олон нийтийн байгууллагын алба хаагчид хамтран ажиллах талаар идэвх санаачилгагүй байдал тогтоогдов.

2.Хууль бус уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой нийт бүртгэгдсэн гэмт хэрэгт 51 хувиас дээш хувьд нь хохирогчоор байгаль орчны байцаагчийг Засаг даргын захирамжаар томилж байгаа нь байдлаас дүгнэж үзэхэд:

- Байгаль орчны байцаагч гэсэн албан тушаалтан нь тухайн ажиллаж байгаа орон нутгийн нутгийн өөрөө удирдах байгууллага болон төрийг төлөөлөх бүрэн эрхтэй эсэх, орон нутаг, төрийг төлөөлж энэ төрлийн гэмт хэрэг, зөрчил үйлдсэн иргэн, хуулийн этгээдээс учруулсан хохирлыг нэхэмжлэх эрхийг хуулиар олгоогүй атал хохирогчоор тогтоож байгаа буруу жишиг тогтсон байна.
- Хууль бус уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой орон нутгийн төрийн байгууллагын албан тушаалтан хамтран оролцсон хэрэгт хохирогчоор хэнийг тогтоох эрх зүйн нарийн зохицуулалт байгаа тул холбогдох хуульд энэ зохицуулалтыг нарийн тусгах шаардлагатай байна.

3.Судалгаанд Сэлэнгэ аймгийн хэмжээнд хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох нийт хаасан хэрэг бүртгэлийн хэргийн 70 хувь нь тусгай зөвшөөрөлгүй, 30 хувь нь тусгай зөвшөөрөлтэйгөөр ашигт малтмал хайх, ашиглах, олборлох үйл ажиллагаа явуулсан байна. Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйлийн

24.2.1-д “Тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмалын эрэл хайгуул, олборлолт, боловсруулалт, ашиглалт явуулсан бол” гэж энэ төрлийн гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг тодорхойлсон байхад нийт хаасан хэрэг бүртгэлтийн хэргийн 70 хувь нь тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулсан үйлдэл байгаа нь анхаарал татаж байна.

4.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд гэмт хэрэгт хамтран оролцогчдыг тогтоох, үйлдэл холбогдлыг нотлох ажиллагаа хангалтгүй, мөрдөгч, прокурор нь гадны ямар нэгэн нөлөөлөлд автаж, гэмт хэрэгт хамтран оролцогчдыг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх асуудал байна гэж үзэж болохоор байгаа боловч гэмт хэрэгт хамтран оролцогчдын үйлдэл холбогдлыг нэг бүрчлэн тогтооход мөрдөгч, улсын байцаагч нарын ур чадвар дутмаг, үйлдэл холбогдолыг нэг бүрчлэн тогтоох, нотлоход шаардлагатай нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх, тоног төхөөрөмж дутмаг байдал нөлөөлж байна.

Санал

- Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх тодорхой асуудлаар хамтран хяналт шалгалтыг тодорхой газар орон, бүс нутаг, үйлдвэр, аж ахуйн нэгжид явуулж, түүний үр дүнг хэлэлцэж, урьдчилан сэргийлэх ажлыг гадаадын улсын сайн туршлагыг судлан зохион байгуулах.
- Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий алба хаагчдыг сургах, мэргэшүүлэх.
- Уул уурхай, ашигт малтмалын хууль тогтоомжийн хэрэгжилт, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулийн уялдаа холбоо, ял шийтгэлийн бодлогын суурь судалгааг хийж, эрх зүйн орчныг сайжруулах.
- Цагдаагийн байгууллагыг энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд шаардлагатай техник, хэрэгслээр хангах.

Ашигласан материал

- Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох” гэмт хэргийн шүүхийн өмнөх шатны шийдвэрлэлтэд хийсэн дүн шинжилгээ, судалгааны тайлан 2022 он

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГААС ЯВУУЛАХ ЗАРИМ ОБЪЕКТЫН СУДАЛГАА, БОЛОВСРУУЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ

IMPROVING RESEARCH AND PROCESSING OF POLICE FACILITIES

Г.Бямбадорж

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн
тэнхимийн дэд профессор, доктор,
цагдаагийн дэд хурандаа*

Товч агуулга: Цагдаагийн байгууллагаас явуулах объектын судалгаа, боловсруулалтын хүрээнд хариуцсан нутаг дэвсгэрийн онцлог, газар нутгийн хэмжээ, хот төлөвлөлтийн өнөөгийн байдал, газар ашиглалт, сургууль, цэцэрлэг, нийтийн тээврийн хэрэгсэл, инженерийн шугам сүлжээг зэргийг судлах замаар судалгаа боловсруулалтыг сайжруулах боломжтой гэж үзсэн. Түүнчлэн, судлагдаж буй субъектын хувийн байдлыг дэлгэрэнгүй судалж, судалгаа боловсруулалтыг сайжруулах талаар дурдсан.

Abstract: It has been suggested that research can be improved by studying the geographical features, geographical size, current state of urban planning, land use, schools, gardens, public transportation, and engineering networks. It also examined the personality of the subject being studied in detail and discussed improving research and development.

Түлхүүр үг: Цагдаа, объект, субъект, судалгаа, мэдээллийн сан, хувийн байдал, хуулийн этгээд, дэд бүтэц, хөгжил

Keywords: Police, objects, subject, research, database, personality, infrastructure, legal entity, development

Үндсэн хэсэг

Цагдаагийн байгууллагын объектын судалгаанаас үзвэл хариуцсан нутаг дэвсгэрийн ерөнхий байдал газар нутгийн хэмжээ, хот төлөвлөлтийн өнөөгийн байдал, газар ашиглалт, сургууль, цэцэрлэг, зам, нийтийн тээврийн хэрэгсэл, цахилгааны эх үүсвэр, усан хангамж, дулаан хангамж, холбоо сүлжээ, мэдээллийн технологи зэргийг судлаагүй байгаа нь хариуцсан нутаг дэвсгэрийн онцлог, дэд бүтцийг мэдэхгүйгээр гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийг хэрэгжүүлэхэд хүндрэл учирч болох юм. Иймд бид цагдаагийн байгууллагаас хариуцсан нутаг дэвсгэрийн ерөнхий байдал, дэд бүтэц, онцлогийн талаар дор дурдсан чиглэлээр судлаж, объектын судалгаа боловсруулалтыг төгөлдөржүүлэх боломжтой гэж үзэж байна. Үүнд:

1.Нутаг дэвсгэрийн танилцуулга: Нутаг дэвсгэр, засаг захиргааг хэзээ, ямар зорилгоор бий болгосон, засаг захиргаа өөрчлөгдсөн, өөр нутаг дэвсгэрт хамаарч байсан, эсхүл нутаг дэвсгэрийн харъяанаас салж ямар нутаг дэвсгэр засаг захиргаанд нэгдсэн, өнөөгийн засаг захиргааны хэлбэр, газар нутгийн хэмжээ, хязгаар, хүн амын тоо, өрхийн тоо, малын тоо, төрөл бүрийн эмийн ургамал, бут сөөг, мод, жимс жимсгэнэ, нэн ховор ан амьтад, түүх соёлын дурсгалт зүйл бүртгэгдсэн байдал зэргийг тусгана.

2.Хот төлөвлөлт, барилгажилтын одоогийн байдал: Хариуцсан нутаг дэвсгэрийн зам, байшин барилга, өргөжин тэлэх, төсөл хүн амын суурьшилт, нутаг дэвсгэр зохион байгуулалтын одоогийн тогтолцоог бүрдүүлсэн байдал зэргийг тусгана.

3.Орон сууцны хангамж: Нутаг дэвсгэрийн одоогийн орон сууцны хангамжийн судалгаагаар нийт өрхийн хэдэн хувь нь инженерийн бүрэн хангамжтай тохилог сууцанд амьдарч байгаа, хэдэн хувь нь инженерийн бүрэн хангамжгүй сууцад буюу монгол гэрт, ердийн халаалттай сууцанд амьдарч байгаа зэргийг тусгана.

4.Газар ашиглалтын одоогийн байдал: Газар ашиглалтын одоогийн байдлыг иргэдийн хувийн өмчийн, байгууллага байгууламжийн, нийтийн хэрэгцээний, хөдөө аж ахуйн, ус болон усны сан бүхий гэх мэт зориулалт зэргийг тусгана¹¹⁰. Үүнд: Гэр хорооллын бүс, эдэлбэр газартай хувийн орон сууцны бүс, нам давхар орон сууцны бүс, хорооллын худалдаа үйлчилгээ ажил хэргийн бүс, цэцэрлэг, сургуулийн бүс, хөнгөн үйлдвэрийн бүс, соёл, спорт, цэцэрлэг, амралт зугаалга, ногоон байгууламжийн бүс, эрүүл ахуйн хамгаалалтын ногоон байгууламжийн бүс, тусгай зориулалтын бүс, зуслангийн бүс, инженерийн барилга байгууламжийн бүс гэх мэт.

5.Байгалийн тогтоц газар нутаг: Нутаг дэвсгэр нь голын ай сав, уулын эрэг, налуу хосолсон гэх мэт байгалийн тогтоц газрын онцлогийг тусгана.

6.Ерөнхий боловсролын сургууль: Нутаг дэвсгэрийн ерөнхий боловсролын сургуулийн тоо, багш ажилтан алба хаагчдын тоо, сурагчдын тоо гэх мэт. Ерөнхий боловсролын сургуулийн барилга зориулалтын эсхүл зориулалтын бус барилга эсэх, хэд хэчнээн хүүхэд хичээллэх хүчин чадал, хичээллэх ээлж, хичээл эхлэх, тарах цагууд зэргийг тусгана.

7.Цэцэрлэг: Нутаг дэвсгэрийн төрийн өмчийн, хувийн өмчийн хэд хэчнээн болох барилгын нийт хүчин чадал, хүүхдийн тоо, цэцэрлэгийн насны огт цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа хүүхдийн тоо.

8.Авто зам, нийтийн тээврийн одоогийн байдал: Нутаг дэвсгэрийн авто зам, гүүр ашиглалтад орсон он, авто замыг өргөтгөл шинэчлэлийн ажил хийгдсэн байдал, явган хүний зам, дугуйн зам байгаа эсэх, гэрэлтүүлэгтэй эсэх, далан, хөвөө зэргийн өргөн, хатуу хучилттай, сайжруулсан, шороон зам хаана хэдэн км хаашаа хүрч очдог, замын ус зайлуулах төмөр бетон хоолой хэд хэчнээн болох. Нийтийн тээврийн хэрэгслийн автобусны буудал, их болон бага оврын автобусны чиглэл ажил, амралтын өдөр хэдэн удаа үйлчилгээ үзүүлдэг зэргийг тусгана.

9.Дулаан хангамж: Дулаан хангамжийн объектын байршил, хэмжээ, хамгаалалтын хашаа, харуулын байр, барилга байгууламж, бусад онцлог зүйлүүдийг тусгах.

10.Усан хангамж: Усны эх үүсвэр усан сан, хамгаалалтын хашаа, харуулын байр, барилга байгууламж, айл өрхийг усаар хангадаг систем, зөөврийн болон гүний худаг байршил, тоо зэргийг тусгах.

11.Цахилгаан хангамж: Нийт станцуудын насжилт, шинэчлэх солих шаардлагатай станц, тэдгээрийн хүчин чадал, айл өрх, байгууллагуудын цахилгаанаар хангагдсан байдал зэргийг тусгана.

12.Холбоо мэдээллийн сүлжээ: Мэдээлэл, холбоо, сүлжээний байгууламж станц, сүлжээнд холбогдсон байдал, үүрэн болон суурин телефон хэрэглэгч, интернет үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагууд зэргийг тусгана.

13.Эдийн засгийн салбар: Нутаг дэвсгэрийн ерөнхий ба хэсэгчилсэн төлөвлөгөөний хот төлөвлөлт, хот, сум, баг, хороог хөгжүүлэх салбар, тэргүүлэх чиглэл, тухайлбал, эрчимжсэн мал аж ахуй (сүүний чиглэлийн фермер), байгалийн аялал жуулчлал, ахмад, хүүхдийн сувилал, хүүхдийн зуслан, амралт зугаалга, хүлэмжийн аж ахуй (хүнсний ногоо, жимс, жимсгэнэ) салбар зэргийг тусгана.

Дээрх асуудлыг судалснаар хот, тосгон, сум хорооны эдийн засаг, нийгмийн хөгжлийн төлөвлөлт, хот байгуулалтын бодлогын харилцан уялдаа, хөгжлийн бодлого, эдийн засаг, нийгмийн хөгжлийн тэргүүлэх чиглэл, харилцан хамаарал, төлөвлөлт хөрөнгө оруулалтын тогтолцоог бүрдүүлж, нийгмийн ямар үйлчилгээг аль

¹¹⁰ Газрын мэргэжлийн байгууллага «Геоботаник» ХХК газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө 2016-2030

судалгааны тайлан.-УБ., 16 дахь тал.

хот, тосгодоод шилжүүлж хэрхэн хөгжүүлэх төлөвлөлт, хөрөнгө оруулалтын талаар, нийслэл, дүүргийн засаг дарга, иргэдийн хурал бусад үүрэгтэй нэгжийн оновчтой бодлого боловсруулж хэрэгжүүлэхэд ач холбогдолтой.

Аж ахуйн нэгж байгууллагын судалгааг авч үзвэл тухайн судалгаанд хуулийн этгээдийн нэр, хэзээнээс үйл ажиллагаа явуулж эхэлсэн, үйл ажиллагааны чиглэл, хяналтын камерын тоо, харуул хамгаалалтын хэлбэр, тусгай зөвшөөрлийн дугаар, хаяг байршил, эдийн засгийн чадахи, ажилчдын тоо зэргийг багтаасан судалгааны агуулгыг өргөжүүлж аж ахуйн нэгж байгууллагын судалгааг эрх бүхий байгууллага (улсын бүртгэлийн байгууллага) явуулах үед дараах асуулт загварын дагуу судалгаа явуулах бөгөөд энэ чиглэлээр цагдаагийн алба хаагч илүү мэдээлэлтэйн хувьд зөвлөх боломжтой гэж үзэж байна.Үүнд:

- Аж ахуйн нэгж байгууллагын нэр;
- Үйл ажиллагааны чиглэл;
- Улсын бүртгэлийн дугаар;
- Тусгай зөвшөөрлийн дугаар;
- Тухайн объектын байршил;
- Объекттой холбогдох шугам, хоолой, хонгил;
- Тухайн объект гэмт халдлагад өртөж болох эмзэг цэгүүд хэдэн цонх хаалга, шал, хана, тааз, дээвэр гэх мэт;
- Барилгын шал, хана, тааз, дээвэр, тагт, хоолой шугам, хаалга нь ямар материалаар хийгдсэн;
- Ажилчдын тоо;
- Аж ахуйн нэгж байгууллагын доторх схем зураг;
- Аж ахуйн нэгж байгууллагын барилга байшингийн ерөнхий зураг төсөл;
- Ажилчдын дунд гэмт хэрэг, зөрчилд холбогдсон хүмүүсийн тоо бүртгэл гэх мэтийг судлаж аж ахуйн нэгж байгууллагын судалгааг боловсронгуй болгох.

Үүнээс гадна аж ахуйн нэгж байгууллагын объект руу хүрч очих, хэдэн гол болон туслах, нуугдмал зам хэд хэчнээн байгаа, шаардлагатай үед хамгийн ойр байгаа цагдаагийн газар, хэлтэс, тасаг, хэсэг хэдэн км зайд байгааг зэргийг тусгаж нөхцөл байдал хүндэрсэн үед гүйцэтгэх ажлын төлөвлөгөө боловсруулж, батлуулан гэмт халдлага үйлдэгдсэн үед гарах замыг хаах, бүслэх, гэмт этгээдийг баривчлах ажиллагааг хэрэгжүүлэх замаар объектын судалгааг ашиглах боломжийг нэмэгдүүлж болно.Тухайн нутаг дэвсгэрт үйлдэгдээд эзэн холбогдогч нь тогтоогдоогүй хэргийн судалгааг боловсронгуй болгох зорилгоор тухайн судалгааны агуулыг нэмэгдүүлж гэмт хэрэг үйлдэгдсэн цаг хугацаа, гэмт хэрэг үйлдэгдсэн арга (цохисон, алгасан, хатгасан, хутгалсан, түлсэн, хазсан, булаасан, хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, хаалга, цонх, дээвэр, тагтаар нэвтэрсэн, цонх хаалга хөшссөн, эвдэлсэн, түлхүүр тааруулсан) гэм мэт мөн уг судалгаанд гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан зэвсэг хэрэгсэл зэргийг тусгаж энэхүү судалгааг ашиглан гэмт хэрэг илрүүлэх боломжийг нэмэгдүүлж болно¹¹¹.

Мөн хороо хариуцсан хэсгийн байцаагч нар хэргийн газар очиж үйлдэгдсэн хэргийн халдлагын зүйл, гэмт хэрэг үйлдэгдсэн арга зэргийг судлаж эзэн холбогдогч тогтоогдоогүй хэргийн судалгааг хийж байгаа боловч ажил үүргийн шаардлагаар хэргийн газарт очиж ажиллах боломжгүй үед тухайн үйлдэгдсэн гэмт хэргийн халдлагын зүйл, аргыг судлаж чадахгүйд хүрч байгаа учир хэргийн газрын үзлэгийн баг эзэн холбогдогч нь тогтоогдоогүй хэргийн халдлагын зүйл, үйлдлийн аргыг тогтоож хариуцсан хэсгийн байцаагчид мэдэгдэж ажилснаар энэхүү судалгаа боловсруулалтыг сайжруулж болно.

Гарсан гэмт хэрэг түүний шалтгаан нөхцлийн талаарх судалгааг боловсронгуй болгох үүднээс хэсгийн байцаагч нар эрүү хэв журмын нөхцөл байдлын судалгааг тухайн хороонд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн тоо, халдлагын зүйл, холбогдох хуулийн зүйл заалт, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдсэн газар, цаг хугацаа, гэмт

¹¹¹ Гэмт явдалтай тэмцэх асуудал онол, арга зүйн сэтгүүл.-УБ.,2020 №1. 102 дэх тал

хэрэг зөрчлийн өсөлт бууралт зэрэгт товч дүн шинжилгээ хийх явдлын шалтгаан нөхцлийг ерөнхий байдлаар тодорхойлохоос татгалзуулах шаардлагатай.

Гэмт хэрэг үйлдэгдсэн шалтгаан нөхцөлийг тогтоохдоо өнгөрсөнд байнга дурдаж ирсэн нийтлэг нөхцөл байдал болох «ажилгүйдэл», «ядуурал», «архидалт», «нийгмийн өөрчлөлт» гэх «ерөнхий, тодорхой бус» нийтлэг хүчин зүйлийг дурдахаас татгалзах бодлого баримталж, судалгааны тодорхой арга, арга зүйг практик үйл ажиллагаатай хослуулах шаардлага үүсч буйг сүүлийн үед хийгдсэн судалгааны үр дүн харуулж байна¹¹². Иймд гэмт хэргийн шалтгаан нөхцлийн талаарх судалгаа хийхдээ гэмт хэргийн шалтгаан нөхцлийг нийгэм, эдийн засгийн бүтэц, тухайн газар, нутаг, улс орны газар зүйн байршил, хүн ам зүй, хотын төвлөрөл, нийгмийн халамж, түүний хүртээмж, эрүүл мэнд, боловсрол, хууль зүйн дэд бүтэц гэх мэт асуудалтай холбон судлах шаардлагатай¹¹³. Ийнхүү судалгаанд гэмт хэрэг үйлдэгдсэн арга, гэмт хэрэг зөрчлийн нягтаршил, гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгдэж буй хэсэг, хүн ам, тээврийн хэрэгслийн өсөлт бууралт, хотжилт болон бусад нийгмийн хүчин зүйлтэй холбож үзсэнээр гэмт хэргийн шалтгаан нөхцлийн талаарх судалгаа бодитой гарч энэ төрлийн судалгааны ач холбогдол нь нэмдэгдэх болно.

Монгол Улсын гавъяат хуульч, хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор С.Жанцан бие хүнийг судлахад тодорхой зураглал, дараалал шаардлагатай болдог¹¹⁴ хэмээн үзэж бие хүнийг судлах схемийг авч үзсэнтэй бид санал нэгдэж субъектын судалгааг боловсронгуй болгох, түүнийг ашиглан гэмт хэрэгтэй тэмцэх ажлын үр нөлөөг дээшлүүлэхийн тулд хэсгийн байцаагч нар субъектын судалгаанд дор дурдсан зүйлийг заавал судлах замаар боловсронгуй болгож болох юм гэж бид үзэж байна. Үүнд:

Ерөнхий мэдээлэл: Судалгаанд авагдсан этгээдийн хувийн дэлгэрэнгүй мэдээллийг олж аваад зогсохгүй, хэний гэрт, хэн хэнтэйгээ амьдардаг, хаана ямар ажил эрхэлдэг, одоо ямар хаягт оршин сууж байгаа, холбоо барих утасны дугаар зэргийг мэдэж авсанаар гэр бүлийн болон хамтран амьдарч байгаа хүмүүсийн дотор гэмт хэрэг үйлдэж байсан, ял шийтгэгдсэн хүмүүс байгаа эсэх, гэмт этгээдийг баривчлах ажиллагааны төлөвлөгөө, зураглал боловсруулах, сэжигтэй этгээдийн оршин сууж байгаа хаягыг тодорхойлох, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр албадан ирүүлэхээр даалгасан, эсхүл эрэн сурвалжлагдаж байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан түүнчлэн гэмт хэрэг үйлдсэнд сэрдэгдэж байгаа гэх үндэслэл байгаа эсэх, согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэгцэд нөлөөт бодис хэрэглэсэн, химийн хорт бодист хордсоны улмаас өөрийн үйлдлийг удирдан жолоодох чадваргүй болсон хүний нэр, хаягийг тогтоох зэрэг үйл ажиллагаа явуулахад ач холбогдолтой.

1.Биеийн онцлог: Аман зураг гаргаж, тодорхой этгээдүүдийг сэжиглэн баривчилсан тохиолдолд гэрч, хохирогчоор таниулах процессын ажиллагаа явуулах, анх удаа эрэн сурвалжлагдаж байгаа болон оргон зугтсан этгээдийн дүр төрхийг тодорхойлон бичиж эрэн сурвалжлах ажиллагааг зохион байгуулах, хүний дүр төрхийн шинж тэмдгийг эрүүгийн процессын үед хаана ч адил утгаар ойлгож, хэрэглэхэд ач холбогдолтой байдаг. Мөн хэрэгт холбоотой гэрэл зураг дээрх хүнийг бие хүн болон зурагтай адилтгаж, нэг хүн мөн эсэхийг тогтоох, дүрс бичлэгийг оношлох, хүн, зурагтай адилтгах шинжилгээ. Хэрэгт холбоотой дүрс бичлэг дээрх хүнийг бие хүн, дүрс бичлэг болон зурагтай адилтгаж, нэг хүн мөн эсэхийг тогтоох. Мөн оношлогооны шинжилгээгээр хүний анатоми, үйл хөдлөлийн шинжийг тогтоох зэрэг ач холбогдолтой¹¹⁵. Түүнчлэн судалгаанд байгаа этгээдийн буруу зуршил юу болох, буруу зуршлийн улмаас үйлдэж болзошгүй гэмт хэрэг энэхүү буруу зуршил нь амьдралын хэв маяг, өдөр тутмын үйл ажиллагаанд нөлөөлж байгаа эсэхийг

¹¹² Оюунболд, Г. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга зүй. -Уб., 2017. 7 дахь тал.

¹¹³ Агапов, А.Ф. Криминологи (Учебник для вузов). –М., 2011. С.124.

¹¹⁴ Жанцан, С. Хууль зүйн сэтгэл судлал. -Уб., 2005. 147 дахь тал.

¹¹⁵ Бат-Эрдэнэ, Б., Баясгаланбат, Н., Лхагвасүрэн, Б. Криминалистик. –Уб., 2013. 77 дахь тал.

тогтоохоос гадна тухайн этгээдийн амьдралд сүүлийн үед гарсан өөрчлөлт нь гэмт хэрэгтэй холбоотой байж болох таамаглал дэвшүүлэх, тухайн этгээдийн хувийн байдлыг тогтооход ач холбогдолтой.

2.Гэр бүлийн байдал: Судалгаанд байгаа этгээдийн гэр бүлийн харьцаа, гэр бүлийн харилцаанд хэн нь давуу эрх эдэлдэг, гэр бүлийн харилцааны тогтвортой, тогтворгүй байдал зэргийг судалснаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг үйлдэх шалтгаан, нөхцлийг тогтооход ач холбогдолтой.

3.Мэргэжил: Судалгаанд авагдсан этгээдийн эзэмшсэн үндсэн мэргэжил ямар болох, мэргэжил нь өмнө эрхэлж байсан ажилтай холбоотой эсэхийг тогтоох, эзэмшсэн мэргэжил нь (цонх хаалганы үйлдвэрт ажилладаг, тээврийн хэрэгсэл, төмөрлөсөн хаалганы түлхүүр тааруулдаг, хаалга цонхны цоож, сейф онгойлгодог, түлхүүр хийдэг болон бусад салбарын нарийн мэргэжил эзэмшсэн) зэрэг нь гэмт хэрэг үйлдэхэд дөхөм хялбар байгаа эсэхийг тогтооход ач холбогдолтой.

4.Боловсрол: Судалгаанд авагдсан этгээдийн бага, бүрэн бус дунд, бүрэн дунд, бакалавр, магистр, докторын сургалтанд хамрагдсан байдал, төгссөн сургууль зэргийг харгалзан тухайн этгээдийн боловсролын түвшинг тогтоох, аль ямар салбарын мэдлэг эзэмшсэн, шалгаж буй гэмт хэргийг үйлдсэн байж болох таамаглал дэвшүүлэх, мөрдөгчийн хэрэг шалгах түүвэр болон кландарчилсан төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, тухайн этгээдийн хувийн байдлыг бодиттой тогтооход тустай.

5.Хувийн бусад мэдээлэл: Судалгаанд авагдсан этгээдийн өссөн орчин, ахуй амьдрал, ядуу зүдүү, баян чинээлэг, хот суурин, суурингаас алслагдамал, гэр бүл, найз нөхөд бусад орчиндоо нүд үзүүлэгдсэн, байнгын дарамтад байсан, гадуурхагдсан, ганцаардсан, зодуур нүдүүр амссан зэрэг байдал нь тухайн этгээдийн зан төрх, сэтгэл зүйд хэрхэн нөлөөлсөн зэргийг тодорхойлоход тус дөхөм болно.

6.Хувийн зан байдал: Судалгаанд авагдсан этгээд хувь хүний ангиллын хувьд ууртай, уян зөөлөн, хурдан, шуналтай, өөдрөг үзэлтэн, хямсгар, төлөвшөөгүй, ноомой, зан төрхийн хувьд цус ихтэй (сангвиник), салс ихтэй (флегматик), шар цөс ихтэй (холерик), хар цөстэй (меланхолик) эсэх; мөн «пикник» хэв шинжтэй - намхан, эсвэл дунд зэргийн нуруутай, тарган махлагдуу, булчин шөрмөс сул, «атлетик» хэв шинжтэй – өндөр, эсвэл дунд зэргийн нуруутай, булиа, өргөн мөртэй, цээж толгой томтой, нүүрээрээ ясархаг. «диспластик» хэв шинжтэй- биеийн хөгжил, харьцаа муу, зан ааш нь тодорхойгүй эсэхийг тогтоосноор хувийн байдлыг тогтоогоод зогсохгүй, тэдэнтэй холбоотой гэмт хэргийн таамаглал дэвшүүлэн шалгахад дөхөм болно.

7.Ял шийтгэл эдэлсэн байдал: Судалгаанд авагдсан этгээдийн урьд өмнө баривчлагдсан, саатуулагдсан үндэслэл, ял шийтгэгдсэн, хорих ангид хамт ял эдлэж байсан этгээдүүд хэн хэн хаана амьдарч байгаа зэргийг судлан тухайн этгээд ямар гэмт хэрэг үйлдэж болох талаар таамаглал дэвшүүлэх, шалгагдаж байгаа хэрэгт хорих ял хамт эдлэж байсан этгээдүүд хамтран үйлдсэн эсэх, гэмт бүлэг байгуулсан гэмт бүлэгт орсон эсэхийг тогтоовол илүү үр дүнтэй.

8.Гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээлэл: Сэжиглэн шалгаж байгаа гэмт хэргийн үйлдлийн арга, зэвсэг хэрэгслийг судалгаанд авагдсан этгээдийн гэмт хэрэг үйлдсэн арга, зэвсэг хэрэгсэлтэй харьцуулах, судалгаанд авагдсан этгээдүүдийн гэмт хэрэг үйлдсэн арга, зэвсэг хэрэгслийн мэдээллийн сан бий болгож эзэн холбогдогч нь тогтоогдоогүй хэргийн арга, гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан зэвсэг хэрэглэсэн хэрэгтэй адилтган гэмт хэрэг илрүүлэхэд ашиглах боломж бүрдэнэ.¹¹⁶Түүнчлэн, субъектын судалгаа хийхдээ судлагдаж буй этгээдийн сэтгэл зүйн байдлыг гүнзгийрүүлэн тогтоож, сэтгэл зүйн хөргийг тодорхойлсноор субъектын судалгааг боловсронгуй болгох боломжтой. Судалгаанд авах дээрх асуултын дагуу нарийн судалж, бүртгэл судалгааг хөтөлснөөр судалгаанд авагдсан этгээдүүдээс гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, үйлдэгдсэн гэмт хэргийг шуурхай илрүүлэх, гэмт хэргийн илрүүлэлтийн хувийг нэмэгдүүлж болох юм.

Судалгааг дээр дурдсанаар явуулснаар хариуцсан нутаг дэвсгэрт үйлдэгдсэн болон бусад нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийг эзэн холбогдогч нь тогтоогдоогүй гэмт хэргийг түргэн шуурхай илрүүлж, гэмт эдгээдийг цаг алдалгүй баривчлах боломжийг бүрдүүлнэ.

Цагдаагийн байгууллагын «Патрол-2» цахим судалгаа, бүртгэлийн программд оруулж байгаа субъектын судалгааны, тухайлбал, гэмт хэрэг үйлдэж болзошгүй хүмүүсийн судалгаа, гэр бүл орчиндоо тааламжгүй байдал гаргадаг этгээдүүдийн судалгаа, насанд хүрээгүй хүмүүсийг уруу татагчдын зэрэг судалгааг хийхдээ дурдсан асуулттай ижил асуултын хүрээнд судалсан нь учир дутагдалтай байгаа учир дээр дурдсан субъектын судалгааны ерөнхий загварын дагуу судлахаас гадна субъектын судалгааны онцлогоос хамаарч дараах агуулгын хүрээнд судлаж болно. Үүнд:

а) Гэмт хэрэг үйлдэж болзошгүй хүмүүсийн судалгаа. Гэмт хэрэг үйлдэж болзошгүй хүмүүсийн судалгаанд дээрх субъектын судалгааны загвараас гадна дараах мэдээллийг нэмж тодруулбал зохино. Үүнд:

- Өмнө үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийн давтамж;
- Үйлдсэн гэмт хэргийн ангилал, төрөл;
- Үйлдэж болзошгүй гэмт хэрэг гэх мэт.

Судалгаанд авагдсан этгээдийн урьд өмнө үйлдсэн зөрчлийн давтамж, үйлдсэн гэмт хэргийн ангилал, төрөл зэргийг судалснаар тухай этгээд дахин гэмт хэрэг үйлдэх цаг хугацаанд прогноз гаргаж, тухай этгээдийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх боломжтой. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9-р зүйлд заасан **«гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн чиглэлийг хэрэгжүүлж** урьдчилан сэргийлэх арга хэмжээг оновчтой хэрэгжүүлэх» боломжтой. Мөн урьд өмнө ямар төрлийн гэмт хэргийг үйлдэж байсныг судлаж тодруулсанаар тухайн этгээдийн зүгээс ямар төрлийн гэмт хэрэг өдүүлэх гэж байгаа талаар таамаглал дэвшүүлэх, эзэн холбогдогч нь тогтоогдоогүй гэмт хэрэгт холбогдуулан шалгаж, эзэн нь тогтоогдоогүй гэмт хэргийг илрүүлэх, цаашид ямар төрлийн гэмт хэрэгт холбогдож болзошгүй зэргийг тогтооход чухал ач холбогдолтой.

б) Гэр бүл орчиндоо тааламжгүй байдал гаргадаг этгээдүүдийн судалгаа. Гэр бүл орчиндоо тааламжгүй байдал гаргадаг этгээдүүдийн судалгаанд дээр дурдсан субъектын судалгааны загвараас гадна дараах мэдээллийг нэмж тусгавал зохино. Үүнд:

- Гэр бүлийн орчны байдал;
- Гэр бүлийн хамаарал бүхий хүмүүсийн харилцаа;

Гэр бүлийн орчны байдлыг судлах, гэр бүлийн хамаарал бүхий хүмүүсийн харилцааг судлах нь тухайн этгээдийн зүгээс гэр бүлийн орчиндоо ямар шалтгааны улмаас тааламжгүй байдал гаргаж байгаа шалтгаан нөхцлийг тодорхойлж, хөндлөнгөөс нөлөөлж буй шалтгаан нөхцлийг арилгуулах, гэр бүлийн хүчирхийллийн зөрчил үйлдэгдэж болзошгүй эмзэг цэг, бүлгүүдийг тодорхойлох, тэднийг хамтарсан багийн эрсдэлтэй бүлгийн судалгаанд авах, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд эерэг нөлөө үзүүлэх боломжийг бүрдүүлнэ. Үүнээс гадна гэр бүлийн орчиндоо тааламжгүй байдал гаргадаг хүмүүсийг хуулийн дагуу шийтгэхээс илүүтэйгээр тэдгээрийн зан үйлийг засах, нөлөөлөх зэрэг арга хэмжээг хорооны хэсгийн байцаагч, хамтарсан багийн дарга гишүүдтэй хамтран зохион байгуулах ажил арга хэмжээг оновчтой төлөвлөн хэрэгжүүлэхэд энэхүү субъектын судалгаа түлхэц болно.

в) Насанд хүрээгүй хүмүүсийг уруу татагчдын зэрэг судалгаа. Насанд хүрээгүй хүмүүсийг уруу татагчдын зэрэг судалгаанд дээр дурдсан субъектын судалгааны загвараас гадна дараах мэдээллийг нэмж тодруулбал зохино. Үүнд:

- Урьд өмнө насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэрэгт уруу татаж байсан эсэх;
- Насанд хүрээгүй хүмүүсийг ямар төрлийн гэмт хэрэгт уруу татаж байгаа;

- Гэмт хэрэг үйлдэх талаар зааж өгч байгаа эсэх;

Уг хүүхэд сургууль завсардсан, орон гэргүй, тэнэмэл эсэх, тухайн этгээдийн нөлөөнд автагдах шалтгаан, нөхцөл зэргийг судалбал илүү үр дүнтэй болно. Судалгаанд авагдсан этгээдийн урьд өмнө нь насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэрэгт уруу татаж байсан эсэхийг судалснаар тухайн этгээдийн гэмт хэрэг, зөрчлийн талаарх өмнөх түүх, хувийн байдал, уруу татагдаж байгаа хүүхдийг гэмт хэргийн золиос болгон орхих, гэмт хэрэг үйлдэхдээ хүүхэд ашиглаж явдлаас сэргийлэх боломжийг олгох юм. Насанд хүрээгүй хүмүүсийг ямар төрлийн гэмт хэрэгт уруу татаж байгаа, гэмт хэрэг үйлдэх талаар зааж өгч байгаа эсэхийг судалснаар тухайн хүүхэд ямар төрлийн гэмт хэрэг үйлдэх хандлагатай байгаа, гэмт хэрэг үйлдэх арга зүйд суралцан гэмт хэрэгтэн бие хүн болж төлөвшиж байгаа эсэхийг тогтоох ач холбогдолтой.

Түүнчдэн хүүхэд сургууль завсардсан, орон гэргүй, тэнэмэл эсэх, тухайн этгээдийн нөлөөнд автах болсон нь нийгэм, эдийн засаг, сургуулийн орчин, боловсролын түвшин, гэр бүлийн байдал зэргээс шалтгаалсан эсэх зэрэг шалтгаан нөхцлийг тогтоож цагдаагийн байгууллагаас түүнийг арилгах арга хэмжээг авах талаар төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах чиглэлээ тодорхойлж, түүнийг арилгах талаар харилцан ажиллах нөхцлийг бүрдүүлж болно.

Дүгнэлт

Цагдаагийн байгууллагын явуулж буй объектын болон субъектын судалгааг боловсронгуй болгох гарцыг эрэлхийлэх, арга замыг сонгох үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэх иж бүрэн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүний тулд эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, техник, технологийн шинэчлэл хийх, судалгаа боловсруулалтыг төгөлдөржүүлэх, удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах, алба хаагч, мэргэжилтний сургалтыг шинэ агуулгаар баяжуулах зэрэг цогц арга хэмжээг бодлогын хүрээнд авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Түүнчлэн, гэмт хэргийг илрүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зэрэг чиглэлээр объектын болон субъектын судалгааг ашиглах өргөн боломж, гарц, арга замууд байгаа нь харагдаж байгаа бөгөөд Цагдаагийн албаны тухай хууль, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам зэрэгт дээрх боломжуудыг хуульчилсан, байгууллагын дотоод хэм хэмжээ болгон журамласан байна, өөрөөр хэлбэл, дээр дурдсан үйл ажиллагааг эрхлэх эрх зүйн орчин ямар нэгэн хэмжээгээр бүрдсэн гэж дүгнэх боломжтой байна.

Санал

Судалгааны үр дүнд үндэслэн дараах санал дэвшүүлж байна. Үүнд:

1. Практик байгууллагын ажилтнуудад объект, субъектын судалгаа хийх ажилд шинжлэх ухааны ололт амжилт, орчин үеийн техник технологийг нэвтрүүлэх замаар судалгаа боловсуулалтыг төгөлдөржүүлэх;
2. Гадаадын зарим орны цагдаагийн байгууллага объектын болон субъектын судалгаа явуулж буй практикийг судлан эрх зүйн орчноо бүрдүүлсэн байдал, судалгааны арга зүй, удирдлага, зохион байгуулалтын онцлог зэргийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх, нутагшуулах;
3. судалгаа, боловсруулалт хийх ажилд судалгааны нэгдсэн сан бүрдүүлж ашиглах; ШШГЕГ, ОБЕГ, ПЕГ, ШЕЗ, УБЕГ зэрэг төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагын судалгаа бүртгэлийг нэгтгэж нэгдсэн мэдээллийн нэг сантай холбох замаар тэдгээр байгууллагын дүн мэдээг эргэлтэд оруулах, санг байнга баяжуулах нөхцөл бололцоогоор хангах, цагдаагийн төрөл мэргэжлийн албадын жигд оролцоог нэмэгдүүлэх;
4. Объектын болон субъектын судалгааны загварыг өөрчилж, хариуцсан нутаг дэвсгэрийн онцлогт тохирсон өргөн мэдээлэл агуулсан үр дүнтэй шинэ загвар бий болгож, судалгаанд дээр дурьсан агуулыг тусгаж нэг мөр хэрэгжүүлэх;

5. Объектын судалгаа явуулахдаа тухайн объектын талаарх холбогдох лавлагааг холбогдох байгууллагаас авч судалгаа, баяжуулалт хийж эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, мэдээллийн үнэн баттай байдлыг хангаж судалгааг боловсронгуй болгох гэх мэт.

Ашигласан эх сурвалж

- Агапов, А.Ф. Криминологи (Учебник для вузов). М., 2011.
- Жанцан, С. Хууль зүйн сэтгэл судлал. Уб., 2005.
- Бат-Эрдэнэ, Б., Баясгаланбат, Н., Лхагвасүрэн, Б. Криминалистик. Уб., 2013.
- Газрын мэргэжлийн байгууллага «Геоботаник» ХХК газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө 2016-2030 судалгааны тайлан. Уб. 2017.
- Билгээ, Л. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга зүй. Уб., 2005.
- Бямбадорж, Г. Архидан согтуурах явдалтай тэмцэх үйл ажиллагаа. Уб., 2011.
- Бямбадорж, Г. Цагдаагийн байгууллагаас хийх объектын судалгаа. Уб., 2020.
- Дашдэмбэрэл, Ц. Хэсгийн байцаагчийн гарын авлага. Уб., 2012.
- Гэмт явдалтай тэмцэх асуудал» онол, арга зүйн сэтгүүл. Уб., 2020 №1 дугаар
- Оюунболд, Г. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга зүй. Уб., 2017.
- Цагдаагийн алба хаагчийн ёс зүй, үйл ажиллагааны орчин, түүний шинэтгэл сэдэвт судалгааны тайлан. Уб., 2013.
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын гэмт хэргийн статистик» сэдэвт судалгааны тайлан. «Гэмт хэргийн статистикийг боловсронгуй болгох асуудал» шинжлэх ухаан, технологийн төслийн хүрээнд хийсэн судалгааны тайлангийн эмхэтгэл. Уб., 2018.
- ЦЕГ-ын Мэдээллийн технологи, холбооны төвийн танилцуулга. Уб., 2019.
- Баянзүрх дүүргийн гэмт хэрэг зөрчлийн шалтгаан, нөхцөл криминологи судалгааны тайлан. Уб., 2019.

ДОТООДЫН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТҮҮХЭНД ГҮЙЦЭТГЭСЭН ҮҮРЭГ, ТҮҮНИЙ ОНЦЛОГ

IN THE HISTORY OF INTERIOR MILITARY ORGANIZATIONS DUTIES PERFORMED AND ITS CHARACTERISTICS

Т.Хүрэлбаатар

*ДХИС-ийн ЭШНХ-ийн Гэмт явдал, цагдаа судлалын
Хүрээлэнгийн Дотоодын цэрэг судлалын эрдэм*

шинжилгээний ахлах ажилтан-багш,

бригадын генерал

Б.Ариунтөгс

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн

Дотоодын цэргийн албаны тэнхимийн багш,

ахлах дэслэгч

Товч агуулга: Дотоодын цэрэг нь түүхэн хөгжлийнхөө явцад төр засаг, яам, командлалаас даалгасан үүргийг нэр төртэй гүйцэтгэж, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргээ хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд хэрэгжүүлж ирсэн 102 жилийн арвин их түүхтэй төрийн цэргийн байгууллага юм. Энэхүү өгүүлэлд Дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагааны түүхэн үүрэг, онцлогийн талаар товчхон дурдсан.

Abstract: In the course of its historical development, the internal military is a state military organization with a rich history of 102 years, which honorably fulfills the duties assigned by the government, ministries, and command, and carries out its main functions of ensuring the national security of Mongolia within the scope of its mandate provided by law. The article briefly mentions the historical role and features of the internal military organization.

Түлхүүр үг: Дотоодын цэрэг, аюулгүй байдал, бослого, засан тохинуулах, олзлогдсон цэрэг, хорих байр, шорон, гяндан, төрийн хамгаалалт, онц чухал объект, гадуур харуул хамгаалалт, цэргийн хүч.

Key words: Internal military, security, insurgency, corrections, military prisoners, prisons, dungeons, state security, critical objects, external security, military force.

Монгол Улсын Дотоодын цэрэг нь 1922 оны 7 дугаар сарын 16-ны өдөр Ардын Засгийн газар, Бүх цэргийн Зөвлөлийн шийдвэрээр байгуулагджээ. Тус байгууллага нь 1922-1936 онд Дотоодыг хамгаалах газар, 1936-1955 онд Дотоод явдлын яам, 1955-1959 онд Цэргийн ба Нийгмийг аюулаас хамгаалах хэрэг эрхлэх яам, 1959-1990 онд Нийгмийг аюулаас хамгаалах яам, 1990-оноос одоог хүртэл Цагдаагийн ерөнхий газарт тус тус харъяалагдан алба ажиллагаагаа явуулж байна.

Дотоодын цэрэг нь түүхэн хөгжлийнхөө он жилүүдэд төр засаг, яам, командлалаас даалгасан үүргүүдийг гүйцэтгэж байсныг судлан үзэхэд 1985 он хүртэл тухайн анги байгууллагын дарга, захирагчийн тушаалаар батлагдсан заавар, 1985 оноос Нийгмийг аюулаас хамгаалах яамны сайдын тушаалаар батлагдсан “Дотоодын цэргийн алба, байлдааны ажиллагааны заавар”, 1995 оноос “Дотоодын цэргийн тухай” хуулийг тус тус мөрдөж алба, ажиллагаагаа зохион байгуулж байсан бөгөөд дараах үүргүүдийг аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй байгууллагуудын хүч хэрэгсэлтэй хамтран болон дангаар хэрэгжүүлэн ажиллаж байжээ. Үүнд:

Нэг.Улс орны дотоодод гарсан бослого хөдөлгөөнийг дарахад дотоодын цэрэг оролцсон нь

1.1 ХӨВСГӨЛ АЙМАГТ ГАРСАН БОСЛОГЫН ТУХАЙ

Улсын Бага Хурал, Засгийн Газрын 1932 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн хамтарсан онц хуралдаанаар Хөвсгөл аймагт гарсан хувьсгалын эсэргүү бослогын

тухай Дотоодыг хамгаалах газрын дарга Даваагийн Намсрайн илтгэлийг сонсоод уг эсэргүү бослогыг дарах, хор холбогдлыг нь олон нийтэд таниулах тусгай комисс томилж босогчидтой тэмцэх нэгдсэн отряд гаргах, зэвсэг хэрэгслэлээр хангахыг Бүх цэргийн зөвлөлөөс Дотоодыг хамгаалах газарт даалгажээ.

Улсын Бага Хурал, Засгийн Газрын шийдвэрийн дагуу эсэргүү бослогыг дарах Ж.Лхүмбэ даргатай тусгай комисс байгуулагдаж, тусгай хорооноос байлдааны 2 отрядыг гаргажээ.

Тусгай отрядуудын ерөнхий командлагчаар Дотоодыг Хамгаалах Газрын орлогч дарга Цэрэнгийн Гиваапил, отрядын даргаар тусгай хорооны жагсаал ангийн туслах Ядамын Батаа, мөн хорооны бага даргын сургуулийн захирал Далайн Нясалдаг, нарыг томилсон байна.

Я.Батаагийн отряд 1932 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр хүчээ 2 хувааж нэг хэсэг нь Рашаантын хүрээний зүүн хойд чиглэлээс нөгөө хэсэг нь Сандал уулын энгэрээр зүүн өмнө талаас нь давшин орж тэнд үүрлэж байсан Самбуу дүвчин, Жамсрандорж нарын удирдсан 700 гаруй хүнтэй босогчидтой ширүүн тулалдаж дайсны 200 гаруй хүнийг устгаж, мөн 200 шахам хүнийг буулган авч бослогын төв штаб болон “Очирбатын яам”-ны тамга, баримт бичгийг олзлон авчээ.

Рашаантын хүрээний босогчдыг дарсаны дараа Хялганат, Загзуу, Жалханз, Тэсийн хүрээний хэсгүүдэд бөөгнөрсөн босогчдыг бут цохин толгойлогчдын заримыг нь устгаж, заримыг нь баривчилжээ.

Тус отрядын бие бүрэлдэхүүн байлдахын зэрэгцээ нутгийн ардууд, хүрээний лам нарын дунд ухуулга, суртал нэвтрүүлгийн ажил хийж, эзэнгүй орхигдсон эд хөрөнгийг хамгаалан орон нутгийн байгууллагуудад шилжүүлэн өгөх арга хэмжээг зохион байгуулж байв.

Д.Нясалдагийн отряд ихэвчлэн Мөрөнд байрлаж аймаг, сумын төв, сүм хийд хамтралуудыг хамгаалах, ойр хавьд гарсан үймээн самууныг дарах, шаардлагатай үед Я.Батаагийн отрядод туслах, бослого дарагдсан нутагт ухуулгын ажлыг отрядаасаа тусгай бүлэг гарган гүйцэтгэж байв.

Я.Батаа Д.Нясалдаг нарын удирдсан отрядууд олон удаагийн байлдаанд онцгой баатарлаг гавьяа байгуулан амь бие хайргүй тулалдсан юм.

Могойтын голд бүгж байсан “Ээмэгт” хэмээх Дамдинг баривчлуулахаар салааны захирагч Түмэнгийн Дорлиг пулемётын наводчик Г.Чойндон нарын бүрэлдэхүүнтэй бүлгийг явуулжээ.

“Ээмэгт” хэмээх Дамдин сэжиг авч хоёр гартаа буу барин ойртсон хүн бүрийг буудсан байна. Энэ үед Г.Чойндон, байлдагч Бавуу нар хоёр талаас нь зэрэг буудаж устгажээ.

Т.Дорлигийн салаа “Ээмэгт ламын 70-аад хүнээс 25-ыг устгаж 28-ыг нь амьдаар барьсан байна.

Тэр үед зэвсэглэсэн босогчидтой хийх тэмцэл тийм ч хялбар байгаагүй юм.

Тэд дайралдсан бүхнээрээ зэвсэглэсэн орон нутгаа сайн мэддэг учраас ой хөвч, уул, хад асга зэрэг аль бартаа саад бүхий газар хэсэг бүлгээрээ байрлаж байв. Тусгай отрядуудын бүрэлдэхүүн гол төлөв морьтой эсвэл явганаар явж халуун, хүйтэн, өдөр, шөнө, бэрхшээл саадыг үл хайхран эрэлхэг зоригтой, тэсвэр хатуужил сахилга баттай цуцалтгүй байлдаж ялалтад хүрч байв.

Хөвсгөл аймгийн ард иргэдээс “Зэвсэгт бослогыг баатарлагаар дарж устгасан Дотоодыг Хамгаалах Газрын тусгай хорооны дарга цэргүүдэд халуун баяр хүргэе” гэсэн үгтэй улаан туг дурсгасан нь тус хорооны алдрын танхимд одоо хадгалагдаж байгаа билээ.

Намын Төв Хороо, Засгийн Газрын шийдвэрээр Я.Батаа, Д.Нясалдаг нарын удирдсан отрядыг ардын хувьсгалын 11 жилийн ойн баяр наадамд оролцуулах шийдвэр гаргаснаар Хөвсгөлөөс өдөр, шөнөгүй явсаар 1932 оны 7 дугаар сарын 10-ны өдөр Шар хөвийн дөрвөлжид ирэхэд нь Намын Төв Хороо, Засгийн Газар, Дотоодыг Хамгаалах Газрын сайд, дарга нарын 100 гаруй хүн угтан авчээ.

Хувьсгалын эсэргүү хөдөлгөөнийг дарж устгах удаа дараагийн байлдаанд гарамгай байлдаж гавьяа байгуулсан тусгай хорооны жагсаал ангийн туслах Ядамын Батаа, бага даргын сургуулийн захирал Далайн Нясалдаг нарыг Төрийн дээд шагнал Цэргийн гавьяаны улаан тугийн 1 дүгээр зэргийн одонгоор шагнажээ.

1.2 АМАРБУЯНТИЙН ХҮРЭЭНИЙ ЛАМ НАРЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ТУХАЙ

1932 оны эхээр тус хүрээний хамба лам унзад Жамсран, тайж Жалбаа нар одоогийн Баянхонгор аймгийн өмнө талын хэсэг сумын 1500 гаруй айл өрх, 1000 гаруй лам нарыг мал хөрөнгийнх нь хамтаар улсын хил давуулан гадагш гаргахаар бэлтгэж байв.

Энэ хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох үүргийг тусгай хорооны Дэжидийн Бөө захирагчтай салаанд ногдуулжээ. Д.Бөө нь 1935 онд Дотоодыг хамгаалах газрын төв сургуулийн анхны төгсөгч бөгөөд Монгол улсын хилийн заставын анхны дарга нарын нэг юм.

Энэ салаа Улаанбаатараас Баянхонгор аймгийн Баацагаан сум хүртэл машинаар явж тэндээс орон нутгийн 20 гаруй хүнтэй хүч хавсран Баян-Өндөр сумын харъяат Дансран, Жарантай, Өвгөн нараар газарчлуулан сумын төлөөлөгч Далхжавын хамт тэмээн уналгаар гэмт этгээдүүдийг мөрдөн хөөж толгойлогчдыг нь баривчлан авч тэдний эрхшээлд байсан ардуудыг мал хөрөнгийнх нь хамт эргүүлэн буцааж тавигдсан үүргийг амжилттай биелүүлжээ.

Тус салаа үүргээ биелүүлсний дараа Алтай аймгийн хязгаарын ангийн мэдэлд шилжиж харуулын цагдааг өөрчлөн Алагнуур, Захуйн хилийн салбаруудыг байгуулахад үндэс суурь нь болжээ.

Хоёр.Алтайн хязгаарыг тохинуулахад дотоодын цэрэг оролцсон нь:

1933 онд Алтайн хязгаараар хасгийн дээрэмчид үлэмж хүчээр хил нэвтрэн ирж дээрэм тонуул, аллага, тагнуул хийж байсныг дарж устгахаар тусгай хорооны сумангийн дарга Түмэнгийн Дорлигоор удирдуулсан тусгай бүлэг томилогдон ажиллаж 1933 оны 03 дугаар сараас 11 дүгээр сар хүртэл 9 сарын турш баатарлагаар тулалдан хил хязгаарын амгалан тайван байдлыг хангахад зохих үүрэг гүйцэтгэсэн юм.

Байлдааны тушаалыг гарамгай биелүүлсэн Түмэнгийн Дорлиг цэргийн гавьяаны 2 дугаар зэргийн одонгоор шагнуулжээ.

1934 оны 02 дугаар сард Алтай аймгийн Алтай, Цээл, Тамч сумдын хилийн районоор хасгийн дээрэмчид хил зөрчин ирж дээрэм тонуул хийх, ард иргэдийг алан хядах зэргээр түйвээн бусиулж хилийн цагийн байдал нэн түгшүүртэй болов.

Дотоодыг хамгаалах газрын даргын 1934 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн 620 тоот тушаалын 2 дугаар зүйлд: **“Тус газрын тусгай хорооноос ахлах дарга 2, дунд тушаалын дарга 2, мөн хорооны доктор 1, бага дарга, цэргүүд 50-ын хамт бүгд 55 дарга, цэргүүдийг энэ сарын 8-ны өдрөөс эхлэн Алтайд тусгай отрядаар явахыг мэдэгдсүгэй”** хэмээн заажээ.

Дээрх шийдвэрийн дагуу тусгай хорооноос томилогдсон 110 хүний бүрэлдэхүүнтэй отряд нь энэхүү ажиллагааг удирдахаар томилогдсон Дотоодыг хамгаалах газрын Цэргийн ба Хязгаарын хэлтсийн байлдааны ангийн дарга Жанцангийн Намсрайгийн удирдлага дор ажиллаж газар зүйн байрлалыг нарийвчлан судлаж уулын эгзэгтэй газруудыг чадмаг ашиглан давшсаар Бага толь, Шар булагийн орчимд үүрлэсэн 200 гаруй айл өрхтэй 500-аад хүнтэй дээрэмчдийн томоохон бүлэглэлийг хагас цагираг маягаар бүслэн 6 цагийн турш ширүүн тулалдаж 300 шахам дээрэмчдийг устгаж олон тооны хүмүүсийг олзлон авч удирдлагаас өгсөн үүргийг чадварлагаар гүйцэтгэсэн байна.

Энэхүү тулалдаанд тусгай хорооны отрядаас томилогдон ажилласан Завхан аймгийн Жаргалан сумын харъяат байлдагч Пунцагийн Лхамсүрэн, Өвөрхангай аймгийн Богд сумын харъяат байлдагч Гэндэндашийн Дулам, Төв аймгийн харъяат байлдагч Жамбалын Пунцаг нар эх орныхоо төлөө баатарлагаар амь эрсэджээ.

1937 оны 10 дугаар сард Алтайн чиглэлд гоминдан, хасгийн дээрэмчидтай байлдахаар Цэргийн ба Хязгаарын Хэргийг Удирдах Газрын дарга, бригад командлагч захирагч Баянгийн Аравнийсүрэнгийн удирдлага дор Тусгай хорооноос 2 суман цэрэг, 4 хуягт, 20 гаруй автомашинтай явж Бага толь, Захуй, Шарнуурын талд очин Ядамжавын морьт бүлэгтэй нийлж улсын хилээр нэвтрэн ирсэн олон тооны дайсныг хөөн зайлуулж тухайн бүс нутгийн хил орчмын амгалан тайван байдлыг сахиулсан байна.

Гурав.Дорнод хязгаарын хамгаалалтыг бэхжүүлэхэд дотоодын цэрэг оролцсон нь:

1930-аад оны дунд үеэс Японы түрэмгийлэгчид манай улсын зүүн хил хязгаарын цаана үлэмж хэмжээний цэргийн хүч хэрэгсэл хуралдуулж байлдааны ажиллагаанд бэлтгэх, улсын хилийг удаа дараалан зөрчин газар нутгийн маргаан үүсгэж өдөөн хатгах болсон нь дайны аюул заналхийлэл тулж ирсний нэг нотолгоо болж байв.

Монгол Улсын төр засаг энэхүү нөхцөл байдлыг үнэлж Ардын Цэргийн анги, салбаруудыг хилийн ойролцоо байрлуулан байлдааны бэлэн байдалд шилжүүлэх, Дорнод хязгаарын хамгаалалтыг бэхжүүлэх бүх талын арга хэмжээг шуурхайлан авч хэрэгжүүлж байв.

Хилийн отряд, заставт шаардлагатай бага дарга, жолооч зэрэг бага мэргэжилтнүүдийг Дотоодын цэргийн анги, салбаруудад бэлтгэх, зэвсэгт тулгаралт байлдааны ажиллагаанд туршлагажиж, хатуужил тэвчээр суусан Дотоодын цэргийн шилдэг, тэргүүний олон арван дарга, захирагч, улс төр, ар тал хангалтын ажилтнуудыг томилон явуулах зэрэг нь дээрх арга хэмжээний нэг хэсэг байлаа.

Дотоодын цэргээс зүүн хязгаарт томилогдон очсон олон арван офицер, цэрэг дайчид өөрт ноогдсон үүргээ нэр төртэй үлгэр жишээ биелүүлж байсны дотор бага даргын сургууль төгсөгч Пунцагийн Чогдон, Самдангийн Төмөрбаатар нар 1939 оны Халх голын байлдааны үед хилийн застваа удирдан дайсны эсрэг эрэлхэг зоригтой байлдан удаа дараалан баатарлаг гавъяа байгуулсан тул БНМАУ-ын баатар хэмээх эрхэм дээд алдар цолыг хүртсэн байна.

Дөрөв.Өмнөговийн өмнөд зах хязгаарыг тохиулахад дотоодын цэрэг оролцсон нь:

Өмнөговь аймгийн өмнөд хязгаар нутагт 1931-1932 онд цагийн байдал эрс хурцдаж эрх ямба, эд хөрөнгөө хураалгасан зарим этгээдүүд нутгийн олныг хувьсгалын эсэргүү үйл ажиллагаандаа элдвээр уруу татаж хил давуулан нүүлгэх ажиллагааг идэвхтэй явуулж байлаа.

Тэд 1929 онд улс даяар явагдсан феодалын хөрөнгийг хураах ажил, зүүний нугалаа завхарлыг овжин ашиглаж төр, засгийн эсрэг, ард түмнийг уриалан босгохыг эрмэлзэж, зүйл бүрийн арга хэрэглэн зэвсэглэсэн хүчирхийлэл, дээрмийн ажиллагаа явуулж байв.

Тэдний гол толгойлогчид нь Өмнөговийн зарим сүм хийдийн нөлөө бүхий хутагт хувилгаад болох "Ганжуурваа" Цэнддоо, "Очирдарь" Түвдэн, "Ширээт лам Жамъяндорж нар байжээ.

1931 оны зун, 1932 оны хавар "Алаг" Намнан, Дэлэгсамба, бөө Гончиг, Нуухын шар нараар удирдуулсан эсэргүү хөдөлгөөн Булган, Аргалант, Хүрмэн, Жавхлант зэрэг 12 суманд гарч ард олныг гадаадад жанчих, буу тулган нүүлгэх цуурхлыг хүчтэй явуулж ухуулга, ятгалганд ороогүй хүн ардыг зодож сүрдүүлэх аргыг хэрэглэж хүчээр гэр орныг нь буулгаж, мал хөрөнгийг нь дээрэмдэж байв.

Эсэргүү хүчнийхэн нутгийн ард иргэдийн төөрөгдсөн хэсгээс бүрдсэн зэвсэгт бүлгүүдийг байгуулж, орон нутгийн сумын захиргаа, сургууль, дэлгүүр, хоршоо зэрэг албан байгууллагуудад довтлон алба хаагчид, нам, эвлэлийн гишүүдийг баривчлах, алах, тарчилаан зовоох, барилга байшин, эд хогшил, мал хөрөнгийг галдан шатаах,

дээрэмдэх зэргээр хэрцгий догшиноор түйвээн, ард нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулж самуун дэгдээж байв.

Монгол Ард Хувьсгалт Намын Төв Хороо, Засгийн Газар энэ байдалд дүгнэлт хийж хил хязгаарын ард иргэдийн амгалан тайван байдлыг хангахын тулд дээрх балмад үйл ажиллагааг таслан зогсоох үүргийг Дотоодыг Хамгаалах Газарт өгчээ. Дотоодыг хамгаалах газрын даргын 1932 оны нэгэн тушаалд **"Дотоодыг Хамгаалах Газрын тусгай хорооноос зэвсэг бүхий нэгэн салааг дээрэмчдийг дарж устгахаар томилсугай"** гэжээ.

Дотоодыг хамгаалах газрын даргын энэхүү үүргийг биелүүлэхийн тулд тусгай хорооноос салааны захирагч Халзангийн Чансаа суртлын сургагч Лувсангийн Надмид нараар удирдуулсан дарга, цэрэг 40 хүнтэй бүлгийг Өмнөговь аймаг дахь хэлтэстээ хүч нэмэгдүүлэн явуулсан байна.

Тус бүлэг зарим сумын захиргаа хоршоо, хамтралыг дээрэмдэн, шатааж Өлзийт, Жавхлант зэрэг 3 сумын 700 гаруй өрх айлыг гадаадад нүүлгэхээр хүчээр хөдөлгөж явсан Дэлэгсэмбэ, Гомбодорж, Дагдан нараар толгойлуулсан дээрэмчдийн хүчинд автагдсан ард олныг салгаж авахаар Мөнх-Овоо сумын нутаг Хардэл хэмээх газар зам тосож 1932 оны 2 дугаар сарын 13-ны өдөр анх тулгарч байлджээ.

Энэ байлдаан 3 өдөр үргэлжилж дайсны 40 гаруй хүнийг устгаж, олон айл өрхийг хөрөнгө, малын хамт тэднээс салган авчээ.

Мөн одоогийн Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын нутаг Толийн булаг гэдэг газар цугларан "Шарын цэрэг"-ээр хамгаалуулан хил давахаар явж байсан олон айлуудыг Дотоодыг хамгаалах газрын Тогоочоор удирдуулсан цэргүүд урьдчилан мэдэж ардын цэргийн Гончигдорж даргатай бүлэгтэй хүч хавсран 1932 оны 02 дугаар сарын 16-ны үдэш байлдааны зохиомол үйл ажиллагаа явуулах аргаар тэднийг сандралд оруулж улмаар 400 гаруй өрх айлыг гадагш гаргалгүй буцаасан байна.

Энэ байлдааны үеэр Өмнөговь аймгийн Дотоодыг хамгаалах ангийн төлөөлөгч Намнангийн Чоймбол, хилийн харуулын цагдаа Борын Цэдэв, тусгай хорооны салааны захирагчийн орлогч, бага дарга Амбаа нар дээрэмчдийг мөрдөж яваад Толийн хяр хэмээх газар нуугдаж байсан дайсанд баригдан элдвээр байцаалган тамлуулж, буудуулан эх орон, ард түмэндээ өргөсөн тангарагтаа үнэнчээр амь үрэгдсэн юм.

Оргодол, дээрэмчдийг богино хугацаанд дарж устгахын тулд тусгай хорооноос нэмэгдэл хүч болгож сумангийн дарга Сэрээтэр, улс төрийн удирдагч Бадамын Намдаг, салааны захирагч Далайн Нясалдаг нараар удирдуулсан 34 хүний бүрэлдэхүүнтэй тусгай бүлэг сар гауй хугацаанд жинхэнэ байлдааны ёсоор явж хязгаар нутагт амгалан тайван байдлыг тогтооход оролцсон билээ.

Дээрх дурдсан бүлгүүдэд явж үүргээ нэр төртэй амжилттай биелүүлсэн салааны захирагч Халзангийн Чансаа, суртлын сургагч Лувсангийн Надмид нарыг байлдааны гар буугаар, сумангийн дарга Сэрээтэр, улс төрийн удирдагч Бадамын Намдаг, салааны захирагч Далайн Нясалдаг, пулемётын наводчик Чойбат, байлдагч Сүрэнхорлоо, Базарсад, Ванчиг, Лувсандаш, Бат, Галсан, Намсрайноров нарыг цагаар, бусад хүмүүсийг мөнгө, үнэ бүхий зүйлээр шагнажээ.

Тав.Цэргийн олзлогсоодыг дотоодын цэрэг хамгаалсан нь:

Японы эсрэг 1945 онд явуулсан дайнд манай орны улс ардын аж ахуйд тухайн үеийн ханшаар 200 гаруй сая төгрөгийн гарз хохирол учирсан юм.

Дайны уршаар сүйдсэн болон саатсан улс ардын аж ахуйг сэргээхэд Японы цэргийн олзлогдогсдын хүчийг ашиглахаар Сайд нарын зөвлөлийн 1945 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 75 дугаар хурлын тогтоолоор шийдвэрлэж Дотоод явдлын яамны сайдын 1945 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 428 тоот тушаалаар Японы цэргийн олзлогдогсод болох 12318 хүнийг хот, хөдөөгийн 38 объектод тараан байрлуулж Дотоодын цэргийн хамгаалалтад шилжүүлжээ.

Ийнхүү “Цэргийн олзлогдогсдын дэглэмийн тухай” Женевийн 1929 оны конвенцийг Дотоодын цэрэг эх орондоо амжилттай хэрэгжүүлсэн нь Ази тивд анхдагч болсон юм.

Засгийн газрын шийдвэрээр 1947 оны 10 дугаар сард Японы олзлогсодыг нутаг буцаах шийдвэр гарч Дотоодын цэргээс томилогдсон бүрэлдэхүүн тэднийг Зөвлөлт Холбоот Улсын төмөр замын Наушка өртөөнд хуяглан хүргэх үүргийг амжилттай хэрэгжүүлжээ.

Зургаа.Хорих байр, шорон, гянданг дотоодын цэрэг хамгаалсан нь:

Дотоодын Цэрэг байгуулагдсан цагаасаа эхлэн хэрэгтэн, ялтанг харгалзах, шорон, гянданг хамгаалах үүргийг гүйцэтгэж ирсэн бөгөөд 1950-иад оны эхэн үе хүртэл гол төлөв Дотоод явдлын яамны хорих байр, төв хорихыг хамгаалж байжээ.

1947-1953 онд Төв хорих, Цагаанхуаран, Амгалан, Хужирбулан, Налайх, Махкомбинат, Зүүнхараагийн зэрэг хорих лагериудын 50 гаруй объектыг өдөр бүр 148 постоор хамгаалж байв.

Хүн хүч хүрэлцэхгүй байсан тул 1949 онд Хүүхдийн колони, Салын рам, Үдлэг, Баянгол, Ерөө зэрэг 9 салбарыг, 1950 онд Рашаант, Цагаан-Эрэг, Зүүнхараагийн салбаруудыг тус тус татан буулгажээ.

1960-аад оны дунд үеэс манай Төр засгаас хууль ёсыг улам чангатгах, нийгэмд харш үйлдэл, үзэгдэл бүрийг илрүүлэн хуулийн хариуцлага хүлээлгэж хэрэгтэн этгээдийг хөдөлмөрөөр засан хүмүүжүүлэх, ажлын үр нөлөөг дээшлүүлэх бодлого шийдвэр гаргасантай уялдуулан гяндан, онцгой, чанга дэглэмтэй хорих лагериудыг Дотоодын цэргээр хамгаалуулахаар шийдвэрлэжээ.

Монгол ардын Хувьсгалт Намын Төв Хорооны Улс төрийн товчооны 1966 оны 341 дүгээр тогтоолоор урьдчилан хорих төв буюу төв шорон, Нийгмийг Аюулаас Хамгаалах Яамны сайдын 1967 оны 12 дугаар 17 ны өдрийн тушаалаар Хар айраг дахь хорих анги, Авдрант дахь хорих анги, мөн сайдын 1979 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 515 тоот тушаалаар Баянзүрх дэхь хорих анги, Сайд нарын зөвлөлийн 1982 оны 87 дугаар тогтоолоор Зүүнхараа дахь хорих анги, Сайд нарын зөвлөлийн 1984 оны 51 дүгээр тогтоолын дагуу Нийгмийг Аюулас Хамгаалах Яамны сайдын мөн оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 407 тоот тушаалаар Дүүрэн дэхь хорих анги, Сайд нарын зөвлөлийн 1985 оны 301 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж Нийгмийг Аюулаас Хамгаалах Яамны сайдын 1986 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн А/5 тоот тушаалаар Багануур дахь, Дарьт дахь гяндан онцгой болон чанга дэглэмтэй хорих ангиудын гадуур харуул хамгаалалтыг хариуцан гүйцэтгэж байв.

Монгол Улсын Засгийн Газрын 2002 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 155 дугаар тогтоолын дагуу Дотоодын цэргийн хамгаалалтад байсан гяндан, онцгой, чанга дэглэмтэй хорих ангиудын гадуур харуул хамгаалалтыг Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газарт шилжүүлэн өгсөн юм.

Дотоодын Цэрэг түүхэн хөгжлийнхөө он жилүүдийн 55 жилд нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай нягт хамтран ажиллаж гяндан, онцгой, чанга дэглэмтэй хорих ангиудын гадуур харуул хамгаалалтыг хариуцан гүйцэтгэж хорих ангиудад тогтоосон дэглэм журмыг сахиулан ажилласан байна.

Долоо.Төр засгийн удирдагчдыг дотоодын цэрэг хамгаалсан нь:

Дотоод Явдлын Яамны сайдын 1941 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 750 дугаар тушаалаар маршал Х.Чойбалсангийн Их тэнгэр дэх өвлийн байрыг хамгаалах шинэ үүргийг Дотоодын цэрэгт хүлээлгэжээ.

Маршал Х.Чойбалсангийн Их тэнгэр дэхь өвлийн байрыг хамгаалах дээрх үүргийг биелүүлэх суманг тусгай хороонд байгуулж сумангийн захирагчаар Сономын Дорж, улс төрийн удирдагчаар Лувсандорж, салааны захирагчаар Цэдэн-Ишийн Бат-Очир, Лодойн Цэдэндорж, Дондогийн Доржсүрэн нарыг анх томилжээ.

Тус суман маршал Х.Чойбалсангийн өвлийн байрны хамгаалалтыг Цагдан сэргийлэхийн буурал хэмээх н.Дамба даргатай харуулаас хүлээн авсч төр, засгийн удирдагчдын аюулгүй байдлыг сахин хамгаалах үүргийг хэрэгжүүлж эхэлсэн байна.

Дотоод явдлын яамны сайдын 1946 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн 526 тоот тушаалаар Ерөнхий сайд, Улсын Бага Хурлын Төлөөлөгчдийн дарга, Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга нарын ажлын байр /Засгийн газрын ордон/, гэр орон, Баянгол дахь зуслан зэрэг объектууд, Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хороо, Улс Төрийн Товчооны 1954 оны 51/306 дугаар тогтоол, Дотоод явдлын яамны сайдын 1954 оны 913 тоот тушаалаар Х.Чойбалсангийн бунхан, Ерөнхий сайдын өвөл, зуны өргөө, Их тэнгэрийн аман дахь зочдын байр, Багатэнгэрийн аман дахь хүнсний лаборатори, Цэргийн ба Нийгмийг аюулаас хамгаалах хэрэг эрхлэх яамны сайдын 1957 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 711 тоот тушаалаар Төрийн ёслол хүндэтгэлийн үүрэг /энэ үүргийг 1959 оны 7 дугаар сар хүртэл гүйцэтгэсэн/ 1962 онд Их тэнгэрийн аман дахь Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хороо, Засгийн газрын 50-ын 3 дугаар зочид байрын

хамгаалалтыг Дотоодын цэргийн хамгаалалтад шилжүүлж, мөн манай оронд айлчлан ирж байгаа гадаад орны төр засгийн тэргүүн, өндөр дээд хэмжээний хүндэт зочид, төлөөлөгчдийн байрлаж байгаа байр, хөлөглөж яваа онгоц, галт тэрэг, автомашиныг нь хамгаалах үүргийг даалгасан байна.

Улсын онц чухал объект болох дээрх объектуудын гадуурх хамгаалалтыг Дотоодын цэргийн байгууллага нь 1941 оноос Монгол Улсын их Хурлаар "Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль" батлагдан хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Засгийн газрын 1995 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 127 дугаар тогтоолоор Төрийн тусгай хамгаалалтын газар шилжүүлжээ. Монгол төрийн тусгай хамгаалалтын нэн хариуцлагатай зарим чиг үүргийг 54 жилийн хугацаанд хэрэгжүүлэн ажиллаж иржээ.

Найм. Улсын үйлдвэр, албан газрын дотоодын цэрэг хамгаалсан нь:

Монгол Улсын Үндсэн хууль 1960 онд шинэчлэн батлагдав. Үндсэн хуулийн хэрэгжилтийг хангахын хүрээнд манай орны хөгжил, цэцэглэлтэд үнэтэй хувь нэмэр болох эдийн засгийн онцгой ач холбогдол бүхий уул уурхай, цахилгаан станц, үйлдвэр завод олноор байгуулагдаж эхлэв.

Шинээр байгуулагдсан үйлдвэр завод, албан газруудыг Дотоодын цэргийн хамгаалалтад шилжүүлэх Төр засгийн шийдвэр гарч улс орны хөгжил цэцэглэлт, бүтээн байгуулалтад Дотоодын цэргийн гүйцэтгэх үүрэг өсөн нэмэгдсэн байна.

Үүнтэй уялдуулан Нийгмийг аюулаас хамгаалах яамны сайдын 1961 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 403 тоот тушаалаар 1 дүгээр цахилгаан станц, Сайд нарын зөвлөлийн 1974 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 147 дугаар тогтоолыг үндэслэн Нийгмийг Аюулаас Хамгаалах Яамны сайдын мөн оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 469 тоот тушаалаар Сэлэнгэ аймгийн Бугант дахь/албан баримт бичигт Толгойт гэнэ/ алтны үйлдвэр, Сайд нарын зөвлөлийн 1978 оны 439 дүгээр тогтоолоор Дархан хотын болон 3 дугаар цахилгаан станц, Дорнод аймгийн Чойбалсан хотын цахилгаан станц, Сайд нарын зөвлөлийн 1978 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн 223 дугаар тогтоолыг үндэслэн Нийгмийг Аюулаас Хамгаалах Яамны сайдын мөн оны 8 дугаар сарын 19-ний өдрийн 569 тоот тушаалаар Эрдэнэт Уулын Баяжуулах Үйлдвэр, Сайд нарын зөвлөлийн 1983 оны 35 дугаар тогтоолын дагуу 4 дүгээр цахилгаан станцын хамгаалалтыг хүлээн авч хариуцан гүйцэтгэсэн байна.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1979 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 259 дүгээр тогтоолоор Дотоодын цэргийн орон тоон дээр хугацаат цэргийн албан хаагчдыг татан авч Улсын цагдан сэргийлэх ерөнхий газрын харъяанд ажилуулж Нийслэл Улаанбаатар хотод нийгмийн дэг журам сахиулах үүргийг гүйцэтгүүлж байсан нь цаашид Цагдаагийн байгууллагын хүч хэрэгсэл хүрэлцэхгүй үед Дотоодын цэргийг гэмт хэргийг таслан зогсоох, нийгмийн хэв журмыг сахиулахад оролцуулах чиг үүргийг хэрэгжүүлэх эхлэл тавигджээ.

Манай оронд цагаан морин жилд буюу 1990 онд өрнөсөн ардчилсан хувьсгалын үр дүнгээр Төр засгийн байгууллагуудын бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт орж БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1990 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 192 дугаар тогтоолоор “БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх Улсын цагдан сэргийлэх ерөнхий газар”-ыг байгуулахад түүний бүтцэд Дотоодын цэрэг шилжиж урьдын адил “Улсын онц чухал объект болох” Их тэнгэр дэхь цогцолбор Төр засгийн тэргүүн нарын орон байр, Дулааны цахилгаан станцууд, Гяндан, онцгой чанга дэглэмтэй хорих ангиуд, Урьдчилан цагдан хорих төв зэрэг объектуудын хамгаалалтыг хугацаат цэргийн албан хаагчдын хүчээр гүйцэтгэж байлаа.

Улсын Их хурлаар 1992 онд шинэ “Үндсэн хууль” батлагдав. Үндсэн хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн шинэчлэлийн ажлын хүрээнд 1995 онд “Дотоодын цэргийн тухай хууль” батлагдаж түүхэнд анх удаа дотоодын цэргийн үйл ажиллагааны зарчим, гүйцэтгэх чиг үүрэг, алба хаагчийн эрх зүйн үндэс хуульчлан баталгаажжээ.

1995 онд батлагдсан дээрх хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсэгт, Улсын Их хурлаар 2017 онд шинэчлэн баталсан “Дотоодын цэргийн тухай хууль”-ийн 5-р зүйлийн 5.1.4-т “Дотоодын цэргийн хамгаалалтад байх Улсын онц чухал объектын жагсаалт”-ыг Засгийн газар батална гэж тус тус заажээ.

Хуулийн энэхүү заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор Дотоодын цэргийн хамгаалалтад байх Улсын онц чухал объектуудын жагсаалтыг Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 135 дугаар тогтоол, 2017 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 281 дүгээр тогтоолоор батлуулан мөрдөж байна.

Засгийн газрын тогтоолд заасны дагуу Монголын Үндэсний Радио Телевизийн хэрэг эрхлэх газар, эфирийн студи, МОНЦАМЭ агентлаг, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Чойбалсан, Ховд, Даланзадгад хотын төвлөрсөн усан сан, өргөх байгууламж, Ховд, Говь-Алтай аймаг дахь усан цахилгаан станц, Баян-Өлгий аймаг дахь Цагаан нуурын чөлөөт бүс, Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэр, Стандарт хэмжилзүйн Үндэсний төв, цагийн эталон, ИЗОТОП төв, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн төв лаборатори, Халдварт өвчин судлалын Үндэсний төвийн төв лаборатори, Биокомбинат, ЗООНОЗ төв, Өмнөговь аймгийн Цагаан хад суурьшлийн бүс, Улаанбаатар хотын II, III, IV дүгээр дулааны цахилгаан станцууд зэрэг улс орны нийгэм, эдийн засгийн нэн чухал ач холбогдол бүхий объектуудыг хамгаалж, аюулгүй байдлын үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудтай нягт харилцан ажиллагаатайгаар ханган ажиллаж байна.

Дүгнэлт

Дотоодын цэргийн байгууллагын түүхэн хөгжлийн хугацаанд гүйцэтгэсэн үүргүүдийг судалж дүгнэхэд:

1.Ардын хувьсгалын эхний жилүүдэд улс орны дотоод аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх үүрэгтэй цэргийн хүчийг шинээр байгуулан бэхжүүлсэн байна.

2.Шинэ тутам байгуулагдсан цэргийн хүч нь 1922-1940-өөд он хүртэл чухал албан газар, байгууллагуудыг манах, алслагдсан нутаг хошуудад нууц бичиг баримтыг хүргэх, хоригдогсодыг цагдан манах, хуяглан хүргэх, улс орны дотоодод гарсан бослого, хөдөлгөөнийг дарж устгахад оролцох, хувьсгалын ололтыг хамгаалан бэхжүүлэх, хил хязгаарыг хүч нэмэгдүүлэн хамгаалах зэрэг үүргүүдийг гүйцэтгэж байснаас үзэхэд аюулгүй байдлыг хангах цэргийн шинжийг агуулсан төрөл цэрэг бий болсон гэж үзэхээр байна.

3.1940-1990 он хүртэл Төр засгийн ордон, Төр засгийн тэргүүн нарын орон байр, гадаад орноос манай оронд айлчилж байгаа Төр засгийн тэргүүн, дээд өндөр хэмжээний зочид төлөөлөгчдийн хөлөглөж яваа нисэх онгоц, галт тэрэг, бусад унаа хөсөг, Төрийн ёслолын хүндэт харуулын үүрэг, шинэ тутам байгуулагдсан үйлдвэр завод, цэргийн олзлогсод, хорих ангиудын гадуур хамгаалалт, нийслэл Улаанбаатар хотод нийгмийн хэв журам сахиулах эргүүлийн үүргийг гүйцэтгэсэн байдлаас үзэхэд Төрийн торгон цэргийн зарим үүргийг биелүүлсэн байна.

4.Монгол Улсын Цагдаагийн байгууллагатай нэгэн удирдлага дор өдөр тутам хамтран ажиллаж Монгол Улсын Засгийн газраас тогтоосон Улсын онц чухал объектуудыг хамгаалах, гэмт хэргийг таслан зогсоох, нийгмийн хэв журмыг сахиулахад дэмжлэг үзүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох, зорчигч ачаа тээшийг тээврийн замд харгалзан хүргэх, объектыг түр хугацаагаар хамгаалах, террорист үйлдлийн тусгай ажиллагаанд оролцох, хуулиар хүлээлгэсэн бусад чиг үүргүүдийг хэрэгжүүлж байгаа Дотоодын цэргийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасны дагуу “Үндэсний аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн цэргийн байгууллага” болон хөгжсөн байна.

Санал

Дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөлт, уул уурхай, ашигт малтмалын хууль бус олборлолт, орчны бохирдолтын уршгаар экологи, эдийн засгийн тэнцвэрт байдал алдагдаж хүн амьтны гоц халдварт өвчин, хүн амын ядуурал, интернет орчны зохисгүй хэрэглээнээс үүдэлтэй цахим гэмт хэрэг ,халдлага нэмэгдэж байгаа өнөө цаг үед Дотоодын цэргийн байгууллагын бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгон төгөлдөржүүлж, алба хаагчдын хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлэх, албаны мэдлэг, ур чадвар, дадлагыг дээшлүүлэхэд чиглэгдсэн ажлыг үе шаттай зохион байгуулан явуулах зорилгоор **“Дотоодын цэргийн хөгжлийн хөтөлбөр”**-ийг тусгайлан боловсруулж Төр засгийн түвшинд батлуулан мөрдүүлэх.

Ашигласан материал

- Ч.Хасдорж “Хос Одонт тусгай хорооны түүх” 1967
- Дотоодын цэрэг сэтгүүл 2012 оны 10 дугаар хэвлэл
- Дотоодын цэргийн түүх 2022
- Тагнуулын ерөнхий газар тэргүүн дэвтэр 2012
- Т.Хүрэлбаатар “Зорилтыг хэрэгжүүлэх зарим асуудал” 2006
- А.Дунбурай “Монгол Төрийн цагдаагийн уламжлал түүхэн хөгжил” 1999
- Б.Пүрэв “Монгол улсын Засгийн газрын дэргэдэх Цагдаагийн байгууллага” 2016 он
- Я.Лувсанцэрэн “Одонт хороо минь” 2012 он
- М.Ганболд, Г.Хүүжий “ Тусгай хороог эргэн дурсахуй” 2012 он
- НАХБ-ын түүхэнд холбогдох баримт бичгийн эмхэтгэл (1922-1960). УБ., 1971
- Т.Хүрэлбаатар. Хувийн архивийн задгай материалууд

ЭРДЭМТЭН, СУДЛААЧДЫН ҮЗЭЛ БОДОЛ

FRAMEWORK OF THE EUROPEAN DATA PROTECTION LAW

Namsrai Battulga

Ph.D. student at University of Pecs, Hungary

Abstract: Personal data protection policy is defined as granting individuals a right to control the nature, content, and circulation of information. However, data storage and protection structures vary from country to country. For the European Union, this policy is moving forward more steadily.

Keywords: public record, personal consent, unduplicated data.

Data is an intangible asset, and social interaction consists of data fusion and information-based decision-making. Thus technological advances are accelerating community, institutional, and personal data proactive in the long run.

If personal information was mainly owned by the state, but today, the freedom¹¹⁷ of using, and sharing personal data with others is enhanced as well. With the reference to countries, they are not limiting the aforementioned freedom as much as possible but follow the policy of improving the legal framework.

The process has advanced over the last 40 years, with the United Nations and the Organization for Economic co-operation and development issuing guidelines on personal data privacy, storage, and data flow since 1981. According to the data privacy, ethics, and protection guidance note on big data for achievement of the 2030 agenda:

Data access, analysis, or other use must be consistent with the United Nations Charter and in furtherance of the sustainable development Goals. Whether directly or through a contract with a third-party data provider, data should be obtained, collected, analyzed, or otherwise used through lawful, legitimate, and fair means.

“In particular, data access (or collection, where applicable), analysis or other use should be in compliance with applicable acts, including data privacy and data protection laws, as well as the highest standards of confidentiality and moral and ethical conduct. Legally binding agreements outlining parameters for data access and handling (e.g. data security, data formats, data transmission, fusion, analysis, validation, storage, retention, re-use, licensing, etc.) should be established to ensure reliable and secure access to data provided by third-party collaborators.” (*Data privacy, ethics and protection guidance note on big data for achievement of the 2030 agenda*, sec.3)

As regards the European Union first adopted the data protection directive in 1989, and also updated it in 2016, gradually releasing rules aimed at ensuring the confidentiality of data related to credit information, public records, and e-commerce databases, and prohibiting illegal use. “The goals of the EU Directive on Data protection are to facilitate the free flow of data throughout the European Union while ensuring a high level of protection of the rights of data subjects. Besides giving individuals the right to prevent the use of their personal data for direct marketing purposes, the directive also provides the right to access and correct personal information. The directive imposes very strict rules regarding sensitive information such as ethnic and racial origin, political and religious beliefs, union membership, sexual orientation, and health.” (*Mark J. Smith and others, European law*, p.698)


¹¹⁷ Personal rights are guaranteed by national constitutions and the European Convention on Human Rights, and, on the other hand, the fundamental freedoms are enshrined in the EC Treaty. In addition, the conflict between private law and fundamental rights arises because of the perceived tension between party autonomy, on the one hand, that is, the right of any private person to choose which transaction to conclude, with whom, and on what terms—and, on the other hand, the limitations on this that the various fundamental rights could impose. “See details”, Kristian Twigg-Flesner, *A key features of European Union Private law*, p.10

The legal framework for data protection consists of directives as well as other regulations. It includes:

- Directive 95/46/EC defined principles on data-processing such as whether they must, whatever the nationality or residence of natural persons, respect their fundamental rights and freedoms, notably the right to privacy.
- Directive 2000/31/EC of the European Parliament aims at improving the functioning of the internal market with respect to online commerce. Directives contain the regulation concerning the data requirements of service providers as well.
- European Commission Regulation 330/2010 defines records data processing, submitting data breach notifications or data protection impact assessments, and has notably extended obligations regarding the handling of data subjects' requests.
- General Data Protection Regulation (2016/679) and the Law Enforcement Directive (2016/680) with a set of harmonized rules applicable to the design, development, and use of certain high-risk AI systems and restrictions on certain uses of remote biometric identification systems.

Furthermore, European Commission declares a country "data protection safe" because of GDPR. It protects the personal privacy rights of EU residents and businesses. In other words, it makes organizations accountable for personal data protection. This includes having security measures in place to guard against data breaches and taking quick action to notify individuals and authorities in the event a breach does occur. This platform gives the opportunity to holistically reassess all the data.¹¹⁸

In Europe, driven by the increasing awareness of data risks and threats, the global Cyber security market has witnessed robust growth over the last years with revenue increased. Revenue is expected to show an annual growth rate of 12.54 percent, resulting in a market volume of 73.3 billion USD by 2027. (<https://www.statista.com/outlook/tmo/cybersecurity/europe#revenue>)



With the improvement of the legal framework of data protection, business and information, communication, and electronic operators in the economic bloc of the European Union have a wide opportunity to collect and analyze any data and diversify customer services.

Under the Common European Sales law, digital content is often supplied not in exchange for a price but in combination with separate paid goods or services, involving a non-monetary consideration such as giving access to personal data or free of charge in the context of a marketing strategy based on the expectation that the consumer will purchase additional or more sophisticated digital content products at a later stage.¹¹⁹

¹¹⁸ "See details", Aleksandra Danielewickz, Ensuring GDPR compliance can boost your business, 2021

¹¹⁹ The buyer may only claim damages for loss or damage caused to the buyer's property, including hardware, software, and data, by the lack of conformity of the supplied digital content, except for any gain of which the buyer has been deprived by that damage. "See details", Regulation of the European Parliament and of the Council on a Common European Sales law, 2011/0282, Art.107

Namely, a business entity creates a customer database to organize its services quickly. This database includes the user's name, age, gender, home address, contact email, phone number, and account number. Some institutions, such as banks and insurance, law enforcement¹²⁰, security companies, create a fund by taking unduplicated customer information such as fingerprints.

The right to store this information is granted by the user to the business owner, and on the other hand, the contracting party undertakes not to disclose the information and to use it only for the user. In terms of general legal regulations, parties to the contract are prohibited from transmitting information on behalf of others in any form.

The legal framework of the European Union has a wide range of regulations, including fair access to data, use for mutually agreed purposes, and deletion once the purpose has been met. The data protection framework consists of information encryption, data transfer and cross-border data flow control, and data protection impact assessment.

"According to EU constitution policy, article 49 requires transparency of the proceedings of Union Institutions whereas article 50 protects personal data." (*Jürgen Schwarze, Enlargement, the European Constitution, and Administrative Law*, p.980)

The EU member states are responsible for appointing independent organizations and officials¹²¹ to monitor the activities of knowing, accessing, correcting, and deleting information, and guaranteeing the rights of the data owner in accordance with domestic laws.¹²²

As regard, the requirements are to process the data only on the grounds and to the extent stipulated by the law, or according to the consent given by the data owner, to stop the data collection immediately if it is refused, to check the accuracy and completeness of the data, and to monitor the requirements.

While member states adhere to the principles of data protection, the traditional regulations on limiting the use, collection, and exchange of data for the purpose of ensuring national security, as well as keeping government activities open to the public and officials' incomes, remain in the former platform.¹²³ Also, without violating the rights and legal interests of others, taking into account their demands and needs, in order to support the economy and business, develop research and analysis work, and increase the transparency and availability of information, the form of general overview can be made open data.

Conclusion

Part of this century's fastest-growing virtual social interaction is the process of collecting, handling, using, and securing data with the help of hardware and software. Biometric information such as fingerprints, face, voice recognition, genetics, communication, wealth, income, religion, beliefs, sexual orientation, and other personal information of a person, except for ensuring national and public security¹²⁴ should be unassailable.

¹²⁰ All remote biometric identification systems are considered high risk and subject to strict requirements. Such use is subject to authorization by a judicial or other independent body and to appropriate limits in time, geographic reach and the databases searched. "See details", EU Commission Proposal for Artificial intelligence act and amending certain union legislative acts. 2.1. 2021/0106

¹²¹ Data access should be limited to authorized personnel, based on the "need-to-know" principle. Personnel should undergo regular and systematic data privacy and data security trainings. Prior to data use, vulnerabilities of the security system (including data storage, way of transfer, etc.) should be assessed. "See details", Data privacy, ethics and protection guidance note on big data for achievement of the 2030 agenda, UN

¹²² An example, the Italian Parliament passed legislation on data protection, with a new law implementing the EU Directive on Data Protection. In some respects, this law is stricter than the EU Directive. In Particular, the owner of the data has various duties regarding notification, obtaining consent, and ensuring data confidentiality. Criminal and civil sanctions apply to breaches of this law. "See details", Mark J. Smith and others, *European law*, p.703

¹²³ As of today, 110 countries in the world have data protection laws. In addition, about 30 countries are making efforts to adopt this type of law. "See details", *National comprehensive data protection/privacy laws and bills*.

¹²⁴ Also, the confidentiality of trade data will have to be assessed in light of newer legal avenues for access to such data for law enforcement, and anti-terrorism initiatives. "See details", Hal Burman, *Private International Law*, p.754

The legal framework is not just about data protection. Moreover, the choice of data sharing is an individual right. If the information is collected with personal consent, it shall be used to provide information that is useful to a person in accordance with a contract.

This principle is a vital interest of the regulation, not only in the European Union but also worldwide. In any form, the data receiver must obtain permission from the data owner to process, collect, and use the data, as well as report on the legality and security of these transactions and activities, including government oversight. The form of control should not only be legislation but flexible management and organizational policies and regulations should be implemented.

Within the framework of this policy, European Union directions and regulations are aimed at preventing illegal data collection, monitoring and evaluating integrity, and confidentiality. And the availability of information systems used for data collection, processing, and use, developing measures to be taken in the event of data loss, and limiting the use of data, and procedures. Those instructions are being adopted to delete information and make it impossible to identify the owner of the information.

Along with this extensive process, there will undoubtedly be steps to increase and diversify legal responsibilities on how to promptly investigate and resolve any complaints related to data collection, processing, and use at the European Union and member state level. In short, they are closely looking at the current situation while developing future policies.

REFERENCES

- Aleksandra Danielewickz, Ensuring GDPR compliance can boost your business, 2021
Data privacy, ethics and protection guidance note on big data for achievement of the 2030 agenda, UN, 2017
Directive 2000/31/EC
Directive 95/46/EC
EU Commission Proposal for Artificial intelligence act and amending certain union legislative acts. 2021/0106
European Commission Regulation 330/2010
General Data Protection Regulation 2016/679
Hal Burman, Private International Law, 2009
Jürgen Schwarze, *Enlargement, the European Constitution, and Administrative Law*, 2004, The International and Comparative Law, Vol. 53
Kristian Twigg-Flesner, A key features of European Union Private Law, 2014
Mark J. Smith and others, European law, 1999
National comprehensive data protection/privacy laws and bills, 2019
Regulation of the European Parliament and of the Council on a Common European Sales law, 2011/0282
The Law Enforcement Directive 2016/680

ТАНЫ СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙН МЭДЛЭГТ: СУДАЛГААНЫ ТАЙЛАН БИЧИХЭД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

KNOWLEDGE OF YOUR RESEARCH METHODOLOGY: SOME ISSUES TO CONSIDER WHEN WRITING A RESEARCH REPORT

Д.Батцэцэг

ДХИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Нийгмийн ухааны тэнхимийн эрхлэгч, цагдаагийн хошууч

Товч агуулга: Ихэнх судалгааны бүтээлд судалгааны тайлан бичихэд тавигдах шаардлагуудын талаар дурдсан байдгаас тайланг бичихэд ямар явц, дарааллаар хэрхэн бичих талаар тэр бүр дурдаагүй байдаг. Гэтэл тайлангийн бичилтийн явц зөв, буруу байсан эсэхээс хамааран судалгааны үр дүн, ач холбогдлын талаарх үнэн зөв, бодит мэдээлэл, хандлага олон нийтийн дунд бий болох нөхцөл бүрддэг. Цаашлаад судалгааны үр дүнг практикт нэвтрүүлэх боломж нь ч тайлан зөв бичигдсэнтэй холбоотой байдаг. Иймээс энэхүү өгүүллээрээ эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж буй хэн бүхэнд судалгааны тайланг хэрхэн зөв бичих талаарх мэдлэг, мэдээллийг дамжуулахыг зорилоо.

Abstract: Although the requirements for writing a research report are mentioned in most research papers, the process and sequence of writing a report are not always clearly stated. Depending on whether the report is written correctly or incorrectly, the truth, factual information, and attitudes about the survey results and the significance of the research can be rightly or wrongly understood by the public. Furthermore, the possibility of applying research results in practice is directly related to the correct writing of the report. Therefore, with this article, we have aimed to provide knowledge and information on how to correctly write a research report to everyone doing academic and research work.

Түлхүүр үгс: Судалгаа, тайлан, тайлан бичих үйл явц

Keywords: Research, report, writing process for report

Судалгааны ажлыг хэрхэн зохион байгуулсан талаараа дэлгэрэнгүй тайлбарлах, үр дүнг мэдээлэх нь судалгааны үйл явцын хамгийн сүүлийн чухал алхам юм. Судалгааны ажлын үр дүнг мэдээлэх үйл явц бичвэр тайлан хэлбэртэй байдаг. Энэ үйл ажиллагааны эргэх холбооны хэм хэмжээ нь судалгааг хэрхэн зохион байгуулсан болон үр дүнг олон нийтэд бүрэн хүргэж мэдээлснээр тодорхойлогддог.

Социологичид, “Судалгааны тайлан гэдэг нь уг судалгаагаар шийдвэрлэх асуудал, зорилт, таамаглал, судалгааны онол, арга зүй, аргачлалын үндэс, судалгаанаас гарсан баримт, түүнд хийсэн дүгнэлт, саналыг эмхлэн нэгтгэж, судалгааны онол практикийн ач холбогдол, үр дүнг иж бүрнээр нь илтгэсэн эрдэм шинжилгээний өвөрмөц бүтээл мөн”¹²⁵ гэж тодорхойлсон байдаг.

Тайлан бичих болсон шалтгаанууд: Судалгааг гүйцэтгэх үе шатыг дуусгасны дараа судалгааны тайлангаар дамжуулан үр дүнг олон нийтэд мэдээлэх үе шат эхэлнэ. Та шинжлэх ухаан, техникийн бичиглэлийн хэлбэрийг судалж суралцах, олон янзын нийтлэлүүдийг унших явцдаа судалгааны тайлан бичих талаар ихийг мэдэж болно.

Судалгааны ажлын тайлан гэдэг нь судалгааны ажлын арга барил, үр дүнг бусдад мэдээлэх бичмэл баримт бичиг (эсвэл бичгийн баримтад үндэслэсэн аман илтгэл) юм. Энэ нь судалгааны ажлын хураангуй биш, харин судалгааны үйл явцын дэлгэрэнгүй тэмдэглэл юм.

¹²⁵ Социологийн судалгааны арга зүй, аргачлал. Монгол улсын Шинжлэх ухааны академи. Философийн хүрээлэн. Социологи, нийгмийн сэтгэл зүйн салбар. УБ., 2021. 372 дахь тал

Та судалгаа хийхдээ тайлангаа урьдчилан бодож, бүртгэлээ сайтар хөтлөх ёстой. Судалгааны үр дүнгээс гадна тайланд судалгааг эхлүүлэх болсон шалтгаан, үйл явцын үе шат, өгөгдлийн танилцуулга, өгөгдөл нь судалгааны асуулт эсвэл сэдэвтэй хэрхэн холбогдож буй талаарх хэлэлцүүлгийг багтаасан байна.

Тайлан нь судлаач та юу хийж, юу олж мэдсэнээ бусдад дамжуулах үйл ажиллагаа буюу олж авсан мэдлэгээ түгээх арга зам юм.

Тайлан бичих бусад шалтгаанууд нь анги, ажлын даалгавраа биелүүлэх, судалгааг захиалсан байгууллагын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, асуудлын тодорхой хэсгийг шийдвэрлүүлэхэд мэргэжлийн багийг ятгах, олж авсан үр дүнг олон нийтэд мэдээлэх зэрэг болно.

Тайлан бичих үйл явц¹²⁶:

Таны үзэгч - Мэргэжлийн зохиогчид хэнд зориулж бичиж байгаагаа үргэлж мэдэж байх ёстой гэж хэлдэг. Учир нь тайлангийн бичлэг нь тодорхой үзэгчдэд тохирсон байх үед хамгийн үр дүнтэй байдаг. Анхан шатны сонсогч нь багш, оюутнууд, мэргэжлийн нийгэм судлаачид, дадлагажигчид эсвэл олон нийт байгаа эсэхээс хамаарч судалгааны тайлангаа өөр өөрөөр бичих хэрэгтэй. Бичлэг нь ямар тайлбар хийхгүйгээр тодорхой, үнэн зөв, сайн зохион байгуулалттай байх ёстой гэдгийг хэлэх нь зүйтэй.

Зааварлагчид олон шалтгааны улмаас тайланг хэрхэн бичих талаар шаардлага тавьж болно. Ерөнхийдөө зааварлагчид нь ойлгомжтой, логик сэтгэлгээг тусгасан байдал, зохион байгуулалтыг бичвэрээс харахыг хүсдэг. Оюутны илтгэл нь үндсэн болон арга зүйн үзэл баримтлалыг сайтар хангасан байх ёстой. Үүнийг хийх хамгийн сайн арга бол шаардлагатай үед тодорхой нэр томъёог ашиглах явдал юм; тэдгээрийг хэт их эсвэл буруугаар ашиглаж болохгүй.

Оюутнуудад зориулж бичихдээ техникийн нэр томъёог тодорхойлж, тайлангийн хэсэг бүрийг шошголох хэрэгтэй. Хэлэлцүүлгийг тодорхой олон жишээн дээр логик, алхам алхмаар үргэлжлүүлэх ёстой. Судалгааны ажлын тодорхой алхмуудыг хэрхэн, яагаад гүйцэтгэсэн тухайгаа энгийн үгээр тайлбарла. Нэг стратеги нь судалгааны асуултаас эхэлж, дараа нь тайланг хариулт болгон зохион байгуулах явдал юм.

Эрдэмтэд техникийн нэр томъёоны тодорхойлолт эсвэл яагаад стандарт аргачлалыг (жишээ нь, санамсаргүй түүвэрлэлт) ашигласан тухай тайлбарыг оруулах шаардлагагүй гэж үздэг. Судалгаанд онолыг хэрхэн ахиулах талаарх мэдээлэл болон өмнөх олдворууд /хоёрдогч мэдээлэл/ хамгийн чухал байдаг. Тэд таныг хэрхэн өгөгдөл цуглуулж, хувьсагчдыг хэмжиж, өгөгдөлд дүн шинжилгээ хийсэн зэрэгт анхаарлаа хандуулдаг.

Дадлагажигчид танаас судалгааг хэрхэн хийсэн тухай товч хураангуй, үр дүнг хэд хэдэн энгийн графикаар харуулахыг илүүд үздэг. Тэд судалгааны загвар, хэмжилт, мэдээлэл цуглуулалт, хоёрдогч мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг төдийлөн сонирхдоггүй.

Олон нийтэд зориулж бичихдээ та энгийн үг хэллэг хэрэглэж, тодорхой жишээнүүдийг гаргаж, өнөөгийн нийгмийн тулгамдсан асуудлын практик үр дагаварт анхаарлаа хандуулах шаардлагатай. Судалгааны загвар, үр дүнгийн дэлгэрэнгүй мэдээллийг бүү оруул, олон нийтэд зориулж бичихдээ гомдол гаргахаас болгоомжил. Олон нийтэд мэдээлэх нь мэргэжлийн бус хүмүүст олон нийтийн асуудлын талаар илүү сайн дүгнэлт хийхэд тусалдаг чухал үйлчилгээ юм.

Загвар ба өнгө аяс - Судалгааны тайланг тодорхой өнгө аястай, нарийн хүрээний хэв маягаар бичдэг. Тайлангийн зорилго нь судалгааны арга, үр дүнг тодорхой, шууд, шударгаар хүргэхэд оршино.

Загвар гэдэг нь бичигчийн сонгосон үгийн төрөл, түүнийг ашигласан өгүүлбэр, догол мөрний урт, хэлбэрийг хэлнэ. Өнгө аяс гэдэг нь бичигчийн тухайн сэдэвт хандах хандлага юм. Жишээлбэл, албан бус, харилцан ярианы хэв маяг (жишээ нь,

¹²⁶ Lawrence W.N. Social research methods: Qualitative and Quantitative approaches. 2014. p. 515

ярианы үг, хэлц үг, улиг үг, бүрэн бус өгүүлбэр), хувийн өнгө аяс (жишээ нь, эдгээр нь миний мэдрэмж) нь дотны найздаа захидал бичихэд тохиромжтой боловч судалгааны тайланд тохирохгүй. Судалгааны тайлангийн хэв маяг нь албан ёсны бөгөөд товч (цөөн үгээр, олон зүйлийг хэлэх) байх ёстой. Өнгө аяс нь тухайн сэдвээс тодорхой зайг илэрхийлдэг; Энэ бол мэргэжлийн бөгөөд чухал зүйл юм. Зөвхөн онцгой тохиолдолд л судлаачид албан бус хэв маяг, хувийн өнгө аястай бичлэгийн хэлбэрийг ашиглаж болно. Ёс суртахуунлаг, уран цэцэн үг хэллэгээс зайлсхийх хэрэгтэй. Учир нь, тайлангийн үндсэн зорилго нь мэдээлэл өгөх болохоос ямар нэг албан тушаал, ёс суртахуун, чөлөөт цагийг сурталчлах биш юм.

Судалгааны тайлан нь бодитой, үнэн зөв, ойлгомжтой байх ёстой. Дэлгэрэнгүй мэдээллийг (жишээ нь, ишлэл дэх хуудасны лавлагаа) шалгаж, дахин шалгаж, судалгааг хэрхэн явуулсан талаар бүрэн тодруулна уу. Тайланг уншигчид бичилтийн явцад гарсан хайхрамжгүй байдлыг олж мэдвэл судалгаанд эргэлзээж магадгүй юм.

Тодорхой бичих хамгийн зөв арга зам бол судалгааны асуудал, дизайныг сайтар бодож үзэх, нэр томъёог зөв тодорхойлох, товч өгүүлбэрээр бичих, дүгнэлтийг нотлох баримтаар нотлох, хязгаарлах явдал юм.

Санаа бодлыг удирдах - Бичлэг нь ид шидээр бүтдэггүй, эсвэл үзэг цаас (эсвэл хуруугаараа компьютерийн товчлуурт хүрэхэд) нийлүүлэхэд хүнээс зүгээр л урсдаг зүйл биш. Харин хичээл зүтгэл шаарддаг шаргуу ажил бөгөөд дараалсан алхмуудыг дагаж эцсийн үр дүнд хүргэдэг. Судалгааны тайлан бичих нь бусад төрлийн бичлэгээс эрс ялгаатай биш юм. Хэдийгээр зарим үе шатууд нь ялгаатай, зарим нэг нарийн төвөгтэй байдлын түвшин нэмэгдэж болох ч сайн зохиогчийн урт бөгөөд төвөгтэй захидал, шүлэг, зааварчилгаа, богино өгүүллэг бичихдээ хийдэг ихэнх зүйл нь судалгааны тайлан бичихэд ч мөн адил хамаатай.

Юуны өмнө зохиогчид юу бичих вэ гэдэгт нь “ямар нэг зүйл” хэрэгтэй болно. Судалгааны тайлангийн “ямар нэгэн зүйл” нь судалгааны сэдэв, судалгааны асуулт, загвар, хэмжилт, мэдээлэл цуглуулах арга техник, үр дүн, үр дагавар зэргийг багтаасан зүйл юм. Маш олон зүйлийн талаар бичих учраас сайн зохион байгуулалт чухал. Бичлэгийг зохион байгуулах гол хэрэгсэл бол товч агуулга юм. Товч агуулга нь зохиогчид бүх санааг багтаасан, тэдгээрийн хоорондын хамаарлыг тодорхой болгоход тусалдаг. Товч агуулга нь сэдэв (үг, хэллэг) эсвэл өгүүлбэрээс бүрдэнэ. Бидний ихэнх нь товч агуулга хийх үндсэн хэлбэрийг мэддэг (Загвар 1-ийг үз).

Загвар 1. Товч агуулга хийх хэлбэр

I. Эхний ерөнхий сэдэв	Хамгийн чухал хэсгийн эхнийх нь
A. I дэх ерөнхий сэдвийн дэд сэдэв	2 дахь чухал хэсэг
1. A сэдвийн дэд сэдэв	3 дахь чухал хэсэг
a. 1 дугаарын сэдвийн дэд сэдэв	4 дахь чухал хэсэг
b. 1 дугаарын сэдвийн дэд сэдэв	-
(1) b дугаарын сэдвийн дэд сэдэв	5 дахь чухал хэсэг
(2) b дугаарын сэдвийн дэд сэдэв	-
(a) (2) дугаарын сэдвийн дэд сэдэв	6 дахь чухал хэсэг
(b) (2) дугаарын сэдвийн дэд сэдэв	-
i. (b) дугаарын сэдвийн дэд сэдэв	7 дахь чухал хэсэг
ii. (b) дугаарын сэдвийн дэд сэдэв	-
2. A сэдвийн дэд сэдэв	3 дахь чухал хэсэг
B. I дэх ерөнхий сэдвийн дэд сэдэв	2 дахь чухал хэсэг
II. Хоёр дахь ерөнхий сэдэв	Хамгийн чухал хэсгийн хоёр дахь нь

Товч агуулга бол зүгээр л санаануудыг цэгцлэхэд туслах хэрэгсэл юм. Энэ нь 1. санаануудыг дэс дараалалд оруулах (жишээ нь, нэгдүгээрт, хоёрдугаарт, гуравдугаарт юу хэлэх вэ), 2. холбоотой санаануудыг бүлэглэхэд (жишээлбэл, эдгээр нь хоорондоо төстэй боловч тэдгээрээс ялгаатай) тусалдаг, 3. илүү ерөнхий буюу дээд түвшний санааг илүү тодорхой санаанаас, тусгай санааг маш тодорхой нарийн ширийн зүйлээс салгахад тус тус тусална.

Зарим оюутнууд бичилт хийхээсээ өмнө бүрэн товч агуулга гаргах хэрэгтэй бөгөөд товч агуулгыг бэлтгэсний дараа түүнээс хазайх боломжгүй гэж үздэг. Цөөхөн сайн зохиогчид бүрэн, нарийвчилсан товч агуулгаар эхэлдэг. Анхны товч агуулга нь ихэвчлэн ерөнхий байдаг, учир нь бүгдийг бичих хүртэлх бүх санааг дарааллаар нь оруулах, нэгтгэх, ерөнхий зүйлийг тодорхой зүйлээс салгах боломжгүй юм. Ихэнх зохиогчдын хувьд бичих явцад шинэ санаа гарч ирдэг эсвэл илүү тодорхой болдог.

Эхлэлийн товч агуулга нь эцсийн товч агуулгаас бүрэн байдлын зэргээрээ ялгаатай байж болно. Зохиол бичих үйл явц нь зохиогчийн санааг илэрхийлж, тодруулаад зогсохгүй шинэ санаа, санаа хоорондын шинэ холболт, өөр дэс дараалал, ерөнхий ба тусгай хоёрын шинэ харилцааг өдөөж болно. Нэмж дурдахад, бичих үйл явц нь уран зохиол эсвэл хоёрдогч мэдээллийг дахин шинжлэх эсвэл дахин шалгахад түлхэц болно. Энэ нь бүгдийг шинээр эхлүүлэх шаардлагатай гэсэн үг биш юм. Үүний оронд зохиогч шинэ ойлголтод нээлттэй байж, судалгааны ажлын бүх асуудлуудад бүх талаар шууд хандах хэрэгтэй гэсэн үг юм.

Мэдээллийн сан /номын сан/ руу буцах - Төсөл эхлүүлэхийн өмнө та ном зохиолтой танилцсан байх ёстой, харин мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийж дууссаны дараа ашигласан нрм, зохиол руугаа буцах шаардлагатай болдог. Энэ байдал хэд хэдэн шалтгааны улмаас үүсдэг. Нэгдүгээрт, судалгааны ажлын эхлэл, төгсгөлийн хооронд цаг хугацаа өнгөрч, шинэ судалгаа хийгдсэн байж магадгүй. Хоёрдугаарт, судалгааны ажлыг дуусгасны дараа та судалгааны гол асуудлыг илүү сайн мэддэг болох бөгөөд ном зохиолын судалгааг дахин уншихад шинэ асуултууд гарч ирж магадгүй. Эцэст нь тайлан бичихдээ таны тэмдэглэл хангалтгүй эсвэл лавлагааны эх сурвалжийн мэдээлэл дутуу байгаа үед ном зохиолын судалгаа руу буцах шаардлагатай болдог.

Судалгааны тайлан бичихдээ бидний ихэнх нь судалгааны ажлыг дуусгахаас өмнө цуглуулсан зарим тэмдэглэл, эх сурвалжаа хаядаг. Энэ нь номын сангийн анхны ажил, ном зохиолын тойм зэрэг ажилд цаг хугацаа, хүч хөдөлмөрөө дэмий үрсэн гэсэн үг биш юм. Судалгааны ажлыг дуусгахын өмнө бидний авсан зарим тэмдэглэл (жишээ нь, 25 хувь) нь ажлын гүйцэтгэл хангагдах тусам судалгааны ажилд хамааралгүй болж болно.

Лавлагаа, мэдээлэл, ишлэлээ шалгах, өргөжүүлэхийн тулд номын сан руу буцаж очих нь таны санааг улам тодорхой болгож чадна. Энэ нь мөн оюуны бүтээлийн хулгайн гэмт хэргээс зайлсхийхэд тусалдаг. Хууран мэхлэлтийн ноцтой хэлбэр болох хулгайн гэмт хэрэг бол эх сурвалжийг зөв дурдаагүй, өөр хүний хэлсэн үгийг ашиглах явдал юм. Олон улсад олонх их, дээд сургуулиуд энэ төрлийн хууран мэхлэх үйлдэл хийсэн оюутнуудаа сургуулиас хөөдөг журамтай.

Санамсаргүй байдлаар оюуны бүтээлийн хулгай хийхээс зайлсхийхийн тулд анхааралтай тэмдэглэж, хэллэг, санааны эх сурвалжийг тодорхойл. Шууд иш татсан үг болон хувирсан санаануудын эх сурвалжийг иш тат.

Дүгнэлт

Америкийн социологич А.Гидденсийн судалгааны үр дүнгийн тайлангийн талаар хийсэн тайлбараар өгүүллээ дуусгая. “Судалгааны тайлан нь судалгааны мөн чанар, гаргасан дүгнэлтийн үндэслэлийг тайлбарлаж өгдөг. Энэхүү тайлбар нь зөвхөн тухайн судалгааны нэр томъёонуудын хувьд л сүүлчийнх нь байдаг. Олонх тайлан нь хариулаагүй үлдсэн олон асуудлуудыг илрүүлдэг бөгөөд ингэснээр цаашдын судалгааны ажлыг явуулах эхлэл болдог. Бие даасан ямар ч судалгааны

үйл ажилллагаа нь нийгмийн харилцаан доторх судалгааны тасралтгүй үйл явцын нэг хэсэг нь болдог.”¹²⁷

Ашигласан материал

- Социологийн судалгааны арга зүй, аргачлал. Монгол улсын Шинжлэх ухааны академи. Философийн хүрээлэн. Социологи, нийгмийн сэтгэл зүйн салбар. УБ.,2021
- Социологи. Мон судар. УБ.,2015
- А.Гидденс. Социологи. УБ.,2006
- Sociology Writing Group, UCLA. A guide to writing sociology papers. NY 1991
- Donald, Robert B, et al. Writing clear paragraphs. 1983
- Lawrence W.N. Social research methods: Qualitative and Quantitative approaches. 2014

¹²⁷ А.Гидденс. Социологи. УБ.,2006. 552 дахь тал

ИРГЭНИЙ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААН ДАХЬ ПРОКУРОРЫН ОРОЛЦОО, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

PROSECUTOR'S PARTICIPATION TO THE COURT PROCEDURE OF CIVIL LITIGATIONS

М.Отгонжаргал

*ДХИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн
7021 дүгээр дамжааны магистрант*

Н.Мөнхзул

*ДХИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн
Нийтийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор,
цагдаагийн дэд хурандаа*

Abstract: The goal of the Report exists on addressing the prosecution power, theory, practice and some issues of law applications during the prosecutors' involvement to the civil case procedure in the court of Mongolia. In relation with this,

1.To reflect the prosecution involvement to the civil case procedures, comprehensively to the relevant laws,

2.To make comparative studies on the limits of prosecutors' involvement to the civil case procedures on behalf of the state with the legal regulations in foreign countries and to refine them in accordance with international standards,

3.To develop theoretical and methodological issues on the application of existing laws and regulations in this area in Mongolia

4.For Mongolia, social demand or need of the prosecutors' involvement to the civil cases and litigation procedures has been increased by comparing to those in previous decades. It includes,

In the frame of national security of Mongolia, it is required to emphasize the importance of protecting the territorial integrity and natural resources, the wealth of all nation that is determined by the Constitution and the proper application of laws and regulations,

It is required to consider and refine that the prosecutors are inevitably required to participate for the public interest on behalf of the state on the issues related to spending public properties.

Түлхүүр үг: Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, прокурор, төр, нийтийн ашиг сонирхол, нэхэмжлэл гаргах, оролцох

Keywords: Civil proceedings, prosecution, state and public interest, participate

Эрх зүйн зохицуулалтын уламжлал

Монгол Улсад иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурорын оролцох эрх хэмжээ, онол, практик, хууль хэрэглээний зарим асуудлыг хөндөн авч үзэхэд илтгэлийн зорилго нь оршино.

Прокурорын байгууллагын хөгжил, түүний эрх зүйн үндэс нь аливаа улсын төр, хууль цаазын хөгжлийн тодорхой шатанд зайлшгүй хэрэгцээ, шаардлагаар үүсэж бий болсон, түүхэн улбаа бүхий зүй тогтолтой, төрт ёсны салшгүй хэсэг юм.

Төрөөс зөвхөн хууль гаргаад зогсохгүй, түүнийг хэрэгжүүлэх, биелэлтийг хангуулах, хянах асуудалд эрх мэдлийн хуваарлалт хийгдэж хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллага тус тусын эрх хэмжээний хүрээнд хуулийн биелэлтийг хангуулах болсон. Ингээд зогсохгүй төрийн хуулийн биелэлтийг тусгайлан хангах үүрэг бүхий алба төрийн механизмын бүрэлдэхүүнд бий болсноор прокурорын байгууллага үүссэн¹²⁸ байна.

¹²⁸Б.Цэрэнбалтав, Б.Амарбаясгалан. Прокурорын хяналт. Уб., 2009. 17 дахь тал

Харьцуулсан эрх зүйн үүднээс авч үзвэл тухайн улс орныхоо эрх зүйн бүлийн онцлогоос хамаарч прокурорын тогтолцоо, чиг үүрэг өөр өөрийн хэв шинжээр төлөвшиж хөгжиж ирсэн байна.

"Procurare"¹²⁹ хэмээх латин гаралтай үг "хянах", "анхаарах", "хөтлөн удирдах" гэсэн утгатай, хааны ашиг сонирхлыг хамгаалах байгууллагыг XIII-XIV зууны тэртээгээс Францад олон жижиг ванлигуудтай тэмцэх, тэдгээрийг хянах, төвлөрсөн эрх мэдлийг бэхжүүлэх зорилгоор анх бий болсон гэж үздэг.¹³⁰

Хожим европын бүх оронд, ОХУ-д үүрэг функцын хувьд бага зэрэг ялгаатайгаар прокурорын байгууллага үүсч хөгжсөн байна.

Монголын Улсын хувьд хорьдугаар зууны гучаад он хүртэл "Прокурор" нэртэй бие даасан байгууллага байгаагүй, харин БНМАУ-ын Бага хурлын тэргүүлэгчдийн тогтоолоор "Улсын прокуроруудын тухай дүрэм"¹³¹-ийг баталснаар Монголд прокурорын байгууллага үүссэн гэж үздэг. Тухайн үед Улсын Ерөнхий прокурорыг Шүүх яамны дэд сайд хавсардаг, харьяа прокурорууд нь аймгийн шүүх таслах газарт байнга сууж ажилладаг ("шүүхийн прокурор" гэдэг) байсан нь барууны орны жишигтэй нэлээд төсөөтэй байжээ. Харин 1940 оны Үндсэн хуулиас хойш Зөвлөлт маягийн загварт орж 1992 оны шинэ Үндсэн хуулийг хүртэл явж ирсэн байна.

Монголын түүхэн уламжлалаас дурьдвал, Их засаг хуулийн биелэлтэд тусгайлан хяналт тавих үүргийг Чингис хаан өөрийн хүү Цагаадайд үүрэгжүүлсэн байдаг нь төрийн хуулийн биелэлтэд хяналт тавьсан анхны алхам байсан¹³² гэж үзэж болох юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн тавин зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно", мөн зүйлийн 3 дахь хэсэгт "Монгол Улсын прокурорын байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно" гэж тус тус заасан байдаг.

Үндсэн хуулийн үзэл баримтлал, нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн Улсын Их хурлаас 1993 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр Прокурорын байгууллагын тухай хуулийг батлан гаргаж, 2002 онд дахин шинэчлэн найруулсан байна. Улмаар эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөр, шүүх эрх мэдлийн байгууллагуудын шинэчлэл, нийгмийн харилцааны хувьсал, өөрчлөлт, эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэгддэг гол хуулиудыг шинэчлэн найруулсантай холбогдуулан 2002 онд батлагдсан Прокурорын байгууллагын тухай хуулийг хүчингүй болгож, 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдөр Прокурорын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Улсын Их Хурлаас баталсан нь одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Монгол Улсын Үндсэн хууль, Прокурорын тухай хуульд заасан эрх, үүргийнхээ дагуу прокурор нь зөрчил, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцохоос гадна захиргааны болон иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн нэрийн өмнөөс оролцдог.¹³³

Прокурор нь шүүх мэдлийг хэрэгжүүлэхэд шууд оролцдог гол субъектын хувьд "Шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс" оролцож, төр, нийтийн хууль ёсны ашиг сонирхолыг илэрхийлж, хүний эрх, эрх чөлөө, нийтийн ашиг сонирхлыг хамгаалж, түүнийг зөрчигдөхөөс сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх арга хэмжээ авах үүрэгтэй.

¹²⁹Прокурорын байгууллагын түүхэн замнал, үйл ажиллагаа, цаашдын хөгжлийн чиг хандлага. УБ., 2015. 36 дахь тал

¹³⁰Францын ван IV Филипп зоргоор авирлагч феодалууд, салан тусгаарлагчидтай тэмцэхийн тулд 1302 оны 03-р сарын 25-ны өдөр гаргасан ордононсе /органик хууль/-аар прокурор анх бий болсон гэж судлаачид үздэг.

¹³¹Монгол Улсын Ерөнхий Прокурорын газар. Прокурорын ном /гарын авлага/. УБ., 2001. 6 дахь тал

¹³²Б.Цэрэнбалтав, Б.Амарбаясгалан. Прокурорын хяналт. УБ., 2009. 17 дахь тал

¹³³Прокурорын тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 17 дугаар зүйл. Төрийн мэдээлэл. 2017, №24/981/

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурорын оролцоог тодорхойлсон зохицуулалтын түүхэн уламжлалаас үзвэл,

- Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Анхдугаар Үндсэн хуульд Улсын хянан байцаагч /прокурор/ нь Засгийн газрын гишүүн байхаар заасан.¹³⁴

-1940 оны Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хуулийн шүүх прокурор хэмээх долдугаар бүлэгт “бүх яамд ба төв орон нутгийн албан байгууллагууд хийгээд тэдгээрийн харьяат газрууд, мөн албан тушаалын хүмүүс ба ард нийтээс хууль цаазыг нарийнаар биелүүлж байгаа явдлыг байцаан хянах туйлын үүргийг улсын прокурор (хууль сахигч) хүлээнэ”¹³⁵ гэж заасны дагуу 1992 оны Үндсэн хууль батлагдах хүртэл нийгмийн бүхий л харилцаанд төрийн ерөнхий хяналтыг хэрэгжүүлж ирсэн байна.

-1967 оны Иргэний байцаан шийтгэх тухай хуулиар иргэний хэрэгт оролцож, шүүхийн шийдвэрийн үндэслэлд хяналт тавьдаг, улмаар эсэргүүцэл бичих эрхтэй байв.

-1994 оны Иргэний хэрэг хянан шийдвэрлэх хуулиар прокурор шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно. Давж заалдах журмаар гомдлын эсэргүүцэл бичих, Улсын ерөнхий прокурорт санал бичих эрхтэй төдийгүй, төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл прокурор төрийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй байхаар хуульчлагджээ.

-2002 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд прокурор иргэний хэргийн оролцогч байх үндэслэл нь зөвхөн төрийн нэрийн өмнөөс, төрийг төлөөлөн оролцох¹³⁶ болсон онцлогтой. Дээх хуулийн зохицуулалтаас улбаалан 2002 оны Прокурорын байгууллагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт "Прокурор төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчийн төлөөлөгчөөр оролцож, өмгөөлөгчийн бүрэн эрх эдэлнэ"¹³⁷ гэж заасан байна.

Энэ талаар Монгол Улсын дээд шүүх 2003 онд "Прокурорын байгууллагын тухай хуулийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай" тогтоол¹³⁸ гарсан бөгөөд үүнд:

- Хуулийн 16.1-ийн "Прокурор төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчийн төлөөлөгчөөр оролцож..." гэдгийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.1 дүгээр зүйлд зааснаар прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн нэрийн өмнөөс хэргийн оролцогчоор оролцоно гэж ойлгоно.
- Прокурорын байгууллагын тухай хуулийн мөн зүйлийн "...өмгөөлөгчийн бүрэн эрх эдэлнэ" гэдгийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 34 дүгээр зүйлд зааснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа өмгөөлөгчийн эрхийг эдэлнэ гэж ойлгоно гэж тайлбарласан байна.

Дээр дурьсан хуулийн заалтаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан үүссэн байх бөгөөд Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар маргааныг хэлэлцээд "Прокурорын байгууллагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1-д прокурор иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо "Өмгөөлөгчийн бүрэн эрх эдэлнэ" гэж заасан нь Үндсэн хуулийн заалт зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна. Учир нь Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлд прокурорын үйл ажиллагааны чиглэлийг тодорхой тоочиж тодорхойлсон. Тухайлбал энд зааснаар прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох л үндсэн эрх, үүрэгтэй гэж ойлгож болно. Тэгэхлээр "Өмгөөлөгчийн бүрэн эрх эдэлнэ" гэсэн нь Үндсэн хуульд томъёолсон прокурорын

¹³⁴БНМАУ-ын Анхдугаар Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйл, 1924

¹³⁵БНМАУ-ын Үндсэн хуулийн тавин долдугаар зүйл, 1940

¹³⁶ИХШХШТХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 2002

¹³⁷Прокурорын байгууллагын тухай хууль, 2002 он, Төрийн мэдээлэл, №28

¹³⁸Монгол Улсын Дээд шүүхийн 2003 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 02 дугаартай тогтоол

эрхийг хэт өргөжүүлэн үндэслэл муутай тайлбарлаж хуульчилсан байна. Прокурор шүүх хуралд оролцохдоо прокурорынхоо л эрх, үүргийг оролцогчийн хувьд эдлэхээс биш /оролцогчийн эрх, үүрэг буюу ИХШХШ тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан эрх, үүргийг эдлэх гэдэг нь нээлттэй бөгөөд энэ тухай прокурорын байгууллагын тухай хуульд ч заачихсан байгаа/ аль нэг өөр оролцогчийн, тухайлбал өмгөөлөгчийн бүрэн эрх эдлэх нь зохимжгүй юм. Учир нь ИХШХШ тухай хуулийн 25 дугаар зүйлд хуралд оролцсон прокурорт хэрэгтэй байж болох бүх эрх, үүрэг хуульчлагджээ. Мөн Прокурорын байгууллагын тухай хуулийг тайлбарласан Дээд шүүхийн 2003 оны 2 дугаар сарын 20-ны 2 дугаар тогтоолын 6 дугаар зүйлийн 3-д "Өмгөөллийн тухай хуулийн 16.3 дугаар зүйлд прокурор ажлаасаа өөрчлөгдсөнөөс хойш 3 жилийн хугацаанд өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглосон тул прокуророор ажиллаж байх үедээ Өмгөөллийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан өмгөөлөгчийн бүрэн эрхийг эдлэхгүй" гэж заасныг энд анхаарч үзэх нь зүйтэй байна" гэсэн дүгнэлт хийж, Прокурорын байгууллагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтын "...өмгөөлөгчийн бүрэн эрх эдэлнэ" гэсэн хэсэг, мөн хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Прокурор энэ хуулийн 16.1-д заасан ажиллагаанд оролцохдоо Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25, 34 дүгээр зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ" гэсэн заалтын "...34 дүгээр" гэсэн хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсгийн "Монгол Улсын иргэн ...шударга шүүхээр шүүлгэх ...шүүхийн шийдвэрийг давж заалдах ...эрхтэй", Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно" гэсэн заалтуудыг тус тус зөрчиж байгаа тул хүчингүй болгосугай гэж шийдвэрлэжээ.¹³⁹

Үндсэн хуулийн цэцийн дээрх тогтоолоор өөрчлөлт орсонтой холбоотойгоор хууль тогтоогчоос Прокурорын байгууллагын тухай хуулийн 16.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт 2007 оны 08 дугаар сарын 14-ний өдөр "Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчийн төлөөлөгчөөр оролцоно" гэсэн¹⁴⁰ өөрчлөлтийг оруулж байсан байна.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Прокурорын тухай хуулиар прокурорын оролцооны хүрээг дараахь байдлаар хуульчилсан. Үүнд:¹⁴¹

1. Зөрчил шүүхээр хянан шийдвэрлэх,
2. Эрүүгийн хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх,

3. Захиргааны болон иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэхэд хуульд заасан журмын дагуу шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс төрийг төлөөлөн тус тус оролцохоор тодорхойлоод, улмаар прокурор төрийн ашиг сонирхол¹⁴² зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлт, эсхүл өөрийн санаачилгаар захиргааны болон иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчоор, эсхүл гуравдагч этгээдээр оролцох, ингэхдээ хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд нотлох баримт цуглуулах тодорхой ажиллагаа явуулах, иргэн, байгууллага, албан тушаалтнаас холбогдох баримт, мэргэжлийн шинжээчийн дүгнэлтийг гаргуулан авах эрхтэй, прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо Иргэний

¹³⁹Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон прокурорын байгууллагын тухай хуулийн зарим заалт үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай" Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2003 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 02 дугаартай тогтоол. Төрийн мэдээлэл. 2003. №27/312/

¹⁴⁰Прокурорын байгууллагын тухай хууль, <https://legalinfo.mn/>

¹⁴¹Прокурорын тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 20 дугаар зүйл. Төрийн мэдээлэл. 2017 оны 06 дугаар сарын 27 өдөр. №24/981/

¹⁴²Төр нь иргэний эрх зүйн харилцааны нэг субъект болох бөгөөд төрийн байгууллагын эрх, үүрэг ямар нэгэн байдлаар зөрчигдсэнийг ойлгоно. Прокурорын байгууллагын тухай хуулийн тайлбар. 2003. 73 дахь тал.

хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25, 26 дугаар зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ, прокурор өөрийн санаачилгаар төр, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах ажиллагааг хэрэгжүүлж байгаа тохиолдолд итгэмжлэлгүйгээр оролцохоор заасан байна.

Мөн Улсын Их хурлаас Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийг 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар “Прокурор төр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, эсхүл өөрийн санаачилгаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25, 26 дугаар зүйлд заасны дагуу төрийн нэрийн өмнөөс оролцоно” гэж өөрчлөн найруулж, энэхүү заалтыг 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр заасан байна.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь прокурорын оролцоо

Улсын Ерөнхий прокурорын 2019 оны А/28 дугаартай тушаалаар Улсын Ерөнхий Прокурорын Газар, түүний харьяа прокурорын газруудын бүтэц, орон тоог шинэчлэн батлахдаа Ерөнхий прокурорын газрын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дотор “Төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах алба”-ыг бий болгосон. Тус алба нь хуулиар прокурорт олгосон эрх, үүргийн хүрээнд төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилготой.

Прокурорын байгууллагаас 2019-2020 онд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор оролцох оролцоог нэмэгдүүлэх, прокурорын иргэний эрх зүйн мэдлэг, ур чадвар, дадлага, туршлагыг эзэмшүүлэх, нэхэмжлэл гаргах асуудлаар төрийн байгууллагуудтай хамтран ажиллах бодлого чиглэлийг хэрэгжүүлэх, 2021-2022 онд гэмт хэрэг, зөрчлийн улмаас иргэд эрүүл мэндийн даатгалын сангаас тусламж үйлчилгээ авсан зардлыг буруутай этгээдээс нөхөн төлүүлэх нэхэмжлэл гаргах, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах ажлыг хэвшил болгох, хүүхдийн зөрчигдсөн эрхийг сэргээлгэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах ажлыг эхлүүлэх зорилтыг тавин ажиллаж, тодорхой үр дүнд хүрсэн тоон судалгаа гаргасан байдаг байна.¹⁴³

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь прокурорын оролцоо, маргааны төрөл, нэхэмжлэлийг шүүхээс шийдвэрлэсэн байдлыг 2019-2022 оны байдлаар судлан үзвэл,

График 1. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь прокурорын оролцоо





График 2. Прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон байдал

Төрийн ашиг сонирхол зөрчигдсөн	• 2019 онд: 1228 (851.2 тэрбум төг) • 2020 онд: 1605 (191.8 тэрбум төг) • 2021 онд: 1502 (66 тэрбум төг) • 2022 онд: 1319 (83.1 тэрбум төг)
Нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн	• 2019 онд: 131 (56.9 тэрбум төг) • 2020 онд: 167 (245.2 тэрбум төг) • 2021 онд: 98 (1.1 тэрбум төг) • 2022 онд: 212 (4.4 тэрбум төг)
Төр, нийтийн ашиг сонирхол аль аль нь зөрчигдсөн	• 2020 онд: 24 (238.2 тэрбум төг) • 2021 онд: 277 (208.7 тэрбум төг) • 2022 онд: 853 (5.5 тэрбум төг)

График 3. Шүүхэд бичсэн прокурорын нэхэмжлэл, түүний шийдвэрлэлт

¹⁴³<https://prokuror.mn/>



2019-2022 оны хооронд прокуророос 1 их наяд 9 гаруй тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий нэхэмжлэлтэй иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсоноос төр, нийтэд ашигтайгаар шийдвэрлэсэн үнийн дүн 54.8 тэрбум төгрөг¹⁴⁴ байна.

Дээрх тоон судалгаанаас үзэхэд сүүлийн 4 жилд прокурор төр, нийтийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр иргэний хэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон оролцоо нь тогтмол өссөн байхын зэрэгцээ өөрийн санаачилгаар нэхэмжлэл гаргах явдал 2019 онтой харьцуулахад 2022 онд 97 хувиар өссөн байна. Харин шүүх үнийн дүн ихтэй нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн авч хангах ажиллагаа төдийлөн хангалтгүй байгаа нь харагдаж байна.

Прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон маргааны төрөл, прокурор өөрийн санаачлагаар бичсэн нэхэмжлэл, түүнийг шүүх хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн үндэслэл, түүний шалтгаан нөхцлийг 2022 оны байдлаар судлан үзлээ.¹⁴⁵

Хүснэгт 1. Прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон маргааны төрөл

№	Маргааны төрөл	Тоо
1.	Зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэл	887
	Сум хөгжүүлэх сан	250
	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	160
	Хөдөө, аж ахуйг дэмжих сан	6
	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан	5
	“Монгол Улсын Хөгжлийн банк”-аас олгосон зээл	1
	Зээлийн төрлийг тодорхойлоогүй	462
2.	Эрүүл мэндийн даатгалын санд учруулсан хохирол гаргуулах	806
3.	Цагаатгалын нөхөх олговор олгох	33
4.	цахим гав	97
5.	Нийгмийн даатгал, татвар, газрын өр, төлбөр гаргуулах	85
6.	Улсын байцаагчийн актаар тавигдсан төлбөр гаргуулах	8
7.	Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах	6
8.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал гаргуулах	10
9.	Мөрдөгч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас	15

¹⁴⁴Прокурорын байгууллагын 2022 оны ШТТ хэлтсийн хяналтын ажлын мэдээ.

¹⁴⁵Прокурорын байгууллагын үйл ажиллагааны цахим бүртгэлийн нэгдсэн системийн судалгааны цэс модулаас гаргаж авсан тоон судалгаа.

	учирсан хохирлыг нөхөн төлүүлэх	
10.	Гэмт хэргийн улмаас төрд учирсан хохирол гаргуулах	21
11.	Зөрчлийн улмаас төр, нийтийн ашиг сонирхол учирсан хохирол гаргуулах	34
12.	Төрийн албан хаагчийг хууль бусаар халсны улмаас төрд учирсан хохирол гаргуулах	25
13.	Хүүхдийн эрх сэргээх	4
14.	Налуу замын стандарт хангуулах	7
15.	Хариуцагчийн эрэн сурвалжлах	9
16.	Маргааны төрөл тодорхойгүй	335

2022 онд прокурор өөрийн санаачлагаар 880 нэхэмжлэл бичсэнээс шүүх 246 буюу нийт нэхэмжлэлийн 27.9 хувийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 2. Прокурорын нэхэмжлэлийг шүүх хүлээн авахаас татгалзсан маргааны төрөл

№	Маргааны төрөл	Тоо
1.	Хариуцагчийг эрэн сурвалжлах	6 буюу 2,5%
2.	Татварын өр, Нийгмийн даатгалын сан	7 буюу 2,9%
3.	Төрийн албан хаагч	8 буюу 3,3%
4.	Цахим гав	16 буюу 6,7%
5.	Зөрчил, гэмт хэргийн улмаас ТНАС-д учирсан хохирол (зөрчил-15, гэмт хэрэг-4)	19 буюу 7,9%
6.	Газрын өр төлбөр	20 буюу 8,3%
7.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	36 буюу 15%
8.	Эрүүл мэндийн даатгалын сан	50 буюу 20,8%
9.	Сум хөгжүүлэх сангийн зээл	67 буюу 27,9%

Хүснэгт 3. Прокурорын нэхэмжлэлийг шүүх хүлээн авахаас татгалзсан үндэслэл

№	Үндэслэл	Тоо	Эрх зүйн эх сурвалж
1.	Хариуцагч нас барсан	1	ИХШХШТХ-65.1.10
2.	Хэргийн харьяалал зөрчсөн	5 буюу 2.1%	ИХШХШТХ-65.1.1
3.	Шүүхийн харьяалал зөрчсөн	9 буюу 3.7%	ИХШХШТХ-65.1.2
4.	Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан захирамжийн заалтыг биелүүлээгүй, шийдвэр хүчин төгөлдөр байгаа	7 буюу 2.9%	ИХШХШТХ-65.1.6
5.	Нэхэмжлэлийн үндэслэл, шаардлага тодорхойгүй	31 буюу 12.9%	ИХШХШТХ-65.1.11
6.	Хариуцагчийн хаяг тодорхойгүй	53 буюу 22.1%	ИХШХШТХ-65.1.9
7.	Нэхэмжлэгчийг төлөөлөх бүрэн эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан	134 буюу 55.8%	ИХШХШТХ-65.1.5, 65.1.11

Дээрх тоон судалгаанаас үзэхэд шүүх хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн нэхэмжлэлийн 55.8 хувьд нь прокурорыг нэхэмжлэгчийг төлөөлөх бүрэн эрхгүй гэж дүгнэсэн байгаа нь анхаарал татаж байна.

ИХШХШТХ болон Прокурорын тухай хуульд төр, нийтийн эрх ашиг зөрчигдсөн гэж үзвэл прокурор өөрийн санаачлагаар нэхэмжлэл гаргах эрх нь байсаар байтал шүүх ямар учраас прокурорыг нэхэмжлэгчийг төлөөлөх эрхгүй гэж үзэв, хууль хэрэглээний зөрүүтэй ойлголт байгаа эсэх, прокурор төр нийтийн, ашиг сонирхол

зөрчигдсөн бүхий л маргааны төрөлд өөрийн санаачилгаар нэхэмжлэл гаргаж болох эсэх, ямар тохиолдолд прокурор өөрийн санаачилгаар нэхэмжлэл гаргавал зохих, прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох хэрэгцээ шаардлага юу болох зэргийг зөв тодорхойлж, нэгдсэн ойлголтонд хүрэх нь зүйтэй байна.

Шүүх тухайн маргаанд прокурорыг нэхэмжлэл гаргах эрхгүй гэж дүгнэх болсон гол үндэслэл нь "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай Монгол Улсын хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай" Монгол Улсын Дээд шүүхийн 2002 оны 07 дугаар сарыг 24-ний өдрийн 263 дугаартай тогтоол¹⁴⁶ гэж үзэхээр байна. Уг тогтоолд " ...7.Хуулийн 31.1 дэх заалтын "Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл *төрийн байгууллагын хүсэлтээр* иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ... төрийн нэрийн өмнөөс оролцоно" гэсний "төрийн байгууллагын хүсэлт"-эд Монгол Улсын Их хурал, Засгийн газар болон тэдгээрээс эрх олгосон байгууллагаас Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийг төлөөлүүлж прокурорыг оролцуулах хүсэлтийг бичгээр гаргасныг хамааруулан ойлгоно. Прокурор төрийг төлөөлж иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо хуулийн 25 дугаар зүйлд заасан хэргийн оролцогчийн эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ заалтын "прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэх" үндэслэлд Монгол Улсын Их Хурал, Засгийн газар нь хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, төрийн өмчийн зүйлийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, төрөөс төлөх нөхөн төлбөр, олговор зэрэг асуудлаар Үндсэн хууль болон бусад хуулиар тодорхойлсон эрх, үүргээ хэрэгжүүлэх, иргэний эрх зүйн харилцаанд оролцох явцад маргаантай асуудлыг шүүхээр шийдвэрлүүлэх зайлшгүй шаардлагатай тохиолдолд уул асуудлыг хариуцах төрийн байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд байхгүй, тийм этгээд бий боловч тэрээр нэхэмжлэл гаргахаас татгалзсан, эсхүл нэхэмжлэл гаргах боломжгүй /эрх нь дуусгавар болсон, эрхийг түдгэлзүүлсэн, зогсоосон зэрэг/ байхыг ойлгоно" гэж тайлбарласан байна.

Улсын дээд шүүхийн дээрх тайлбарыг ор тас үгүйсгэхгүй боловч энэхүү тайлбар 20 жилийн өмнө гарсан, тухайн үед нийтийн ашиг сонирхлын талаар мөн прокурор өөрийн санаачлагаар нэхэмжлэл гаргах тухай эрх зүйн зохицуулалтууд хуульд тусгагдаагүй байсан гэдгийг одоогийн цаг үед анхаарвал зохилтой.

Нөгөө талаас иргэний эрх зүйн харилцаа нь эдийн болон эдийн бус баялагтай холбоотойгоор эрх зүйн этгээдийн хооронд үүсдэг маш өргөн хүрээтэй, эдийн засгийн суурь харилцаа байдаг. Иргэний хэрэг бусад маргаан шүүхээр шийдвэрлэхэд оролцоно гэдэг бол иргэн-төр хоёр адил тэнцүү эрх зүйн байдалд байдаг онцгой өөр нөхцлийг харгалзахыг шаардана. Энд ч бас бодох, тодруулах, магадгүй одоогийн практикийг эрс өөрчлөх зүйл цөөнгүй¹⁴⁷.... гэсэн нь прокурор эрүүгийн хэрэгт гол төлөв ордогийн илэрхийлэл гэж үзэж болохоор байна.

"Public interest" гэдэг нь яг шууд тодорхойлолт байхгүй ч хүлээн зөвшөөрөгдөх, хамгаалах шаардлагатай олон нийтийн сайн сайхан байдал, олон нийтийн эрх ашиг гэдэг агуулгаар тайлбарлагдаж байна. Өөрөөр хэлбэл нийт иргэдийн нийтлэг сонирхол бөгөөд хувь хүмүүсийн тус тусын сонирхлын нийлбэр, эсхүл тухайн нэг бүлгийн сонирхол биш гэсэн агуулгатай байна.

Төрийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой зөрчилдлөө гэхэд төрийн ашиг сонирхол гэдэг нь төрийн байгууллагын удирдлагын буруу шийдвэрийн үр дүн байх бөгөөд явцуу эрх ашиг болно. Хэрвээ төр зөв ажиллавал ямагт нийтийн ашиг сонирхолд нийцсэн шийдвэр гарах ёстой тул төрийн ашиг сонирхол гэж тайлбарлаж болохгүй тул энэ нь төрийн байгууллагын удирдлагын буруу шийдвэр гэж үзэж болох юм.

¹⁴⁶Төрийн мэдээлэл. 2002. №29/362/

¹⁴⁷Прокурор аль зүгт явна вэ?. Б.Чимид. Прокурорын ном /гарын авлага/. УБ., 11 дэх тал

Прокурор нь төр, нийтийн ашиг сонирхолд учирсан хохирлыг төлүүлэхэд санаачлагатай ажиллаж, дараах төрлийн хэрэг, маргаанд өөрийн санаачилгаар оролцож иргэний журмаар нэхэмжлэл гаргах нь зүйтэй. Үүнд:

- Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэгч байгууллагын ирүүлсэн зөрчлийн улмаас төр, нийтийн ашиг сонирхолд учирсан хохирол төлөгдөөгүй,

- Газар, газрын хэвлий, гол мөрөн, нуурын усыг зохих зөвшөөрлийн дагуу эзэмшиж, ашиглаж, өмчилж байгаа иргэн, хуулийн этгээд, түүнчлэн зөвшөөрөлгүйгээр ашигласан, эсхүл нөхөн сэргээх ажиллагааг хийгээгүйгээс байгаль орчин бохирдуулж, нийтэд хохирол, хор уршиг учруулсан,

- Эрүү, зөрчлийн хэргийг шийдвэрлэхдээ төр, нийтийн ашиг сонирхолд учирсан хохирлыг шийдвэрлээгүй,

- Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, прокурор, шүүхийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас төрд учирсан эд хөрөнгийн хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх,

- Эрүүгийн болон зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс прокурорыг иргэний нэхэмжлэгчээр тогтоосон бөгөөд хохирлыг эрүүгийн хэргийн шүүх шийдвэрлээгүй орхисон,

- Нийтийн эзэмшлийн эд хөрөнгөд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан санаатай болон болгоомжгүйгээр гэм хор учруулсан гэх мэт.

Харин төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэдэгт Иргэний хуулийн 6 дугаар зүйлд заасан “Иргэний эрх зүйн харилцааны объект нь төрийн мэдлийнх бөгөөд төрийн эдийн болон эдийн бус баялгийг өмчлөх, эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх” зөрчигдсөнийг хамааруулж ойлгоно.

Прокурорын хийх ажил нэлээд хийсвэр боловч бодит үр дагавартай сонирхлоор нөхцөлддөг. Гэтэл заримдаа прокурор юу илэрхийлэн маргаанд оролцох гэж буй нь тодорхой бус байдгаас ИХШХША дахь оролцоо нь эрүүгийн процесстой харьцуулахад шаардлага бага мэт. Прокурор иргэний хэрэгт оролцох практик олон улсын түвшинд байдаг. Гэхдээ маргаанд илэрхийлэх, хамгаалах сонирхол нь тодорхой бөгөөд хүрээтэй байдаг. Тухайлбал, ихэвчлэн нийтийн гэрээ /хэлцэл/-тэй холбоотой маргаанд оролцдог байна.

Европын Холбооны Улсын Сайд нарын Хорооны 2000 оны 10 сарын 06-нд баталсан Зөвлөмж № (2000)19-д прокурорыг: “Нийгэм болон олон нийтийн эрх ашгийн өмнөөс, хувь хүний эрх болон шүүн таслах тогтолцооны зайлшгүй үр нөлөөтэй байх байдлыг харгалзан хууль зөрчсөн тохиолдлуудад гэмт хэргийн шийтгэлийг хуулийн дагуу зөв хэрэглэх төрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэгч” гэжээ.¹⁴⁸

Европын Холбооны гишүүн улсуудад прокурорын үүрэг буюу яллах эрхийг хэрэгжүүлэгч өөр өөр нэртэй, ялгаа бүхий үүрэгтэй байгууллагууд байдаг. Гишүүн улс орнуудад шүүхийн байгууллагууд харьцангуй ижил төстэй байдаг бол прокурорын байгууллагууд нь тийм байх нь бага гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Европын Холбооны бүх гишүүн орнуудад прокурор нь эрүүгийн хэрэгт маш чухал оролцоотой буюу заавал оролцоотой байдаг бол иргэний болон захиргааны эрх зүйн хүрээнд харин ихэнхи улс орнуудын хувьд оролцоо бүхий байдаг гэж хэлж болно.

Өөр нэг анхаарал хандуулах зүйл нь гишүүн орнууд дахь прокурорын бие даасан байдал нь янз бүрийн түвшинд байдаг явдал юм. Зарим улс орнуудад прокурор нь шүүгчтэй адил буюу ижил түвшний бие даасан байдлаараа хамгаалагддаг бол Хууль Зүйн Сайд нь гэмт хэргийн талаар баримтлах бодлогыг тодорхойлдог зарим улс орнуудад тэдний бие даасан байдал нь хязгаарлагдмал байна. Гэхдээ гишүүн орнуудын ихэнх буюу 32 оронд прокурор нь иргэний болон захиргааны хэргүүдэд оролцох үүрэгтэй байдаг.

Харин Япон Улсын Прокурорын тухай хуулийн дагуу Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор нь нийтийн ашиг сонирхлын төлөөлөгч

¹⁴⁸<https://www.google.mn/search?tbm=bks&hl=en&q=prosecutor+le+to+civil+case+proceeding+>

байж, шүүх шийдвэр гаргахдаа хууль тогтоомжийг зөв хэрэглэсэн эсэхэд хяналт тавих эрхтэй.

Япон Улс нь 2006 болон 2007 онуудад тодорхой хууль тогтоомжид өөрчлөлт оруулж, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр томоохон ахиц гаргасан. Тухайлбал, Хэрэглэгчдийн гэрээний тухай хууль (Consumer Contract Act)-д хэрэглэгчдийн төлөө байгууллагууд аж ахуйн нэгжийн эсрэг нэхэмжлэл гаргах эрх зүйн тогтолцоог бий болгосон.¹⁴⁹ Энэхүү тогтолцооны онцлог нь тодорхой шалгуурыг хангаж хэрэглэгчдийн төлөө байгуулсан эвлэл, бүлэглэлүүдийг хэргийн оролцогчоор тогтоох боломж олгож, тодорхой аж ахуйн нэгж, байгууллагын хэрэглэгчдийн хууль ёсны эрх ашгийг хохироосон тодорхой үйл ажиллагааг нь зогсоох талаар нэхэмжлэл гаргах эрх зүйн орчныг бүрдүүлсэнд байгаа юм.

Үүнээс гадна, Япон Улсын прокурор нь холбогдох хууль тогтоомжид заасны дагуу иргэний бусад маргаан, тухайлбал тус улсын нийгэм, соёлын онцлогоос шалтгаалан Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5 дугаар зүйл, Гэр бүлийн тухай хуулийн 6 дугаар зүйлд тус тус прокурор хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрхэн оролцох талаар тусгайлсан зохицуулалтыг тусгасан байна.

Хэдийгээр иргэний хэрэг маргаанд прокурорын оролцоо нь эрүүтэй харьцуулахад бага гэдэг нь харагдаж байгаа хэдий ч цаашид Монгол Улсад прокурор иргэний хэргийг шүүхээр шийдвэрлэхэд оролцох оролцоог илүү боловсронгуй болгохын тулд гадаадын улс орнуудын тухайн чиглэлд оролцдог оролцоог харьцуулан судлах нь зүйтэй юм.

Дүгнэлт

Прокурор зөрчил шүүхээр хянан шийдвэрлэх, эрүүгийн хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх, захиргааны болон иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэхэд хуульд заасан журмын дагуу шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс төрийг төлөөлөн оролцож байна. Өөрөөр хэлбэл прокурор шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно гэдэг нь зөвхөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэлэхгүй бөгөөд иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ч төрийн нэрийн өмнөөс оролцоно гэсэн үг юм.

Төрийн нэрийн өмнөөс оролцоно гэдэг утгаараа нийтийн эрх ашгийг хамгаалах үүргийг төрийн байгууллагын хүсэлтээр, эсхүл өөрийн санаачилгаар хэрэгжүүлэх ба энэ агуулгаар нийтийн ашиг сонирхлыг хамгаалж, зөрчигдсөн эрхийг сэргээлгэх, шүүхэд нэхэмжлэл гаргахаар шаардах чиг үүрэг прокурорт байх ёстой болж байна.

Бусдын эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалж нэхэмжлэл гаргах эрх нь Хүний эрхийн үндэсний комисс, Сууц өмчлөгчдийн холбоо, Санхүүгийн зохицуулах хороо, Төрийн бус байгууллага гэх зэрэгт Монгол улсын хууль, тогтоомжоор олгогдсон байдаг хэдий ч эдгээр байгууллагууд зөвхөн өөрийн салбарын хүрээнд /явцуу хүрээнд/ л нийтийн ашиг сонирхлыг хамгаалдаг байхад прокурор өргөн агуулгаар буюу нийтийн ашиг сонирхол зөрчигдсэн бүхий л тохиолдолд буюу бүх харилцаанд нийтийн ашиг сонирхлыг хамгаалж, шүүхэд нэхэмжлэл гаргах шаардлага үүсч байна. Түүнчлэн, Монгол Улсын хувьд иргэний хэрэгт прокурор оролцох нийгмийн хэрэгцээ, шаардлага өмнөх үетэйгээ харьцуулахад өсөн нэмэгдсээр байна. Тухайлбал, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын хүрээнд газар нутгийн бүрэн бүтэн байдал, Үндсэн хуулиар тогтоосон нийт ард түмний өмч болох байгалийн баялгийг хамгаалах, хууль тогтоомжийг зөв хэрэглэх, нийтийн өмчийг захиран зарцуулах асуудлаар улсын эрх ашгийн үүднээс, төрийн нэрийн өмнөөс оролцох шаардлага бий болсон. Иймд:

1.Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь прокурорын оролцоог холбогдох хуулиудад илүү нарийвчлан тусгаж зохицуулах,

¹⁴⁹Japan's Consumer Policy, Research Institute of Economy, Trade and Industry (2008), available at <https://www>

2.Иргэний хэрэгт прокурор төрийг төлөөлөн оролцох эрх хэмжээг гадаадын улс орнууд дахь эрх зүйн зохицуулалттай харьцуулан судалж, олон улсын нийтлэг жишигт уялдуулан боловсронгуй болгох,

3.Монгол Улсад тухайн чиглэлээр хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийг хэрэглэх, онол, арга зүйн асуудлыг төлөвшүүлэх шаардлагатай байна.

Ашигласан материал

- Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он.
- БНМАУ Анхдугаар Үндсэн хууль. 1924 он.
- БНМАУ Үндсэн хууль 1940, 1960 он.
- Прокруорын тухай хууль. 2017 он.
- ИХШХШТ хууль 2002 он.
- Үндсэн хуулийн эрх зүй, гарын авлага. Уб., 2019 он.
- Д.Лүндээжанцан, Н.Жамбалжав, Х.Сэлэнгэ, Д.Отгонтуяа. Эрх зүйн философи. Уб., 2014 он.
- Авилгын гэм хэрэг ба прокурорын хяналт, гарын авлага. Уб., 2022 он.
- Гадаад орны прокурорын байгууллагыг бүтэц, чиг үүргийн талаар харьцуулсан судалгаа. Уб.,2022 он.
- Ч.Нямсүрэн. Эрх зүйн ерөнхий онол. Уб., 2010 он.
- Б.Цэрэнбалтав, Б.Амарбаясгалан, Прокурорын хяналт. Уб., 2009 он,
- Прокурорын байгууллагын түүхэн замнал, үйл ажиллагаа, цаашдын хөгжлийн чиг хандлага. Уб., 2015 он.
- Монгол Улсын Ерөнхий Прокурорын газар. Прокурорын ном /гарын авлага/, Уб., 2001 он.
- Монгол Улсын прокурорын байгууллагын хууль тогтоомжийн түүхэн эх сурвалжийн эмхтгэл. Уб., 2020 он.
- Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал. Уб., 2 дахь хэвлэлт, 2017 он.
- <https://www.shuukh.mn/>
- <https://prokuror.mn/>
- <https://legalinfo.mn/mn>
- Japan's Consumer Policy, Research Institute of Economy, Trade and Industry (2008), available at <https://www>
- [https://www.google.mn/search?tbm=bks&hl=en&q=prosecutor le+to+civil+case+proceeding](https://www.google.mn/search?tbm=bks&hl=en&q=prosecutor+le+to+civil+case+proceeding)

ШИНГЭРҮҮЛСЭН ХИЙН ТҮЛШНЭЭС ҮҮДЭЛТЭЙ ГАМШГИЙН ЭРСДЭЛ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

DISASTER CAUSED BY LIQUEFIED GAS FUEL RISKS AND CURRENT STATUS

О.Ганхуяа

Монгол Улсын Зөвлөх инженер

Товч агуулга: Монгол Улсад хийн аж ахуй, хийн түлшний хэрэгцээг өргөжүүлэх талаар анх 2000 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр Монгол Улсын Засгийн газрын 184 дугаар тогтоол гарч “Шингэрүүлсэн шатдаг хий хөтөлбөр” баталсан нь бодлогын хүрээний анхны бичиг баримт юм.

Засгийн газрын анхны хөтөлбөр хэрэгжин дуусаж, хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнээд цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзээд 2 дахь хөтөлбөрийг 2006 оны 6 дугаар сарын 21-ний Монгол Улсын Засгийн газрын 140 дүгээр тогтоолоор баталжээ.

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр шингэрүүлсэн нүүрс устөрөгчийн шатдаг хийн хэрэглээ нь үйлчилгээний таксины 90 хувь, нийтийн хоолны үйлчилгээний газрын 80 хувь, аялал жуулчлалын 70 хувь, ахуй хэрэглээний 40 хувь, автомашины 20 хувь, үйлдвэрлэлийн 70 хувийг эзлэх хэмжээнд хүрнэ гэсэн зорилт тавьсан байна.

Ингэснээр хий хэрэглэгчдийн тоо 21 аймагт 30 мянга, Улаанбаатар хотод 14 мянга гаруй байгаа нь 2008 онтой харьцуулахад хоёр дахин өссөн байна. 2011 оны байдлаар 40 мянга орчим байнгын хэрэглэгчдэд үйлчилж байна гэсэн судалгаа байдаг. Аймгуудын шингэрүүлсэн шатдаг хийн хэрэглээний нэгдсэн судалгаанаас харахад Дундговь, Дархан-Уул, Сэлэнгэ, Хэнтий, Сүхбаатар, Дорноговь, Төв, Өвөрхангай, Баянхонгор, Архангай, Говь-Алтай, Ховд, Завхан, Увс, Хөвсгөл аймагт шингэрүүлсэн нүүрсустөрөгчийн хийн Автомашинд хий цэнэглэх станц (АХЦС) үйлдвэрлэл, үйлчилгээний салбаруудыг байгуулан 150 гаруй төрлийн хийн плитик, халаагуурын төхөөрөмжийг ахуйн хэрэглээнд ашиглаж байна.

Шингэрүүлсэн нүүрс устөрөгчийн хийн түлш нь бүрэн шатдаг учраас агаарт цацагдах хорт бодис нүүрснээс олон дахин бага байдаг. Түүний дулаан ялгаруулах чадал, тухайлбал пропаных 24,3 мянган ккал/м³, бутаных 32,0 мянган ккал/м³, байдаг учраас нийтийн аж ахуйд хэрэглэх нь нэн тохиромжтой. Хийн түлшийг тээврийн хэрэгсэлд хэрэглэж эхлээд багагүй хугацаа өнгөрчээ. Хийн түлшний октаны тоо өндөр, тухайлбал: пропаных 120, бутаных 93 байдаг нь бензин /АИ 80, АИ 92/- ээс хавьгүй дээгүүр юм. Хийн түлш нь бензинээс 1-2 дахин хямд, байгаль эколог, эдийн засгийн ач холбогдолтой.

Abstract: On November 29, 2000, the Government of Mongolia issued Resolution No. 184 on the expansion of gas farming and the demand for gas fuel in Mongolia. After the implementation of the first program of the government, after evaluating the implementation of the program, it was considered necessary to continue its implementation, and the second program was approved by Resolution No. 140 of the Government of Mongolia on June 21, 2006.

With the implementation of the program, the goal is that the consumption of liquefied hydrocarbon gas will reach 90 percent in service taxis, 80 percent in catering services, 70 percent in tourism, 40 percent in household consumption, 20 percent in automobiles, and 70 percent in industry.

Түлхүүр үгс. Химийн олон төрлийн бодисын дүн шинжилгээ, пропан - бутаны нэгдлийн багц ойлголт.

Key words: Analysis of various chemical substances, set concept of propane - butane compound.

Удиртгал

Хийн түлшийг аж ахуйн нэгж, байгууллага болон ахуйн хэрэглээнд өргөнөөр хэрэглэх болсон нь шингэрүүлсэн нүүрс устөрөгчийн хийн тээвэрлэлт, хадгалалт,

хэрэглэгчдийн хайхрамжгүй аливаа үйл ажиллагаа зэрэг нь тэсрэх дэлбэрэлтийн аюулаас гадна эрдэнэт хүний амь нас эрсдэх, учирч болох хохирол, иргэд, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь ихсэх хандлагатай байна.

Байгалийн хий ("Шатдаг хий" гэж нэрлэх нь бий) нь үндсэндээ метанаас тогтсон, шатах ашигт малтмал юм. Байгалийн хийн найрлагад этан, пропан, бутан, пентан зэрэг нүүрсустөрөгчид, бага хэмжээгээр нүүрстөрөгчийн давхар исэл, азот, гели ба хүхэртустөрөгч агуулагдана[1]. Байгалийн хий нь газрын тос ордод газрын тостой хамт, эсвэл дангаараа хийн орд, мөн нүүрсний ордод нүүрсний хий байдлаар тохиолдоно. Анаэробик бактерийн тусламжтайгаар үүсэж буй метанаар баяжсан хийг "биохий" буюу "намгийн хий" гэж нэрлэнэ. Энэ биохий нь төрөл бүрийн намаг, малын өтөг бууц, томоохон хот суурингийн хогийн цэг зэрэгт үүснэ.

Химийн найрлага:

Байгалийн хийн гол бүрдүүлэгч нь нүүрсустөрөгчдийн бүлгийн хамгийн хөнгөн, богино молекул болох метан (CH_4) байна. Мөн этан (C_2H_6), пропан (C_3H_8) ба бутан (C_4H_{10}), болон хүхэрт хийнүүд агуулагдана. Байгалийн хий нь гели ялгаж авах үндсэн эх үүсвэр болно.

Хүснэгт 1.

Найрлага	%
Метан (CH_4)	70 - 90
Этан (C_2H_6)	5 - 15
Пропан (C_3H_8) ба Бутан (C_4H_{10})	< 5
CO_2 , N_2 , H_2S зэрэг	Үлдэх нь

Азот, гели, CO_2 болон H_2S , ус, мөн үнэрт нүүрсустөрөгч маш бага хэмжээтэй байна [2]. Зарим хийн ордод мөнгөн ус тааралдана[3]. Гэхдээ хийн орд тус бүр дээр хийн найрлага өөр байна.

Хүлэмжийн нөлөө болон дэлхийн дулаарлыг нэмэгдүүлэхэд хамгийн их хувь нэмэр оруулдаг хийн нэг бол метан хий юм. Энэ бол усанд уусдаггүй, үнэргүй, өнгөгүй хий юм. Химийн томъёо нь CH_4 бөгөөд хоргүй ч гэсэн шатамхай байдаг.

Шингэрүүлсэн нүүрс устөрөгч нь нүүрстөрөгч, устөрөгч гэсэн 2 элементээс бүрдсэн органик нэгдэл /холбоо/ юм. Олон улсад Пропан (C_3H_8), Бутан (C_4H_{10}) –ны нэгдлийг шингэрүүлсэн шатдаг хий гэж нэрлэдэг.

Шатамхай хий нь өнгөгүй бөгөөд ихэнхдээ үнэргүй байдаг. Тиймээс хийн хоолой, сав, тоног төхөөрөмжөөс алдагдсан тохиолдолд өрөө, байгууламжид тэсрэх хий-агаарын холимог үүсдэг.

Хийн алдагдлыг цаг тухайд нь илрүүлэхийн тулд тодорхой хурц үнэрийг өгдөг (үнэртэй) Этил меркапан ($\text{C}_2\text{H}_5\text{SH}$)-ийг үнэртүүлэгч бодис болгон ашигладаг бөгөөд үүнийг 1000 м³ байгалийн хий тутамд 16 грамм, 1 тонн шингэрүүлсэн хий тутамд 60-90 граммын хэмжээгээр хийдэг.

Шингэрүүлсэн нүүрсустөрөгч нь нүүрстөрөгч, устөрөгч гэсэн 2 элементээс бүрдсэн органик нэгдэл /холбоо/ юм. Олон улсад Пропан (C_3H_8), Бутан (C_4H_{10}) –ны нэгдлийг шингэрүүлсэн шатдаг хий гэж нэрлэдэг.

Шингэрүүлсэн нүүрсустөрөгчийн хий нь ердийн нөхцөлд (0 °C, 760 мм.м.у.б) хийн төлөвт ордог хийнүүд багтдаг бөгөөд даралт нь харьцангуй бага эсвэл дулааны хэм нь бага зэрэг буурсан тохиолдолд шингэн төлөвт шилждэг.

Пропан-бутан нь шингэрүүлсэн (ангилаас монгол хэлнээ хөврүүлвэл Liquefied Petroleum Gas, LPG буюу шингэрүүлсэн газрын тосны хий, ШГТХ) газрын тосны хий, пропан ба бутаны холимог юм. Ихэвчлэн пропан гэж товчлон нэрлэдэг.

Пропаныг яаж гаргадаг вэ? Газрын тос, түүнчлэн холбогдох хольцийг хийн төлөвт байлгахын тулд 16 атм (1.6 МПа) даралтаар шингэн төлөвт хадгалж, тээвэрлэдэг.

Пропан, бутан, метаны онцлог шинж чанарыг хүснэгт 1-д харуулав.

Хүснэгт 2.

Шинж чанар	(Пропан+бутан) хольц	Метан
Химийн томъёо	$C_3H_8 + C_4H_{10}$	CH_4
Хувийн жин (нягт) кг/ м ³	2,4	0,73
Хувийн хаьцангуй жин, кг/м ³	2.0 (агаараас 2 дахин хүнд)	0,5 (агаараас 2дахин хөнгөн)
Дулаан дамжуулалт, ° С	2100	2000
Тэсрэлтийн (дээд..доод) зааг,%	2 – 10	5 – 15
Хий шатахад шаардлагатай агаарын хэмжээ, м ³	25	10
Дөлний дэлгэрэлтийн хурд,м.сек	0,82	0,67

Шингэрүүлсэн нүүрсустөрөгчийн хий хадгалах байгууламж дахь гал түймрийн тархалт дэлгэрэлтийн онцлог шинж чанарыг эдгээр хийн шинж чанараар тодорхойлдог.Тоног төхөөрөмжийн битүүмжил алдагдан даралт буурахад ШНХ нь ууршилт ихтэй тул агаар мандалд хурдтай задран тархах үед агшин зуур ялгарч буй хийн болон урсгалын хэмжээ, мөн цаг уурын нөхцөл байдал (салхины хурд, агаарын дулааны хэм) зэргээс шалтгаалан их хэмжээгээр агаарт хийн урсгалын уурын үүл, хуралдаж хамгийн аюултай нь "Галт бөмбөлөг" үүсгэх боломжийг бүрдүүлдэг.

Монгол орны нөхцөлд шингэрүүлсэн нүүрсустөрөгчийн хий эрхэлдэг Аж ахуйн нэгж байгууллагын болон ахуйд хэрэглэж байгаа тоног төхөөрөмж, технологийн процесс, хийн баллоны аюулгүй байдлыг хангуулах, аюул, эрсдлээс урьдчилан сэргийлэх судалгааны эхлэл тавигдаж байгаагаараа ач холбогдолтой.

Шингэрүүлсэн пропан, бутан ба метаны шинж чанар, чадвар ШНХ-ийн бусад төрлийн түлшнээс ялгарах гол ялгаа нь гадны тодорхой нөхцөлд шингэн төлвөөс хий болон буцах төлөв байдлыг хурдан өөрчлөх чадвар юм Эдгээр нөхцөлүүдэд орчны дулааны хэм, сав дахь дотоод даралт, бодисын эзэлхүүн хамаардаг байна.

Автомашиньг хийгээр цэнэглэх станц болон ахуйн хэрэгцээнд нийлүүлэх хийг олон улсын стандартад нийцсэн, ашиглалтын хугацаа урт, хэрэглээний аюулгүй ажиллагааг хангасан, газан баллоны стандарт болох улбар шар өнгөтэй ISO стандартын 5, 10, 14, 15, 50 кг-ийн баллоныг борлуулах болон цэнэглэх үйлчилгээг үзүүлдэг. Зураг 1.



Зураг 2.

Сав доторх эзэлхүүн, техникийн үзүүлэлтийг хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 2.

Үзүүлэлтүүд	Эзэлхүүн, л					
	5	8	9.2	12	18	27

Шингэрүүлсэн хийн хүнд, кг	2,0	3,5	4,0	5,0	7,5	11,4	21,2
Хоосон баллоны хүнд,кг	3,3	4,2	4,7	6,0	7,6	12,0	19,5
Ажлын даралт,МПа	1,6	1,6	1,6	1,6	1,6	1,6	1,6
Туршилтын даралт,МПа	2,5	2,5	2,5	2,5	2,5	2,5	2,5
Савны хананы зузаан,мм	2,0	2,0	2,0	2,0	2,0	2,5	2,5
Нээх, хаах хаалтын төрөл	ВБ-1 ВБ-2	ВБ-1 ВБ-2	ВБ-1 ВБ-2	ВБ-1 ВБ-2	ВБ-1 ВБ-2	ВБ-2	ВБ-2
Сав баглаа боодол	Цаасан хайрцаг	Хуванцар уут	Цаасан хайрцаг	Хуванцар уут	Хуванцар уут	Хуванцар уут	Хуванцар уут
Овор хэмжээ							
Өндөр,мм	272	295	350	485	530	600	970
Диаметр, мм	222	222	260	222	260	292	292

Байгалийн хийг дэлхийн улс орнууд үйлдвэрлэлд болон ахуйн хүрээнд өргөн ашиглагдааас гадна тухайн улс орон өөрийн байгалийн баялгийн нөөц, эдийн засгийн чадавх, хөгжлийн түвшингээс хамааран байгалийн, шингэрүүлсэн нүүрс-устөрөгчийн хийг ашиглахдаа хүрэн нүүрс, газрын тос олборлолт, ашиглалтын үед боловсруулан гаргаж авч байгаа ч хамгийн хямд, хялбаршуулсан технологээр байгалийн хийг боловсруулан ашиглахад анхаарлаа онцгой хандуулж байна.

Судалгаа:

Судалгаанд дотоодын хоёр компани (“Дашваанжил”ХХК, “Гор газ” ХХК), гадаадын хөрөнгө оруулалттай нэг “Юни газ” ХХК үйл ажиллагаа явуулж байна. Бусад компаниуд “Хийн тулга” ХХК, “Монгаз сервис” ХХК-иуд хийн түлш тоног төхөөрөмж,тусгай зориулалтын машин техник хэрэгсэл, тоноглолыг импортлон оруулж ирдэггүй бөгөөд жижиглэнгээр дотооддоо худалдан борлуулдаг байна.

Манай улсад шингэрүүлсэн хийн түлшийг өргөн хэрэглэх болсноор тэдэнд үйлчлэх зорилгоор Хийн түлшний үйлдвэр эрхлэгчдийн холбоо ТББ байгуулагдан 10-аад компани нэгдэж байснаас хамгийн идэвхтэй, ажил үйлчилгээ нь тогтмолжин тууштай үйл ажиллагаагаараа “Дашваанжил”ХХК нь эдүгээ 30 жил энэ салбартаа тэргүүлэн ажиллаж байна.

Тус компаний үйлдвэр, үйлчилгээ, технологийн просесс, үйл ажиллагаанд суурилан судалгаагаа хийж байна.

Тус компани нь хэрэглэгчдийн хэрэгцээнд тулгуурлан олон улсын стандартад нийцсэн импортын бүтээгдэхүүнийг орлохуйц бүтээгдэхүүнийг 2015 оноос дотооддоо үйлдвэрлэж эхэлсэн.

Өнөөгийн байдлаар ХБНГУ, БНСУ, БНХАУ, Япон улсад үйлдвэрлэгдсэн сав, тоног төхөөрөмжийг хэрэглэж, ОХУ-ын стандартыг хөрвүүлэн ашиглаж байгаа нь учир дутагдалтай байгаа бөгөөд ОХУ-д мөрдөгддөг СНИП болон бусад дүрэм журмыг багасган боловсруулсан. Дэд Бүтцийн Яамнаас баталсан “Хийн хангамж БНБД-42-01-04”, “Хийн аж ахуйн аюулгүй ажиллагааны дүрэм” /2004/, “Хийн аж ахуйн техник ашиглалтын дүрэм” /2001/ зэрэг дүрэм журмыг мөрддөг. ШНХ болон ШБХ-г ахуйн, тээвэр, үйлдвэрлэлийн зориулалтаар ашигладаг бөгөөд ихэвчлэн ердийн тээврийн хэрэгслээр зөөвөрлөн түгээхдээ гар аргаар ,үүрч, өнхрүүлэн хүргэж

өгч байгаа нь шинжлэх ухаан техник эрчимтэй хөгжиж байгаа өнөө үед үнэхээр учир дутагдалтай байна.

Аль ч улс оронд өөрийн онцлогт тохирсон стандарт, дүрэм журам, зааварчилга гарган хэрэгжилтэнд нь хууль хяналтын болон мэргэжлийн байгууллагын инженер-техникийн ажилтанууд нь үйлчилгээний ажилчдын албаны болон мэргэжлийн ур, чадвар, аюулгүй ажиллагааны болон технологийн процесс ялангуяа гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх ажилд түлхүү анхаарч, хяналт шалгалт, аюулгүй ажиллагааны горимыг чанд мөрдүүлэн ажилладаг байна.

Зуун дамжин шатамхай хийг ашиглах үйлдвэрлэл үйлчилгээг боловсронгуй болгох талаар хөгжиж ирсэн баруун болон төв европын орнуудын хийн ашиглалтын талаар суралцаж, судлах зүйл асар их байгаа билээ.

Орчин үед хийн ноцтой осол, аюул гарахыг урьдчилан таамаглах боломжгүй. Иймээс дэлхий улс орнуудад болон манай оронд гарсан хохирол ихтэй осол, гал түймрийн судалгаанд үндэслэн түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөдөг. Эмзэг байдлаас үүссэн ослоос дурьдвал:

Хүснэгт 3.

Он	Осол гарсан газар	Бүтээгдэхүүн	Шалтгаан	Хохирол сая доллар	Гэмтэж, нас барсан хүн
1944	АНУ, Клиленд	Пропан-Бутан	5000-20000м ³ резервуарт дэлбэрэлт болж 64,7 га газарт гал түймэр гарсан		255 / 130
1962	АНУ, Нью-Йорк	Пропан	Төмөр замын осол гарч Цистерн эвдэрснээс пропан алдагдаж 120-180м “галтбөмблөг” үүссэн	0,4	17 / 40
1966	Франц	Пропан-бутан	1700м ³ савнаас дээж авсан цоргоо хааж чадаагүйгээс үүлэнцэр үүсч 30 минутын дараа автомашины яндангийн очноос дэлбэрэлт үүссэн	1,8	105 / 18
1970	АНУ, Аризона	Пропан	ТЗ-ын цистер – нээс пропан юүлэх үед залгаасаар нь шингэн урсаж түүнийг засварлах гэж байхад оч үсрэн шаталт болж 10 минутын дараа цистерн дэлбэрч 365 метрт шидэгдэж 60 метрийн диаметртэй “галт		95 / 20

			бөмбөлөг” үүсч 300 метрийн цаана байгаа хүмүүс түлэгдсэн		
1974	АНУ, Вест Сант Лос	Пропан-бутан	Шингэн хий хадгалах баазад автоцистернтэй холбосон холбоосноос хий алдагдаж 10-15 минутын дараа дэлбэрэлт болсон	3	47 / 4
1978	Испани	Пропан	Автын осол болж 22 тонн пропан асгарч дэлбэрэн шатсан		627 / 215
1984	Мексик	Пропан-бутан	Шингэн хий дамжуулах хоолойд ан цав гарч 200х150х2 хэмжээтэй үүлэн-цэр үүсгээд 12 минутын дараа тэсрэлт гарч 1600м ³ багтаамжтай 7 резервуар дэлбэрсэн	13	7097 / 644
2012	ОХУ, Астархан	Порпан-бутан	Орон сууцны 9 давхар барилгын 2 дугаар давхрын айлд ахуйн хий дэлбэрсний улмаас бүхэл бүтэн нэг орц нурсан		60 / 20
2013	Мехико	Порпан-бутан	Хий тээвэрлэж явсан автомашин осолдож дэлбэрсэн		3 / 20

Статистикийн мэдээгээр, хийн баллон дэлбэрч, хүн бэртэж, нас барсантай холбоотой гал түймэр нь гал унтраах үед байлдааны ажиллагаа явуулах явцад гарсан ослын нийт тохиолдлын 18 гаруй хувийг эзэлдэг байна. Ийм гал түймэрт гал түймэртэй тэмцэх албаны нас барсан бие бүрэлдэхүүний нийт тоо нь 45% -д хүрсэн харамсалтэй боловч үнэн судалгаа гарсан байдаг..

Мехико хотын хойт дүүрэгт 2013 онд Шингэрүүлсэн хий тээвэрлэж явсан ачааны автомашин осолдож дэлбэрсний улмаас 20 орчим хүн амиа алдаж гурван хүн түлэгдсэн байна.

“Ассошэйтед пресс” агентлагийн уламжилснаар дэлбэрэлтийн хүч ойр орчмын 45 метрийн зайнд туссан байна. Үүний улмаас ойр хавийн оршин суугчдын байшин, гудамжинд байсан автомашин, 20 айлын байшин өртжээ.

2013 онд Мексикийн булангийн Веракруз мужид хий тээвэрлэж явсан хоёр ачааны автомашин дэлбэрсний уршгаар 43 хүн амиа алдаж байв. Тус улсын хувьд хийн ачааны автомашин 80 тонн хэмжээтэй хий тээвэрлэхийг зөвшөөрдөг бол АНУ дээд тал нь 40 тонн байдаг.

Улсын хэмжээнд 2009-2015 онд бортого бүхий шингэрүүлсэн хийтэй холбогдон гарсан гал түймрийн судалгаа.

Хүснэгт.5.

д/д	Он	Хаяг	Аж ахуйн нэгж, иргэн	Шатсан эд зүйл	Хохирол /төгрөг/	Гэмтэж, нас барсан	Шалтгаан
1	2009	ХУД	“Коко-Коло Кебаб” хоолны газар	Хийн тулга		2 / - 1	Хийн тулга дэлбэрсэн
2	2011	БЗД	“Loving hut” цагаан хоолны газар	Хийн тулга		4 / -	Хийн тулгыг цэнэглэх гэж байгаад
3	2012	БЗД	Хүнсний үйлдвэр	Хий дэлбэрсэн		4 / -	
4	2012	Дархан	Дархан 12 дугаар баг 26 тоот	Хий дэлбэрсэн		3 / -	Хий алдснаас дэлбэрсэн
5	2012	СБД	“Дашваанжил” ХХК-ий хий тээвэрлэгч автомашин	Хийн баллон ачсан машины дугуй нь эвдэрсэн			СУИС-ийн зүүн 4 замын уулзварт автомашин
6	2014	СХД	“Барс-2” Хүнсний захын Цайны газар	Хийн баллон дэлбэрсэн			Цайны газрын барилга, эд хөрөнгө шатсан

Дархан-Уул аймгийн Дархан хот буюу 12 дугаар багийн шинэ хорооллын 14 дүгээр байрны 7-н давхрын 26 тоотод 2012 оны 1 дүгээр сарын 21-ний 21 цагийн орчим хийн түлшний баллон дэлбэрэх үед 32 өрхийн 113 иргэд байжээ.

Дэлбэрэлтэнд 4 цонх цуурч, 63 цонх хагарсан, 2 айлын хана, тааз цөмөрсөн, 10 айлын хаалга эвдэрснээс гадна эсрэг талд нь байрлах Дархан хотын шуудан холбооны барилгын цонхнууд хагарсан байсан нь дэлбэрэлтийн хүч маш их байсныг гэрчилж байна. Энэ дэлбэрэлтээс нэг сарын дараа ОХУ Астарханы осол аюул дээр ОХУ-ын Засгийн газрын тэргүүн В.Путин, Онц Байдлын Яамны сайд С.Шойгу нар газар дээр нь хүрэлцэн ирж шуурхай арга хэмжээ авч ажиллажээ.

Төрийн тэргүүний хувиар гамшгийн нөхцөл байдлыг биечлэн нүдээр үзэж байгаа нь Төрөөс энэ талаар цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээндээ анхаарч тусгах бодлогоо тодорхойлох гэсэн холч мэргэн бодлого гэж үзэхээс өөр аргагүй юм.

Өнгөрсөн гурван жилд шингэрүүлсэн шатдаг хийн ашиглалтын аюулгүй ажиллагаа, технологийн горим, техникийн бүрэн бүтэн байдлын зөрчлөөс болж 20 удаа гал түймрийн аюул гарснаас найман хүн хүнд хөнгөн гэмтэл авч төр, иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 299 сая төгрөгийн хохирол учруулсан судалгаа байдаг.

Хамгийн сүүлийн үеийн судалгаа, мэдээлэлд 2022 оны эхний 6 сард 100 гаруй хүүхэд хий үнэрлэн мансуурчээ. Хийн аюулын онцлог, хортойг тэр бүр ойлгоогүй нь аюулын харанга дэлдэж байгаад бодитой дүгнэлт хийхийг сануулсан сэрэмжлүүлэг болж байна.

Хий буюу газрын тосны хийг үнэрлэн, мансуурч донтсоноос 5-7 секундийн дотор тархинд нэвтэрч тархины эд, эс үхждэг талаар холбогдох мэргэжлийн байгууллага анхаарах цаг болсон ноцтой баримт юм.

2014 онд “Барс-2” Хүнсний захын зэргэлдээ орших “Цайны” газарт хийн баллон дэлбэрч ихээхэн хохирол учруулсныг гал унтраах 4 ангийн хүчээр унтрааж байсан билээ.



Зураг 2. Гал түймэр гарсны дараах байдал.

Дээрх баримтуудаас үзэхэд, ажил үйлчилгээ эрхэлдэг ажилчин, албан хаагч нарын зүгээс галын аюул бүхий тоног төхөөрөмж, шатах шингэлэг, хийн бодистой буруу харьцах, хөдөлмөр хамгаалал, аюулгүйн ажиллагааны анхан шатны шаардлага, дүрэм, журмыг мэддэггүй, мэддэг ч гэсэн дагаж мөрддөггүй, хэнэггүй зангаасаа болж өөрийгөө болон гэм зэмгүй олон хүний амь нас, амьдралыг хохироож болох харамсалтай бөгөөд эмгэнэлтэй дүр зураг харагдаж байна.

Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор баталсан “Шингэрүүлсэн шатдаг хийн хөтөлбөр” нь дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн байгаль орчинд хор нөлөөгүй, эдийн засгийн өндөр ашигтай, дэвшилтэд технологийг өөрийн орны өвөрмөц ахуйн нөхцөлд зохицуулан нэвтрүүлэхэд чиглэгдсэн байдаг.

Хийн аж ахуйн аюул, хор хөнөөл эрсдлийн талаар нэгдмэл зөв ойлголт, тодорхой чиглэсэн бодлого болон хувийн хэвшлийн аж ахуйн байгууллагыг дэмжих нэгдсэн нэг тогтолцоотой болох хамтарч ажиллах шаардлага ихээхэн үгүйлэгдэж байна.

Ашигласан материал

- Natural gas overview (1)
- WU*AFVTP – Propane Review
- Using Gas Geochmistry to Assess Mercury Risk
- Монгол Улсын Үндсэн хууль. Улаанбаатар, 1992 он
- Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал, 3.2.4, 3.3, 3.4.
- Монгол улсын “Галын аюулгүй байдлын тухай хууль” шинэчлэн найруулсан УБ.2015 он.
- Монгол улсын “Гамшгаас хамгаалах тухай хууль” хууль. УБ.2003 он.
- БНБД 21-02-02 Барилга, Байгууламжийн Зураг Төсөл Зохиох Галын Аюулгүйн Норм
- Хийн Аж Ахуйн Техник Ашиглалтын Дүрэм УБ, 2004 он
- Хийн Аж Ахуйн Аюулгүйн Ажиллагааны Дүрэм УБ, 2004 он
- Даралтад Савыг Төхөөрөмжлөх Аюулгүй Ашиглах Дүрэм УБ, 2004 он
- 2022 №1(8) Ч.Уранхайч (Мс.С) нарын Хивэгч малаас ялгарч байгаа метан хий тодорхойлсон дүн, Гамшиг судлал, инноваци, 2022 №1(8) х-59-74

- С.Базаррагчаа доктор (Ph.D) Хот суурин газрын объектын гал түймрийн эрсдэлийн үнэлгээнд орчин үеийн арга техникийг ашиглах нь Гамшиг судлал,инновац, 2022 №1 (8) х-32-47
- Абдургимов И,М, Говров В.Ю, Крылов Е.В. Физико-химические основы развития и тушения пожаров, - М.ПИПТШ МВД СССР, 1980,- 364 с.
- Баратов А.Н. Справочник Пожаро взрывоопасность веществ и материалов и средств их тушения. А.Н. Баратов, А.Я. Корольченко. М, Химия, 1990-384 с.
- В.В.Требнев “ Пожарная тактика” Книга 5. Пожаротушение Часть 3. Горючие жидкости и газы. Москва,2020.
- Научно - исследовательский институт противопожарной обороны. “ Рекомендация “ Москва, 2000г.
- Рябов И.В. Справочник Москва,70 “Пожарная опасность веществ и материалов, в химических промышленности.

**УУЛ УУРХАЙН САЛБАРТ АЖИЛЛАГСДЫН ХҮҮХДҮҮДИЙН НИЙГМИЙН
ЗАРИМ АСУУДАЛ**

/Өмнөговь аймгийн Ханбогд сумын жишээн дээр/

SOME SOCIAL PROBLEMS OF CHILDREN WORKING
IN THE MINING SECTOR

/On the example of Hanbogd sum of Umnugove province/

Э.Золбоо

*ДХИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн
Нийтийн эрх зүйн тэнхимийн багш, цагдаагийн ахмад*

Товч агуулга: Өмнөговь аймгийн Ханбогд сумын хэмжээнд хөдөлмөрийн насны нийт иргэдийн 34% нь Оюутолгой болон гэрээт компаниудад ажилладаг. Ханбогд сумын Б.Чогдовын нэрэмжит 1 дүгээр сургуулийн нийт 654 сурагчаас 240 хүүхдийн 338 эцэг, эх уул уурхайн салбарт ажилладаг. Ханбогд сумын 2 дугаар сургуулийн нийт 797 сурагчдын 344 сурагчийн эцэг, эхийн хэн нэг нь “Оюу толгой” болон бусад гэрээт компанид ажилладаг. Ээлжийн буюу ростерын хуваарийн дагуу 28/14 гэж ажилладаг ба цаг үеийн үүссэн нөхцөл байдлаас шалтгаалан ажил дээрээ удаан хугацаагаар тусгаарлагдан гэртээ ирэх боломжгүй байна. Иймээс хүүхдэдээ тавих хараа хяналт, халамж багасаж, үүний улмаас сургууль завсардалт ба хожимдолт, ялгаварлан гадуурхалт, сургууль дээрх дээрэлхэлт, хүүхдийн хүмүүжил орхигдож байгаа тул эдгээр нийгмийн асуудлуудыг хөндөх шаардлага үүсэж байна.

Уул уурхайн хөгжилтэй холбоотой бас нэг шинэлэг үзэгдэл бол “өрх толгойлсон” хүүхдийн асуудал юм. Өмнөговь аймгийн Ханбогд сумын 1 болон 2 дугаар сургуулийн сурагчдын 10 хүүхэд тутмын 4 нь эцэг, эхийн аль нэг нь эсвэл хоёулаа уул уурхайн ажил эрхэлдэг. Мөн тэдний зарим нь гэртээ ганцаараа харгалзах хүнгүйгээр урт, богино хугацаанд бие даан амьдрах явцад олон төрлийн эрсдэл тулгардаг. Тийм учраас Өмнөговь аймгийн Ханбогд сумын иргэдийн уул уурхайн ажил эрхлэлт ба түүнийг дагасан хүүхдийн нийгмийн асуудлыг хөндлөө.

Abstract: 34% of all working-age citizens in Hanbogd Sum work in Oyu Tolgoi and contract companies. 338 parents of 240 children out of 654 students of the 1st school named after B. Chogdov ABTA of Khanbogd sum work in the mining industry. One of the parents of 344 students out of a total of 797 students of Hanbogd 2nd School works in "Oyu Tolgoi" and other contracting companies. According to the shift or roster schedule, he works 28/14, and due to the current situation, he is unable to come home after being isolated at work for a long time. Therefore, there is a need to address these social issues, as there is less supervision and care for children, resulting in school dropouts and tardiness, discrimination, bullying at school, and child rearing.

Another innovative phenomenon related to mining development is the problem of "single-headed" children. According to the students of the 1st and 2nd schools of Hanbogd Sum, 4 out of 10 children have one or both parents engaged in mining. And some of them face various risks during long and short-term independent living alone at home. That's why Hanbogd clarified the mining employment of Sum people and the social problems of children that follow it.

Түлхүүр үгс: Хүүхдийн хөгжил, ажил эрхлэлт, ажил гэр бүлийн тэнцвэрт байдал, уул уурхай, хүүхдийн нийгмийн асуудал

Key words: Child development, employment, work-family balance, mining, children's social issues

Үндсэн хэсэг

Хөгжил гэдэг үгийг “Монгол хэлний тайлбар толь”-д хөгжих үйлийн нэр, дэвшил хэмээх үг гэж, “Монголын үндэсний нэвтэрхий толь”-д матери ба ухамсар, тэдгээрийн түгээмэл шинжийн эргэлтгүй чиглэсэн, зүй ёсны өөрчлөлт. Хөгжлийн үр дүнд объектын түүний бүтэц, бүрэлдэхүүний чанарын шинэ төлөв үүсдэг зэргээр

тодорхойлжээ. Дээрх тодорхойлолтууд ёсоор хөгжил бол өөрчлөлт шинэчлэлт гэсэн нийтлэг утга тод ажиглагдаж байна. Хүүхдийн хөгжил гэдэг бол хүүхэд бүр дамжин өнгөрөх үйл явц юм.

Сургалт ба оюун ухааны хөгжлийн харьцааны тухай Оросын сэтгэл зүйч Л.С.Выготскийн¹⁵⁰ үзэж байгаагаар, бидний өссөн орчин танин мэдэхүйн чухал үүрэгтэй байдаг. Бидний суралцах үйл явцад үзүүлж буй нийгмийн нөлөөг харгалзахгүйгээр танин мэдэхүйн хөгжлийг ойлгох боломжгүй гэж үздэг. Танин мэдэхүйн хөгжил нь бусадтай хамтран асуудлыг шийдвэрлэх нийгмийн харилцан үйлчлэлийн үр дүнд явагддаг. Энэ харилцан үйлчлэлд орсноор хүүхдийн танин мэдэхүйн хөгжлийн түвшин дээшлэх бөгөөд оюун ухааны үйл ажиллагаа нь хөгжиж эхэлдэг.

Швейцарын сэтгэл зүйч Жан Пиаже¹⁵¹ **Хүүхдийн оюун ухааны хөгжлийг дараах** байдлаар явагддаг гэж үзжээ. “Мэдлэг бол үйлдэл юм” үйлдлийн явцад схемүүд бий болно. Хүмүүс хөгжлийнхөө явцад мэдээллийг зохион байгуулах, гаднын ертөнцийг ойлгохын тулд илүү нарийн схемүүд хэрэглэдэг. Пиаже хүүхдийн оюун ухааны хөгжлийг чанарын хувьд өөр хоорондоо ялгаа бүхий 4-н үе шат болгон ангилжээ.

- Хүртэх-хөдөлгөөний үе шат \0-2 нас\
- Үйлдэл төлөвшихөөс өмнөх үе шат \2-7 нас\
- Тодорхой үйлдлийн шат \7-11,12 нас\
- Формаль үйлдлийн шат \12-с дээш\

Формаль үйлдлийн шат: Өсвөр насныхан нь тодорхой ба хийсвэр асуудлыг шийдвэрлэх, задлан шинжилгээ хийх чадвартай болсон байна. Тэд бүх боломжийг бодож үзэх, өнгөрснөө дурсан санаж, ирээдүйн төлөвлөгөө зохиож чадах ба адилтгал буюу шилжүүлсэн утгад тулгуурлан эргэцүүлдэг.

Оросын эрдэмтэн Д.Б.Эльконин¹⁵² **хүүхдийн сэтгэцийн хөгжлийн онцлогийг** тодорхойлохдоо “гол зонхилох үйл ажиллагаа”, “шинэ бүрдэлт” гэсэн ухагдахуунтай холбон тайлбарласан. Хүүхдийн сэтгэцийн үечлэлийг тодорхойлсон Д.Б.Эльконины үечлэлээс “Өсвөр нас\11-15\, Сургуулийн ахлах нас \15-17\ дараах хүснэгтээр харуулсан байна.

Хүснэгт 1.

Өсвөр нас /11-15/	Сургалт ба зохион байгуулалт бүхий хөдөлмөрийн үйл ажиллагааны явцад илрэх харилцаа	Янз бүрийн нөхцөлд илрэх харилцааны тогтолцоог танихад	Бие хүний / хэрэгцээ-сэдлийн тал/	“Том болох” мэдрэмж, тэмүүлэл өөрийн үнэлгээ, хамтын амьдралын хэм хэмжээнд захирагдах чадвар
Сургуулийн ахлах нас /15-17/	Мэргэжлийн хандлагатай сурах үйл ажиллагаа	Мэргэжлүүдийг танихад	Танин мэдэхүйн тал	Ертөнцийг үзэх үзэл мэргэжлийн сонирхол

Хүүхдийн оюуны хөгжлийг олон улсад үндсэн 3 хэсэгт ангилдаг байна. Үүнд:

- Танин мэдэхүйн хөгжил: Энэ бол хүүхдийн суралцах, аливаа асуудлыг шийдэх чадвар юм.

¹⁵⁰ О.Мягмар нар “Сэтгэл судлал” УБ.,2012 он.,141 дүгээр тал

¹⁵¹ О. Мягмар нар “Сэтгэл судлал”.УБ.,2012 он.,144 дүгээр тал

¹⁵² О. Мягмар нар “Сэтгэл судлал”.УБ.,2012 он.,145 дугаар тал

- Нийгэм ба сэтгэл санааны хөгжил: Энэ бол бусадтай харилцах, өөрийгөө удирдахад туслах чадвар юм.
- Хэл ярианы хөгжил: Энэ бол хүүхэд хэлийг ойлгож, хэрэглэх чадварыг хэлнэ.

Төр нь нийгмийн хөгжилтэйгөө тохируулан хүүхдийн талаар баримтлаж буй бодлогын баримт бичгүүдэд зохих өөрчлөлтүүдийг хийсээр ирсэн. Хүүхдийн хөгжил, төлөвшилд сургууль багш нар, тэдний гэр бүл, эцэг эх асран хамгаалагчаас гадна төрийн баримталж буй бодлого тодорхой нөлөө үзүүлдэг. Өнөөдрийг хүртэл манай улсын хүүхдийн асуудлаар нэгдэн орсон олон улсын конвенц, хүчин төгөлдөр хэрэгжиж буй хууль, эрх зүйн баримт бичиг, хэрэгжиж байгаа хөтөлбөрүүдэд хүүхдийн хөгжлийн талаар хэрхэн тусгасныг авч үзвэл:

Хүснэгт 2.

Хуулийн нэр /Хөтөлбөр, конвенц/	Баталсан он /Нэгдэн орсон/	Хүүхдийн хөгжлийг тодорхойлсон байдал
Хүүхдийн эрхийн тухай хууль	2016.2.5	6.1.Хүүхдийн бие махбодь, оюун санаа, ой ухаан, сэтгэц, зан байдал, харилцаанд гарч байгаа ахиц өөрчлөлтийг хүүхдийн хөгжил гэж үзнэ.
Боловсролын тухай хууль	2002.5.3	44.2.Багш дараахь үүрэгтэй: 44.2.5.суралцагч бүрийн онцлог байдлыг хүлээн зөвшөөрч хүнлэг харьцах, өөрөө өөрийгөө хөгжүүлэх, бие хүн болж төлөвшихөд дэмжлэг үзүүлэх; 46.2.Эцэг, эх, асран хамгаалагч дараахь үүрэгтэй: 46.2.1.хүүхдийн авьяас, чадварыг бага наснаас нь дэмжин хөгжүүлэх,
Гэр бүлийн тухай хууль	1999.8.1	4.5 Хүүхдийг гэр бүлийн дотор эрүүл чийрэг болгон өсгөн хүмүүжүүлэх, хөгжүүлэх, түүний эрх ашиг нь нэн тэргүүнд хамгаалахыг эрхмэлэнэ.
Хүүхдийн эрхийн тухай конвенц /НҮБ/	1989.11.20	Хүүхдийн амьдралыг тодорхойлох 4 үндсэн эрхийг тусгасан.Үүнд: - Эсэн мэнд өсөж бойжих - Хөгжих - Асарч хамгаалуулах - Оролцох эрх
Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөр	2017	2.1.Хөтөлбөрийн зорилгоХүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах, хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог бусад салбарын оролцоотойгоор бэхжүүлж, хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино. 2.2.2.хүүхэд бүрийг хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлж, хүүхдийн авьяас, чадварыг нээн хөгжүүлнэ.

Аливаа улсын үнэт баялаг бол иргэн нь байдаг билээ. Ирээдүйн иргэд болох хүүхдийг хөгжүүлэх, төлөвшүүлэхэд эцэг эх, багш нараас анхаарал тавьж, төрийн бодлогоод нарийн тусган уялдаа холбоотой ажиллах шаардлага бидэнд тулгарч байна.

Хүүхэд хөгжил, хүмүүжил, төлөвшлийн талаар бусад улс орнуудын бодлогодоо хэрхэн тусгасан байдаг талаар судлан үзэхэд:

Боловсролын салбарт тэргүүлэгч *Финлянд* улсын төрийн бодлогын хувьд “төр нь нийт ард иргэдийн аз жаргалын өмнө хариуцлага хүлээнэ” гэсэн зарчмыг баримтлан, төрийн үнэт капитал бол хүн гэж үзсэн ба хүнийг хөгжүүлж төлөвшүүлэх боловсролын бодлогодоо маш их анхаардаг байна. Хүүхдийн өөрийнх нь өсөлт, хөгжлийн хирээр өөрсдөд нь шинэ хэрэгцээ үүсэж байдаг. Хэрэгцээг хүүхэд өөрөө бие даан хангаж чадахгүй. Эцэг эх болон насанд хүрэгчдийн анхаарал халамж дэмжлэг туслалцаатайгаар хангагддаг байна.

ОХУ-д хүүхдийн бие бялдрын, ёс суртахууны, хөдөлмөрийн зэрэг уламжлалт хүмүүжлийн чиглэл дээр санхүү эдийн засгийн, эрх зүйн хүмүүжил, сүүлийн үед шашны хүмүүжилд их анхаарах болжээ. Хүүхдийн хүмүүжил, төлөвшлийг хичээл сургалт, хичээлээс гадуурх олон төрлийн үйл ажиллагаагаар хангахыг сургууль боловсролын байгууллага, багш мэргэжилтнүүд, гэр бүлийн үүрэг болгож тодорхойлсон байна.

БНХАУ “Хүүхдийн хөгжлийн үндэсний хөтөлбөр 2011-2020” бодлогын баримт бичиг баталж хүүхдийн хөгжлийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал, нийгмийн орчин гэсэн дөрвөн хүрээнд үндсэн зорилго, хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа тодорхойлсон байна. Хүүхдийн өв тэгш хөгжлийг дээшлүүлэх хот, хөдөөгийн хүүхдийн хөгжлийн ялгааг багасгах хүүхдэд ээлтэй нийгмийн уур амьсгал бүрдүүлэх, ялангуяа гэр бүлийн боловсрол үүрэг оролцоог онцолжээ.

Гэр бүл нь хүний хөгжил төлөвшлийн анхдагч орчин, нийгмийн үндсэн нэгж, соёл, зан заншил уламжлал өвлөгдөн шинэчлэгдэх аж төрөх ёсны бичил ахуй билээ. Монгол улсын төрөөс баримтлах хүн амын бодлогод “Гэр бүл нь хүний амьдралын анхдагч орчин, нийгмийн үндсэн нэгж гэж үзэж, түүний хөгжлийн тухай асуудлыг төрийн бодлогын анхааралд байлгана” гэж заасан нь өнөөгийн төр засгаас гэр бүлийн талаар баримтлах бодлогын үндэс болж байна.

Хүүхдүүд дийлэнх хугацааг гэр бүлийн орчинд өнгөрүүлдэг тул зөвхөн сургууль, багшид даатган орхихгүйгээр эцэг эх өөрсдөө хүүхдэдээ тавих анхаарал халамжаа нэмэгдүүлэн, өөрөө үлгэрлэн тэднийг хөгжүүлэх хэрэгтэй.

Нийгмийн асуудал: Социологийн шинжлэх ухаанд нийгмийн асуудлын талаар дагнан судалдаг чиглэл бий болсон бөгөөд зохиол бүтээлүүдээс харахад нийгмийн асуудлын тухайд онолын болон эмпирик социологийг хөгжүүлж байна. Нийгмийн асуудал гэж юу вэ? гэсэн асуултад Линда нарын судлаачид нийгмийн асуудал нь олон янзын хэлбэртэй байж болох боловч, ямарч асуудал объектив болон субъектив элементтэй гэжээ. Тэднийхээр объектив элемент нь оршин буй нийгмийн нөхцөл байдал бол субъектив элемент нь энэхүү нөхцөл байдал нь нийгэмд эсвэл түүний тодорхой хэсэгт хор нөлөөтэй. Тиймээс өөрчлөгдөх ёстой гэсэн итгэл үнэмшил болохыг тэмдэглэжээ. Түүнчлэн, судлаач Винсентийн тодорхойлсончлон, нийгмийн асуудал нь дараах дөрвөн үндсэн элементийг агуулдаг байна. Эдгээр нь:

1. Хувь хүн болон нийгэмд бодит болон оюун санааны хор хөнөөлийн шалтгаан болдог,
2. Нийгмийн гишүүдийн, тэр дундаа хүч нөлөө бүхий хэсгийн үнэт зүйл, стандартыг зөрчиж байдаг,
3. Тодорхой хугацааны туршид оршдог ба даруй шийдвэрлэгдэх боломжгүй,
4. Өөр хоорондоо өрсөлдөх хандлагатай олон шийдлүүдийг бий болгодог, учир нь нийгэмд янз бүрийн байр суурь бүхий бүлгүүдээс харилцан адилгүй байдлаар үнэлдэг бөгөөд энэ нь түүнийг шийдвэрлэх талаар зөвшилд хүрэх явцыг сунжруулдаг.

Нийгмийн асуудал нь хувь хүн, бүлэг цаашилбал бүхэл нийгэмд хор хөнөөл учруулах боломжит эрсдэлийг агуулдаг бөгөөд түүний учир шалтгааныг тодорхойлж, ойр, холын үр дагаврыг бууруулах явдал хамгийн чухалд тавигддаг.¹⁵³ Нийгмийн асуудлын хор хөнөөлийг социологичид хувь хүн, бүлгийн амьдралд бий болох

¹⁵³ М.Энхбадрал. “Орон нутгийн залуучуудын нийгмийн асуудалд хийсэн социологийн шинжилгээ: Өмнөговь аймгийн жишээн дээр” магистрын ажил

нийгмийн асуудал, сэтгэлзүйн, эдийн засгийн, эрүүл мэндийн үр дагавар гэсэн гурван чиглэлээр тооцоолон гаргах оролдого хийж байх нь бий. Нийгмийн асуудал нь хүч нийгмийн гишүүдийн үнэт зүйл, стандартыг зөрчиж буй зүйл бөгөөд тиймээс түүний талаарх ойлголт цаг хугацаа, орон зайгаас хамааран өөрчлөгдөж байдаг. Түүхэн, нийгэм соёлын хүчин зүйлээс хамаарч нийгмийн асуудал шинээр бүтээгдэж, тайлбарлагдаж байдаг гэж үзэх бөгөөд тухайлбал, гэр бүлийн хүчирхийлэл нь хөгжиж буй орнуудад саяхнаас нийгмийн ноцтой асуудал гэдгийг хүлээн зөвшөөрсөн бол исламын шашинтай орнуудад соёлын хүчин зүйлээс хамаарч өрнөдийн жишгээс өөрөөр ханддаг.

Ажлын байран дахь бэлгийн дарамтыг барууны орнуудад нийгмийн асуудал гэдгийг хүлээн зөвшөөрч, тусгайлсан хууль дүрмээр зохицуулсан бол хөгжиж буй орнуудад нийгэмд энэ талаар нэгдмэл ойлголт үгүй байгаа юм. Гэхдээ тухайн нийгмийн хамгийн хүч нөлөө бүхий хэсгийн зүгээс үнэт зүйлс, стандарттай нийцэхгүй байгаа гэж үзэх нь ихээхэн чухал байдаг. Социологийн өнөөгийн мэдлэгийн төвшинд нийгмийн асуудал шийдвэрлэгдэхгүй удтал оршин байхад хүргэдэг хүчин зүйлс бий. Үүнд: 1) одоогийн нөхцөл байдал нь хүч нөлөө бүхий хүмүүст ашигтай байгаа бол, учир нь зарим шийдэл уламжлалт эрх мэдлийн бүтэц, хүчийг өөрчлөхөд хүргэдэг, 2) нийгмийн хөгжил нь тухайн асуудлыг шийдвэрлэх техник технологийн төвшинд хүрээгүй бол, 3) олон түмний ойлголт мэдлэг доогуур, хандлага, итгэл үнэмшил нь асуудал гэж үзэхгүй байгаа бол, 4) түргэн шийдвэрлэх синдром буюу аливаа асуудлыг шийдвэрлэхэд хугацаа хэрэгтэй байдаг зэргийг дурдаж болно.

Америкийн социологичид Иерл (Earl), Мартин (Martin) нар “Нийгмийн асуудлуудын судалгаа бүтээлдээ” нийгмийн асуудал бол илэрхий олон тооны хүмүүсийн үнэт зүйлстэй нийцэхгүй байгаа эдгээр хүмүүс түүнийг засч, сайжруулах үйл ажиллагаа хэрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрч буй нөхцөл байдал мөн.¹⁵⁴

Хүснэгт 3.

№	Нийгмийн институтууд	Нийгмийн асуудлууд	Нийгмийн бодлогын хувилбарууд
1	Гэр бүлийн институт	Гэр бүл салалт, гэр бүлийн хүчигхийлэл, хүүхдийн хүмүүжил доройтох	Гэр бүлийн бодлого, гэр бүлийн нийгмийн ажлын үйлчилгээ
2	Боловсролын институт	Сургууль завсардалт ба хожимдолт, ялгаварлан гадуурхалт, сургууль дээрх дээрхлэлт	Хүүхдэд ээлтэй сургууль, сургуулийн нийгмийн ажил, хүмүүжлийн хөтөлбөр,
3	Эдийн засгийн институт	Ядуурал, ажилгүйдэл, мөлжлөг, боолчлол	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих идэвхтэй бодлого, старт ап, хөтөлбөр, нийгмийн зээл
4	Эрүүл мэндийн институт	Халдварт, халдварт бус өвчлөл, эх нялхсын эндэгдэл, сэтгэцийн эмгэг	Нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрүүд, эрүүл мэндийн нийгмийн ажил
5	Шүүх эрх мэдлийн институт	Гэмт хэрэг, мансууруулах дон, амиа хорлолт, биеэ үнэлэлт, хүний наймаа, эрүүдэн шүүлт, терроризм	Шүүх эрх мэдлийн бодлого, урьдчилан сэргийлэлт, хорих байгуулгын нийгмийн ажил
6	Улс төрийн институт	Оролцоогүй байх, эрх үүргээ мэдэхгүй байдал, ялгаварлан гадуурхалт	Засаглалын бодлого иргэний боловсрол, иргэдийн оролцоог

¹⁵⁴ М.Энхбадрал. “Орон нутгийн залуучуудын нийгмийн асуудалд хийсэн социологийн шинжилгээ: Өмнөговь аймгийн жишээн дээр” магистрын ажил. УБ хот., 2020 он

			дээшлүүлэх, чадваржуулах үйлчилгээ
7	Нийгмийн экологийн асуудал	Цаг уурын өөрчлөлт, орчны бохирдол, дэлхийн дулаарал	Экологид ээлтэй үйлдвэрлэл, нөлөөллийн үнэлгээ, компанийн нийгмийн хариуцлага

Нийгмийн асуудлыг 4 арга замаар танин мэддэг бөгөөд

- 1) олон нийтийн санал бодлоор
- 2) экспертийн санал бодлоор,
- 3) хэвлэл мэдээллийн агуулгаар,
- 4) хамтын зан үйл ба нийгмийн хөдөлгөөнөөс зэргийг дурьдаж болох юм.

Ажил эрхлэлт ба гэр бүлийн тэнцвэрт байдал: *Ажил-амьдралын тэнцвэр* Work-life balance: “Ажил-амьдралын тэнцвэр” гэдэг нэр томьёо нь зөвхөн тэжээлгэгч, хамаатан саднаа асран халамжлахыг төдийгүй “хичээлээс гадуурх” үүрэг хариуцлагыг буюу амьдралын чухал хүрээг хамруулдаг. Ажлын цагийн зохион байгуулалт нь аль аль хүйсийн ажиллагчдыг насан туршдаа суралцах, ажил мэргэжлийн болон хувь хүний цаашдын хөгжилдөө анхаарах боломж олгохуйц хангалттай уян хатан байх ёстой.¹⁵⁵ Ийнхүү насан турш суралцах хөгжиж боловсрох нь эрхэлж буй ажилтайгаа холбоотой байх албагүй юм. Өрх гэр болон ажлын байран дахь үүрэг хариуцлагыг эмэгтэй эрэгтэй хүмүүс илүү тэгш хуваалцахыг дэмжих нь гол зорилго болж, ажил мэргэжилдээ ахиж дэвших боломж, насан туршийн суралцах болон бусад ажил мэргэжлийн ба хувийн хөгжлийн үйл ажиллагаатай холбоотой асуудлууд нь хоёрдугаарт тавигдаж байна.

Ажил- гэр бүлийн тэнцвэр Work-family balance: Гэр бүлийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлага болон ажлын шаардлагын хооронд гардаг зөрчил нь хөдөлмөрийн зах зээлд эмэгтэй хүнийг ашиггүй байдалд оруулж, хөдөлмөр эрхлэлтэд эмэгтэй эрэгтэй хүмүүст тэгш боломж олгох, тэгш хандахад чиглэсэн дэвшилд тушаа болдог. Эмэгтэйчүүд гэр бүлийн үүрэг хариуцлагаа цалин хөлстэй ажилтай хослуулахын тулд цалин хөлс багатай, баталгаагүй, хагас цагийн, гэрээс гүйцэтгэх, эсхүл албан бус ажлыг сонгодог, эсхүл сонгохоос өөр аргагүйд хүрдэг бол эрэгтэйчүүдийн ажлын шаардлага болон гэр бүлийн амьдралаа хослуулахад тулгардаг бэрхшээл нь тэднийг гэр бүлд нь ашиггүй байдалд оруулж, гэр бүлийнхээ амьдалд оролцох чадварыг нь хязгаарладаг байна.

“Өрх толгойлсон хүүхэд” ба холбогдох эрсдэлүүд: Эцэг, эхчүүд хөдөө уул уурхай, мал аж ахуйн болон бусад ажил эрхлэхээр урт хугацаагаар эзгүй үедээ хүүхдээ хэн нэгэнд даатган асран хамгааллын хариуцлагын ямар ч гэрээгүй үлдээдэг. Зарим эцэг эхчүүд хүүхдээ аймгийн төв, сумын төвд сургахын тулд айлын хашаанд гэр барьж үлдээснээр дүү нараа асран хамгаалах үүргийг сурагч ах, эгч нар хүлээснээр “өрх толгойлогч хүүхэд”, мөн **“тавиул”** хүүхэд гэх нэр томьёо манай орон нутгийн хэмжээнд шинээр дэлгэрээд байна. Хэдийгээр нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг Монголчуудын хувьд хүүхдүүдээ хамаатан садныдаа удаан хугацаагаар суулгах үзэгдэл нийтлэг байдаг ч, уул уурхайгаас үүдэлтэйгээр өрх толгойлсон хүүхдийн асуудал илүү хурцаар тавигдаж байна.

“Өрх толгойлсон хүүхэд” нь дүү нарынхаа асран хамгаалагчийн үүргийг гүйцэтгэж, харин өөрийг нь асран хамгаалах хүн байхгүйн улмаас эрүүл аюулгүй орчинд өсч хөгжих эрх нь зөрчигдөж, сурч боловсрох эрхээ бүрэн эдэлж чадахгүй, үе тэнгийнхэндээ болон нийгэмд гадуурхагдах дээрэлхүүлэх, гэмт хэргийн хохирогч болох, холбогдох эрсдэл ихтэй амьдарч байна. “Тавиул” буюу айлд амьдарч байгаа хүүхдийн хувьд ч дээрх эрсдэлүүд байсаар байгаагийн дээр амьдарч байгаа айлдаа гэрийнх нь хүнд хүчир ажлуудыг нугалан амьдардаг ба бие махбод, сэтгэл санааны

¹⁵⁵ ОУХБ, Эмэгтэй ажиллагчдын эрх ба жендерийн тэгш байдлын лавлах., Уб хот., 2011 он

хүчирхийлэлд өртөх, хэрэгцээний хомсдолд орсноор сурч боловсрох, оролцох эрх нь хаагдах өндөр эрсдэлтэйгээр асран хамгаалагчийн хайр энэрлээс гадуур амьдардаг байна. Эцэг эхийн хараа хяналтгүй урт, богино хугацаанд бие даан амьдарч буй хүүхдүүдийн хувьд олон төрлийн эрсдэл тулгардгаас дурдвал:

- Ахуйн осол гэмтэлд өртөх;
- Хоол хүнс дутагдах,
- Эрүүл ахуй, ариун цэвэр алдагдах;
- Дүү нараа харахын тулд хичээл таслах,
- Үдэш орой гадуур тэнэх, гэмт хэрэг зөрчилд холбогдох;
- Согтууруулах ундаа хэрэглэх;
- Бэлгийн харьцаанд эрт орох;
- Танихгүй хүмүүст дээрэлхүүлэх;

Хүүхдийг уул уурхайн нөлөөлөлд өртөгч тал бөгөөд бие даасан оролцогч тал гэж үздэггүй тул тоо баримт хомс, дутуу байхын зэрэгцээ хүүхдэд уул уурхайн зүгээс үзүүлж буй нөлөөлөл, үүсч буй нийгмийн асуудлуудыг илрүүлж тодорхойлоход хүндрэлтэй байдаг.

Шигтгээ 1.

Ээж 2 сарын эхнээс хойш бараг 3 сар гэртээ ирэлгүй ажил дээрээ тусгаарлагдсан. Намайг өөр харах хүн байхгүй би гэртээ ганцаараа байдаг. Манайх айлын хашаанд байдаг, тиймээс ээж намайг тэр айлтай ханьтай байг гээд үлдээсэн. Түлээ, хүнсний зүйлс авах мөнгө ээж өгдөг тул асуудал их

Байгууллагуудын хүүхдэд чиглэсэн үйл ажиллагаа: Иргэдээ ажилтай орлоготой байлгах зорилгоор Уул уурхайн компаниудын ажилчдын 50-аас доошгүй хувь нь орон нутгийн иргэн байх гэсэн үндсэн шаардлагыг тавьдаг байна. Өнөөдрийн байдлаар манай сумаас Оюу толгой ХХК болон туслан гүйцэтгэгч компаниудад нийт 1632 иргэн ажиллаж байна. Ханбогд сумын хувьд хөдөлмөрийн насны 4810 иргэн байгаагаас төрийн албанд 435, уул уурхайд 1632, жижиг дунд үйлдвэрлэлт эрхлэгчид 27, малчид 1126 байна.

Уул уурхайн салбарын хөгжил Монгол Улсын эдийн засаг, нийгэмд үр өгөөжөө өгсөөр байгаа билээ. Тиймээс уг үр өгөөжийг ажилчид, тэдний үр хүүхэд, ажиллаж буй нийгэм, орон нутагтаа тэгш хүртээхээр дараах бодлогуудыг “Оюу толгой” ХХК Ханбогд суманд:

- Оюу толгой компани ирэх 30 жилд “Говийн Оюу” хөгжлийг дэмжих сангаар дамжуулан орон нутгийн хөтөлбөр, төслүүдийг санхүүжүүлэхэд жил тутам 5 сая ам.долларын хувь нэмэр оруулдаг.
- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн 100% хөрөнгө оруулалтаар бүтээн байгуулсан 640 хүүхдийн багтаамжтай 2-р сургууль, 200 хүүхдийн багтаамжтай 29-р цэцэрлэг 2018 оны 12 сард нээлтээ хийж, үйл ажиллагаагаа эхлүүлэв.
- 350 хүний суудалтай “Үлэмжийн чанар” соёлын өргөөг байгуулан хүлээлгэн өгөв.
- “Говийн Оюу” оюутны тэтгэлэг
- “Залуу манлайлагч” хөтөлбөр
- “Чадварлаг сурагчаас оюунлаг иргэн” хөтөлбөр
- “Жаргалтай хүүхдүүд” төсөл
- “Хөгжлийн төлөөх залуучууд” хөтөлбөр
- “Сэтгэмж” хөтөлбөр зэргийг хүүхдийн хөгжлийн чиглэлээр 2016 оноос үе шат дараалалтайгаар хэрэгжүүлж байна.

Ханбогд суманд үйл ажиллагаа эрхэлж байгаа “Уужим-Од” ХХК-ын төсөл хариуцсан менежер Г-тэй хүүхдийн хөгжлийн талаар ямар бодлого баримталж буйн талаар хийсэн ярилцлагаас:

- “Манай компани энэ жилийн хувьд хүүхэд хөгжлийн чиглэлээр дараах ажлыг хийж эхлэж байна. East Education Academy боловсролын төвтэй хамтран Ханбогд сумын 1,2-р сургуулийн төгсөх ангийн сурагчдад Нийгэм, Математик, Англи хэлний онлайн сургалтыг зохион байгуулж байна. Тус сургалтыг компанийн өөрийн хөрөнгөөр уг сургалтыг эхлүүлсэн. Мөн ажилчдынхаа хүүхдүүдэд уралдаан тэмцээнд орох болон буцалтгүй мөнгөн тусламж хандив өгдөг. Жил бүр хүүхдийн баярыг тохиолдуулан Эрдэнэ-Очир захирлын ивээл доор сумын шилдэг 100 хүүхдийг хүлээн авч шагнал урамшуулал олгодог. Боловсролын чиглэлээр шилдэг багш нар болон шилдэг хүүхдүүдийг урамшуулан компанийн нэрэмжит “Багшийн хишиг” мөнгөн шагнал болон өргөмжлөл цомыг гардуулдаг. Ажилчдынхаа ар гэрт уян хатан нөхцөлөөр хандаж ажиллуулдаг. Орон нутгийн ажилчид их байдаг болохоор ар гэрт ямар нэгэн асуудал гарах тохиолдолд чөлөө зөвшөөрөл өгдөг. Мөнх ногоон галба ТТБ захиргааны алба хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан ажилтантай хийсэн ярилцлага.

- Манай байгууллага суман дээр үйл ажиллагаа явуулдаг учраас ростер байдаггүй. Ажлын 5 өдөр амралтын 2 өдөртэй ажилладаг. Манай байгууллага байгаль орчны төрийн бус байгууллага, хүүхдүүдийн экологийн боловсролыг дээшлүүлэх гэсэн үндсэн хүүхэд хөгжлийн чиглэлээр дараах ажилуудыг хийдэг 1-р сургуулийн Эко клуб мөн шувуу хамгаалах төвтэй хамтраад сургууль хоорондын харилцааны хөтөлбөр хэрэгжүүлсэн экологийн боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагаа явуулдаг.

Оюу Толгой ХХК болон бусад уул уурхайн компаниуд нийгмийн хариуцлагынхаа хүрээнд орон нутагтаа хүүхдийн хөгжлийг дэмжсэн, тэдэнд чиглэсэн үйл ажиллагаануудыг зохион байгуулдаг.

Хүүхэд гэр бүлийн хүрээнд хөгжих сэдвийн дагуу сурагчдаас авсан судалгааны үр дүн

Уул уурхайд ажилладаг эцэг эхтэй хүүхдүүдийн нийгмийн асуудлыг болон тэдэнд учирч буй бэрхшээл эрсдэлийг ярилцлагын аргад тулгуурлан илрүүлж, шийдвэрлэж болох саналыг боловсруулах зорилгоор Ханбогд сумын 2-р сургуулийн 10 сурагч, сургуулийн нийгмийн ажилтан, ханбогд сумын цагдаагийн хэлтсийн дарга болон эцэг эхийн төлөөллөөс сонгож авч ганцаарчилсан ярилцлага өрнүүллээ. Эдгээр ярилцлагын үр дүнгээс үзвэл:

Сурагчдийн ярилцлагын явцад нийт судалгаанд хамрагдсан сурагчдаас 3 сурагч гэртээ бие даан ганцаараа амьдарч байна.

Шигтгээ 2

Манай ээж ажил дээрээ намар 3сар орчим гэртээ ирэлгүй хоригдсон. Тиймээс өглөө сэрээх хүн байхгүй хичээлдээ хааяа хааяа хоцордог байсан. Сая бас гэртээ ирэлгүй 2 сар шахуу болж байна. Манай хашаанд эмээгийн гэр бас байдаг болохоор хоол унд эмээгийнд орж иддэг. Харин гэртээ дандаа ганцаараа хонодог. ” 14 настай 8-р ангийн сурагч А

Эдгээр сурагчид 1-2 сарын хугацаанд харах хүнгүй гэртээ бие даан амьдарч байгаа нь нэг талаараа тэдэнд анхаарал халамж, хараа хяналт дутаж, тухайн хүүхдийн сурлага хоцрогдох, бусдаас тусгаарлагдах, ганцаарах зэрэг сөрөг нөлөөллийн үзүүлж байгаа цаашлаад сэтгэл зүйн хувьд асар их хор учруулж байна.

Харин эсрэгээрээ хичээл танхимаар орж байхад хичээл дээрээ идэвхи санаачлагагүй, нийгмийн оролцоо дутмаг байсан сурагчийн хувьд эцэг эх нь анхаарал хандуулсанаар тухайн хүүхдэд эерэг нөлөө үзүүлдэг байна.

“Манай ангийн сурагч Ө нь танхимын сургалтын үед сахилгагүй, хичээлийн даалгавар хийдэггүй байсан. Харин хөл хорионы үеэр өмнө ээжийнх нь ажил зогссон. Тиймээс ээж нь гэртээ байх хугацаандаа хүүхдүүдийнхээ хичээл сургаланд санаа тавьж, цахим хичээлд тогтмол суулгаж, гэрийн даалгаврыг нь хийхэд нь туслаж байгаа нь тус хүүхдийн сурлагад эергээр нөөлөөлж байгааг хичээл ордог багш нар нь сайшаан магтаж байна.” Ханбогд

Дүгнэлт

Судалгааны үр дүн болон сурагчдын кейс тохиолдлоос харахад эцэг, эх нь ажилдаа ихэнх цагаа зарцуулж байгаа нь хүүхдэдээ тавих анхаарал халамж, хараа хяналтыг бууруулахад хүргэдэг. Улмаар сурагчдын сурлагын амжилт буурах, тэдний хөгжил, хүмүүжил, төлөвшлийн асуудал зарим тохиолдолд бүрэн орхигдож байна.

Сүүлийн жилүүдэд бий болсон өрх толгойлсон хүүхэд гэсэн ойлголт Ханбогд суманд дэлгэрсэн байна.

Уул уурхайн салбараа дагаад хүмүүсийн ажил эрхлэлтийн байдал нэмэгдэх нь нэг талаараа нийгэм, эдийн засагт олон эерэг үр дагаварыг авчирч байгаа боловч нөгөө талаараа эцэг эхчүүдийн хүүхдээ сургуульд бүрэн даатгаж орхих явдал нь эргээд хүүхдийн зан төлөв, харилцаа хандлагын байдал сөргөөр нөгөөлөөд зогсохгүй боловсролыг чанаргүй эзэмшихэд хүргэж байна. Үүнээс үүдэн гэр бүл салалт, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн хүмүүжил доройтох, сургууль завсардалт ба хожимдолт, ялгаварлан гадуурхалт, сургуулийн орчин дахь дээрхлэлт нэмэгдэж байна.

Одоо шинээр үүссэн цаг үеийн байдалд эцэг эхийн үүрэг оролцоо орлуулашгүй их ба эцэг эхчүүд ажил, гэр бүлээ тэнцвэржүүлж хүүхдэдээ гаргах анхаарал халамжийг нэмэгдүүлж чөлөөт цагаа тэдэнтэй өнгөрүүлэх, гэр бүлийн орчинд хөгжих боломжийг бүрдүүлж өгөх шаардлагатай байна.

Санал

- Эцэг эхчүүдэд эцэг эх болох ёс суртахууны боловсрол, гэр бүл төлөвлөх мэдлэг олгох
- Хүмүүжлийн эерэг аргыг сурталчлах
- Ажил олгогчид ажилчиддаа эцэг, эхийн үүргээ биелүүлэх цаг олгодог байх, уртасгасан цагаар болон амралтын өдрүүдэд ажиллуулахгүй байх
- Уурхайн ажилчдын ростерийн хугацааг уян хатан нөхцөлөөр тодорхой хэмжээгээр багасгах
- Гэр бүлийн бодлого, гэр бүлийн нийгмийн ажлын үйлчилгээ
- Хүүхдэд ээлтэй сургууль, хүмүүжлийн хөтөлбөрийг сургуульд хэрэгжүүлэх

Ашигласан материал

Ном товхимол

- О. Мягмар “Сэтгэл судлал” УБ хот, 2012 он
- Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, “Хүүхдийн хөгжил, төлөвшил, хүмүүжилд сөрөг нөлөө үзүүлж болох хүчин зүйлийг тодорхойлох судалгаа” УБ хот., 2019 он
- ОУХБ, Эмэгтэй ажиллагчдын эрх ба жендерийн тэгш байдлын лавлах. УБ хо., 2011 он
- “Бүх хүүхдийн эрхийн төлөө” НҮБ-ийн хүүхдийн эрхийн хороонд илгээх тайлан. УБ хот., 2015 он

- М.Энхбадрал. “Орон нутгийн залуучуудын нийгмийн асуудалд хийсэн социолгийн шинжилгээ: Өмнөговь аймгийн жишээн дээр” магистрын ажил. Уб хот. 2020 он

Хууль, тогтоомж

- Гэр бүлийн тухай хууль. Уб., 1999 он
- Хүүхдийн эрхийн тухай хууль. Уб., 2016 он
- Хүүхдийн эрхийн конвенц. Уб., 1989 он
- Боловсролын тухай хууль. Уб., 2002 он
- Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөр. Уб., 2017 он

Цахим эх сурвалж

- https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/---ro-bangkok/---ilo-beijing/documents/publication/wcms_537372.pdf
- www.OT.mn
- www.khanbogd.gov.mn
- www.goviinoyu.mn

“ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ АСУУДАЛ” ОНОЛ, АРГА ЗҮЙН СЭТГҮҮЛ- 20 ЖИЛ

Б.Мөнхзул

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн
тэнхимийн багш, цагдаагийн ахмад*

Товч агуулга. Гэмт явдалтай тэмцэх асуудал онол, арга зүйн сэтгүүлийн 20 жилийн ойн хүрээнд тус сэтгүүлд нийтлэгдсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэлд дүн шинжилгээ хийж, чиг хандлагын тодорхойлсон.

Түлхүүр үг. Гэмт явдал, эрдэм шинжилгээний сэтгүүл, өгүүлэл, нийтлэл.

Дотоод хэргийн их сургуулиас эрхлэн гаргадаг “Гэмт явдалтай тэмцэх асуудал” онол, арга зүйн улирал тутмын сэтгүүл нь 2002 оноос эрдэмтэн, судлаачдын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг нийтийн хүртээл болгож эхэлснээс хойш эдүгээ 20 жил өнгөрчээ.

Энэ хугацаанд улирал тутмын дугаарыг тасралтгүй эрхлэн гаргаж, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чансааг илэрхийлсэн, олон нийтэд танигдсан, гэмт явдалтай тэмцэх үйл хэрэгт тодорхой хувь нэмэр оруулсан, хууль сахиулах салбарын ууган сэтгүүлүүдийн нэг болсон төдийгүй олон улс, улс, салбарын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн сэтгүүл болж чадсан.

Сэтгүүлийн нийтлэлийн бодлого нь эрдэмтэн судлаач, суралцагчдын шинжлэх ухааны мэдлэг, чадвар, сэтгэлгээг хөгжүүлэх, эрдэм шинжилгээний ажлын үр дүнг практикт нэвтрүүлэх, шинэ мэдлэг, технологи, туршлагыг түгээн дэлгэрүүлэх, нийгэмд сурталчлах, тулгамдсан асуудлыг орчин үеийн онол, арга зүйн түвшинд судлан шинжилж, ажиглалт, дүгнэлт хийж, асуудал дэвшүүлэн, шийдвэрлэх арга замыг тодорхойлох улмаар түүнийг нийтийн хүртээл болгон ашиглахад чиглэдэг.


“Гэмт явдалтай тэмцэх асуудал” онол, арга зүйн сэтгүүл нь 21 жилийн хугацаанд нийт 83 дугаарыг эрхлэн гаргасан ба эдгээр дугаарт нийт 1163 эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл хэвлэгдэн нийтийн хүртээл болсон байна. Тухайлбал, эрдэмтэн, судлаачид криминологийн чиглэлээр хамгийн олон буюу 298, эрүүгийн эрх зүйн чиглэлээр 158, эрүүгийн процессын эрх зүйн чиглэлээр 195, цагдаагийн эрх зүйн чиглэлээр 121, төр, захиргаа, иргэн, олон улсын эрх зүйн чиглэлээр 63, шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн чиглэлээр 35, шинжлэн магадлахуйн чиглэлээр 3, бусад салбар эрх зүй болон дуулиант хэрэг, бодлого, эрдэмтдийн үг, гэмт хэргийн статистик зэргээр 296 нийтлэл тус тус нийтлүүлсэн байна.



Сэтгүүлийн зөвлөл нь эрхлэгч, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэх ба эрхлэгчээр хууль зүйн доктор (Ph.D), профессор, Дотоод хэргийн их сургуулийн Хүндэт профессор Д.Зүмбэрэлхам, нарийн бичгийн даргаар доктор (Ph.D) В.Амарсанаа, гишүүдэд Монгол Улсын гавьяат хуульч-3, хууль зүйн шинжлэх ухааны доктор-4, доктор-25, гадаадын эрдэмтэн -1 ажиллаж байна.

Уг сэтгүүлийн 2013 оны дугаарт анх удаа гадаад хэлээр бичсэн өгүүлэл нийтлэгдэж байсан ба нийт гадаад хэлээр 62 өгүүлэл нийтлэгдсэнээс 19 нь Англи хэлээр, 43 Орос хэлээр нийтлэгдсэн байна. Үүнээс харахад, энэхүү сэтгүүл нь зөвхөн үндэсний хэмжээний бус гадаадын нэр хүндтэй эрдэмтэн, судлаачдын эрдэм шинжилгээний бүтээлийг нийтэлдэг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сэтгүүл юм.

Гадаадын их, дээд сургуулиас 36 өгүүлэл нийтлүүлсэн ба АНУ-аас 2, ОХУ-аас 23, Вьетнам улсаас 1, Өвөр Монголын их, дээд сургуулиас 10 өгүүлэл нийтлүүлсэн байна.



Монгол Улсын бусад их, дээд сургуулиар нь авч үзвэл:



Мөн сэтгүүлд их, дээд сургуулийн профессор багш нараас гадна төрийн өндөр албан тушаалтнууд эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлдэг нь тус сэтгүүлийн нэр хүндийг илтгэж байгаа явдал юм. Тухайлбал, 2004 онд Б.Болор Улсын Их хурлын гишүүн, Монголын эмэгтэй парламентчдын бүлгийн дарга, Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбооны тэргүүнээр, хууль зүйн доктор (Ph.D), профессор Л.Батжав Улсын Их хурлын Тамгын газар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгийн

газарт зөвлөхөөр, Э.Болормаа Улсын Их хурлын Тамгын газрын зөвлөхөөр, Г.Ганзориг Монгол Улсын Ерөнхийлөгчийн орон тооны бус хуулийн зөвлөхөөр, Б.Баярмаа Улсын Их хурлын Хууль зүйн байнгын хорооны зөвлөхөөр, Б.Түвшинтөгс Улсын Их хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны Ажлын албаны зөвлөхөөр, Ч.Нямсүрэн Улсын Дээд Шүүхийн Шүүхийн практик судлалын хэлтсийн даргаар тус тус ажиллаж байх үедээ эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлж байжээ.

Эрдэм шинжилгээний сэтгүүлд хамгийн олон өгүүлэл, нийтлэл нийтлүүлсэн эрдэмтэн, судлаачид:

№	Нэр, албан тушаал (Одоо эрхэлж байгаа)	Тоо	Тайлбар
1.	Б.Энхболд-Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, доктор (Ph.D), дэд профессор	26	Цагдаагийн академийн 141 дүгээр дамжааны сонсогч байх үеэс эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлсэн.
2.	Б.Батзориг-Монголын криминологчдийн холбооны гүйцэтгэх захирал, доктор (Ph.D), дэд профессор	20	Сэтгүүлийн нарийн бичгийн даргаар ажиллаж байсан, 2002 анхны дугаараас эхлэн эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлж эхэлсэн.
3.	Б.Эрдэнэбилэг-Хүний эрхийн Үндэсний Комиссын Ажлын албаны дарга	20	Цагдаагийн Академийн Эрүүгийн ба эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн тэнхимийн багшаар ажиллаж байх үеэс эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлж эхэлсэн.
4.	Б.Баянмөнх-Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D), цагдаагийн дэд хурандаа	19	Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн тэнхимийн багшаар ажиллаж байх 2014 оноос өгүүлэл нийтлүүлж эхэлсэн.
5.	С.Гантулга-Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирал, доктор (Ph.D), дэд профессор, цагдаагийн дэд хурандаа	18	Цагдаагийн академийн Захиргааны эрх зүйн тэнхимийн багшаар ажиллаж байх 2007 оноос эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлж эхэлсэн.
6.	Г.Гантөмөр-Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, доктор (Ph.D), профессор	17	Цагдаагийн Академийн Эрүүгийн ба эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн тэнхимийн ахлах багшаар ажиллаж байх 2002 оноос эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлж эхэлсэн.
7.	С.Жанцан-Монгол Улсын гавьяат хуульч, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор, цагдаагийн хурандаа	16	Цагдаагийн Академийн Эрүүгийн ба эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн тэнхимийн эрхлэгчээр ажиллаж байх 2003 оноос эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлж эхэлсэн.
8.	Л.Бат-Очир-Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн	15	Цагдаагийн Академийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн багшаар ажиллаж байх 2011 оноос эрдэм

	эрхлэгч, доктор (Ph.D), дэд профессор, цагдаагийн дэд хурандаа		шинжилгээний өгүүлэл нийтлүүлж эхэлсэн.
9.	Х.Сэлэнгэ-МУИС-ийн Хууль зүйн сургуулийн дэд профессор, доктор (Ph.D), профессор	13	2008 оноос эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлж эхэлсэн.
10.	Г.Бямбадорж-Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D), цагдаагийн дэд хурандаа	13	Хан-Уул дүүргийн Цагдаагийн хэлтсийн хэсгийн байцаагчаар ажиллаж байх 2010 оноос эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлж эхэлсэн.

Нэр бүхий судлаачид бакалаврт суралцаж байсан, их, дээд сургуульд багшилж байх үедээ эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлж байсан ба одоогийн байдлаар 9 хүн эрдмийн зэрэг хамгаалжээ.

Сэтгүүлд эрдэмтэн, судлаачдын хамтарсан 65 өгүүлэл нийтлэгдсэн байгаа нь зөвхөн хууль зүйн салбараас гадна бусад салбар шинжлэх ухааны чиглэлээр хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, тэдгээрийн үр дүнг нийтлэх, олны хүртээл болгох асуудалд шинэчлэл хийж байна гэж дүгнэж болохоор байна.

Дүгнэлт

“Гэмт явдалтай тэмцэх асуудал” онол, арга зүйн улирал тутмын сэтгүүл нь анх эрхлэн гаргаж эхэлснээс хойш нэг ч дугаар алгасаагүй, тогтмол хэвлэгддэг, олон улс, улс, салбарын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, сэтгүүлийн зөвлөлд гадаадын болон дотоодын нэр хүнтэй эрдэмтэд ажиллаж өндөр хянан магадлагаа хийдэг, криминологийн чиглэлийн ууган, цахим анхны сэтгүүлийн нэг юм.

Цаашид сэтгүүлийн бодлогын болон редакцын зөвлөлөөс эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэлийг төлбөртэй хүлээн авч, нийтлэх, англи хэлээр дугаарыг эрхлэн гаргах, сэтгүүлийн зөвлөлд гадаадын их, дээд сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн нэр хүнтэй эрдэмтдийг олноор урьж ажиллуулах, тэдний бүтээлийг нийтэлж, судалгааны эргэлтэд оруулах, олон улсын өндөр хянан магадлагаа бүхий сэтгүүлийн жагсаалтад бүртгүүлэхээр зорьж байна.

Ашигласан материал

- “Гэмт явдалтай тэмцэх асуудал” онол, арга зүйн сэтгүүлийн 2002-2022 оны дугаарууд

ӨМГӨӨЛӨГЧ НИЙТИЙН ЭРХ, АШИГ СОНИРХЛЫГ ХАМГААЛАХ ЗОРИЛГООР ШҮҮХЭД НЭХЭМЖЛЭЛ ГАРГАХ АСУУДАЛ

THE MATTERS WITH ATTORNEYS FILING CLAIMS TO PROTECT THE RIGHTS AND
INTERESTS OF THE PUBLIC

Д.Энх-Амар

*ДХИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн
Нийтийн эрх зүйн тэнхимийн багш, цагдаагийн ахмад*

Г.Мөнхцэцэг

*Эрх зүйн магистрын хөтөлбөрийн
7021 дүгээр дамжааны магистрант*

Товч агуулга: Нийтийн эрх, ашиг сонирхлыг хамгаалж шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийн талаар материаллаг болон процессын хуулиудад тодорхой зохицуулалт байхгүй байсан бөгөөд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулга 2016 онд батлагдсантай холбоотой анхны зохицуулалт хуульд тусгалаа олж байжээ. Улмаар Өмгөөллийн тухай хууль 2019 онд батлагдаж уг хуулиар өмгөөлөгч нь нийтийн эрх ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг хуульчилж өгсөн болно. Тодруулбал, Өмгөөллийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3-д “Өмгөөлөгч энэ хуульд заасан нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад нийтийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор өөрийн нэрийн өмнөөс төрийн байгууллага, шүүхэд гомдол, нэхэмжлэл гаргах эрхтэй” гэж заасан бөгөөд уг эрхийнхээ хүрээнд өмгөөлөгч шүүхэд нэхэмжлэл гаргахад практикт тулгамдаж буй асуудлыг энэхүү сэдвийн хүрээнд хөндөнө.

Abstract: There was no explicit provision in the substantive or procedural laws governing the right to sue for the protection of public rights and interests. The first regulation relating to the enactment of the revised Law on Administrative Procedure in 2016 was reflected in the law.

As a result, the Law on Advocacy was enacted in 2019, and the law legislates an advocate's power to initiate a lawsuit in order to protect public interests. Specifically, Paragraph 29.3 of the Law on Advocacy states that "a lawyer has the right to file a complaint or claim on his own behalf with a government organization or court in order to protect public rights and interests in carrying out professional activities that are beneficial to the public as stipulated in this law" and the attorney will address the practical issues in the context of this topic within the framework of this right.

Түлхүүр үг: Өмгөөлөгч, нийтийн эрх, ашиг сонирхол, өмгөөлөгч шүүхэд нэхэмжлэл гаргах эрх,

Key words: Attorney, public rights and interests, attorney's right to file a claim,

Үндсэн хэсэг

Шүүхүүдийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулиудын зохицуулалтыг авч үзвэл Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиас бусад Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нийтийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор аливаа этгээд нэхэмжлэл, өргөдөл, мэдээлэл гаргах эрхийг тодорхой нарийн зохицуулаагүй ч энэхүү эрхийг нь хориглож хязгаарлаагүй билээ. Гэсэн хэдий ч уг эрхийн талаар тодорхой зохицуулалт хийгээд нэгдсэн ойлголтыг хууль тогтоомжид тусгах замаар бий болгох хэрэгцээ шаардлага байгаа юм.

Өдгөө нийтийн эрх, ашиг сонирхлыг хамгаалж нэхэмжлэл гаргах зохицуулалттай Захиргааны хэргийн шүүх ч уг эрхийг зохистойгоор хангаж байгаа эсэх нь эргэлзээтэй.

Захиргааны хэргийн шүүх нь “төрийн гүйцэтгэх эрх мэдэл” буюу захиргааны хууль бус үйл ажиллагаанаас хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хүн, хуулийн этгээдийн нэхэмжлэлээр хэрэг үүсгэн хянан шийдвэрлэдэг шүүх эрх мэдлийн байгууллага буюу хэлбэржсэн эрх зүйн хамгаалалтыг хэрэгжүүлэгч захиргааны гадаад буюу хөндлөнгийн хяналтын нэг төрөл юм.¹⁵⁶ Тус шүүх нь нийтийн эрх, ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээдээс гаргасан нэхэмжлэлийг хянан шийдвэрлэдэг ба “захиргааны хэргийн шүүхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд” гэж хуулиар эрх олгогдсон этгээд¹⁵⁷ гэж заасан байна.

Энэхүү заалтын дагуу хуулиар эрх олгогдсон этгээд гэдэгт Өмгөөллийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3-т зааснаар өмгөөлөгч нь нийтийн эрх, ашиг сонирхлыг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг олгосон байна.

Нийтийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор гаргаж буй нэхэмжлэлд тавигдах шаардлага нь маргаж байгаа асуудлын талаар хангалттай ашиг сонирхлоо илэрхийлсэн байх бөгөөд нийтийн ямар ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болозошгүй талаар нэхэмжлэлдээ тодорхой ойлгомжтой тайлбарлах ёстой. Гэвч уг шаардлагыг хангасан ч шүүх хэд хэдэн өмгөөлөгчийн гаргасан нэхэмжлэлээр захиргааны хэрэг үүсгэж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахгүй байгаа юм.

2019 онд Өмгөөллийн тухай хууль батлагдснаас хойш өмгөөлөгчдөөс нийтийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор захиргааны хэргийн шүүхэд хэд хэдэн удаа нэхэмжлэл гаргасан боловч шүүхээс нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн байна. Тодруулбал,

1/ Өмгөөллийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3-д заасан эрхийн хүрээнд буюу өмгөөлөгч энэ хуульд заасан нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад нийтийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор өөрийн нэрийн өмнөөс нэхэмжлэлийг гаргасан хэмээн тайлбарласнаас үзвэл нэхэмжлэгч нарын маргаж буй асуудал дээр дурдсан нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээдийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй байхаар хуулиар тогтоосон асуудлын хүрээнд буюу Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-д “... хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах...” гэж заасан хуулийн зохицуулалтад хамаарахгүй гэж дүгнэн “захиргааны хэргийн шүүхийн харъяаллын маргаан биш”¹⁵⁸ гэсэн үндэслэлээр;

2/ Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д “нэхэмжлэл” гэж хүн, хуулийн этгээдээс захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд тусгайлан заасан бол захиргааны байгууллагаас нийтийн эрх зүйн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдон үүссэн маргааныг шийдвэрлүүлэхээр захиргааны хэргийн шүүхэд гаргасан өргөдлийг”, 3.1.9-д “Захиргааны хэргийн шүүхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд” гэж хуулиар эрх олгогдсон этгээд, энэ хуулийн 18.3-д заасан шаардлага хангасан төрийн бус байгууллагыг”, 18.3-д “Хуулиар тусгайлан эрх олгогдсоноос бусад нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд нь хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд уг этгээд дараахь шаардлагыг хангасан байна”, 18.3.1-д “нэхэмжлэлийн шаардлага нь тухайн

¹⁵⁶Г.Банзрагч, Захиргааны процессын эрх зүй, УБ. 2019., х.24.

¹⁵⁷Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9.,

¹⁵⁸Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 20 дугаар тогтоол

байгууллагын дүрмийн зорилгод нийцсэн байх”, 18.3.2-т дүрмийн зорилгын дагуу сүүлийн гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх” гэж тус тус нарийвчлан зохицуулжээ. Дээрх хуулийн зохицуулалтаас үзэхэд захиргааны хэргийн шүүхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах тохиолдолд уг асуудлаар төлөөлөн нэхэмжлэл гаргах эрх нь олгогдсон байх төдийгүй хуульд заасан шаардлагуудыг хангасан байх нөхцөлийг шаардахаар байна. Өмгөөллийн тухай хууль болон энэхүү журамд заасан өмгөөлөгчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа нь нийтийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор шүүхэд гомдол, нэхэмжлэл гаргах эрхтэй хамааралгүй, нэхэмжлэл гаргагчийг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-т заасан хуулиар тусгайлан эрх олгогдсон нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд гэж үзэх үндэслэлгүй гэж дүгнэн “нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан”¹⁵⁹ гэсэн үндэслэлээр тус тус нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзжээ.

Шүүхийн эдгээр шийдвэрүүдээс үзвэл Өмгөөллийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3-т заасан хуулийн зохицуулалтыг шүүхээс “өмгөөлөгч нь хуулиар тусгайлан нэхэмжлэл гаргах эрх олгогдсон этгээд биш” гэж үзэж байхын зэрэгцээ хуулиар тусгайлан нэхэмжлэл гаргах эрх олгогдоогүй этгээдэд тавигдах шаардлагыг өмгөөлөгч хангах ёстой гэдэг байдлаар тайлбарлаж байна. Судлаачийн хувьд Өмгөөллийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсгийг шүүхээс тайлбарлаж буй байдалтай санал нийлэхгүй байгаа бөгөөд шүүх тус хуулийн заалтыг хэт явцууруулж тайлбарлаж байна.

Учир нь Өмгөөллийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд өмгөөлөгчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааны талаар зохицуулсан бөгөөд нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа гэдэг нь өмгөөлөгч бусдаас хөлс авахгүйгээр нийтийн тусын тулд болон нийгмийн эмзэг хэсгийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах зорилгоор үзүүлж байгаа хууль зүйн мэргэжлийн туслалцаа, мөн олон нийтийн эрх зүйн боловсролыг дэмжих зорилготой аливаа үйл ажиллагаа¹⁶⁰ гэж тодорхойлжээ.

Өмгөөлөгчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааг явуулах арга хэлбэрийг тодорхойлохдоо¹⁶¹:

1. Хууль зүйн зөвлөгөө өгөх;
2. Олон нийтийн эрх зүйн боловсролыг дэмжих зорилготой үйл ажиллагаа;
3. Төрийн байгууллага, албан тушаалтанд хандан гомдол гаргах;
4. Шүүхэд нэхэмжлэл, гомдол гаргах

Нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа гэх ойлголтыг дан ганц төлбөрийн чадваргүй хүнд хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаа гэж явцуу байдлаар ойлгож хэрэглэж болохгүй юм. Өөрөөр хэлбэл, нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааны нэг илрэх хэлбэр нь нийтийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор өмгөөлөгч шүүхэд нэхэмжлэл, гомдол гаргах замаар хэрэгжих боломжтой.

Түүнчлэн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсгээс үзэхэд нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжлэл гаргах этгээдүүд нь материаллаг хуулиар тусгайлан эрх олгогдсон этгээд, эсхүл хуулиар тогтоосон шаардлага хангасан төрийн бус байгууллага байна.

Өмгөөллийн тухай хууль нь материаллаг хууль бөгөөд уг хуулиар нэгэнт өмгөөлөгчид нийтийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг олгосон байтал үүнийг хуулиар тусгайлан эрх олгогдсон этгээд гэж үзэхгүйн зэрэгцээ Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хуулиар тусгайлан эрх олгогдсноос бусад нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх

¹⁵⁹Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 4630 дугаар захирамж

¹⁶⁰3.Сүхбаатар, Өмгөөллийн тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар (Өмгөөлөл судлалын цуврал), УБ, 2021, х-273,

¹⁶¹3.Сүхбаатар, Өмгөөллийн тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар (Өмгөөлөл судлалын цуврал), УБ, 2021, х-274,

бүхий этгээдийн нэхэмжлэл гаргах хүрээ буюу хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах асуудлаар тус шүүхэд нэхэмжлэл гаргах боломжтой гэж тайлбарлаж байгаа нь хэт явцуу хуулийг хэрэглэж байна гэж үзэхэд хүргэж байна.

Нөгөөтэйгүүр өмгөөлөгчийг нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хүрээ хязгааргүйгээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй гэж үзээгүй бөгөөд уг хүрээ хязгаарыг Монголын Өмгөөлөгчдийн холбооны Удирдах зөвлөлөөс Өмгөөллийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-т заасан эрхийнхээ хүрээнд нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хэлбэр, журмыг батлах замаар тогтоох боломжтой юм.

Дүгнэлт

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д “захиргааны хэргийн шүүхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд” гэж хуулиар эрх олгогдсон этгээд, энэ хуулийн 18.3-т заасан шаардлага хангасан төрийн бус байгууллагыг”, 18 дугаар зүйлийн 18.3-д “Хуулиар тусгайлан эрх олгогдсоноос бусад нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд нь хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд уг этгээд дараахь шаардлагыг хангасан байна” гэж тус тус зааснаас үзвэл тус шүүхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд гэдэгт хуулиар эрх олгогдсон этгээд, эсхүл хуульд тавигдах шаардлага хангасан төрийн бус байгууллагын ойлгоно.

Өмгөөлөгчийн хувьд Өмгөөллийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3-д зааснаар дээр нийтийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй хуулиар эрх олгогдсон этгээд байхад шүүхийн процесст түүнийг хуулиар тусгайлан нэхэмжлэл гаргах эрх олгогдоогүй гэж үзэж, цаашилбал төрийн бус байгууллагад тавигдах шаардлагыг заах замаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж байна.

Шүүхийн процесст өмгөөлөгчийн гаргаж буй нэхэмжлэлийг хоёр үндэслэлээр хүлээн авахаас татгалзаж байгаа байдал нь ойлгомжгүй, тодруулбал, нэхэмжлэл нь хуулиар тусгайлан эрх олгогдсоноос бусад этгээдэд тавигдах хүрээ хязгаарыг хэтрүүлсэн гэж үзэж тухайн нэхэмжлэл нь шүүхийн харъяалалын биш, эсхүл Өмгөөллийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3-д заасан эрх нь хуулиар тусгайлан олгогдсон эрх биш гэж үзэн нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд биш гэж үзэн хүлээн авахаас татгалзаж байгаа нь ойлгомжгүй нөхцөл байдлыг бий болгож байна.

Иймд өмгөөлөгчийн нийтийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор гаргаж буй нэхэмжлэлийн хэмжээ хязгаарыг зайлшгүй тогтоох шаардлага үүсч байгаа бөгөөд үүнд дорвитой арга хэмжээг авч, холбогдох журмыг боловсруулж, батлуулан хэрэгжүүлж, өмгөөлөгчдийн нэхэмжлэл гаргах эрхийг хангуулах талаар арга хэмжээ авах шаардлагатай.

Ашигласан материал

- Г.Банзрагч, Захиргааны процессын эрх зүй, УБ. 2019
- Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
- Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 20 дугаар тогтоол
- Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 4630 дугаар захирамж
- 3.Сүхбаатар, Өмгөөллийн тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар (Өмгөөлөл судлалын цуврал), УБ, 2021
- 3.Сүхбаатар, Өмгөөллийн тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар (Өмгөөлөл судлалын цуврал), УБ, 2021

